

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-34
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	35-143
<i>1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	40-69
<i>2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	69-71
<i>3.“Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	71-83
<i>4.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	83-99
<i>5.Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	99-102
<i>6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	102-106
<i>7.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	106-131
<i>8.““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	131-143

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын
ээлжит чуулганы 12 дугаар сарын 22-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Сандаг-Очир, Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Б.Жаргалмаа, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Д.Сарангэрэл, Ч.Ундрэм;

Тасалсан: Б.Энхбаяр;

Хоцорсон: Ц.Анандбазар- 19 минут, Д.Бат-Эрдэнэ- 12 минут, С.Батболд- 2 цаг 23 минут, Б.Бейсен- 13 минут, Х.Болорчулуун- 59 минут, Т.Доржханд- 27 минут, Б.Жавхлан- 4 цаг 14 минут, Ц.Мөнх-Оргил- 33 минут, С.Одонтуяа- 4 цаг 26 минут, М.Оюунчимэг- 35 минут, Д.Өнөрболор- 31 минут, Ж.Сүхбаатар- 37 минут, Ц.Сэргэлэн- 5 цаг 31 минут, Ц.Туваан- 14 минут, Н.Учрал- 58 минут, Д.Цогтбаатар- 43 минут, О.Цогтгэрэл- 12 минут, Ж.Чинбүрэн- 12 минут, Ж.Эрдэнэбат- 2 цаг 03 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Нэг.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн газрын ахлах зөвлөх А.Нинжин, Хуулийн хэлтсийн ахлах референт Ж.Мөнх-Оргил, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн захирал Х.Алтай, мөн компанийн Бизнес, хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “Монголын экспортлогчдын холбоо”-ны ерөнхийлөгч Д.Галсандорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Г.Дамдинням, Н.Алтанхуяг, Н.Ганибал, Ж.Батсуурь, Ш.Раднаасэд, Ц.Даваасүрэн, Б.Батгөмөр, С.Ганбаатар, Д.Ганбат, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн захирал Х.Алтай, Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Монголын экспортлогчдын холбоо”-ны ерөнхийлөгч Д.Галсандорж нар хариулж, тайлбар хийв.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин, Хуулийн хэлтсийн ахлах референт Ж.Мөнх-Оргил, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн захирал Х.Алтай, мөн компанийн Бизнес, хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “Монголын экспортлогчдын холбоо”-ны ерөнхийлөгч Д.Галсандорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг дэмжиж үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	21
Бүгд:	50
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ш.Адъяаа, С.Чинзориг, Т.Доржханд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	21
Бүгд:	50

58.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тайлбар хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцав./13:17/

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 12 минут үргэлжилж, 13 цаг 18 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 04 минутад эхлэв.

Дөрөв. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга Р.Чингис, мөн штабын

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

орлогч, харуул хамгаалалтын хэлтсийн дарга Н.Мөнх-Итгэл, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ц.Мөнх-Оргил, Н.Энхболд, Ж.Чинбүрэн, Н.Наранбаатар, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Дотоодын цэргийн штабын дарга Р.Чингис нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Н.Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Ж.Буянбат, Шүүхийн шинжилгээний дүн бүртгэл, мэдээллийн газрын захирал Д.Мөнхбат, Криминалистикийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэ-Очир, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн А.Амгаланболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Ж.Буянбат нар хариулж, тайлбар хийв.

Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Н.Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Ж.Буянбат, Шүүхийн шинжилгээний дүн бүртгэл, мэдээллийн газрын захирал Д.Мөнхбат, Криминалистикийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэ-Очир, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн А.Амгаланболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

55.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 15 цаг 33 минутад хаалттай горимд шилжив.

Хуралдаан 15 цаг 50 минутад нээлттэй горимд шилжиж, үргэлжлүүлэн хуралдав.

Долоо.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга О.Одончимэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ж.Чинбүрэн, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн нар хариулж, тайлбар хийв.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй санал томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Г.Амартүвшин, Х.Булгантуяа, Г.Ганболд, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 33.3 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг” гэснийг “зөвшөөрлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 24
Бүгд: 43
44.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1, 2, 4, 5, 6 дахь заалт, мөн зүйлийн 3 дахь заалтын 20.1 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Саналын томъёоллын 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан 2 дугаар зүйлийн “дараах хэсэг, заалтыг” гэснийг “20 дугаар

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зүйлийн 20.6 дахь хэсгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалтын “байшин,” гэсний дараа “стандартын шаардлага хангасан дулаалгатай гэр,” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн ““хэрэгжилтэд мэргэжлийн” гэсний дараа “хяналтын асуудал эрхэлсэн” гэж нэмж, мөн зүйлийн ““тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг “болон энэ хуулийн 25.5-д заасан мэргэжлийн байгууллагын эрх олгоход тавигдах шаардлагыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, мөн зүйлийн “Засгийн газраас томилсон эрх бүхий” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, мөн зүйлийн “хяналтын стандартын хэрэгжилтэд холбогдох” гэснийг “стандартын хэрэгжилтэд холбогдох” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ” гэснийг “ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 22
Бүгд: 42
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.7-д заасан” гэснийг хасаж, мөн зүйлийн 3 дахь заалтын 29¹.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29¹.1.Энэ хуулийн 20.2-т заасан ховор амьд амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрөл, 25.1-д заасан тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу дуудлага худалдааны журмаар олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 22

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Бүгд: 42
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 29^{1.2} дахь хэсгийн “баталснаас” гэснийг “баталсан шийдвэр гарснаас” гэж өөрчилж, 29^{1.3} дахь хэсгийн “этгээд” гэсний дараа “, эсхүл” гэж, 29^{1.4} дэх хэсгийн “24 цагийн өмнө” гэсний дараа, 29^{1.7} дахь хэсгийн “24 цагийн дотор” гэсний дараа “дуудлага худалдаа зохион байгуулагчийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 29^{1.8} дахь хэсгийн “Хэрвээ ялсан этгээд тогтоосон хугацаанд” гэснийг “Дуудлага худалдааны ялагч” гэж, 29^{1.9} дэх хэсгийн “дүрс” гэснийг “дуу-дүрсний” гэж, 29^{1.10} дахь хэсгийн “худалдааны ялагч нь тэмдэглэл болон гэрээнд” гэснийг “худалдаанд оролцогчид тэмдэглэлд үндэслэлгүйгээр” гэж, мөн хэсгийн “зайлсхийсэн” гэснийг “татгалзсан” гэж, 29^{1.14} дэх хэсгийн “29.1-д” гэснийг “29^{1.1}-д” гэж, мөн тус тус өөрчилж, мөн заалтын 29^{1.12.3} дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29^{1.12.3}.энэ хуулийн 29^{1.8}-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээд татгалзсан тохиолдолд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 36.7, 36.8 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“36.7.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 36.1-д заасан зөвшөөрлийг сунгуулах өргөдлийг хүлээн авах, магадлан шалгах ажиллагааг ажлын 15 өдрийн дотор явуулах бөгөөд уг ажиллагааг дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

36.8.Засгийн газар энэ хуулийн 36.7-д заасан саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын 25.5 дахь хэсгийн “заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга” гэснийг “заасан зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд” гэж, мөн зүйлийн 5 дахь заалтын 36.1 дэх хэсгийн “заасны дагуу нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар” гэснийг “заасан зөвшөөрлийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу Засгийн газар” гэж өөрчилж, мөн заалтын 36.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх асуудлыг мөн хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Нэн” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.5-д заасны дагуу нэн” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга” гэснийг “заасан зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 29¹.8 дахь хэсгийн “29¹.7-д заасан” гэсний дараа “хугацаанд” гэж нэмж, 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын “25.1, 25.5 дахь” гэснийг “25.1 дэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Тав.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд архивын баримтыг хадгалуулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зургаа.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 30
Бүгд: 42
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Долоо.Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Найм.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 24.2.2 дахь заалтын, мөн зүйлийн 5 дахь заалтын 36.20.5 дахь заалтын “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал,” гэж гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “10¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “аргачлал, эрх олгох” гэснийг “аргачлалын” гэж” нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “10¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав.Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван нэг.Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 139.1.13 дахь заалтын “, Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг нотолсон цагдаа, гаалийн байгууллагын тодорхойлолт” гэснийг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 171.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“171.1.10.хилийн боомт, олон улсын нисэх буудалд ажиллаж байгаа татваргүй барааны дэлгүүр зорчигчийн гадаадад зорчих тийз, гадаад паспорт, гаалийн нутаг

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дэвсгэрийн гүнд байрлах дэлгүүр нь Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтнуудын паспорт эсхүл дипломат үнэмлэх болон худалдан авсан барааны мэдээллийг борлуулалт хийх тухай бүр цахим төлбөрийн баримтын системд бүртгэж, цахим баримт олгох;" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Арван хоёр.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд
нэмэлт оруулах тухай:*

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7.7, 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.7.Гадаадын иргэн нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу улсын онц чухал объектод ажиллаж болно.

7.8.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 7.6-д заасан өргөдлийг хүлээн авч Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу магадлан шалгах ажиллагааг хэрэгжүүлж, саналаа хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газарт хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7.11 дэх хэсгийн “7.7, 7.8, 7.9-г” гэснийг “7.8-д” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.10, 7.12 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 17

Бүгд: 44

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

*Арван гурав.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.4 дэх хэсгийн, мөн зүйлийн 5 дахь заалтын 12.2 дахь хэсгийн “худалдаа эрхлэх,” гэсний дараа, “газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 5 дахь заалтын “12.2.1 дэх заалтын “4.1.10-г” гэснийг “4.1.9-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 5.2.5 дахь заалтын “1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт” гэснийг “3.3 дугаар зүйлийн 1-д” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь заалтын 8.3.5 дахь заалтыг, мөн зүйлийн 4 дэх заалтын 9.2.2 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын “бүтээгдэхүүнийг” гэсний дараа “энэ хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь заалтын “уг зөвшөөрлийг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван дөрөв.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Арван тав.Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10, 11, 12 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“10.Засгийн газар энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөвшөөрлийн түдгэлзүүлэх, сэргээх эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлнэ.

11.Энэ хуулийн 6 дахь хэсэгт заасан зөвшөөрөл хүссэн өргөдөл болон зөвшөөрөл сунгуулах өргөдлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авах, магадлан шалгах ажиллагааг ажлын 15 өдрийн дотор явуулах бөгөөд уг ажиллагааг дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

12.Засгийн газар энэ зүйлийн 11 дэх хэсэгт заасан саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 13 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 4 дэх хэсгийн “13 дахь” гэснийг “3 дахь” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Арван зургаа.Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “18 дугаар зүйлийн 18.5” гэснийг “19 дүгээр зүйлийн 19.5” гэж, мөн зүйлийн “, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Галт зэвсэг ашиглах спортын тэмцээн, сургалтад оролцох, ан агнах зорилгоор” гэснийг “Ан агнах зорилгоор” гэж” гэснийг “13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “загвар, гэрчилгээ олгох журмыг” гэснийг “загварыг” гэж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Арван долоо.Гамиггаас хамгаалах тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7.9 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Арван найм.Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 15.13, 15.14 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Арван ес.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас ажлын хэсгийн гаргасан, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Хорин нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2, 6, 7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 10.14 дэх хэсгийн “Командлалын зөвшөөрлийг үндэслэн” гэснийг “Командлал, эсхүл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 1 дэх хэсгийн “1.1, 1.21,” гэснийг, мөн зүйлийн 3 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтын 10.11 дэх заалтын “үйлчилгээ эрхлэх” гэсний дараа “зорилгоор талбай ашиглах” гэж нэмэх гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “5.2 дугаар” гэснийг “4.2 дугаар” гэж, мөн зүйлийн “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар” гэснийг “Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, мөн зүйлийн “12.13 дахь” гэснийг “12.14 дэх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн “Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэсний дараа “мөн хэсгийн 1.23 дахь заалтын “сум, дүүргийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	23
Бүгд:	46

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	18
Бүгд:	47

61.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	42
Бүгд:	47

10.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Техникийн саатлын улмаас санал хураалтын систем ажиллаагүй тул Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх санал хураалтыг хүчингүйд тооцов.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	30
Татгалзсан:	17
Бүгд:	47

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “, 10 дахь хэсгийн 10.11 дэх хэсгийн “болон нийтийн эзэмшлийн гудамж, талбайд” гэснийг” хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 16
Бүгд: 47
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 18, 21, 22 дахь” гэснийг, мөн зүйлийн “6.1 дүгээр зүйлийн 18, 21, 23 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.6 дугаар зүйлийн 6,7 дахь хэсэг, 7.15 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 10.23 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэснийг “тусгай зөвшөөрөлгүйгээр” гэж,” гэснийг, мөн зүйлийн “7.15 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “, зөвшөөрөл” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг ”тусгай зөвшөөрлийг” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 18
Бүгд: 47
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4, 5 дугаар зүйл болгох:

“4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтын “, эсхүл зөвшөөрөл авах журам зөрчсөн” гэснийг, 6.15 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулсан” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг, 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг, 6.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг, 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг, 7.13 дугаар зүйлийн 9.5 дахь заалтыг, 7.15 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг, 7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг, 7.18 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг, 10.18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг, 12.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг, 13.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг, 13.4 дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсгийг, 14.5 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг, 16.3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 17
Бүгд: 47
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай:

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, мөн зүйлийн 6.10 дахь заалтын “14.13” гэсний дараа “,14.15” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 15
Бүгд: 47
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин дөрөв.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 14
Бүгд: 47
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин тав.Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай:

Хуралдаан даргалагчаас ажлын хэсгийн гаргасан, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Хорин зургаа.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 20.2.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 35
Бүгд: 46
23.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын “7.1.4, 7.1.5 дахь” гэснийг “7.1.4 дэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.1.5 дахь заалтыг 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгон, мөн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 20.2.5-20.2.12 дахь заалтыг 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт болгон, мөн заалтын 20.2.4 дэх заалтыг 2 дугаар зүйлийн 3 дахь заалт болгон, мөн заалтын 20.3 дахь хэсгийг мөн зүйлийн 4 дэх заалт болгон, мөн заалтын 20.5 дахь хэсгийг мөн зүйлийн 5 дахь заалт болгон тус тус шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хорин долоо.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 25.5 дахь хэсгийн “зөвшөөрлийг үндэслэн” гэснийг “зөвшөөрлийн дагуу” гэж, мөн хэсгийн “боомт нэвтрэх зөвшөөрлийг олгоно” гэснийг “боомтод нэвтрэх үйл ажиллагаа явуулахад энэ хуулийн 25.4-т заасан баримт бичгийг бүрдүүлж, энэ хуулийн 25.2-т заасан байгууллагад хүргүүлнэ” гэж, мөн зүйлийн 25.6 дахь хэсгийн “25.4, 25.5-д” гэснийг “25.4-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 25.8 дахь хэсгийн “нислэг үйлдэх” гэсний дараа “нислэгийн бүрэлдэхүүнд хилийн зурвас, бүсэд нэвтрэх” гэж нэмж, мөн хэсгийн “ажлын нэг өдрийн дотор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “26.2.3, 30.2.3-т” гэснийг “26.2.3-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин найм.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 14.3 дахь хэсгийн “зөвшөөрөл олгох,” гэсний дараа “сунгах,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин ес.Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 4 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 17
Бүгд: 46
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 19
Бүгд: 47
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 17
Бүгд: 47
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 19
Бүгд: 47
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гуч.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.6 дахь хэсгийн “Сонгон шалгаруулалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна” гэснийг хасаж, 3 дугаар зүйлийн 4 дэх заалтыг 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтад шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 17
Бүгд: 47
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Гучин нэг.Радио долгионы тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгон шилжүүлж, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 11.1 дэх хэсгийн “зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл /цаашид “эрхийн бичиг” гэх/” гэснийг “болон энгийн зөвшөөрөл” гэж, мөн хэсгийн “тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авах өргөдлийг хүлээн авч” гэснийг “зөвшөөрөл хүссэн” гэж тус тус өөрчилж, мөн заалтын 11.4 дэх хэсгийн “Сонгон шалгаруулалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 17
Бүгд: 47
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 18
Бүгд: 47
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин хоёр.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 15
Бүгд: 47
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн “чөлөөт бүсийн захирагчид” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.4 дүгээр зүйлд зааснаас гадна” гэж нэмж, мөн заалтын 15^{1.1.3} дахь заалтын “хяналтын” гэснийг “хяналт шалгалт хэрэгжүүлэх” гэж өөрчилж, мөн заалтын 15^{1.1.4} дэх хэсгийг хасаж, мөн заалтын 15^{1.2} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15^{1.2}.Энэ зүйлийн 15^{1.1}-д заасан баримт бичиг нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 15
Бүгд: 47
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15^{1.4} дэх хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлийн 3 дахь заалтын 15^{2.1} дэх хэсгийн “нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчилж, мөн заалтын 15^{2.1.3} дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 16
Бүгд: 47
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 18
Бүгд: 47
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “татвар, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.2-т заасан журмын дагуу” гэснийг “татварын байгууллагын санал, хяналтын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 16
Бүгд: 47
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн “даргад,” гэснийг “дарга, эсхүл” гэж, мөн хэсгийн “бичгийн хамт албан бичиг /цахим/-ээр” гэснийг “бичгийг цахимаар” гэж, мөн заалтын 15^{1.3} дахь хэсгийн “хийж шийдвэр гаргах” гэснийг “шийдвэрлэж, зөвшөөрөл олгох” гэж тус тус өөрчилж, мөн заалтын 15^{1.3} дахь хэсгийн “дүгнэлт гаргах” гэсний дараа “үүрэг бүхий” гэж, мөн хэсгийн “нийслэлийн Засаг дарга,” гэсний дараа “эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт” гэж, 15^{1.4} дэх хэсгийн “нийслэлийн Засаг дарга,” гэсний дараа “эсхүл” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 15
Бүгд: 47
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Гучин гурав.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 52.16 дахь хэсгийн “Ийнхүү шилжсэн” гэснийг “Зөвшөөрөл эзэмших эрхийг шилжүүлэн авсан” гэж өөрчилж, мөн заалтын 52.15.6 дахь заалтын “нэн” гэснийг, 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 53.2 дахь хэсгийн “заавал” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 14
Бүгд: 47
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Гучин дөрөв.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний
итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:*

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн заалтын 9.6 дахь хэсгийн “нь энэ зүйлийн 9.5-д заасан стандартыг заавал” гэснийг “энэ хуулийн 6.7-д заасан техникийн зохицуулалтыг дагаж” гэж өөрчлөх.

“9.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.3, 1.5, 1.12, 1.13, 1.15, 1.16, 1.17, 1.18, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.2, 7.4, 7.6 дахь заалт, 11 дэх хэсгийн 11.7 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн болон 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.9, 1.11 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.1 дэх заалтад заасан энгийн зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 15

Бүгд: 47

68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт болгон шилжүүлэх.

“Тайлбар: Энэ зүйлийн 4.1.2-т заасан “сонгон хэрэглэх баримт бичиг” гэж хүчин төгөлдөр стандартаас хэрэглэхэд тохирох стандартыг сонгож хэрэглэх эрхийг ойлгоно.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

*Гучин тав.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 7¹.2 дахь хэсгийн “стандартад заасан” гэснийг “холбогдох стандартын шаардлагаас гадна” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 17

Бүгд: 47

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн “чөлөөт бүсэд тухайн” гэснийг “чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт” гэж, мөн зүйлийн 7.11 дэх хэсгийн “зөвшөөрлийн хугацаа” гэснийг “зөвшөөрлийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.11.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 17

Бүгд: 47

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Гучин зургаа.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай:*

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“16.12.Төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.1-д заасны дагуу Засгийн газар олгох, сунгах, хүчингүй болгох бөгөөд мөн хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх шийдвэрийг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 15
Бүгд: 47
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин долоо.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 33
Бүгд: 47
29.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Гучин найм.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 18
Бүгд: 47
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн” гэсний дараа “14.1 дэх хэсгийн “авмагц доор дурдсан ажиллагаа явуулна” гэснийг “авч, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2-т зааснаас гадна дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж, мөн зүйлийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 20
Бүгд: 47
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Татгалзсан: 19
 Бүгд: 47
 59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин ес.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран” гэснийг, мөн зүйлийн “13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын төв байгууллагын зөвшөөрөлтэйгөөр худалдаж” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэнээр шилжүүлж” гэж, мөн зүйлийн “13.4” гэснийг “13.2” гэж, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын төв” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “энэ хуулийн 5.1.6-д заасан журмын дагуу мэдээллийн нэгдсэн санд” гэж,” гэснийг, мөн зүйлийн мэргэжлийн хяналтын төв байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх зүйлийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 23.3 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтын төв байгууллага” гэснийг “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
 Татгалзсан: 17
 Бүгд: 47
 63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын төв байгууллага,” гэснийг, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтын “болон мэргэжлийн хяналтын” гэснийг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
 Татгалзсан: 17
 Бүгд: 47
 63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөч.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Хуралдаан даргалагчаас ажлын хэсгийн гаргасан, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн /найруулгын санал/ төслийн 2 дугаар зүйлийн “21.1.18, 21.1.20,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “, мөн зүйлийн 21.1.21 дэх заалтын “эрх” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “30.2.2-30.2.6 дахь заалт, 30.3-30.5 дахь хэсэг” гэснийг,” гэснийг,

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

мөн зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.1.38, 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.4,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дөчин нэг. Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 17
Бүгд: 47
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 16
Бүгд: 47
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 14
Бүгд: 47
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөчин хоёр. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 13
Бүгд: 48
72.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 18
Бүгд: 48
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 16
Бүгд: 48
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 16
Бүгд: 48
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөчин гурав. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “11.1.12 дахь заалт,” гэснийг, мөн зүйлийн “заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.10 дахь” гэснийг, мөн зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “батална.” гэснийг “тогтооно.” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 14
Бүгд: 48
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөчин дөрөв. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 41
Бүгд: 48
14.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэх санал гаргасан тул санал хураалтыг хүчингүйд тооцов.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Х.Ганхуяг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дөчин тав. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 20
Бүгд: 48
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөчин зургаа.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 19
Бүгд: 48
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 18
Бүгд: 48
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөчин долоо.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “11¹ дүгээр зүйлийн гарчиг, 11¹.1, 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.3, 18 дугаар зүйлийн 18.8, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.4, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “цөмийн болон цацрагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг, мөн зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “харьяалах хяналтын” гэж,” гэснийг, мөн зүйлийн “19.8 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “цөмийн болон цацрагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг, “, 22 дугаар зүйлийн 22.5.2 дахь заалтын дугаарыг “22.5.1” гэж, 22.5.3 дахь заалтын дугаарыг “22.5.2” гэж,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “23 дугаар зүйлийн гарчгийг” гэснийг “23 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх” гэснийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 12
Бүгд: 48
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөчин найм.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт,

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.2, 7.5 дахь хэсгийн “Малын” гэснийг “Мал, амьтны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 13
Бүгд: 48
72.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, “зөвшөөрлийн” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 14
Бүгд: 48
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөчин ес.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “гэж, 41 дүгээр зүйлийн гарчгийн “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх, худалдах”” гэж гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 14
Бүгд: 48
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “19.8 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор”,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 15
Бүгд: 48
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Найм. *““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн “Зэс, металлын групп”-ын дарга Х.Бадамсүрэн, мөн компанийн Нэгдсэн удирдлага, стратегийн хэлтсийн дарга Б.Цэвээнжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Доржханд нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Б.Баттөмөр, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн “Зэс, металлын групп”-ын дарга Х.Бадамсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Баттөмөр, Т.Энхтүвшин, Т.Аубакир нар үг хэлэв.

““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн, Т.Энхтүвшин нарын гаргасан, ““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	13
Бүгд:	39
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.	

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг “Хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“Хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа эсэхийг асуув. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:31/

Бусад. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Д.Тогтохсүрэн нарт мэндчилгээ дэвшүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 40 минут үргэлжилж, 76 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 89.5 хувийн ирцтэйгээр 18 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 06 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданишатар: Чуулганы үйл ажиллагаа нээснийг мэдэгдье.

Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа УИХ-ын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 12 сарын 19-нд УИХ-ын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, 12 дугаар сарын 22-нд УИХ-ын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн нар төржээ.

УИХ-ын гишүүн Ёндонпэрэнлэйн, Баатарбилэг, Дуламдоржийн Тогтохсүрэн нартаа төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд УИХ-ын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, ал жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Манай Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн маань бол Жамганы Ёндонпэрэнлэй, Пэрлээжсалын Чимэдрэгзэн нарын 7 дахь хүү болж, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн маань Батхүүгийн Дуламдорж, Дэлгэрийн Цэрэндолгор нарын 3 дахь хүүхэд болж эхээс мэндэлцгээжээ.

Ингээд аав, ээж, төрөл төрөгсөд, гэр бүлийн гишүүдэд нь бас ингээд УИХ-ын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

УИХ-ын 22 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

2-т, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

3-т, “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” УИХ-ын тогтоолын төсөл

4. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

5-д, Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

7-д, “Монгол Улсын хилийн зурвас газрыг тогтоож, улсын тусгай хэрэгцээнд авах тухай” УИХ-ын тогтоолын төсөл

8-д, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Энэ бол ЗГ Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа. Зарчмын зөрүүтэй 96 саналтай.

Эцэст нь “Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг

ашиглах тухай” УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу УИХ-ын гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дарааллыг өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол бичгээр энэ тухай саналаа 17 цагаас өмнө ирүүлнэ гэж заасны дагуу УИХ-ын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар, Дашидондогийн Ганбат, Бөхчулууны Пүрэвдорж, Баагаагийн Баттөмөр нараас ирүүлсэн албан бичгүүд ирүүлснийг уншиж танилцуулъя, эхэлье.

Эхлээд Сайнхүүгийн Ганбаатар гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

С.Ганбаатар: Эрхэм нөхөд өө, өнөөдөр бас нэг дахиад л нэг том хулгайг хэдүүлээ зогсоох хэрэг гарлаа. Эрдэнэс таван толгойг хувьчлах гэж байна, үүнийг зогсооё.

Уул уурхайн биржийн тухай хуулийг дагалдаж орж ирж байгаа Монгол УИХ-ын тогтоолын төсөл дээр Эрдэнэс таван толгой ХК-ийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх гэсэн заалт ороод ирсэн байна. Энэ Сайханбилэгийн ЗГ ГОК-ын 49 хувийг хувьчлах гэж оролдоод бөөрөө гаргуулсан. Одоо МАН-ынхан, та нар үүнийг хийснээрээ бүрэн үхэлд хүрнэ. Хэдий сөрөг хүчин ч гэсэндээ ийм байж болохгүй ээ гэдгийг сануулж, анхааруулж зогсоохыг би уриалж байна.

Өнөөдөр төр муу менежер, тэгэхдээ төр муу өмчлөгч байх гэсэн санаа биш шүү. Та нар өмчийн эрхэнд нь халдаж байгаа байхгүй юу. МАН-ын тавьсан гүйцэтгэх захирал Эрдэнэс таван толгойгоос олон зуун сая доллар хулгай хийгээд эздэдээ өгсөн гэдэг бол буруу. Ил тод болгох ёстой, хяналттай болох ёстой. Энэ нь наад гүйцэтгэх захирлаа олон нийтийн хяналтад оруулж, сонгон шалгаруулалтыг нь сайн хийж, хариуцлагын гэрээгээ чангатга гэсэн болохоос биш өмчийн эзэн болсон Монголын ард түмнээс үүнийг нь хулгайлж авна гэсэн санаа биш шүү. Та нар бодоод үз дээ. Эрдэнэс таван толгойн өмчийн эзэн, ард иргэд өнөөдөр дахиад Эрдэнэс таван толгойн тухай жагсаал цуглаан хийх нь битгий хэл ярих ч эрхгүй болж байна шүү дээ. Ингэхээр энэ тогтоолын төслийг хэлэлцэхгүй байхыг би жагсаалтаас хасахыг хүсэж байна.

Өнөөдөр нүүрсний хулгай газар авсан, би тэр нүүрсний хулгайг ярих гээгүй. Нүүрсний хулгай яагаад гарсан бэ гэвэл ил тод биш, хяналтгүй байснаас үнэн. Яаж. Үе үеийн Ерөнхийлөгч нар өнөөдөр ГОК-ийг, эсвэл Ерөнхий сайд бол хоорондоо булаацалддаг юм шүү дээ. ГОК-ийн баялгийн гэрээ, баяжмалын гэрээ, Эрдэнэс таван толгой энэ хэдэн гэрээнүүдийг л булаацалддаг. Үе үеийн төрийн тэргүүнүүд булаацалдаж ирсэн. Тэгэхээр энэ дээр МАН-ынхан оруулж ирсэн энэ хуулиа татаж аваач ээ. Өнөөдрийн энэ ард иргэдийн тэмцлийг дагуулж тонгорч, ингэж өмчийн эрхэнд нь халдаж болохгүй ээ гэдэг энэ байр сууриа илэрхийлж, эсэргүүцэж байгаагаа илэрхийлье.

Г.Занданшатар: Өнөөдрийн хэлэлцэх асуудалд тийм байхгүй, Ганбаатар гишүүн. Одоо бас ард түмнийг төөрөгдүүлж, энэ эгзэгтэй цаг үед хэлэлцсэн байлаа ч гэсэн хэлэлцсэн байлаа. Сонс оо, сонс, Ганбаатар гишүүн ээ, энэ бол ард түмэнд ил тод, нээлттэй болгож, ард түмний 1072 хувьцааг

бүртгэж, бүртгэлд хамруулж зөв болгох гэсэн ийм агуулгатай санаа л УУХҮЯ, холбогдох газрууд ажиллаж байгаа. Тийм учраас, ажлын хэсэг тийм. Биржийн тухай хуультай холбогдуулаад би уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нүүрсийг ил тод энэ ТӨК-ууд худалдах тухай асуудал. Тийм учраас биржийн тухай хуультайгаа л холбоотой асуудал яригдана шүү дээ. Түүнээс юу боллоо гэж тэгж, тэгэх бол тийм, тийм учраас сайн нягтлаарай. Энэ дэмий тооцоо судалгаагүй үндэслэлгүй зарим яриа ард иргэдэд бас буруу зөрүү ойлголт өгч. Түүнийгээ сайн нягталцгаа.

Өнөөдөр хэлэлцэх асуудалд тийм юм байхгүй. Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Өглөөний мэнд. Өнөөдөр бол хамгийн богино өдөр, хамгийн урт шөнө юм байна. Ингээд 9 эхэлж байгаа. Хөдөө гадаа хүмүүсийн амьдрал маш хүнд байна. Тэгээд өнөөдрийн хэлэлцэх асуудалд Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль орж ирж байна, мөн Уул уурхайн биржийн тухай хууль орж ирж байна. Бид нарын энэ батлаад байгаа хуулиуд дутуу дулимаг байна. Уул уурхайн биржээр гэхэд л нэг 30 хувийг нь оруулна гээд, өмчийг хувьчлахдаа нэг 30 хувийг нь хувьчилж байна энэ тэр гээд, дандаа нэг дутуу алсан могой шиг юм хийх юм.

Үндсэн хуулийн өөрчлөлтийг ч гэсэн маш яаруу түргэн хийгээд л, тэр өөрчлөлтөөр нэг хэдэн хүн сайд болоод л, салбараасаа баян сайд нар гарч ирээд л ингэж ажиллах юм. Тэгээд нэг ёс суртахуун гэдэг юм байхгүй болчихжээ. Манай дарга нар өөрсдөө огцорч байвал зүгээр байна, татгалзаад түдгэлзээд явчихвал зүгээр байна.

Өнөөдөр нүүрсний хулгайн асуудлыг ярьж байна. Энэ хэдэн залуучууд маань Монгол Улсын иргэдийн нэг хэсэг, амьдралаа өөрийнхөө боломжийг хулгайлуулчихсан, ирээдүйгээ

хулгайлуулчихсан залуучууд маань 18 өдөр энэ Сүхбаатарын талбай дээр хөхөө өвлийн хүйтэнд, энэ хүйтэн цемент дээр эрүүл мэндээ золиослолоо. Энэ залуучуудын эрүүл мэндийг юугаар ч нөхөшгүй. Гэтэл энэ нүүрсний хулгайчдыг зарла гэж эхэлсэн юм маань нэг их үр дүнд хүрсэн ч үгүй. Гэхдээ Монголын ард түмэн бол харж байгаа. Гэхдээ энэ их олон юмыг мартдаг, ард түмэн бол. Гэхдээ энэ мэдрэмжийг мартахгүй байх гэж бодож байна, мэдрэмж бол үлдэнэ. 10 жил төмөр замыг вагонтой нь, доторх ачаатай нь, бүх юмтай нь хулгайлсан улсууд шийтгэлгүй үлдэж байна. Өчигдөр тэр сонсгол их аятайхан явчих байсан юмыг яаж их үймүүлж, ямар муухай болгож байна. Ард түмний мэдэх эрхэд яаж халдаж байна. Эцсийн эцэст нүүрсний хулгайчдыг өмгөөлөх хурал болоод л тарж байна шүү дээ. Саармагжуулах, ард нийтийн жагсаалыг саармагжуулах ийм л юм болж байна. Өнөөдөр Монгол Улсад хэн жаргалтай байна, нүүрсний хулгайчид л жаргалтай байна, нүүрсний хулгайчдын төлөөллүүд бүх газар шингэчихсэн байна. Энэ хууль хяналтын байгууллага, энэ механизм чинь ажиллахгүй байна аа.

Би бол УИХ-ын даргыг ч бай, тэр үе үеийн ЗГХЭГ-ын дарга хийж байсан хүмүүсийг бүгд татгалзаад түдгэлзээд энэ Монгол Улсын Ерөнхий сайд ч гэсэн, Хууль зүйн сайд ч гэсэн энэ ах дүү 2 бол чадлаараа л хичээж байх шиг байна. Хууль зүйн сайд, Ерөнхий сайд 2 маань. Гэхдээ ер нь түдгэлзээд бүгдээрээ татгалзаад, хариуцлагаа хүлээгээд ингээд сайхан шалгуулчихвал яадаг юм бэ. Гадуур ярьж байна шүү дээ, хулгайч нь хулгайчаа шалгадаггүй юм даа гэж. Тэгээд тэр банкны захирлууд гарч ирээд ирж байна, юун гуя, би төрөөс энэ Монголоос Монголын ард түмнээс авлагатай гэж байна шүү дээ. Энэ хулгайч нарыг гааруулсан л ийм юм болж байна. Тэгээд энэ чинь эцсийн эцэст эмх замбараагүй байдал, тэр Орост хэн жаргалтай вэ гэдгийг бичиж байх үеийн

Октябрийн хувьсгалын урьдчилал болж байсан шүү дээ.

Ийм юм руу Монгол Улсыг, Монголын ард түмнийг түлхэх гэж байгаа бол бид нарын тэр үлдээсэн, эрхэмлэж яваарай гэсэн тусгаар тогтнол, эрх чөлөө, энэ ардчилал чинь бүгд аюулд ороод байна. Энэ дээр эрхэм Их Хурлын гишүүд ээ, бид нар энэ хуулиа сайн боловсруулж, сайн баталъя.

Г.Занданиатар: Энэ бас л зөв ойлголт өгөх зорилгоор Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ээ, энэ тогтоолын төсөл чинь бол уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд экспортод гаргах нүүрсийг цахим системээр болон хөрөнгийн биржээр арилжаалах нөхцөлийг бүрдүүлж экспортод гарах нүүрсний нээлттэй, цахим арилжааны холбогдох харилцааг зохицуулах журмыг баталж мөрдүүлэх гэсэн байна шүү дээ.

Ингэснээр энэ нүүрсний хулгайчийг ил тод болгож, нүүрсний наймааг чинь ил тод болгож, уул уурхайн биржээр борлуулах нөхцөлийг нь хууль хэрэгжих хүртэл хугацааг хүлээхгүйгээр ЗГ хэрэгжүүлж байх ийм чиглэл өгч байна. Уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг баталж, шаардлагатай дэд бүтэц бий болгох гэсэн агуулга байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудтай хамтран ажиллах гэж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж УИХ-д нэн яаралтай өргөн мэдүүлэх, компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга, хүртээмжтэй болгох зорилгоор Эрдэнэс таван толгой ХК-д иргэдэд эзэмшүүлсэн хувьцааг эргэлтэд оруулах, хөрөнгийн биржид бүртгэлтэй, нээлттэй ХК болох хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн

холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх гэж.

Энэ бүхэн маань олон нийтэд нээлттэй, энэ нүүрсний хулгайтай чинь тэмцье гэсэн агуулга болохоос биш энэ тогтоолыг эсэргүүцнэ гэдэг чинь өөрөө олон нийтэд, тэр гүйцэтгэх захирал энэ тэр чинь олон нийтэд хяналтгүй хөрөнгийн биржид бүртгэлтэй болчих юм бол энэ чинь бүх олон нийтэд бүх мэдээлэл нь ил тод болдог, маш том дэвшил гардаг ийм учиртай шүү дээ, дэлхийд. Тийм учраас энэ юмнуудаа сайн үзэх хэрэгтэй юм байна.

Дараагийн асуудалд оръё.
Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Ганбаатар гишүүн ээ, жаахан байж бай. Би сая энэ хагас сайнаас энэ 3 дахь өдрийн хооронд Ховд аймагт тойрогтоо ажиллаад ирлээ. Тэгэхээр 4 сумаар орж дээрээс нь багийн иргэдтэй уулзаад явлаа. Тэгэхээр энд ярьж байгаа гол зүйл бол баруун аймгууд бол энэ цас зуд ихтэй байна аа, өвөлжилт хүндрэх нь ээ, ялангуяа хавар үзүүр дээрээ нэлээн тийм хүнд нөхцөл байдал руу орох нь гэдэг ийм нөхцөл байдал ярьж байна. Тийм учраас малчдын ихэнх нь бол энэ өвс, ялангуяа тэжээл Оросын холбооны улсаас орж ирж байгаа тэжээлийг гаалийн болон НӨАТ-ын татвараас нь чөлөөлөх талаар бас нэг арга хэмжээ аваач ээ гэдэг ийм зүйлийг захиж байна. Энэ дээр Болорчулуун сайд бас тодорхой арга хэмжээ аваарай гэж ЗГ луу санал оруулж шийдээрэй гэж хүсэх байна.

Чандмань сумын Сүлжээ багийн Намсрайн Цэнджав гэдэг хүн энэ Хөшөөтийн уурхай бид нарыг хөлдөж үхүүлэх дөхөж байна гэдэг ийм зүйлийг ярьж байна. Энэ Хөшөөтийн уурхай энэ иргэдийн өвөлжилтөд нүүрс өгдөггүй, нэг хөдөө малчдад нүүрс өгдөггүй, үүнээсээ болоод хүйтэн нойтон хонодог ийм өвчний үүр болсон ийм нөхцөл байдал руу орж байна аа. Энэ дээр тодорхой

арга хэмжээ авч өгөөч ээ гэж ярьж байна. Тэгэхээр Хөшөөтийн уурхай бол энэ жилийн гүйцэтгэлээр бол 2200000 тонн нүүрс гаргаж байна. Гэтэл аймгийн төсөв энэ тэрд нь хэдхэн төгрөг оруулдаг, тэгээд түүнийгээ маш их юм гэж боддог. Гэтэл 12000000 тонн, өөрөөр хэлбэл энэ Хөшөөтийн уурхайгаас тав дахин 5 дахин илүү нүүрс гаргаж байгаа Эрдэнэс таван толгой энэ Монголыг бүгдийг нь тэжээгээд явж байна. Дээрээс нь бас хулгайчдыг бүгдийг нь тэжээгээд явж байна шүү дээ.

Тэгээд энэ Хөшөөтийн уурхай энэ Хонг Конгын лист компани гэдэг нэрийн дор маш замбараагүй үйл ажиллагаа явуулдаг, бараа бүтээгдэхүүнийг дандаа 3, 4 дахин нугалсан өндөр үнээр тайлан гаргадаг, шахдаг. Тэгээд тэндээсээ их хэмжээний ашиг олдог, татварынхаа орлогыг нуун дарагдуулдаг, Эрдэнэс таван толгой Монголыг тэжээгээд байхад чинь түүнээс тав дахин бага нүүрс гаргасан Хөшөөт, тэгээд ерөөсөө энэ Ховдын тэр аймгийг л ерөөсөө нэг хэдхэн төгрөг өгчхөөд л, түүн дээрээ хэдэн дарга нарыг зодолдуулчихаад ингээд л байж байна шүү дээ. Тэгээд иргэдийн эрх ашгийг маш их хохироодог. Тэндээс нэг өөр юм нэг их юм шаардаад байхгүй байгаа шүү дээ. Өвлийн нүүрсээ нэг жоохон ахиухан өгчхөөч ээ л гэж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ ЗГ тэр БНМАУ-ынхаа нэг тогтоолын дагуу, хуулийн дагуу БЭТ томилоод байдаг юм байна лээ, БЭТ тавиад өгөөч, та нар. Тэр доторх янз янзын тэр хулгай дээрмийг нь зохицуулаад өгөөч, татварыг нь зөв шалгаад өгөөч, тэгэхгүй бол энэ арай хэтэрч байна шүү дээ. Тэгээд одоо ингээд нэг зүгээр байгаад байх дээр энэ, өө ингээд тэр нэг Ховдын нэг хэдэн нөхдийг л нааш цааш болгочхоод л ажлаа хийгээд байна гэж бодоод байгаа бол эндүүрэл шүү гэдгийг Хөшөөтийн уурхайн нөхдөд хэлье.

Тийм учраас тэр иргэдийн, тэр өвчний үүр болж байна шүү дээ, хөхөө өвлийн хүйтэнд ямар ч нүүрс байхгүй, ийм нөхцөл байдалд байна. Дөргөн сумын ... /минут дуусав/

Г.Занданшатар: Дараа нь Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлнэ.

Б.Баттөмөр: Нүүрсний хулгай тойрсон асуудал энэ Монголчуудын дунд халуун сэдэв болж байна. Өчигдөр сонсгол болсон, янз янзын л юм болж байна лээ дээ, тэнд харахад. Ер нь Их Хурлын гишүүд өчигдөр үг хэлээ үг, үг саналаа хэлэх үг асуух ийм боломж бол олдоогүй. Ийм учраас УИХ-ын зүгээс энэ Их Хурлын гишүүд энэ болж байгаа юмнаас мэдээлэл олж авах, энэ хууль хяналтын байгууллагуудаас мэдээлэл авах, төрийн эрх барих дээд байгууллагын хувьд бол энэ эрхээ хэрэгжүүлж, энэ ажлыг анхааралдаа авах шаардлагатай гэдгийг би 1 дүгээрт хэлэх гэж байгаа юм.

Энэ таван толгойн орд маань 6 тэрбум тонн нүүрсний нөөцтэй. Үүнээс 1.4 нь коксжих нүүрс, 4.6 нь эрчим хүчний нүүрс гэж байгаа. Үүнийг зөв ашиглах юм бол Монголчуудыг 100 жил тэжээнэ, буруу ашиглах юм бол 10 жилийн дараа дуусна, буруу ашиглаж явж байна, өнөөдөр. Мэргэжлийн бус хүмүүс нь удирдлагад нь ажиллаад мэргэжлийн хүмүүс байхгүй, буруу ашиглаад ингээд явж байгаа. Энэ маш их хэмжээний асуудал байна даа, энд. Эргэн тойрных нь бол дандаа гаднынхан лиценз тойруулаад авчихсан, уг нь 6 тэрбум биш, энэ 10 тэрбумын нөөцтэй орд шүү дээ, ийм байдалтай л байна л даа. Тэгээд баахан хүмүүсийн гараар дамжаад төрд ирсэн, үүнийг хулгай яагаад нүүрлэсэн бэ гээд ингээд үзэхээр мэргэжлийн хүмүүс хэлэхдээ энэ том ордыг ашиглах оновчтой бодлогогүй, олон хуваасантай холбоотой гэж ингэж үздэг юм байна лээ. Маш их олон асуудал хулгай нүүрлэчихсэн байгаа. Энд ингээд энэ 10 оноос хойш 86000000 тонн нүүрсээ

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

экспортолж 12.8 их наяд төгрөг олсон. Үүнээсээ 7.5 их наяд төгрөгөөр худалдан авалт хийчихсэн байгаа байхгүй юу. 576 удаагийн худалдан авалтаар 7.5 их наяд энэ бол АТГ-ын сайтад байж байгаа мэдээлэл шүү. Үүнийг ингээд аваад үзэх юм бол дотно талд нь энэ маш их хэмжээний, тийм хууль бус гэж хэлэхээр их сонирхол татахаар ийм худалдан авалтууд байгаа байхгүй юу. Даатгалын компаниуд аваачаад 100, 100 тэрбумаараа өгчихсөн. Тэгээд дээрээс нь тэр зөвлөх үйлчилгээ гээд л хэдэн арван тэрбумаар нь гэх мэт ийм.

Энэ өнгөрсөн 5 жилд нүүрс худалдах 633 гэрээ байгуулагдсан байгаа. Тэгээд цаашаагаа ингээд өнөөдөр үзэхээр зэрэг үүнээс урьдчилж авсан 603000000 доллароосоо өнөөдөр 405000000 долларыг нь төлж чадаагүй байгаа, 1.4 их наяд төгрөг. Бусад өртэй ингээр 2.2 их наяд төгрөгийн өр үүссэн байгаа. Уулын ажлыг хөнгөлөлттэй үнээр нүүрсээр хийснээс бол 34 их наяд тэрбум төгрөгийн боломжийг алдчихсан байгаа. Уулын ажил гүйцэтгэх компаниудад 716000000000 төгрөгийн өглөгтэй байна. Оффтек яриаг тойрсон асуудлууд байгаа.

2400 автомашин 3400 тонн нүүрсний хулгайн асуудал байгаа. Эрдэнэс таван толгойн өөрийнх нь санхүүжүүлж байгаа энэ 6 төслийн 3.1 их наяд төгрөгийн өр байна, Чалко-ийн өр байна. Нүүрс борлуулах 178 гэрээ гэх мэтийн ингээд маш их олон асуудлууд шалгах асуудлууд энд хуримтлагдсан байж байгаа юм аа.

Тэгээд би өнөөдөр энд юу гэж хэлэх гэж байна гэхээр зэрэг хүчний байгууллага мэдээж үүнийг шалгаж байгаа. Хүчний байгууллагын маань хүчин чадал, боломж ер нь юу байгаа юм бол доо. Энэ дээр ЗГ, яамд, тэгээд мэргэжлийн байгууллагууд, маш сайн эдийн засагч нар, санхүүгийн мэргэжилтнүүдийг оролцуулж, үүнийг богино хугацаанд дуусгах ёстой, дандаа

хулгай яриад ингээд суугаад байх ёсгүй. Энэ том ордыг цаашаа яаж ашиглах юм, яаж Монголын ард түмэнд өгөөжтэй болох юм, үүнийг бид нар яримаар байна. Бидний хэсэг гишүүд энэ 16.4 хувь ард түмэн эзэмшиж байгаа, үүнийг 34 хувь болгох ийм хуулийн төслийг өнөөдөр УИХ-д ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг УИХ-ын гишүүн, Түр хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж орох тусган, төслийн агуулга, зарчмын алдагдалгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн

техникийн шинжтэй засваруудыг хийсэн төслийн эцсийн хувилбарыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Уул уурхайн бүтээгдэхүүний биржсийн тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Отгоншаравын Батнайрамдал, СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Баттулгын Дөлгөөн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, МХБ компанийн захирал Хангайн Галтай, Хөрөнгийн бирж компанийн Бизнес хөгжил газрын захирал Тамирын Хааш-Эрдэнэ, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх Алтанбулагийн Нинжсин, СЗХ-ны Хуулийн хэлтсийн ахлах референт Жаргалсайханы Мөнх-Оргил, Монголын экспортлогчдын холбооны ерөнхийлөгч Дамбын Галсандорж.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүн байна уу. Эцсийн хэлэлцүүлэг шүү дээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тусаллаа.

Жамъянгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

Ж.Мөнхбат: Би нэг 2 юм асуух гэсэн юм. Энэ уул уурхайн биржсийн

тухай, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр худалдаалах энэ асуудлыг дэмжиж байгаа юм аа. Тэгээд энэ түр журам гаргаж байгаа, тэгээд энэ ямар хугацаанд үйлчлэх вэ, тэгээд түр журмыг дагасан гээд бас нэг баахан булхай будилаан гараад ирэх бий дээ. Тийм учраас нөгөө хуулиа маш яаралтай хэрэгжүүлээд, энэ хуулиараа биржсийн хуулиа хэрэгжиж эхлэх энэ хугацааг нь процессыг нь яаралтай явуулах ийм шаардлага байна. 2017 онд энэ Эрдэнэбатын ЗГ-ын үед 1 жил орчим хугацаанд энэ өнөөдрийн бид нарын энэ яриад байгаа энэ биржсийн тухай хууль гэдэг юмыг чинь үндсэндээ хийж байсан. Өөрөөр хэлэх юм бол тухайн үед ямар ч эмх замбараагүй зарагддаг байсан энэ нүүрсний борлуулалтыг цэгцлэх зорилгоор битүүмжлэгдсэн үнийг нь дугтуйнд хийж аваад дуудлага худалдаагаар зардаг байсан. Нүүрс худалдан авах зорилготой иргэн, ААН, бүх хүмүүс үнээ дугтуйнд хийгээд дуудлага худалдаа маягаар өгдөг, хамгийн өндөр үнэ өгсөн санал болгосон компанид нь гэрээ хийх эрх өгдөг, нийт худалдан авах нүүрснийхээ 30, 40 хувийг нь Эрдэнэс таван толгойн дансанд 7 хоногийн дотор байршуулах юм бол гэрээ хийх эрх нь нээгддэг, байршуулж чадахгүй бол дараагийн үнэ санал болгосон компани руу шилждэг ийм л зарчимтай, шударга зарчимтай явж ирсэн.

Тэгээд энэ бол энэ нүүрсний хулгай гэж яриад байдаг, энэ олон янзын үнэ гарч ирээд байдаг, дундаас нь мөнгө төгрөг зувчуулдаг гэж яриад байдаг юмыг байхгүй болгодог юм байна лээ. Тэр биржсийн гэх юм уу, зарчмаар ингэж дуудлага худалдаагаар ингэж хийх юм бол хамгийн өндөр үнэ хэлсэн компани л тухайн үедээ хэд нь ямар үнэ хэлнэ, тэрийгээ л түүгээрээ л нүүрс худалдаж авна, ганцхан хүнтэй болж байгаа юм. Одоо өнөөдрийнх шиг амны үнэ, хилийн үнэ, оффтек гэрээний үнэ, Бодийн үнэ, Чалко-ийн үнэ ч гэдэг юм уу, ийм олон янзын үнэ байхгүй, хүмүүсийн толгой

эргүүлээд хулгай хийх олон олон боломж гаргаад байхгүй болдог. Тийм учраас бол энэ биржийн хуулиа нэн яаралтай, маш хурдан, дагаж мөрдөж энэ түр журам гэдэг хугацааны чинь үед янз янзын юм болох вий гэдэг зүгээр болгоомжлол байгаа.

Тэгээд 18 оноос хойш сураг сонсох нь ээ, юу болсон бэ гэсэн энэ дуудлага худалдаа битүүмжлэгдсэн, үнэ гэдэг юм байхгүй болсон сурагтай байсан. Тэгээд тэрнээс хойш ганцхан амны үнэ гэдэг үнээр зардаг байсан юм одоо 5 янзын үнэтэй болсон, аман дээрээс уурхайн аман дээрээс ганцхан хил гартал ганцхан уртын тээвэртэй байдаг байсан, одоо уртын тээвэр, богинын тээвэр, бөмбөлөг тээвэр гэнэ үү, баахан дундуур нь янз янзын авлига авах, хулгай хийх, ийм боломжууд бүрдсэн нөхцөл байдал бүрдсэн гэж байгаа юм. Тэгэхээр би бол энэ асуудлыг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт, ЗГ-ын гишүүн хэн байна аа. Энэ Уул уурхайн сайд байна, Ганбаатар сайдаас асууя. Үгүй ээ, энэ Чалко-ийн гэрээ чинь дуусаагүй юм уу? Намайг ЗГХЭГ-ын сайд байхад Чалко-ийн гэрээг 17 оны 4 сард дуусаж байсан, 5 жилийн хугацаанд. 350000000 долларыг нь Эрдэнэбатын ЗГ-ын үед дараад дуусгаж байсан. Тэгээд Ти ти ширакогийн хөрс хуулалтыг зогсоогоод Чалко-ийн ийм хөнгөлөлттэй 17 хувийн хөнгөлөлттэй үнээр өгөхгүй ээ гэсэн чинь Монгол Улсын ЗГ-ыг Арбитрын шүүхэд өгнө гэдэг асуудал гарч ирээд тэр гэрээн дээр 5 жил авна, дахиад 5 жил авна, тэр нь 22 оны 4 сард дуусна гэдэг ийм л юм байсан санагдаад байх юм. Гэтэл одоо сошиалаар явж байгаа мэдээгээр дахиад 5 жилээр сунгаад 27 оны 4 сар хүртэл дахиад 17 хувийн хөнгөлөлттэйгөөр өгч байгаа гэсэн гэрээгээ суучихсан гэдэг ийм юм яригдаад байх юм, энэ чинь арай дэндэж байгаа юм биш үү?

Тэгээд энэ Чалко-ийн асуудлыг энэ хэрвээ нууцын зэрэглэлд байдаг бол гаргаж тавиач ээ, энэ чинь 11, 12 оны

үеийн гэрээ. Юу гэж 15 жил, 17 хувийн хөнгөлөлттэй өгдөг ийм гэрээ гэж ер нь дэлхийд хаана байх юм бэ? Аль хэдийн 17 оны 4 сард ... /минут дуусав/

Г.Занданшатар: Уул уурхайн үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар хариулъя.

Ж.Ганбаатар: Мөнхбат гишүүн чухал чухал санал хэллээ. Мөнхбат гишүүний тэр ажиллаж байсан ЗГ-ын үед тэр уурхай дээр хийж байсан зүйлүүдийг бид нар яг хил нөхцөлөөр хийж байгаа юм. Тэгэхээр түр журмаар юу хийх гэж байгаа вэ гэхээр зөвхөн нүүрсээ тестэлж үзнэ. Хууль батлагдаад шууд хэрэгжих боломжгүй байгаа нь маш олон ажлуудыг хууль хэрвээ батлагдсаны дараа бол хийх ёстой. Томоохон 11 журам батална. Тэрнээс гадна бүхэл бүтэн бирж байгуулна. Эс үгүй бол уул уурхайн биржийг тусад нь байгуулна, эсвэл хөрөнгийн биржийн доор байгуулаад явна. Энд мэдээж шууд нэг амьсгаагаар хийчих боломж байхгүй. Тэгэхээр хөрөнгө мөнгө ч гэсэн хэрвээ уул уурхайн бирж байгуулбал томоохон хөрөнгө мөнгө шаардагдах ийм зүйл байгаа.

Нүүрсийг хил нөхцөлөөр зарахаар бэрхшээлүүд бол байгаа. Санаатай санамсаргүй бүр саад болгох ч зүйлүүд бол анзаарагдаж байгаа. Тийм учраас түр журмаар бол бид нар Эрдэнэс таван толгойн нүүрсний 30 хувийг 7 сарын 01 гэхэд ядаж зардаг болгох тэр төстийг хийх ёстой гэж зорилт тавьж байгаа юм. 2 сарын 15 гэхэд бид нар эхний ээлжид ядаж 10 хувиа, 15 хувиа, 20 хувиа Эрдэнэс таван толгой болоод бусад санал гаргасан компаниудын нүүрсийг биржээр зарна. Үүнийг бол зайлшгүй хийх ёстой, хил нөхцөлөөр. Хил нөхцөлөөр гэдэг дээр мэдээж нүүрсний тээвэрлэлт гэдэг юм уу янз янзын байдлаар саад тотгор болох гэж байгаа олон зүйлүүд байгаа, тэгэхдээ даван туулах ёстой.

Тэр үнийн хувьд бол доод үнийг Эрдэнэс таван толгой компани өөрсдөө зарлана. Тэр Чалко-ийн гэрээ сунгасан асуудал үнэн, та зөв мэдээлэлтэй байна. Ийм асуудлууд байсан учраас ЗГ бүрэн эрхт төлөөлөгч томилсон байгаа. Ийм олон зүйлүүдийг засах гэж ЗГ Бүрэн эрхт төлөөлөгч томилсон. Бүрэн эрхт төлөөлөгч ийм завхарчихсан зүйлүүд байгаа учраас, ийм шаардлагууд байгаа учраас энэ алхмыг ЗГ хийсэн гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Уул уурхайн биржийн хууль цаг үеэ олж орж ирж байгаа. Яах вэ, энэ дээр бас энэ олон түмэнд зөв мэдээлэл өгөх үүднээс энэ бол зөвхөн худалдааны л платформ талдаа ажиллаж байгаа биз дээ? Энэ нөгөө 1072 хувьцаа маань яг ямар түвшинд байдаг юм бэ? Би үүнийг бол Байнгын хорооны хуралдаан дээр энэ Хөрөнгийн биржийн захирлаас асууж байсан. Тэгээд УИХ-ын чуулган дээр бас дахиад энэ олон түмэнд мэдээлэл өгөх үүднээс зориуд асууж байгаа юм. Монголын бүх ард түмэн 1072 хувьцаатай гэж яригдаад байдаг боловч хууль номынхоо дагуу бол энэ Хөрөнгийн биржид зүгээр бүртгэлтэй л байгаа болохоос ямар ч хувьцаа биш байгаад байгаа юм. Тэгээд энэ ер нь яаж амь орох юм, үүнийг амь оруулахад ямар хэрэгтэй юм, яах вэ, бид нар яг одоо бол ярьж байгаа нь уул уурхайн бараа бүтээгдэхүүнүүдээ хулгайгүй, яг бодит үнээр нь заръя гэдэг чиглэлээр хууль гаргах гээд ярьж байна. Орж ирсэн орлого нь хэрхэн хянагдаж, олон нийтэд хяналттай нээлттэй байж болох юм бэ гэдгийг энэ бас хувьцаанууд эзэмшихээр л гарах ёстой л доо. Тэгээд 2 асуулт байгаагийн нэгдүгээрх нь саяынх, энэ 72 хувьцаа яаж ямар ажил хийгдвэл амь орох юм бэ? Эрдэнэс таван толгой компанийн хувьцаа яагаад олон нийтийн хяналтад орж хяналттай болохгүй байгаа юм бэ? Юу хийгдэх ёстой юм бэ?

Үүнийг Хөрөнгийн биржийн захирал хариулмаар байна.

2 дугаарт, энэ стратегийн ордуудын 10 хүртэлх хувийг Хөрөнгийн бирж дээр олон нийтийнх болгох тухай хууль ерөөсөө хэрэгжихгүй явж байгаа. Үүний үр дүнгээ бид нар амсаад явж байгаа, яг одоо. Үүнийг хэрэгжүүлэх чиглэлд ямар ажлууд хийгдэх вэ? УУЯ-аас. Энэ 2 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн, ажлын хэсэг хариулах ёстой.

Ц.Цэрэнпунцаг: Дамдинням гишүүний асуусан 2 асуултын эхнийхэд нь хариулъя. Тэгээд дараа нь гүйцээгээд Хөрөнгийн биржийн захирал Алтай захирал хариулаарай.

Хамгийн гол нь энэ саяын таны асууж байгаа энэ 1072 хувьцаа бол өнөөдөр нэг ийм үхмэл байгаа, ард түмэн бол хувьцаа эзэмшигч нэртэй, тэгээд эзэд нь эзэн нь та шүү гээд өгчихдөг, тэгээд нөгөөдөх эзэн нь хөрөнгөндөө хүрээд зарцуулах ч юм уу, тэрнийхээ ашгийг нь авах, ялангуяа тэр хөрөнгө оруулагчдынхаа хөрөнгө оруулагч эзнийхээ хувиар компанийнхаа тэр хөрөнгө оруулагчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож чадахгүй, ийм байдалтай юм ингээд арваад жил явчихсан. Үүнийг бид нар засаж залруулъя, 1-д.

2-т, яг өнөөдрийн үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор бол энэ улсын төрийн өмчтэй энэ компаниудаар чинь тэр хулгай зэргээ гэдэг юм нь явлаа шүү дээ. Энд ард түмэн хяналт алга байна гээд. Энэ төр бол хяналт тавьж чадахгүй байна. Тийм учраас энэ эзэд нь өөрсдөө тэр хянах боломжийг нь энэ хувьцаа эзэмшигчид нь энэ жинхэнэ энэ хувьцаагаа эзэмших тэр эрхийг нь нээж өгөх юм бол энэ хувьцаа эзэмшиж байгаа эзэд нь очоод хяначих учраас бол энэ том хяналтын ажлыг бас давхар хэрэгжүүлэх

ийм боломж бүрдэх юм гэдэг үүднээс энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хууль гарч байгаатай холбогдуулаад Байнгын хороон дээрээ санаачилга гаргаад, ажлын хэсэг санаачилга гаргаад Их Хурлын тогтоолын төсөл тэр ажиглана, гаргая гэж. Үүнийг бол бид нар дараагийн 7 хоногт Байнгын хороон дээр авч хэлэлцэх юм аа.

Тэгээд Ганбаатар гишүүн С.Ганбаатар гишүүн та Байнгын хороон дээр орж ирээд энэ асуудлыг бид нар хэлэлцээгүй, хойшлуулсан. Энэ дээр бол энэ асуудлыг бүрэн ойлголт муутай ингээд яриад байх юм. Энэ ард түмэн чинь өмчийг нь өгье өө, өмчийн эзэмшдэг эрхийг нь нээж өгье өө л гэж байгаа юм байхгүй юу. Тэгээд үүнийг эсэргүүцээд байгааг нь ерөөсөө ойлгохгүй юм. Тэгээд энэ ард түмэнд өмчийг нь 1072 хувьцааг нь өмчлүүлэхгүй гээд байгаа юм уу? Эзэмшүүлэх, эзэмших тэр эзэн нь юм бол эзэмшээд, тэр хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд ороод саналаа гаргаад ингээд явах бололцоог нь олгохгүй гээд байгаа юм уу? Тэгээд ерөөсөө ойлгохгүй юм. Ганбаатар гишүүн та үүнийгээ дараагийн тэр Байнгын хороон дээр дахиж орж ирээд бид нар хэлэлцэхэд нухацтай яриарай. Өнөөдөр бол энэ чуулганаар хэлэлцэх гэж байгаа юм байхгүй шүү, хуваарьт байхгүй, та түүнийгээ бас сайн хараарай.

Дараагийн 7 хоногт Байнгын хороон дээр та дахиж орж ирээд энийгээ сайхан хэлэлцэхэд идэвхтэй сайхан оролцоорой. Байнгын хорооны хурал дээр эхлээд л баахан пижигнүүлж пижигнүүлээд тэгээд дундаас нь гаргаад явчихсан, тэгээд сүүлд нь Байнгын хорооны тэр асуудал дээр яаж шийдсэнийгээ мэдэхгүй, ингээд жоохон буруу зөрүү мэдээлэл өгөөд байна. Ийм байгаа юм. Ингээд Алтай захирал гүйцээж хариулаарай.

Г.Занданшатар: Алтай захирал тэр бүртгэл, ер нь бүртгэгдээгүй шахуу юм биш үү. Тэр бүртгэлд бүртгэгдсэн

мөртөө амилаагүй байна гээд байна шүү дээ. Тэр асуудал дээр энэ Ганбаатар гишүүний асуудал ч гэсэн холбогдож байгаа. 1072 хувьцаагаа бүртгэлд оруулах л асуудал ярьж байгаа шүү дээ, тийм ээ, түүнийгээ нэг тодорхой хариулчихмаар байна.

88.

Х.Алтай: Дамдинням гишүүний асуултад хариулъя. 1072 хувьцааны бүртгэл бол Хөрөнгийн бирж дээр бол хийгдээгүй. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр хийгээд иргэдэд данс нээгээд 2012 оны 3 сарын 1-ээс өмнө төрсөн бүх иргэдэд бол данс нээгээд 1072 хувьцаа бол өгсөн байгаа. Гэхдээ Хөрөнгийн биржийн бүртгэл хийгдээгүй, Хөрөнгийн бирж дээр арилжаалах боломжгүй. Арилжих нөхцөл бүрдүүлэхийн тулд бид бол ЗГ-ын холбогдох шийдвэр гараад 1072 хувьцааг эдийн засгийн эргэлтэд биржээр оруулж болно.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж, ажлын хэсэг.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Дамдинням гишүүний асуултад бас хариулаадахъя. Дамдинням гишүүний асуултад хариулаадахъя, тодруулаадахъя. Энэ хууль батлагдаж байгаатай холбоотойгоор ер нь яах вэ, гишүүд бол ойлгож байгаа шүү дээ, цаг үеэ олсон хууль болж байгаа юм. Ер нь бол ажлын хэсэг энэ зунжингаа ажиллаад бэлэн болгочихсон. Яах вэ, ЗГ дээр журам боловсруулаад цаашаагаа ажиллая гэсэн. Үүнтэй нь холбогдуулаад бид нар нэг жоохон барьж байсан, тэгээд яаралтай ингээд оруулаад баталж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр дагалдсан хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай гээд ингээд УИХ-ын тогтоол удахгүй орж ирнэ. Энэ тогтоол дээр болохоор компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, олон нийтийн

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хяналт оролцоог нэмэгдүүлэх, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга хүртээх зорилгоор Эрдэнэс таван толгой ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцааг энэ нь 1072 хувьцаа юм үү, эргэлтэд оруулах гэж байгаа шүү, эргэлтэд оруулах одоо сая Алтай захирал хэллээ шүү дээ, бүртгэлтэй байгаа болохоос биш эргэлтэд ороогүй байгаад байгаа юм аа. Тэгэхээр ард иргэдэд нэгэнт хүртээсэн энэ баялгаас хүртээж байгаа энэ цаасан дээр юм уу, бүртгэл дээр байх биш эргэлтэд ороод, жишээ нь биржээр оролцох, энэ боломж бололцоог нээж байгаа ийм тогтоол орж ирэх ёстой юм шүү.

Тэгээд үүний цаана энэ ЗГ-т УИХ-аас Монгол Улсын ЗГ Л.Оюун-Эрдэнэд даалгасугай гэсэн ийм тогтоол бол гарч байгаа юм шүү. Тэгэхээр энэ ЗГ-аас тодорхой шийдвэр нь гараад эргэлтэд ороод явах юм байгаа юм шүү.

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүнд тодруулж асууя.

Г.Дамдинням: 1072 гэж яриад, тэгээд яг бодит байдал дээр худлаа л яваад байгаа юм л даа. Тэгээд энэ Их Хурлын тогтоол Эдийн засгийн байнгын хороогоор ороод УИХ-аар орж ирээд батлагдаад гарах юм бол 1072 хувьцаанд яг энгийн одоо Хөрөнгийн бирж дээр байдаг хувьцаа шиг ард иргэд шууд аваад мэдээллээ аваад хяналтаа тавиад явах бүх эрх зүйн орчин бүрдэнэ гэж ойлгож байгаа, зөв үү. Ингэж ойлгож болох уу. Өөр ямар нэг юм бас болсонгүй гээд дараа нь яригдаад л ингээд худлаа яриад яваад байх юм гарахгүй биз дээ, бид нарт бол тийм ээ.

Г.Занданшатар: Энэ хэлэлцэх эсэх болон эхний хэлэлцүүлгийн үед ярьсан юм. Энэ Алтай захирал бүртгэгдээгүй байгаа, бүртгүүлэх ажил хийх хэрэгтэй. Дээр нь тэгээд 2 дахь зах зээлд гаргах асуудлыг бас Ганбаатар гишүүн ойлгоод байж магадгүй. 2 дахь

зээл гарах юм бол мөнгөтэй хүмүүс цуглуулаад авчих учраас түүнийг хааж хориглох ёстой. 2 дахь зах зээлийн талаар бол ерөөсөө яригдахгүй байгаа юм, дахин худалдаалах. Харин 5 хувиас нийт хувьцааныхаа юу. Тэр тэгээд ярьж байгаа бол яг бодитой асуудал болохоор нь ярья. Тэгээд энэ бол тийм нэгдсэн ойлголттой байх нь зүйтэй. Хамгийн гол нь нөгөө 1072 хувьцаагаа иргэд бүртгүүлээд жинхэнэ хувьцаа эзэмшигч нь болох ёстой байгаа байхгүй юу. Хувь эзэмшигч нь, хувь эзэмшигч нь болохоороо тэр хүмүүс чинь тайлан тэнцэл, тооцоо мэдээллээ авна, аудит оруулна, ТУЗ-д хүнээ томилно, ТУЗ нь тэр гүйцэтгэх захирлаа сонгон шалгаруулалтад оролцоно, энэ бүх эрх нь нээгдэх юм байна лээ, нөгөө паблик компани болох. Тэр ажлыг нь хий гэж байгаа юм.

Ингээд Норовын Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Энэ 1072 дээр хэдүүлээ нэг ойлголт зөв болохгүй бол энэ 1072 чинь ингээд Бат-Эрдэнэ гишүүн та нарын яриаг сонсоод байхаар Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй болгоно, тэгээд арай 1072 чинь арилжаанд ороод явчих юм биш биз дээ? Бид нарын мөнхийн проблем энэ л байдаг шүү дээ. Одоо тэр ягаан тасалбар, цэнхэр тасалбар гэдгээ нэг юм өгсөн. Дараа нь түүнийгээ арилжаалдаг болгочихсон чинь цөөхөн хүмүүс хураагаад авчихсан. Би одоо энэ дээр их болгоомжилж байгаа шүү, үүнийгээ та нар маань зөв хийгээрэй. Сая Ганбаатар даргын хэлж байгаагаар бол 1072-ынхоо 5-10 хувийг арилжаална ч гэнэ үү. Ер нь арилжаална л гээд байх юм. Та нар тэр 1072-оос бусдыг нь тодорхой хэсгийг нь арилжаанд оруулах хэрэгтэй, ингэхгүй бол хүнд нэг юм өгдөг, дараа нь тэр хүнд нь цаас үлддэг, одоо ард түмний ахуй амьжиргаа ийм ядуу байгаа юм чинь зүүгээр л хямдхан зараад дуу саа. Тэгэхээр энэ дээр анхаарал тавиарай гэж хэлье, нэг.

2 дугаарт, энэ нүүрсний хулгай ярьж байгаа үед байна шүү дээ, манай Эдийн засгийн байнгын хороо ч юм уу, ингээд нэг ажлын хэсэг гаргаад манай иргэдэд очих ёстой хувь мөнгийг гаргамаар байх юм, баахан хулгай дээрэм хийгээд өчнөөн нүүрс идчихлээ шүү дээ. Тэгэхээр тэр 1072 хувьцаанд чинь энэ өнгөрсөн жилүүдэд заавал мөнгө очих ёстой байхгүй юу. Түүнийг нэг тооцоолж гаргамаар байх юм. Гаргахаар барахгүй өгмөөр байх юм, ноогдол ашгаа манай иргэд авдаг болмоор байх юм, тэнд байгаа нэг компанийн захирал юм уу, хэдэн нөхөд нийлж байгаад ийм юм хөрөнгө оруулалтад зарцуулна гээд ингэчихдэггүй баймаар байх юм.

Би тэр Чалко дээр Ганбаатар сайд та жаахан дахиад нэг жаахан яриадхаарай, энэ ийм учиртай байна шүү дээ. Чалько-ийн гэрээ 11 онд хийгдсэн юм, гол зорилго нь тэр үед бид нар чинь нэг 1.5 сая төгрөг хүмүүст өгнө, 21000 төгрөг өгнө гэж ингээд зарлачихсан. Тэгээд түүнийгээ өгөх гэсэн чинь мөнгө байдаггүй, тэгээд та нар улс төржихгүйгээр сонсоодох, 1 дүгээрт, нь бол Чалько гэдэг нөхөдтэй хамгийн анхны оффтек гэрээ гэдэг юм хийсэн байдаг. Тэрэндээ 350000000 доллар авна аа, урьдчилаад авч байгаа юм. 350000000 доллартоо тохирсон ийм нүүрсийг гаргана, тэр нүүрсийг нь бол 7 жил гаргаж байж төлсөн юм шүү дээ. Дээр нь хүүтэй, тэгээд 60 сая доллар байх 410000000 долларт тохирсон нүүрсийг 7 жил гаргасан юм. Одоо тэгээд түүнийгээ анхаараадах. Одоо тэр гэрээн дээр нь дахиад үргэлжлүүлнэ гэж байна гээд байгаа юм, би тэрийг нь бол гэрээгээ хараагүй учраас мэдэхгүй. Одоо тэр гэрээ чинь цаашаа ахиад 7 нэмэх нь 4, нэмэх нь 4. 15 жил үргэлжлэх гэрээ анхнаасаа хийчихсэн юм шиг л байна лээ. Одоо тэр нэг мэдэхгүй юм чинь яах вэ, та нэг анхаараарай, та бол жаахан өөр юм хэлээд байна шүү дээ. Оюутолгой энэ Таван толгойн удирдлага ингээд хийчихсэн юм шиг, би түүнийг үргэлжлээд байна уу гэж хараад байгаа

юм. Үүнийг нэг учрыг нь олоодох оо гэж хэлье.

Энэ хууль гараад явах нь зөв. Би нэг 2 юмыг асуучихмаар байх юм. Нүүрс дээр та нар үүнийг хэзээ, яаж хийх гэж байгаа юм? Нүүрс маань яаж шударга зарагддаг болох гэж байгаа юм?

2 дугаарт нь, би Галсандорж гуай чинь энэ Лондонд бас нэлээн олон жил ажилласан, би сая асууж байсан. Одоо энэ зэсийн хулгайч нарыг яаж зогсоох гэж байгаа юм? энэ чинь зэсийн 560000 тонн зэсийн баяжмалыг квотлоод л квот тус бүрээс нь нэг хэдэн доллар хусаад л энэ олон жил явсан шүү дээ. Энэ яаж алга болох юм бэ? үүнийг нэг тайлбарлаад өгөөч. Хэдэн оноос яаж, ямар арга механизмаар зарлагдахаар энэ хулгай дээрэм зогсох юм. Уг нь хулгай дээрэм зогсоох гэж байгаа хууль гаргаж байгааг бол би дэмжиж байна. Тэгэхдээ чөтгөр нь дандаа детальдаа байдаг учраас ийм ийм юмыг ингэж ингэж барууны ийм ийм юмнуудыг аваад ингэж хааж байгаа юм гэсэн ийм л юм хэлээд өгөөч ээ гэж. Баярлалаа.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн, сайд.

Ж.Ганбаатар: 1072 дээр болгоомжлолуудыг бүрэн ойлгож байгаа, ЗГ. Ганбаатар гишүүний зүгээр санааг бол маш сайн ойлгож байгаа, 1072 бол угаасаа ард иргэд зараад үрчих вий, уул нь ногдол ашиг авах ёстой. Гэтэл энэ юу гэдэг юм бэ дээ, хөрөнгө мөнгөтэй хүмүүс үүнийг нь аваад эс үгүй бол үүгээр дамжаад өөр хүмүүс рүү өөр улс руу ч гэдэг юм уу, бид нарын нөгөө нэг айлгадаг нэг улс байгаа шүү дээ, тэр улс руу ингээд яваад бүх хувьцаа минь тэнд болоод Эрдэнэс таван толгойн эзэн бараг тийшээ явчих вий гэдэг болгоомжлолыг бол хүн болгон ойлгож байгаа юм, мэдэж байгаа юм. Гэхдээ 1072-ыг Их Хурлын дарга ч хэлж байгаа, бид ч айж байгаа, бид зүгээр амь оруульа л гэж байгаа юм. 1072 гэдэг хувьцаатай

шүү гэдгийг энэ бас үр өгөөжөө өгдөг шүү, энэ нь энэ хувьцаа байгаа шүү гэдгийг тэрний төлөө ч гэсэн ЗГ эхний алхмуудаа хийгээд Эрдэнэс таван толгой компанийг тодорхой ашигтай ажиллуулахын үндсэн дээр энэ Бүрэн эрхт төлөөлөгч тавигдсан гэж үзэж байгаа, Алтанхуяг гишүүн ээ.

Зүгээр 1072 хувьцааг бүгдийг нь иргэд зүгээр нэг өнөөдрийнхөө юу эрх ашгийн төлөө зарчих, борлуулчих вий гэдгийг бүгд харж байгаа, анзаарч байгаа, болгоомжлол түүн дээр маш өндөр байгаа. Харин таны хэлдгээр зөвхөн 1072 маань өгөөжөө авах ёстой, зорилго нь энэ гэдгийг маш сайн ойлгож байгаа юм. Үүнийг ойлгохгүй байгаа хүмүүс бол байхгүй шүү дээ. Гэхдээ үүнийгээ бас ийм байдаг аа, хувьцаатай шүү гэдгийг нь хөрөнгийн бирж бүртгэж аваад амилуулаад тодорхой хувийг нь бас эргэлтэд оруулах тийм зорилтууд байж болох уу гэдгийг л энэ Их Хурлын тогтоолоор зүгээр чиглэл өгөөд энэ хөдөлгөөнд оруулах энэ процессыг нь л харж байгаа юм. Түүнээс биш 1072-ыг бүгдийг нь зараад туучихна гэсэн тийм ойлголт бол ЗГ бол тийм шийдвэр хэзээ ч гаргахгүй шүү дээ. Түүн дээр баталгаатай байж болно оо гэдгийг хэлье.

Чалько-ийн хувьд бол мэдээж үүрэг байгаа гэдгийг ойлгож байгаа. Мэдээж бид нарт гэрээ хийчихсэн, гэрээний үүрэг байгаа. Тэр хүмүүсээс янз янзын гэрээгээр биелүүлэх ёстой юмнууд бол байгаа байх. Тэгэхдээ би хэлэлцэх эсэх асуудал эхний асуудал биш учраас Бүрэн эрхт төлөөлөгчийг суулгасангүй. Нөгөө эцсийн хэлэлцүүлэг учраас энэ танин мэдэхүйн гэдэг юм уу одоо энэ анхны хэлэлцэх эсэх дээр асуугддаг асуултуудыг асууна гэж өнөөдөр бас тооцоогүй учраас, уул нь бол энэ асуудлуудад бол яг таны асууж байгаа асуудлууд бол Бүрэн эрхт төлөөлөгч хариулах ёстой Ганбат.

УУЯ бол ингээд бодлогыг нь гаргаад өгч байгаа. Түүнээс биш тэр гэрээг сунгах, сунгахгүй, асуудлыг бол та сайн мэдэж байгаа. Бид очоод л тэрийг сунга, үүнийг сунга, тэр болохгүй, энэ болохгүй гэсэн байдлаар бол УУЯ, бодлогын яам энэ асуудалд оролцох бол боломжгүй. Тэгэхдээ үүнийг бол Бүрэн эрхт төлөөлөгч сунгаагүй, өмнөх удирдлагууд нь сунгасан. Тэгээд бүр зөв, бурууг нь шийдэж байгаа байх. Шийдэл нь удахгүй гарах байх гэж бодож байна.

Нүүрсний хувьд бол яг бид 7 сарын 01 хүртэл энэ ЗГ-ын гаргасан журмаар нүүрсийг Эрдэнэс таван толгой компани, ялангуяа төрийнхөө нүүрсийг ядаж нэг 30 хүртэлх хувийн биржээр зараад тестлээд үзье гэж байгаа юм. Одоо ямар нэг нэг байдлаар бид нар бирж дээр бол үнэхээр амжилттай ажиллаж чадаж байгаа тийм түүх бид нарт байхгүй байна. Яагаад 30 хүртэлх хувь бэ гэхээр бирж маань амласан зүйлээ биелүүлдэг бирж байх ёстой гэдэг дээр болгоомжлол их өндөр байгаа учраас багаар эхэлнэ ээ гэдэг ийм зүйл бид нар төлөвлөөд 7 сарын 1-нд хууль хэрэгжих хүртэл ядаж нүүрсээ, ядаж нүүрсээ бид нар энэ түр журмаараа зараад ямар ямар бэрхиээлүүд гарч ирэх нь вэ гэдгийг тестэлж үзэж байгаа юм. Өнөөдрийн байдлаар зүгээр хамгийн том бэрхиээл бол тээвэр байна. Тэр хил дээр аваачиж өгөх асуудал дээр бол асуудлууд бол үүсэх магадлал өндөр байна. Гэхдээ бид асуудлуудыг даван туулахын төлөө олон зүйлийг зохион байгуулаад явж байгаа.

Тэр зэсийн хувьд 89 номер хариулах байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, ажлын хэсэг.

Ж.Бат-Эрдэнэ: Алтанхуяг гишүүн асуулаа, зэстэй холбоотой асуудлууд яах юм бэ гээд. Энэ хуулийн 5.4 дээр биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг ЗГ

батална гэж байгаа юм. Ер нь УУЯ-аас анх оруулж ирснээрээ төрөөс гаргаж ирж байгаа зэс болон төрийн байгууллага, төрийн өмчит компаниудаас гарч байгаа энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг эхний удаадаа өөрсдөө бид биржээр ядаж улс өөрсдийнхөө мэдлийн хэмжээнийхээ бүтээгдэхүүнийг биржээр арилжаалъя гэсэн ийм бодлогыг бол барьж байгаа. Тэр утгаараа энэ хуулийн логик утга учир нь бол орж ирж байгаа юм. Тийм болохоор энэ заалтаар биржид арилжаалах бүтээгдэхүүний төрөл ангиллыг ЗГ батална гэхээр ЗГ ямар ямар бүтээгдэхүүнүүд байх юм? Энэ нь ЗГ тогтоогоод, тэр таны асуусанчлан зэс энэ дотор нь ороод, ингээд ангиллыг нь батлаад ингээд арилжаанд ороод явчих юм байгаа шүү.

Энэ хуульд биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг ЗГ батална л гэж байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Баярлалаа. Ер нь өнөөдөр яг Монгол Улсын нүүрсний үнийг хэн тогтоогоод байгаа гэдэг асуудлыг сайн судалсан биз дээ? Сая Ганбаатар сайд байна, дахиж яриад байна л даа. Өнөөдөр Монгол Улсад нүүрсний үнийг богинын тээвэр хийдэг тэр хүмүүс тогтоогоод байгаа юм. Тэр дотор нь эрх баригч нар оролцчихсон, гадаадын хөрөнгө оруулалттай маш олон машинууд байгаа, бараг арваад мянган машиных нь ер хувь нь Хятадын хөрөнгө оруулалттай хятад машинууд. Үлдсэн дээр нь манай эрх баригчдын машинууд ингээд явдаг. Эрдэнэс таван толгой дээр жишээ авъя. Өнөөдөр Эрдэнэс таван толгой аман дээр 109 доллароор нүүрсээ зарж байгаа, энэ үнийг хэн тогтоодог вэ гэхээр богинын тээврийнхэн эхлээд үнээ тогтоогоод, тэгээд дараа нь Эрдэнэс таван толгой амны үнэ гэдэг үнээ тогтоодог. Шалтгаан нь юу юм бэ гэхээр Эрдэнэс таван толгой, бусад

уурхайнууд бүгдээрээ амны үнэ гээд зөвхөн хэзээ хилээр гарах нь тодорхойгүй, хэн тэрийг цааши нь тээвэрлээд гарах нь тодорхойгүй нүүрсийг аман дээрээсээ зардаг. Харин тэнд мафийн сүлжээ ажиллаад өөрсдийнхөө үнэ дээр богинын тээвэр гэдэг хамгийн үнэтэй тээврийг хийдэг. Энэ нь Эрдэнэс таван толгой дээр жишээ авахад Эрдэнэс таван толгойн жилдээ нэг тонн нүүрснээс олдог 70 долларыг зөвхөн богинын тээврийн тэр мафийнхан тэр үнэ тогтоож байгаа, хилээр гарах эрхтэй, хэзээ гарах эрхтэй ган бөмбөлгийн эрхтэй тэр хүмүүс үнэ тогтоогоод байгаа юм аа.

Тэгэхээр бид нар өнөөдөр биржийн хууль хийснээрээ бүх юмаа аман дээр аваачаад зарчихна гэвэл түүн шиг худлаа үлгэр байхгүй ээ. Үнэхээр тэр нүүрсийг биржээр зарах гэж байгаа бол тэр хилээр гардаг эрхтэй нь цуг зарахгүй бол энэ асуудал явахгүй ээ. Эргээд энд байгаа эрх баригч нар тэр үнийг чинь тэр гуйвуулдаг үйл ажиллагааг чинь хийгээд дундаас нь авдаг ашгаа авч л таарна. Тэгэхээр энэ дээр маш сайн анхаар аа. Нэг биржээр нүүрс худалдаж байгаа гээд дундаас нь нэг экспортын энэ биржээр дамжихгүй бол экспорт гарч чадахгүй гээд дундаас нь нэг татвар авдаг байгууллага болчих вий дээ. Энэ хуучин ХАА-н бирж дээр яг энэ асуудал үүссэн юм. Зүгээр л экспортын бичиг өгдөг бараг тийм байгууллага болчихсон байхгүй юу, хөдөө аж ахуйн бирж. Тэгээд дамнуурсан, яг ийм асуудал давтахаас маш сайн сэргийлэх ёстой. Үүнийг бүгдээрээ мэдэж байгаа байх. Ганцхан Чалькод л энэ эрх байдаг. Хилээр гарах эрхтэй нь зарагдсан ганцхан тохиолдол өнөөдөр Чалькод л байгаа. Тэгээд өнөөдөр бирж дээр зарагдсан нүүрс, тэр давхар тээврийн нэмэлт орлого олдог тэр мафийн сүлжээг даваад тэр 285 доллар өнөөдрийн үнэ шүү, 300 доллар хүрэх энэ боломжийг яаж хүргэх юм бэ? Энэ дээр бас нэг яг ингэж хүргэнэ ээ сая ингээд бөөрөнхийлж яриад байна л даа. Энэ маш том асуудал байхгүй юу. Үүнийг

давна гэдэг бол. Тэгэхээр хэзээ хилээр давах нь мэдэгдэхгүй нүүрсийг хэн авах юм, тэрийг зөвхөн хилээр гаргаж чаддаг хүмүүс л авч байгаа. Өнөөдөр сая тонны нүүрсний гэрээ бирж дээрээс авлаа гэхэд хилийн нөхцөлтэй гэвэл өдөрт хэдэн машин гаргах тэр боломжоор нь ханга, хэдэн сарын дотор энэ нүүрсийг нь Монголын хилээр давах тэр боломжоор нь хангаж байж бодитой хилийн цаадах нүүрсний чинь үнэ тогтоно оо.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Уул нь энэ асуудлуудыг хэлэлцэх эсэх дээр асуувал нөгөө хэлэлцүүлгийн хувьд их тус болох зүйлүүд байлаа гэдгийг Ганибал гишүүнд хэлье. Яагаад багаар эхлэх гэж байгаа вэ? Яагаад 30 хувь гэж яриад байгаа вэ? гэдэг утга учир нь яг таны энэ наад олон тээвэр дээр үүсэж байгаа олон асуудлуудад байгаа юм.

Яагаад бүгдийг нь зарахгүй байгаа юм, яагаад 30 хувь гээд болгоомжлоод байгаа юм, яагаад багаас эхлэх гээд байгаа юм, гол асуудал нь өөрөө яг таны ярьж байгаа асуудал байгаа юм. Тийм учраас бид нар эхний ээлжид 2 сарын 15-нд 10 хувиар юм уу, 20 хувиа зөвхөн чингэлэг тээврээр хил дээр аваачиж өгнө, тэр Цагаан хад дээр буулгахгүй, дайрахгүй тэр богино уртын тээвэр гэдгээс ангид, тэр битгий хэл бид нар хэрвээ боломж гарвал биржийн нүүрсийг тусдаа боомтоор тусдаа гарцтай болгохын төлөө Хятадын талтай боомтын сайдтайгаа хамтраад ажиллах энэ төлөвлөгөөг гаргаад явж байгаа юм. Биржийн нүүрсээ их тийм хурдан иуурхай, тэрнээс гадна яг таны ярьж байгаа тэр нэг төлбөр хураамж гэдэг юм уу янз янзын зүйл аваад зогсчихдог, бирж болгохгүй байхын төлөө бид бүр журам дээрээ 0,1 хувийн шимтгэлээс өөр юу ч авахгүй, хамгийн дээд тал нь 0,1 хувийн шимтгэл байна гэдгийг бүр тусгайлан зааж өгсөн. Ийм асуудлууд

гарах, ирээдүйд магадлалтай гэсэн үгднээс.

Өнөөдөр яг үүнээс өөр бусад бүх бэрхшээлүүд яриад байвал үүнээс өөр гаргалгаа алга. Хэрвээ ирээдүйд өөрийнхөө нүүрсийг тодорхой үнээр зөв үнээр бид нар бас их мундаг, их өндөр үнээр зараад өгвөл бид нарт маш том өрсөлдөгч нар гарч ирнэ, яг зах зээлийнх нь бодит үнээр Монголын нүүрсийг их тийм хямд байлгахын төлөө бид явах ёстой, тогтвортой, хямд өрсөлдөх чадахуйц үнээр явах ёстой. Өөрийнхөө нүүрсийг их үнэтэй болгоно гэвэл бид нарт өнөөдөр өрсөлдөгч Индонез, Австрали, ОХУ бид нарт уул нь яг хил дээр байгаа давуу талтай. Зүгээр яах вэ, технологи энэ тэр гээд бид нарт дэлхийд байдаггүй бүтээгдэхүүн байвал тэрийгээ маш өндөр үнээр зарах нь зөв л дөө. Бид нарт бол өөр улсад байдаг бүтээгдэхүүн Монгол Улсынхаа давуу талыг гаргаж тогтвортой, хямд, чанартай нүүрсийг нийлүүлдэг ийм бодлогыг ирээдүйд уул уурхайн яам хэрэгжүүлэхийн төлөө бодлого гаргаж ажиллаж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ер нь нэг товч тодорхой хариулж баймаар байна шүү. Асуултаасаа хариулт нь олдчихоод байгаа юм. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн товч нэмчих, хариулт.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ манайхан нэг зүйлийг арай буруу ойлгоод байгаа юм шүү. Нүүрсний хулгайг хэн хийгээд байгаа юм бэ гэхээр тээвэрчид хийгээд байгаа юм шиг юм яриад байгаа юм. Богинын тээврийнхэн хулгай хийгээд байна гэж яриад байх юм, үгүй байхгүй юу. Үүнийг тухайн компанийн захирал тэр урд хөршүүдийн хэн нэгэн компанитай хийж байгаа гэрээ нууц ч байна уу, нууц биш ч байна уу, оффтек ч байна уу, энэ гэрээн дотор чинь энэ үнийн асуудал энэ нүүрсний хулгай чинь яваад байгаа шүү дээ. Тээврээ өөрсдөө хийж байгаа болохоор наад талаас нь харахаар энэ богинын тээврийнхэн юм идээд байгаа юм шиг харагдаж байгаа

болохоос биш яг үндсэндээ тээвэрчид нөгөө нэг замын зардал энээ тэрээ бензин тос энээ тэрнийхээ цаанаас нэг их гарч чадахгүй байгаа шүү дээ. Хамгийн гол нь бид нар биржийн хуулийг хийх гээд байгаа чинь энэ хоорондоо хулгайгаар хийгээд байгаа тэр компанийн захирлууд нууцаар гэрээ хийгээд байгаа тэр хуйвалдаж гэрээ хийгээд байгаа зүйлийг чинь бирж рүү оруулж байж бид нар засах гээд байгаа байхгүй юу даа. Тэгээд яг өнөөдөр харагдаж байгаа зүйл зөвхөн үүнийг энэ богинын тээврийнхэн тээвэрчид нь хамаг хөлсийг нь хамаг мөнгийг нь идээд байгаа юм шиг хамаг ашигийг нь аваад байгаа юм шиг юм харагдаад байгаа байхгүй юу даа. Тэгэхээр ерөөсөө гол нь энэ тухайн компанийн захирал хуйвалдаж гэрээ хийдгийг л зогсоох ёстой, энэ юугаар биржээр. Хамгийн гол асуудал чинь ерөөсөө л энд байж байгаа юм.

Дараа нь бирж бий болчихсон үед тэр өөрийн гэсэн талбайтай байх, өөрсдийн буулгадаг, лаборатори шинжилдэг лабораторитой байх тээвэрээ хөлсөлж авах эд нар гээд явахаар тээвэр чинь өөрөө цэврээрээ буцаад ороод ирэх байхгүй юу.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд. Энэ 1072 хувьцааг амь оруулъя гэж яриад байна л даа. Тэгээд амь ор нь гэхээрээ хувьцаа эзэмшигчид дивидент ашгаа авч олон нийтийн хяналтад орж, хувьцаа эзэмшиж байгаа бүх хүмүүс, тухайн компанийнхаа хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг хянадаг ийм л зарчмыг хэлэх байх л даа. Тэгэхээр энэ 1072 хувьцааг яг хэдэн онд ард түмэнд шилжүүлсэн, түүнээс хойш одоог хүртэл ер нь ямар хэмжээний дивидент өгөөд байна аа, хэдэн жил болоод байна. 1 дүгээрт.

2-т гэвэл, энэ өнгөрсөн хугацаанд ард иргэдэд очих ашигийн хуваарилалт

дивидентийг өгөөгүй, үүнийг хэзээ нөхөж өгөх юм. Эздээс нь асуухгүйгээр баахан зөвлөх үйлчилгээ гэдэг юм уу, гүйцэтгэх удирдлага нь авлига мөнгө, хээл хахууль хэний ч хүсээгүй баахан зардлуудыг гаргаад ингээд ард түмний мөнгийг устгаад хаячихсан байна. Тийм учраас өнгөрсөн хугацааны энэ ард иргэдийн 1072 хувьцааны алдагдлыг хэзээ нөхөж өгөх юм, хэзээ амь оруулах юм гэсэн тал дээр тодорхой хариултыг ард иргэдэд өгмөөр байна.

Хүн байна аа, өөртөө хэдэн хувьцаа эзэмшиж байгаагаа ч мэдэхгүй хэдэн төгрөг авч байгаагаа ч мэдэхгүй байгаа шүү дээ. Амь орно гэдэг чинь тэнд оролцогч бүх хүмүүс, миний хувьцаа эзэмшиж байгаа компани маань энэ жил алдагдалтай байгаа болов уу, ашигтай байх бол энэ жилд тэдэн төгрөгийн ашиг авлаа, ирэх жил төдийг авах юм байна, миний энэ 5 жилд авах ашиг 1072 хувьцаанаас төд орж ирэх юм байна, тийм учраас миний хуримтлал бол тийм болох юм байна гэсэн ийм л чин эрмэлзэлтэй байж байж амь орох юм аа. Тэгэхээр өнгөрсөн хугацааны энэ алдагдал юуг, хэзээ нөхөж өгөх юм, цаашид энэ олон нийтийн хараа хяналтад ороход бол биржийн асуудлуудыг ярьж байна. Тэгэхээр би энэ Уул уурхайн бирж, ХАА-н бирж гэж саланг биржүүд байгуулах нь бол буруу гэж ойлгож байгаа юм. МХБ гэж бэлэн, гучаад жилийн түүхтэй энэ Хөрөнгийн биржийг барьж байх асуудал байх ёстой. Ахиад ХАА-н бирж, уул уурхайн бирж цаашидаа салаад ямар ямар бирж гэж юу байгуулах юм бол доо. Тэгээд нэг баахан бүтэц, орон тоонууд гаргаж ирдэг, түүнийгээ цалинжуулахын тулд арилжааны шимтгэл авдаг ийм нөхцөл байж болохгүй ээ.

92 онд Хөрөнгийн биржийн нээлтийг хийж байх үед төрийн өмчийг бүгдийг хувийнх болгож, олон нийтийн хяналтад оруулна гэж ирсэн. 30 жилийн дараа төр хөрөнгийн биржээс савраа авахгүй байна. Ер нь эдийн засгийн

нээлттэй бодлого явуулж байгаа газар бол даатгалын асуудал, Хөрөнгийн биржийн асуудлыг л хөгжүүлэх ёстой. Өнөөдөр МХБ даатгалын асуудлуудад төр очиж савраа атгачхаад ингээд хөдлөхгүй, тахир дутуу юм шиг байлгаснаас л явж байгаа юм. Ингээд 30 жилийн түүхтэй боловсон хүчнээр хангагдчихсан, Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт сүлжээ бүхий бирж бэлэн байсаар байтал дахиад л ХАА-н бирж гээд л нэг дарга тавьдаг, хэн ч мэдэхгүй баахан боловсон хүчнүүдийг цуглуулдаг, дахиад уул уурхайн бирж гэж байгуулна, бас нэг улс төрийн томилгоо хийгдэнэ, очсон хүн нь баахан мэргэжлийн бус хүмүүсийг бий болгосон, ийм данхар бүтцүүдийг бий болгоно. Тэгээд тэрэнд нь өөрөө төр хумсаа шигтгэчихсэн, зах зээлийн зарчмаар нь явуулдаггүй. Үнэ хаана тогтдог вэ гэхээр эрэлт нийлүүлэлтийн муруй дээр л тогтдог. Тэгвэл өнөөдөр Монголын бүх хүн захиргааны дарга хэлж байна шүү дээ, бензинийг төд байлга, нүүрсийг төд байлга, арьс ширийг төд байлга гэсэн ийм байдлаар. Тэгэхээр ийм зах зээлийн голдиролд нь хэзээ оруулах юм бэ, Хөрөнгийн биржээ баяжуулаач ээ.

Г.Занданшатар: Ер нь бол ер нь бол Байнгын хороо, ажлын хэсэг л харилцах ёстой. Жамбалын Ганбаатар сайд

Ж.Ганбаатар: Би их богинохон хариулъя, манайхан гүйцээгээд хариулах байх. Яг таны болгоомжилж байгаа зөв. Тийм ч учраас Бат-Эрдэнэ гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг өргөн барьсан хууль нь зөвхөн Уул уурхайн бирж гэсэн заалттай байсан бол ажлын хэсэг дээр тодорхой санал гаргаад Хөрөнгийн биржийн доор байгуулах боломж нь оруулчихсан байгаа хуульд. Ийм учраас таны ярьж байгаа тэр хөрөнгө мөнгө, тэр хүн хүч, санхүү мөнгийг хэмнээд Хөрөнгийн биржийн дор өнөөдрийн нөхцөл байдалтай уялдуулаад уул уурхайн биржийг явуулъя гэдэг энэ санал орчихсон байгаа юм. Тэгэхээр 2

варианттай гэсэн үг. Уул уурхайн биржийг дангаар нь байгуулж болно, эсвэл Хөрөнгийн биржийн доор охин компани хэлбэрээр байгуулах боломжтой. Бид бол тэр сонголтыг нь авч байгаа Батсуурь гишүүн ээ. Тэрийг бол та яг таны болгоомжилж байгаа зүйл дээр энэ санал яваад Хөрөнгийн биржийн доор явж байгаа гэдгийг хэлье.

Тэр хувьцааг бол ногдол ашгийг нэг удаа тараасан, та сайн мэдэж байгаа байх тийм ээ. Тэгэхдээ тэр дүн энэ тэрийг бол хэдэн сарын хэдний өдөр, ямар дүн гэдгийг мэргэжлийн байгууллагууд өөрсдөө хэлж өгөх нь зөв байх. Хэдэн төгрөг, ААН-д хэдэн төгрөг өгсөн юм, хэзээ өгсөн юм, иргэнд хэдэн төгрөг өгсөн юм их тийм, гэхдээ зүгээр яах вэ, би энд нэг зүйлийг бас хэлье. Батсуурь гишүүн та сайн мэдэж байгаа. Би бас нэг Австралид нөгөө нэг листэд болчихсон нэг Монголын залуучуудтай уулзаад, үгүй ээ, та нар Монголд наад мөнгөө босгож болдоггүй юм уу гэсэн чинь Монголын хөрөнгө оруулагч нар маргааш нь надаас ногдол ашиг нэхээд байдаг юм аа. Хувьцаа гэдэг чинь өсөж, буудаг зүйл шүү гэдгийг Монголд хөрөнгө оруулагч нар одоохондоо соёл нь арай тогтоогүй байна аа. Би тэгэхдээ хамааралгүй зүйл ярьж байгаа шүү. Гэхдээ хувьцаа гэдэг зүйл өөрөө жил болгон ногдол ашиг хуваарилах боломжгүй байдаг гэдгийг бас ер нь зүгээр хувьцаатай хүмүүс янз янзын байдлаар ойлгох ёстой юм байна лээ.

Зүгээр өнөөдөр Монголын залуучуудтай би уулзаад сууж байхад бол Монголоос хөрөнгө босгохоор жилийн дараа ирээд надаас мөнгө өссөн байх ёстой гэсэн байдлаар ингээд надаас ажил хийлгэдэггүй юм. Энэ гаднын хөрөнгө оруулагч нар бол хувьцаа гэдэг зүйлийг өсөж урууддаг зарчмаараа явдаг гэдэг ойлголтоо маш сайн, олон зуун жил суучихсан учраас бид нар ер нь гадаадад листэд болох гаднаас хөрөнгө оруулах сонирхол их байдаг юм гэдэг зүйлийг хэлнэ лээ шүү. Гэхээр бид бол хувьцаа

гэдэг зүйл бас өсөж урууддаг шүү гэдэг ойлголтыг бас зарим жил ногдол ашиг өгнө, зарим жил өгөх боломжгүй байдаг гэдгийг бас ойлгох хэрэгтэй гэдгийг та бас сайн мэдэж байгаа. Баярлалаа.

Манайхан гүйцээгээд хариулчихъя.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Зөв өө, Батсуурь гишүүний яриад байгаа тэр амилах асуудлыг л бид нар энэ рүү оруулаад байгаа шүү дээ. Хамгийн гол нь иргэд энэ баялгаас хүртэх ийм боломж бололцоог л бид нар амилуулах гээд байгаа юм. Үүний талаар энэ хууль маань орж ирснээр хамгийн гол нь иргэд энэ 1072 хувьцаагаа авч ийм арилжаанд оруулах, хүртэх ийм боломж бололцоог хангагдах юм. Энэ 1072 хувьцаа нийт хувьцааны 18 хувь болж байгаа, нийт хувьцааны 18. 2.5 сая иргэнд хуваарилагдаж байгаа. Тэгэхээр бид нар ЗГ-т өгснөөр одоогийн энэ 2012 оноос хойш төрсөн иргэдэд эргэлтэд оруулах, тэд нарт бас хүртээх ийм боломж бололцоог бас хангаасай л гэсэн ийм зүйл байгаа юм л даа.

Нөгөөтээгүүр энэ бирж нь ТӨК байна гэж орж ирсэн юм. Тэгэхээр үүнийг бид нар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэдгээр нь ороод, өөрөөр хэлбэл хувийн компаниуд орж ирэх тодорхой хувийг нь эзэмших хяналтаа тавих таны түрүүний хэлээд байгаа тэр зөвхөн ХАА-н бирж дээр бид нар бол том алдаа гаргачаад байгаа шүү дээ, зүгээр цаас худалддаг ийм компани болчихоод байгаа шүү дээ, арилжаа хийгдэхгүй. Тэгээд тэрнээс урьдчилан сэргийлж, энэ хувийн хэвшлийн оролцоог бий болгох ийм бол боломж бололцоо хаалгыг нь хийгээд ингээд явж байгаа.

Нөгөөтээгүүр, одоо Хөрөнгийн биржийг биржээр арилжаалах, одоогийн өнөөдрийн үнэт цаасны хуулийн дагуу Хөрөнгийн биржээр арилжаалах

бололцоог нь энэ хуульд зааж оруулж ирсэн. Энд 5.8 дээр биржийн арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.14-т заасан үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар гүйцэтгэх тохиолдолд ЗГ шийдвэрлэнэ ээ гээд өөрөөр хэлбэл энэ Алтайгаар хийлгэх, хөрөнгийн биржээр хийлгэх боломж бололцоог нь бид нар энэ хуульд нээгээд өгчхөж байгаа юм.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна, 1 минут.

Ж.Батсуурь: Асуултдаа ч нэг их бүтэлтэй хариулт авч чадахгүй байна л даа. Ер нь энэ янз бүрийн олон бирж байгуулдгаа болих хэрэгтэй, бүгдийг татан буулгая, хоёрдмол утгатай байж бол болохгүй. Тэгэхээр ахиад л бүтэц, уул уурхайн бирж байгуулах нь зөв юм байна гээд гараад ирдэг. Энэ ХАА-н бирж, Уул уурхайн бирж, өөр ажил олгогчдын ямар бирж ч билээ энэ бүх зүйлээ Хөрөнгийн бирж дээрээ л зангидах хэрэгтэй. Юуны төлөө 30 жилийн өмнө МХБ-ийг байгуулж, төрийн өмчийг хувьчлах замаар шинээр бий болж байгаа уул уурхайнуудыг олон нийтийн хяналтад оруулна гэсэн юм бэ. Тэгэхээр энэ хөрөнгийн биржээ бярдүүлж байж Хөрөнгийн биржээ жинхэнэ зах зээлийн онолынх нь дагуу явуулж байж ер нь нээлттэй эдийн засаг энэ авлига хээл хахуулиас гаръя л гэж байгаа бол Хөрөнгийн биржээ яг бодитоор нь ажиллуулах, даатгалын шинэчлэл хийх ийм л 2 асуудлыг онцгой анхаарахгүйгээр зүгээр нэг ингэж жижиг мээ ажилбар хийгээд бол ... /минут дуусав/

Г.Занданшатар: Санал байна. Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ сүүлийн үед энэ уул уурхай судлаад энэ ер нь энд биржээ хурдан байгуул аа. Энэ таван толгойн төлөвлөлтийг чинь харахад 23 онд, 32 сая, 24 онд 45 саяыг борлуулна, олборлоно гээд бид чинь дэлхийд

нүүрсээрээ нүүрсний экспортоороо 4-т ордог юм байна. Энэ чинь Монголын нүүрсний экспортын 32 хувийг, зөвхөн Эрдэнэс таван толгой гаргаж байна.

Энэ өнгөрсөн сүүлийн 3 жилд эд нар чинь 61 удаа сонгон шалгаруулалт хийж 108 компанитай гэрээ байгуулсан байгаа юм. Тэгээд сонгон шалгаруулалт гэдэг чинь нэг хүнийг сонгохын тулд шалгаруулалт явдаг биз дээ? Тэгээд 61 удаа хийгээд ингээд дабладчихсан гэрээнүүд хийгээд явчихдаг. Үүнийг цэгцлэхгүй бол одоо энэ худалдан авалт дунд оролцдог Хятад, Монгол нийлсэн зуучлагч нар энэ Чингис хаан банкныг чинь худалдаж авах гээд 100 сая долларын өртэй банкныг чинь худалдаж авах гээд Монголбанк дээр мөнгө байршуулаад явж байна гэх юм, үүнийг хэн хариулах вэ. 100 сая долларын өртэй, тэр Таван толгойн мөнгө ч тэр дотор байгаа. Энэ нийгмийн даатгалын мөнгө байгаа, ЭМД-ын мөнгө байгаа, Хөгжлийн банкны мөнгө байгаа. Тэр банкныг чинь өнөөдөр энэ нүүрсний зуучлагч компаниуд худалдаж авна гээд мөнгөө нийлүүлээд Монголбанк дээр мөнгө байршуулчихсан байна гээд. 100 тэрбум гэсэн үү, 200 тэрбум төгрөг гэсэн үү.

Энэ хулгайч чинь бүр хэтрээд сүүлдээ банк руу ч орж эдийн засгийн чинь амин судас руу орж ирж байна шүү дээ гол судсанд дээр чинь зогсож байна шүү дээ. Үүнийг хэн хариулах ёстой вэ? Энэ Монголбанк тийм байна уу, үгүй юу. Эс үгүй бол Хүрэлбаатар сайд хариулах ёстой юу.

Төрийн эзэмшлийн 81 хувийг өнөөдөр УУЯ барьж байгаа. Тэрний 70 хувь нь уул уурхайн яам, 30 хувийг нь ТӨХ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, энд таван толгойн. Энэ 70 хувийг чинь төлөөлж ямар ямар хүмүүс тэнд байдаг юм бэ Ганбаатар гишүүн ээ, энэ хүмүүсээ сольсон уу. Энэ хүмүүс чинь албан тушаалаар орж байна уу, эс үгүй бол хэн нэгэн сайдын сонголт

шахалтаар орж байна уу. Энэ нэг асуултуудыг хариулах хэрэгтэй.

Явж явж энэ дотор байгаа энэ үнэ тогтоох юман дээр дахиад алдаа гаргах вий, энэ хууль дээр. Үнэ тогтоох хилийн үнээр тогтооно гэж байгаа юм, тухайн хил боомтын үнээр тогтооно гэж байгаа юм, тэрийг хэн тогтоох вэ, хил боомтын үнэ гэдгийг яаж хэн мэдэх юм бэ? Тэгээд дээд доод үнэ дээр нь энэ бирж нь хяналт тавьж тогтооно гэж байгаа юм. Дээд үнийг яах гэж бирж хянах юм, ер нь. Энэ хууль дотор яагаад тийм заалт хийгээд байгаа юм. Одоо энэ гишүүд яриад байна таван толгойн хувьцааг ард иргэдэд эзэмшүүлсэн тэр 18 хувь байх аа, тийм, нийт энэ чинь Монгол Улсын иргэд 18,44 хувийг л эзэмшдэг юм байна шүү дээ, 2512 иргэн. Энэ 34 хувийг нь та нар Хөрөнгийн бирж дээр гаргалаа гээд ягаан тасалбар шиг болгоод эргээд энэ компанийн 66 хувиа барьсан төрийн өмчийн мэдлийг чинь ингээд бүтэн атгасан ийм юм хийчих вий дээ? Энэ 34 хувь чинь гаргасан шийдвэрүүд дээр хориг саад тавьдаг нэг ийм байдал руу юм орох вий. Яг ягаан тасалбар шиг ийм хэлбэр лүү шилжих юм бол энэ чинь бид бүр онох биш, бүр алдаж байгаа юм шүү. Тэгээд энэ хуулиа хурдан батлаад хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Энэ их том худалдан авалтуудыг ирэх жилүүдэд хийнэ гэж байна, энэ биржээр нь бүгдийг нь хийдэг, энэ хэлбэр дээр нь олон нийтийн оролцоог нь тавьдаг, хянадаг ийм байдлаар оруулахгүй бол болохгүй ээ.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Эрдэнэс таван толгой компани одоогоор бол Эрдэнэс Монголын доор байгаа. УУЯ-нд харьяалагддаггүй. Та үүнийг бас сайн мэдэж байгаа байх. Эрдэнэс Монгол маань хэрэг эрхлэх газрын дор харьяалагдаж байгаа. Уул уурхайн яам

бодлого гаргаж байгаа, зугтах юм алга байна. Манайхаас ТНБД ТУЗ-д суудаг, тэр хүн тавигдаад удаагүй, өмнөх ТНБД нь 6 жил болоод хуулийнхаа дагуу өөр ажилд шилжсэн. Шинэ ТНБД ТУЗ-д сууж байгаа.

Таны болгоомжлол зөв өө, Эрдэнэс таван толгой компани журмаараа бол үнээ өөрөө зарлана, өөрөө зарлана, тэр ганцхан Эрдэнэс таван толгой компани өнөөдөр саналаа өгөөгүй, саналаараа Энержи Ресус компани бас өөрийнхөө боловсруулсан угаасан нүүрсээ биржээр заръя гээд л санал өгч байгаа. Тэгээд бид энэ алхмыг хийгээд түмэн зовлон яриад ч гэдэг юм уу, ийм ийм зүйл байна гээд ухрахгүйгээр ямар нэгэн байдлаар болгоомж зөндөө зүйлүүд бол байгаа, асуудал байгаа. Гэхдээ ер нь зүгээр хараад байхад бол явуулахгүй байя гэсэн хэсэг бүлэг хүн, та бол дэмжиж байгаад маш их баярлалаа. Зүгээр явуулахгүй байя, янз янзын шалтаг шалтгаан ярьж байгаад хуучнаар нь байлгачихъя гэсэн зүйлүүд бол маш их байгаа. Тэгээд энүүгээр нь үлдээлгэчихье. Бирж явах нь ерөнхийдөө маш их олон зовлон бэрхшээлүүдийг олон талаас нь дөвийлгөж байгаа зүйлүүд ч байгаа. Гэхдээ үүнийг даван туулахаас өөр арга байхгүй.

Эрдэнэс таван толгой компани одоогоор ЗГ-ын Бүрэн эрхт төлөөлөгчтэй байгаа, тэр хүнийг би зөв үнэ зарлана гэдэгт зуун хувь итгэж байгаа. Маш зөв үнийг зарлана, цаашидаа жишиг болно гэж би ойлгож байгаа. Хууль батлагдсанаар МХБ үнийг зарлах ёстой, МХБ-дээ итгэхгүй бол өөр хэнд итгэх вэ, зөв үнийг зарлах ёстой. Тэр дээд үнэ гэдэг дээр Хөрөнгийн бирж хариулна биз. Ер нь бол хөрөнгийн бирж доод үнээ зарлана, журмаар бол 7 сарын 01 хүртэл шүү дээ, нүүрсний үнийг бол Эрдэнэс таван толгой компани, эс үгүй бол тэр арилжаанд оролцож байгаа 3 компани 3-уулаа зарлаад явах ийм зүйлүүд бол байгаа.

Ер нь бол Раднаасэд гишүүний болгоомжлолуудыг ойлгож байгаа, хүлээж авч ажиллана гэдгээ хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн алга байна, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Би биржийн тухай хууль дээр гишүүдийн хэлж байгаа саналтай санал нэг байгаа юм. Түрүүн бас хэллээ шүү дээ, малын түүхий эдийн биржийн тухай хууль гээд л гаргасан юм, бид нар. Бас л яг ингээд л гоё ярьж байгаад л гаргасан л даа, одоо ингээд л ёстой сайхан болно, газар дээр арьс шир хэвтэхээ болино энэ тэр гээд л. Ингээд л тэгээд л арваад жил боллоо, газар дээр арьс шир хэвтсээрээ л байгаа байхгүй юу. Тийм учраас бол нэг гоё тайлбар хийгээд л хууль гардаг, амьдрал дээр буудаггүй ийм юмыг л бид нар жоохон анхаарах хэрэгтэй. Тэгээд энэ хуулийг дагаад тэр нэг хэрэгжүүлэх тогтоол дотор бол маш аюултай заалт байгаа байхгүй юу. Тэр 6.2 дээр байгаа юм. Эрдэнэс таван толгойн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрөх гэж байгаа байхгүй юу. Зөвхөн 1072 ч биш, бусад нь ороод ирж байгаа юм. Ерөнхийдөө энэ нүүрсээр, Хөгжлийн банкаар хөрөнгөжсөн гарууд эргээд нөгөө таван толгойг авах гэж байна гэсэн үг байхгүй юу. Нөгөө муу 1072 хувьцааг нь эргэлтэд оруулна гэдэг заалт бас байж байгаа юм. Тэгээд нөгөө хөх, ягаан тасалбар шиг нь мөнгөтэй хүн л худалдаад авна шүү дээ. Ядарсан ард түмэн юугаар юу худалдаж авах юм. Тийм учраас амь оруулах нэрээр 1072 хувьцааг нь авч болохгүй ээ.

Харин бол тэр ногдол ашгийг нь өгөх тухай л бодох хэрэгтэй. Бүртгэлгүй юм шиг яриад байх юм Занданшатар аа, чи тэгж болохгүй шүү дээ. Санаж байна уу, чи тэр үед байхгүй байсан юм болов уу. 12 онд шиг санаж байна, нөгөө нэг сая төгрөг өгнө гээд л. Тэгээд ахмадуудын нөгөө нэг сая төгрөг, 1072 хувьцааг чинь тэгээд мөнгөжүүлээд

өгчихсөн шүү дээ, Хөрөнгийн биржээр дамжуулаад. Үгүй ээ, тэр бүртгэлгүй байгаад тэгсэн үү. Тэгээд оюутнуудын 500-г нь бас тэгээд л өгчихсөн шүү дээ, одоо тэд нарт хувьцаа, ахмадад хувьцаа байхгүй 1072. Тухайн үед тэгээд шийдсэн юм, энэ чинь тэр компани дээрээ энэ чинь бүртгэлтэй эд, төр засгаас Их Хурлаас бүх шийдвэр нь гараад ард иргэдээ 1072-ыг эзэмшүүлчихсэн эд. Зүгээр л хөрөнгийн биржид бүртгүүлж, нээлттэй компани болгож хувьчлах тухай л яриад байгаа байхгүй юу. Эрдэнэт, Таван толгой 2-ыг хувьчилж болохгүй. Ковидын хүнд цаг үед хэн гэрлийн мөнгийг нь төлсөн юм, хэн түлшний хөнгөлөлтийг нь төлсөн юм, хэн тэр хүндрэлтэй бүх зардлыг даасан юм, энэ 2 компани.

Тэгвэл өмнө нь төрийн үнэ цэнтэй ААН-ийг хувьчилж авсан хэн ийм мөнгө гаргасан юм, тэгвэл. Энэ 120-д байсан бүх ААН-ийг худалдаж авсан хүмүүс дотроос хэн нь мөнгө гаргаж, ард түмний өмнөөс мөнгө төлсөн юм, хэн ч төлөөгүй за юу, хэн ч төлөөгүй. Тийм учраас мөнгөжчихөөд энэ нэг Эрдэнэт, Таван толгой хоёрыг нь булааж авах тухай энэ бодлоо больсон нь дээр ээ. Норвег, Финлянд, Чили яаж байна, жижиг орнууд. Байгалийн баялгийнхаа стратегийн гол ордуудад дандаа төр нь 51 хувь байна шүү дээ, 51 хувь байна. Хэрвээ таван толгойд гаднын менежмент оруулъя, бас хариуцлагатай больё, дэлхийн зах зээлийн үнээр зардаг больё гэдэг юм бол үүнийг маш сайн ярих хэрэгтэй. Тэрнээс биш зүгээр нэг Их Хурлын тогтоол санаачлаад үүнийг хийдэг эд биш шүү. Гадаа нөхцөл байдал ийм эмзэг байх үед ард түмний өмч болсон энэ компанийг хувьчлах тухай асуудал ярьж болохгүй, гоё сайхан юм эргэлтэд оруулах гэж байна энэ тэр гээд л. Ард түмэн өнөөдөр ойлгодог болчихсон.

Хувьд өглөө гээд яах юм. Нөгөө давхар гэрээ хийгээд л жижиг таван толгой шиг л юм болно шүү дээ. Цаанаа

нэг өөр үнээр зараад л тэр баян нөхөр чинь, нүүрсний хулгай улам гүнзгий болно шүү дээ. Хувьчлалаа гээд сайжрах уу. Жижиг таван толгойг хар л даа. Нөгөө төрийн өмч нь төлөөлөл нь хүнээ тавьж чадахгүй, нөгөө ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулна.

Ж.Ганбаатар: Манай ажлын хэсгийн дарга уучлаарай, дараа нь хариулчих. Даваасүрэн гишүүн ээ, шууд бид бол их гоё сайхан юм яриад 100 хувь хэрэгжинэ гэж яриагүй ээ, эрсдэл бол хамгийн багадаа 70 хувь байгаа, шууд ил хэлж байгаа юм. Тийм ч учраас бид нар 30 хувь дээрээ бирж 30 хувиар нь зарахыг хичээж байна гэж би одоо 5, 10 удаа давтаж хэлж байгаа юм. 2 сарын 1-нд бид нар бүр 10 хувиасаа ч эхэлж магадгүй. Асуудал маш их байгаа учраас бид бага багаар явах гэж байгаа. 7 сарын 01 хүрэхэд бид нар ядаж 30 хувиа биржээр зарахыг хичээж байгаа юм. Энэнээс өөр гоё арга зам байвал хэлээд өгвөл бид мөрдөөд явах, энэ хуульдаа өөрчлөлт оруулах, эцсийн хэлэлцүүлэг дээр ч гэдэг юм уу, дараагийн энэ дээр нэг тийм бэлэн байна. Тэгээд өнөөдөр байж байгаа зүйлүүдийг даван туулах ёстой, би яриад дуусчихъя, тэгээд тодруулна.

1072 хувьцааны хувьд бол таны болгоомжилж байгаа зөв. Яг таны хэлж байгаагаар л байгаа шүү дээ Ганбаатар гишүүний хэлж байгаагаар л байгаа шүү дээ. С.Ганбаатар гишүүний. Яг тэрийг бид нар угаасаа л тэр үр өгөөжөө өгдөг ёстой хувьцаа л гэж ойлгож байгаа шүү дээ. Засагч тэгж ойлгож байгаа, Их Хурал ч тэгж ойлгож байгаа. Үгнүүдийг уншаад хэт их нэг тал руу нь гуйвуулах бол хэрэггүй байх гэж бодож байна.

Харин ажилд тус болох замаар ийм ийм зүйл байна, тэрийг ингэж хийх ёстой, энэ дээр нь ийм үгнүүдийн алдаа гарчихсан байна, асуудалд ингэж хандаж хандъя л даа. Яагаад нэг үгэн дээр өөлөөд

ингээд өөр тийш нь мушгиад бусдад таалагдах гэж ингэж гуйвуулах ёстой юм. Ганбаатар гишүүнд би бол тэгж хандмаар байна, өчнөөн олон жил туршилагатай парламент ч байж байж асуудал ийм үгэн дээр чинь буруу байна аа, энэ үгийг хэн найруулсан юм? Үүнийг зөв болгочих, энэ танай яг бодож байгаа бодлыг чинь өөр тийш нь явуулаад байна шүү дээ гээд. Үгүй ээ, би хаана ч ЗГ бай, Их Хурал бай, хаана ч 1072 хувьцааг зарна барин гэсэн зүйл бол байхгүй байна. Үр өгөөжтэй болгоё, тэр 1072 хувьцааг эзэнжүүлэе, тэр 1072 хувьцаанд энэ өнөөдрийн Бүрэн эрхт төлөөлөгч тавигдсанаар болж өгвөл хэрвээ тэр Эрдэнэс таван толгой компани ашигтай ажиллавал жил болгон хувь ногдол ашиг тараадаг болгоё. Юу нь буруу байгаа юм бэ тийм ээ. Тэгээд үг өгүүлбэр болгоныг үгүй ээ, ингээд олон сонгогдсон гишүүд аливаа зүйл зөв ханд л даа. Засаж залруулах талаас нь зөвлө л дөө. Гуйвуулах, эс үгүй бол асуудлыг өөр тийш нь хөтлөх гэдэг юм уу, өөрийгөө пиардах талаас нь биш, зарим зүйл дээр арай дэндэж байна шүү дээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Надыг өөрийгөө пиардлаа гэнэ үү, юу гэж хэлнэ ээ, хамаа алга. Энэ болохгүй ээ. Жижиг таван толгойн тэгвэл тодорхой хэсэг нь хувьд байж л байгаа шүү дээ. Тэгээд яагаад төр хүнээ тавьж чадахгүй байгаа юм? Тэр жишээ чинь эргээд таван толгой дээр давтагдаж бас болно шүү дээ. Зүгээр зам зааж өгөөч гэж байна. Чили яв, Финлянд яв, Норвег яв. Яаж тэнд төрийн өмчийн компаниудыг зөв удирдаж байгааг хар. Үгүй ээ, тэр хариулт тэнд байж дэлхийд байж л байна шүү дээ. Тэд нараас очоод үзээд тэр цалинг нь хангалттай өгч байна, Тэр корпорат менежмент гэдгийг яаж хийж болдгийг тэр Кадилакаас очоод хар. Тэр Норвегийн нефтийн компаниас очоод хар, тэгээд сан байгуулчхаад ард түмнээ тэгжээгээд байж байна шүү дээ. Бид

яагаад болдоггүй юм? Финлянд бас тэгж байна, жижиг орнууд дандаа тэгж байна шүү дээ. Баялгаараа бол 51 хувийг нь төрдөө байлгаж байгаад тэгээд корпорац менежментийг нь сайжруулж байгаад цалингийн захиралд нь хангалттай өгч байгаад үгүй ээ, ингээд л яв л даа. Хулгай хийхгүй л, цалинг нь тэр захиралд нь өг л дөө, тэр ТУЗ-д нь ч өг л дөө. Тэгэх юм ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсэг хариулах уу? Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Даваасүрэн гишүүний болгоомжлол зөв өө. Энэ оруулж ирэх гэж байгаа зүйл маань яг 1072 хувьцаагаа эргэлтэд оруулъя гэснээс биш бүр арилжаалаад ингээд явчихъя гэсэн зүйл байхгүй шүү дээ. Би түрүүн бас та бүхэнд хэлсэн. Компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, тэгээд олон нийтийн хяналт бололцоог нэмэгдүүлэх, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш хүртээх зорилгоор гэж байгаа байхгүй юу даа. Энэ 1072 хувьцааг эргэлтэд оруулах гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл Хөрөнгийн бирж зөвхөн бүртгэлтэй байгаад байгаа болохоос эргэлтэд оруулж чадахгүй нөгөө ногдол ашгаа авч чадахгүй байгаад байгаа юм аа. Ийшээ орж байж ийшээ орно, энэ Хөрөнгийн бирж рүү орно, Хөрөнгийн бирж рүү орж байж ноогдол ашиг авах бололцоо нээгдэх байхгүй юу. Тэрийг бүртгүүлж байгаа, хэрвээ энэ орж ирэхдээ болохгүй бол үг үсгийг нь сольчихоод дахиад л оруулаад ирье. Тэгээд үг үсгийг нь сольчихоод оруулаад ирье. Хамгийн гол нь ногдол ашиг авах боломж бололцоог нь нээж өгөх байхгүй юу. Тэгвэл яг энэ үг үсгээр нь оруулаад ... /минут дуусав/

Г.Занданшатар: Алтай захирал хариулаадхаач, 88. Одоо бүртгэлтэй байгаа юм уу? үгүй юм уу? Түрүүн хариулсан.

Х.Алтай: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Одоогоор бол Эрдэнэс таван толгой компани хаалттай ХК гэдэг ийм эрх зүйн статустай явж байгаа. Энэ нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр хувьцаа нь хадгалагддаг ийм хэлбэртэй байгаа. Нээлттэй ХК ...

Г.Занданшатар: Дуугүй сонс л доо, бүртгэлтэй юм уу, үгүй юм уу гэдэг нь

Х.Алтай: Хөрөнгийн биржийн бүртгэл бол байхгүй.

Г.Занданшатар: Хөрөнгийн биржид бүртгэл байхгүй гэж байгаа юм байна.

Х.Алтай: Хөрөнгийн биржид бүртгэлтэй болохоор эдийн засгийн эргэлтэд

Г.Занданшатар: Тэр зарагдана гэж байхгүй ээ, төрийн нийтийн өмч энэ чинь хуулиараа ер нь энэ нүүрсний хулгайтай тэмцэж, ил тод болгох гэж байхад олон нийтийн дарга нар энэ хяналтыг хэрэгжүүлж чадна гэж байхгүй шүү дээ, олон нийтийн хяналтад байлгая гэж байхад үүнийг эсэргүүцээд байгаа нь харин ёстой энэ нүүрсний хулгайг өөгшүүлж байгаа хэрэг болно шүү.

Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ уул уурхайн биржийн хуулийг ингээд батлаад гаргах нь зүйтэй. Тэгэхдээ манай энэ уул уурхайн биржээр зарах бүтээгдэхүүн чинь нэг хоёрхон төрлийн л юм байгаа шүү дээ. Нүүрс, төмрийн хүдэр. Өөр юм байгаа юм уу? Өөр юм бараг байхгүй шүү дээ. Тэгээд л нэг их том орон тоотой юм хум яриад л ингээд байгаа юм. Зүгээр сүүлд бид нарын ярьснаар энэ Хөрөнгийн бирж дотор нь уул уурхайн нэг жишжиг салбар байгуулаад удирдлага нь бол хөрөнгийн бирж дээрээ явдаг, ингэж

зардал хэмнэж, ингэж явахгүй бол энэ ХАА-н бирж ишг юм болно шүү. Энэ сүүлийн үед л ерөөсөө энэ төрд байсан юманд л хулгай нүүрлэхчхдэг. Олон нийтийнх болгочихоор их сайхан болгочихдог л гээд л ингэж яриад байгаа юм. Би сая Даваасүрэн гишүүний ярьж байгаатай санал нэг байгаа. Тэр одоо нордик загвар гэж байна шүү дээ. Дэлхийн хамгийн аз жаргалтай хүмүүс тэнд байна шүү дээ. Хамгийн өндөр татвартай, төрд нь өмч нь байдаг хамгийн аз жаргалтай хүмүүс тэр нордикт гэх 3, 4 оронд байж байна шүү дээ. Хамгийн авлигал хаана бага байна тэнд байна. Тэгээд ер нь бол бид энэ өөрийнхөө орны онцлог энэ юмаа тохирох ёстой л доо, сайн тооцох ёстой.

Хулгайч нар аваачиж тавьчхаад л хулгай хийлгэхээд л, тэгээд л ерөөсөө төрийн юм бол ингэчихдэг юм гэж ингээд байж болохгүй шүү дээ. Үүнийг би олон дахин хэлж байгаа шүү. Хулгайч нар битгий тавиач ээ, жинхэнэ ажил хийдэг хүмүүсээ тавиач ээ гэж ингэж байгаа юм.

Тэгээд энэ сүүлийн үед ер нь баахан юм л хувьчилна гэж байгаа юм. Банкны айфо явж байгаа. Хөрөнгийн биржийн хувьчлал явна гэж байгаа юм. Дээрээс нь Эрдэнэс таван толгойн тодорхой юмыг ард түмэнд юу хувьчилна аа, нээлттэй хувьчилна гэж байгаа, энэ мөнгө нь байгаа юм уу? Энэ хөрөнгийн бирж биш, нэг гаднын нэг мөнгөтэй, нэг хүн ирээд л авчихна шүү дээ, бидэн ишг биш. Энэ банкнуудын чинь хувьцаа ер нь ямархуу юм болж байгаа юм, энэ дээр дүн шинжилгээ хийж байгаа юу? Эрдэнэс таван толгойг авах эзэд нь Монголчууд авч чадахгүй, Монголчууд их мөнгөтэй 20 хэдэн их наяд төгрөгийн хадгаламжтай л гэж байгаа юм, 1 дүгээрт, тэр чинь цөөхөн хүнд байгаа, 2 дугаарт нь тэр нөгөө нэг 10 их наяд төгрөгийн чинь нэг хэсэг нь тэр 20 их наяд төгрөгийн хадгаламж дотор явж байгаа шүү. Энийгээ сайн бодмоор байгаа юм.

Би нэг хэд хэдэн асуулт байна. Энэ 1 дүгээрт нь энэ худалдааны хуулиа гаргахгүй юм уу? Худалдааны хуультайгаа энэ биржүүдийн хууль чинь яаж явах юм уялдах ёстой шүү дээ. Үүнийг 1 дүгээрт хэлээч ээ гэж.

2 дугаар асуулт юу вэ гэхээр энэ Эрдэнэс таван толгойн 14.6 орчим хувь нь ард түмэнд байгаа л гэж ингэж ойлгож байгаа юм. Миний ойлгож байгаагаар 85, зургаа орчим хувь нь төрд байгаа гэж ойлгосон чинь өчигдөр нэг цаас үзэж байсан чинь төрд жаран хэдэн хувь болоод явчихсан байх юм. Энэ үлдэж байгаа хориод хувийг нь хэн авчихсан юм, хэзээ. Үүнийг Хөрөнгийн биржийн захирал хариулах юм уу, хэн хариулах юм.

Энэ Таван толгой компани бол нүүрс худалдах 633 гэрээ хийчихсэн байна, 633 гэрээ хийчихсэн байгаа шүү, өнөөдрийн байдлаар. Урьдчилгаа гээд 603000000 доллар авчихсан, үүнээс өнөөдрийн байдлаар 400000000 доллар нь өртэй байгаад байна. 2022 оны 10 сарын 12-ны байдлаар 67000000 тонн нүүрс нийлүүлэх гэрээ хийчхэж, үүнээс зургаахан сая тонныг нийлүүлсэн, 61 сая тонн нь дутуу байгаа юм. Бид нар чинь энэ биржээрээ дамжуулж л нүүрс худалдана гээд байдаг, энэ чинь 2, 3 жилийн нүүрсээ худалдчихсан байгаа юм биш үү. Үүнийг та нар яам юу гэж тооцож байгаа юм.

Энэ ЗГХЭГ-ын харьяанд энэ Таван толгой Эрдэнэс таван толгой байдаг нь хэр зэрэг оновчтой юм бэ? Яагаад салбарын яаманд нь байж болдоггүй юм бэ? Энэ хөгжлөө яримаар байна, дандаа хулгай ярьсаар байгаад он дууслаа шүү дээ. Энэ Эрдэнэс ... /минут дуусав/

Г.Занданшатар: Алтай дарга гүйцээчих. Ганбат дарга ирчихсэн байна, Ганбат дарга, Бүрэн эрхт төлөөлөгч. 80.

Ж.Ганбат: Эрдэнэс таван толгой компанийн санхүүгийн тайланд энэ

хувьцаатай холбоотой 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 81.5 хувь нь Эрдэнэс Монгол энэ дээр 81.51 хувь нь Эрдэнэс Монгол ХХК дээр, иргэдэд 18,43 хувь нь, 486 ААН-д 0,05 хувь нь байна гээд ийм байдлаар бол бүртгэлтэй, яг хувьцааны бүртгэл нь санхүүгийн тайлан дээрээ тусчихсан, яг ийм байдалтай байгаа юм. 18,43.

Юун дээр, тэр яах вэ нүүрстэй гэрээтэй холбоотой нэг ийм л асуудлууд үүсээд байгаа юм. Яг Эрдэнэс таван толгой компани дээр ингээд 4 гол том худалдан авагч байна. Энэ нь бол бүгдээрээ БНХАУ-ын компаниуд байгаа. Энэ Чалько байна, Чалько гэрээ нь бол 2011 оноос хийгдээд яваад эхэлчихсэн, гэрээний дуусах хугацаанд дунд нь 2 удаа сунгасан, энэ бол 27 оны 3 сарын 31-нд энэ гэрээ нь дуусгавар болох ийм гэрээтэй. Энэ дээр бол гэрээний гол эхний нөхцөл нь 11 оноос явж байгаа гэрээн дээр Цанхын зүүн уурхайн олборлолтын жаран хувийг нь Чалько авна гэдэг ийм гэрээтэй юм байна лээ. Энэ дээр 11 оноос яг явж ирсэн, гүйцэтгэл нь бол нийт 25.4 сая тонн нүүрс бол авсан. Энэ оны 22 оны яг өнөөдрийн байдлаар гүйцэтгэл нь 644.7 мянган ам. доллартой тэнцэх хэмжээний нүүрсийг бол авчихсан ийм байдалтайгаар, үлдэх нь бол ийм байдалтайгаар бол яг ингээд Чалько-ийн гэрээн дээр ярина. Колори таун гээд энэ компанитай бол 2020 оны 6 сарын 09-ний өдөр гэрээ хийсэн, энэний бас гэрээнийх нь хугацаа нь 27 оны 6 сарын 30-нд хийгдэнэ. Энэ дээр 15000000 тонн нүүрсний ийм гэрээ хийчихсэн, энэ дээр гүйцэтгэл нь бол 1.5 сая тонн нүүрсийг гүйцэтгэлтэй, үүнээс яг 22 онд бол 805.6 мянган тонн нүүрс авчихсан ийм байдалтай байгаа.

Дараачийнх нь Жай юу интернэшилн Ложистикс гээд Жайишин интернэшилн гээд энэ компани дээр бас мөн 21 оны 7 сарын 05-нд гэрээ хийсэн, 26 оны 7 сарын 05-нд дуусна, 15000000 тонн нүүрсний гэрээтэй, гүйцэтгэл нь бол 986.2 мянган тонн нүүрс ингээд

авчихсан. 22 онд бол яг энэ дүнгээр энэ бол өмнө нь яг зөвхөн энэ онд хэрэгжиж байгаа учраас 986.2 мянган тонн нүүрс авчихсан юм байгаа юм.

Дараачийнх нь Шинхуа энерги болон эко мадетс гээд байгаа энэ гэрээ нь 2021 оны 7 сарын 05-нд хийгдсэн гэрээний дуусах хугацаа нь 26 оны 7 сарын 05-нд байгаа, гэрээлсэн дүн нь бол 15000000 ийм дүнтэй байгаа, яг гүйцэтгэл нь 1.5 сая энэ онд ингээд өгчихсөн, яг адилхан гүйцэтгэлээр ийм гүйцэтгэлтэй. Энэ бол өөрөөр хэлбэл мөнгийг нь урьдчилаад авчихсан энэ компаниудаас нийтдээ Чалько бол оруулахгүйгээр энэ 3 компани дээр нийлээд 300000000 доллар авсан, Чалько-оос 100 сая гээд 400000000, яг нийтдээ 603000000 долларын болон ингээд мөнгийг нь урьдчилаад авчихсан төлбөрийг нь нүүрсийг нь урьдчил, мөнгөөр нь төлбөрөө аваад нүүрсээ нийлүүлэх ийм гэрээтэй байгаа.

Энэ дээр нийлээд Чальког оруулахгүйгээр ингээд 15, 15-аар 3 гэрээгээр 45000000 тонн нүүрс нийлүүлэх ийм гэрээнүүдтэй ийм байгаа.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулъя, Байнгын хорооны дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүний бас асуулт, тэр худалдааны хуулийн талаар асууж байна. Ингээд энэ худалдааныхаа хуулийг гаргахын өмнө бол бид нар бас энэ Их Хурал дээрээ ярьж байж энэ ер нь худалдаа гэж юу юм, энэнийхээ талаар бас үзэл бодлоо нэгтгээд нэг ийм бодлогоо гаргаад, ингээд бодлогоо гаргасныхаа дараа, тэгээд бид нар худалдааны хууль гаргавал ямар чиглэлээр гаргах ёстой юм бодож хийх ёстой юм шиг байгаа юм. Тэгэхээр үүнийг бол бас Их Хурлын гишүүд маань, ингээд Их Хурлын дарга анхаараад бас энэ бодлоготой энэ худалдааныхаа талаар нэг ойлголтоо нэгтгээд худалдааны талаар ямар

бодлого явуулах юм гэдгээ тодорхойлж байж бид нар энэ худалдааныхаа хуулийг ярих нь зүйтэй байх гэж бодож байна. Жишээлбэл, энэ зүүн Европын орнуудад гарсан нэг сөрөг жишээ байгаа. Энэ бол зүүн Европын орнууд Европын холбоонд ороод, тэгээд худалдааны хууль гаргаад, тэр нь бол нээлттэй бодлого гаргаж явуулсан, тэгээд нөгөө жишээг лэн худалдааны дэлгүүрүүд нь бол бүгд шахагдсан. Нөгөө том сүлжээний бөөний том сүлжээний том дэлгүүрүүд, сүлжээ дэлгүүрүүдэд ингээд шахагдсан ийм бас гашиун туршлага гарсан, жишээлбэл байдаг юм байна лээ. Тэгэхээр бол бид нар энийгээ сайн бодож байж гаргах ёстой л юм шиг байна лээ л гэж бодож байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя, 1 минут.

Б.Баттөмөр: Энэ асуултдаа ер нь нэг сайн бас хариулт авч чадахгүй л байгаад байгаа юм. Тэр нэг компаниудтай хийсэн гэрээ, Ганбат захирал аа, тэр бол бүгд ойлгомжтой шүү дээ. 67000000 тонн нүүрсний гэрээг байгуулчихжээ, 6-г нь нийлүүлж, одоо 61 сая тонны нүүрсний гэрээ байна. Одоо өнгөрсөн жилүүдийн дундаж 20 тонноор ингээд бодох юм бол 3 жил нийлүүлэх нүүрсээ гэрээлчихсэн байна шүү дээ. Энэ биржээр чинь юу худалдах юм бэ? Юу гэж бодож байгаа юм? энэ гэрээнүүдийг хүчингүй болгох юм уу? Үүнийг би асуугаад байгаа байхгүй юу. Энд надад хариулт өгөөч ээ.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, ажлын хэсгийн дарга хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ хууль дээр ажиллах явцад бас энэ компаниудын асуудлууд дээр нэлээн ажилласан. Тэгээд Баттөмөр гишүүний тэр санаа зовоод яриад байгаа тэр хулгайч нар томилчихдог гээд асуудал байгаад байна шүү дээ. Яг үнэндээ бид нар ингээд нэг

захирал нь томилогдоод ямар хүн томилж байгааг та ч мэдэхгүй, би ч мэдэхгүй энэ танхимд сууж байгаа хүмүүс мэдэхгүй байгаад байгаа шүү дээ. Нарийн яривал ЗГ нь өөрсдөө тэр хүмүүс нь яаж байгааг ч мэдэхгүй байна. Цаашаа хараад л нөгөө хүн нь гэрээ хийгээд л байдаг худалдаад л байдаг уул уурхайн бүтээгдэхүүнээ цаашаа харж байгаад л тэр Хятадын компани байна уу, хаанахын компани байна уу, тэр тээврийн компани байна уу, хамаа алга нэгэнтэй нь гэрээ хийгээд л байдаг, ямар үнээр хийж байгааг нь бид нар мэддэггүй. Тэгээд хамгийн гол нь таны яриад байгааг тодорхойлоод бол бид нарын энэ гадаа жагсагчдын ч хүртэл яриад байгаа энэ хулгайнаас ангид байх тэр хулгайчийг томилдоггүй байх, тэр хулгайч нь хулгай хийх боломж ч цаашаа харж гэрээнд гарын үсэг зурдаггүй, нээлттэйгээр энэ биржид худалдаалагддаг энэ бололцоог л бид нар хангах гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бирж гэдэг чинь нөгөө мартагд ... /минут дуусав/

Г.Занданшатар: 80 Ганбат дарга хариулж байя.

Ж.Ганбат: Ийм гэрээ байгуулчихсан, нэгд тэр Чалько гээд 11 оноос бусад нь сая би сая огноонуудыг нь хэлчихсэн юм. Энэ асуудлаар энэ ерөөсөө л энэ 4 томоохон худалдан авагч БНХАУ-ын зарим нь бол төрийн өмчийн компани, энэ компаниудтай бол хэлцэлд орсон. Одоо бид ЗГ-аас бид гэрээний нөхцөлөөр хил нөхцөлөөр, дээрээс нь бид биржээр нүүрсээ арилжина. Энэтэй холбогдуулан энэ өмнө явж байж энэ гэрээнд орох өөрчлөлтийн асуудлууд дээрээ бас хэлцэлд орж, энийгээ өөрчилж гэдэг ийм хүсэлтийг бол энэ худалдан авагч талд бол тавьсан. Худалдан авагч талаас бол нэгэнт гэрээ байгуулчихсан, гэрээний үүргийн биелэлт энэ тэр гээд гэрээний тэр заалт дээрх маргаантай асуудал, маргааныг яаж шийдвэрлэх вэ, энэ тэр гэдэг тийм асуудал ярьж байна. Зарим нэг төрийн өмчийн компани нь бол

манайх бол 100 хувь Хятадын БНХАУ-ын ТӨК-аа, бид энэ асуудлуудыг бол бас ЗГ ... /минут дуусав/

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн бол энэ зөв зүйтэй асуудал яриад байгаа юм. Тэгэхдээ агуулга нь ер нь хувьчилж бол болохгүй ээ, Таван толгойг хувьчилж байгаа юм ерөөсөө байхгүй. Тэр 18,43 хувиа л олон нийтийн хяналтыг тогтооё оо л гэж байгаа шүү дээ, тийм ээ.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ биржийг би хуулийг бол анхнаас нь дэмжсэн. Энэ хууль хэрэгтэй, яагаад гэвэл би энэ нүүрсээр зарагдаж байгаа гэрээнүүд ил тод бол, үнэ нь ил тод бол, тэр нөхцөлүүд нь ил тод бол өөр янз бүрийн хувилбарууд байвал сонголттой байг гэдгээр л биржийг сонгож байгаа юм. Үүнийг ярихын хажуугаар өмчлөл рүү нь дайрч болохгүй ээ л гэж хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ чиглэл нь зөв байгаад энэ үг томьёо нь буруу байна. Өнөөдөр одоо яах вэ, намайг юу ч ярьж болно, асуудлаа ойлго, асуудал руугаа ор, унш, асуудал л ярьж байгаа. Би асуудал ярихаар өөдөөс миний хувь хүн рүү ярьж байвал та нар асуудалдаа ялагдсан байна л гэсэн үг. Тэгээд би 3 асуулт асууя.

1 дүгээрт, мэргэжлийн хүмүүс нь хариулсан нь дээр байх. Галсандорж доктор байна уу, хариулсан дээр болов уу. Манай энэ экспортын бүтээгдэхүүний яг чанар их яригддаг. Жонш, зэс, төмөр гээд олон улсын стандартад хүрсэн үү, ер нь хүрсэн юм байгаа юу, хүрээгүй бол яг ямар арга хэмжээ авах гэж байгаа вэ? яг үнэ гэрээ яриад ирэхээр л стандартын биш ээ гээд л өөрсдийнхөө нүхээр сүвээр хулгайгаа хийгээд явчихдаг, бүр зовоодог, мөн ухаантай шүү.

2 дугаар асуулт, Монголын экспортын уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын бирж дээр арилжаалах

боломж нь хэр байна? Одоо энэ хууль батлагдсаны дараа хэлэлцэх эсэхийн эцсийн шатандаа явж байна шүү дээ, ямар бололцоо байгаа вэ?

3 дугаар асуулт, энэ биржийн тухай хуулийг эцсийн хэлэлцүүлэг явж байгаа учраас энэнтэй батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг ав гэдэг дээр би үг үсгийг нь уншъя. 1 томъёоллууд нь тоо нь жоохон зөрчсөн байгаа учраас сүүлийн шууд томъёоллыг нь уншихъя.

4 дүгээрт, одоо миний олсон хувилбар дээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн гаргасан энгийн хувьцааны хяналтын багцаас доошгүй хувь нь төрийн эзэмшилд байх гэдэг үг орж ирсэн байгаа. Энэ чинь нөгөө 34, 66 хувийг яриад байгаа шүү дээ. Энэ миний ойлгож байгаа зөв үү? Энэ яг ард иргэдийн өмчлөл рүү дайрч орж байгаа хувилбар яг мөн байна аа, энэ томъёоллыг нь өөрчлөөч ээ, хасаач ээ гэж гуйсан. Цэрэнпунцаг гишүүн ахалж байсан, ахалж байсан, гар өргөөд хяналт сайжруулах гэж байгаа юм гээд тэгээд дэмжээд явсан. Тэгээд би Эдийн засгийн байнгын хорооны гишүүн биш учраас хэлэлцэх асуудал дээр би орох эрхгүй, санал өгөх эрх байхгүй, тэгээд би гараад явсан. Би бол харин хэлэлцэх үгүй эсэх дээр л би орж саналаа хэлсэн.

2 дугаарт, Эрдэнэс таван толгой компанийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн гэсэн ийм заалт орсон. Тэгээд бүртгүүл ээ гэж байгаа юм. Энэ бол цэвэр энэ өдөр энэ ард түмний өмчийг худалд аа гэсэн санаа. Нүүрсчдийн нам, мөнхийн нүүрсчин нам болж хувирна. Энэ асуудлыг би эргэж хараач ээ, энийгээ болиоч ээ л гэж гуйсан. Үүнийг чимээгүйхэн шиг явуулчихаад дараа нь та нарын бөгсөн дээр хүйтэн жсин тавиад алж өгч байвал харин та нарын яриад байгаа ёстой нөгөө пиар нэр хүндийн төлөө явах болж байна. Би зүгээр энийгээ урьдчилж яриач

ээ, болохгүй шүү гэдгийг хэллээ. Хэлэлцэх асуудлаасаа хасаад өгөөч ээ гэж гуйлаа.

3-т нь, иргэдийг эзэмшиж буй хувьцаагаа бусдад бэлэглэх, өвлүүлэх болон хувьцаа эзэмшигчдийн эрхээ эдлэх боломжоор хангана гэж байгаа юм. Өнөөдөр сангийн аж ахуй хувьчлагдсан, комбайнчин, тэр ногоочид нь хувьчилсан, өнөөдөр 1-2 гэр бүл л тэрийг эзэмшдэг. Ийм байдал гаргахгүйн тулд эднүүсийгээ эргэж хараач ээ л гэсэн. Тэгвэл өнөөдөр зүгээр эргэж харсан үүнийг чинь бодолцсон гэвэл тэгээд бол оо. Үүнийг чинь өнөөдөр та нарыг завдсан байж болно, тэнэг хүмүүсийн захиалгаар үүнийг оруулж ирсэн байж болно. Хамгийн гол нь та нар үүнийг ирэх 7 хоног руу хойшлуулчихсан байгаа. Би өнөөдөр үүнийг яагаад ярьж байна вэ гэвэл эцсийн хэлэлцүүлэг учраас энэ хуулийг батлагдсантай холбогдуулан гэдэг утгаар нь би яриад байгаа байхгүй юу. Мэдээж Их Хурлаас, Их Хурлын даргаас ч юм уу, Их Хурлаас ийм үзэл санаа хэлээгүй байх, тэр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгээс ийм нэг санал явж байсныг Ганбаатар гишүүн ч өөрөө бас саналыг хэлсэн. Байнгын хороон дээр энэ саналыг хүлээж авсан, асуудлыг хойшлуулсан. Ажлын хэсэг дахиж хуралдсан. Ингээд таны тэр санаа зовж байгаа зүйлүүдийг бүгд хасагдсан шүү, бүгд хасагдсан юм. Байнгын хороо удахгүй ингээд хуралдах байх, дараа 7 хоногт хуралдана. Тэгээд энэ асуудал орж ирээд дахиад хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний төсөл гээд, ингээд тухайн арга хэмжээний тухай гээд ингээд тогтоол орж ирнэ. Энд би бүр үг үсгээр нь танд хэлж өгье. Таны саяын санаа зовоод байгаа асуудлууд энэ дотор байхгүй, энэ дараагийн чуулганаар орж

ирэхэд угаасаа танаар дамжаад ингээд ороод ирнэ.

Компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэх, ЗГ-ын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэн тэгш шударга хүртээх зорилгоор Эрдэнэс таван толгой ХХК-ийн иргэдэд эзэмшсэн хувьцааг эргэлтэд оруулах гэж байгаа шүү. Энэ нь өөр хувьцаа, хувьцаа яригдаагүй, зөвхөн 1072 хувьцаагаа ярьж байгаа шүү. Тэгээд Хөрөнгийн биржид бүртгэлтэй, нээлттэй ХК болгох хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын ЗГ Л. Оюун-Эрдэнэд даалгасугай гээд ингээд орж ирж байгаа шүү. Тэр элдэв янзын юу, хувь энээ тэрээ гэсэн асуудал ерөөсөө байхгүй шүү.

Тэгэхээр Байнгын хороогоор дахиж орж ирнэ, та тэр Байнгын хороон дээр орж ирээрэй, тэгээд энэ хувь дээрээ хувилбар дээрээ хэдүүлээ дахиад бас ярилцаад явах асуудал маань нээлттэй байгаа юм шүү, тийм.

Г.Занданшатар: Цэрэндамбын Цэрэнпунцаг гишүүн, Байнгын хорооны дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ганбаатар гишүүн ээ, тэр бид нарын Байнгын хорооны хурал дээр чинь нөгөө техникийн саатал болоод бид нар гар өргөөд явсан шүү дээ. Түүн дээр олон асуудлууд хэлэлцсэн, тэгээд бас та зарим юмыг нь нөгөө Байнгын хороон дээр дэмжээд явчихсан гэж ойлгоод байх шиг, андуураад байх шиг байна шүү. Дараагийн 7 хоногт та Байнгын хорооны хурал дээр орж ирээрэй, сая ингээд ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн сая ерөнхийдөө төслөө энэ чинь 2, 3 төрлийн, 2, 3 хувилбар явж байгаад, тэгээд бид нар энэ чинь хэлэлцэж ярилцаж байгаад ингээд тунгааж байгаад гаргаж байгаа асуудал шүү, нэгд.

2-т, хамгийн гол нь энэ Байнгын хорооны тогтоолыг агуулгыг нь ойлгомоор байгаа юм. Бид нар ард түмнээ эзэнд баялагтай эзэн нь ээ гээд ингээд нэг ийм тоотой нэг хэдэн хувьцаатай гээд, үгүй ээ, тэгээд эзэн нь юм бол энэ компанийнхаа ХК юм бол тэр хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд ордог юм уу? Та энэ дээр нь анхаарч үзсэн үү? Үгүй ээ, миний хувьцаа захирал нь энэ нөхөр хэнийг тавих гээд байна? хэн хэн энд ажилд орох гээд байна? ТУЗ нь хэн хэн орж байна гээд тэр эзэд нь очоод тэнд хуралдаа оролцох бололцоо өнөөдөр байна уу? Тэгээд энэ компанийг удирдаж авч явах гэж одоо бид нар энэ хэдэн жил энэ ямар онигоо шиг юм болоод өнөөдөр ингээд нэг ард түмнийхээ өмнө ингээд сууж байна аа. Үгүй ээ, үүнийг чинь үндсээр нь засъя аа, тэр эзэд нь өмчийн эзэд нь энэ өмчийг нь захиран зарцуулж, тэр үйл ажиллагааг нь авч явах, удирдаж авч явах хүмүүсээ сонгодог, түүнийг нь хянадаг, энэ бололцоог нь нээж өгье өө л гэж байгаа юм шүү дээ. Энэ чинь хаалттай болгож хаячхаад тэгээд та нар эзэн нь шүү гэж хэлчхээд ард түмэнд, тэгээд энэ хэдэн дарга нар, хэдэн эрх мэдэлтнүүд өөрсдийн ах дүү, төрөл төрөгсөд, эргэн тойрон цүнх барьдаг, барьдаггүй нөхдөө аваачиж тавьчхаад энэ асуудал өнөөдөр үүсээд байна шүү дээ, Ганбаатар гишүүн ээ. Та шударга ёс их ярьдаг хүн, үүнийг С.Ганбаатар гишүүн ээ, уучлаарай, уучлаарай, энэ олон Ганбаатар байдаг учраас ингээд андуурагдаад байдаг юм.

Ийм учраас манай Ганбаатар гишүүн бас энэ талаар их ярьдаг хүн, тэгэхээр бид нар энэ алдаа энэ согогийг засъя гээд бид нар эздэд нь л нээж юмыг нь өгөх гээд байгаа юм л даа, эрхийг нь нээж өгье гээд. Тэгээд энд яагаад та бүхэн ингэж зэрэг зэрэг ингэж нэг 2 үг үсгэн дээр орооцолдуулаад л, ингээд л үүнийг ингээд төөрөгдүүлээд байгаа юм бэ. Ард түмнийг, эсвэл ийм их тэнэг гэж боддог юм уу, басдаг юм уу. Тэгээд өөрсдөө энд ард түмнийг юмаа мэддэггүй, үрээд хаячихгүй, 2, 3 настай

хүүхдүүд нэг мөнгө төгрөгийг нь өгчихөөр зэрэг л аваад үрээд хаячих гэж байгаа, тэгээд нэг том аавууд, ах нар, гэрийн эзэд, гэрийн эзэд энд суучхаад тэгээд тэр хүүхдүүд мөнгө хүртэж магадгүй, та нар юу яриад байгаа юм гээд бид нар яриад сууж байгаа юм шиг харагдаж байна. Энд ард түмний эцэг эх сууж байгаа гэж өөрсдийгөө ойлгоод байдаг юм биш биз дээ? бид нар. Би бол төлөөлөл байгаад тэр ард түмэн юу хүсэж байгаа юм, ард түмний санаа бодлыг энэ илэрхийлэх ёстой гэж бодоод суудаг юм шүү дээ. Тэрнээс тэд нарын хөрөнгө мөнгийг нь өмнөөс нь зарцуулдаг, энэнээс илүү өөрсдийнхөө ухаантай гээд бодсон, ард түмнээс илүү мэргэн цэцэн гээд бодчихсон ийм хүмүүс энд цуглаад, тэгээд өмнөөс нь өмч хөрөнгийг нь бид нар зарцуулна. Зөв хүмүүс аваачиж тавьж, тэгээд сайн сайхан болгоно гээд бид нар өдийг хүртэл ингээд солиод хэчнээн удаан солив, хэчнээн хулгайчид солив ийм л байна шүү дээ. Тэгээд үүнийг агуулгаар нь ингээд энэ чиглэл рүү бодлого гаргаад энэ чиглэл рүү УИХ-аас тогтоол гаргаад чиглэлийг нь ЗГ-т өгөөд үүнийг та нар энэ рүү ажиллаадхаач ээ гээд өгөх гэхээр зэрэг ингээд ингэж босон суун ингэж урдаас эсэргүүцээд байгааг ерөөсөө ойлгохгүй юм.

Тэгэхээр яадаг юм эндээ, бид нар эрх барьж чадахгүй байна. Өнөөдөр дараагийн эрх барьдаг болохоороо тэр ТУЗ-ыг нь тавьдаг болохоороо хулгайчдыг аваачиж тавьдаггүй болохоороо өөрсдийнхөө хүмүүсээрээ очиж тавьж идэх болтол ингээд байхгүй болгочих вий гэж айгаад байгаа юм уу. Ямар учиртай юм. Энийгээ ард түмэнд та нар үргэлж ярьж байдаг улсууд бас тайлбарлаж хэлээрэй.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Галсандорж гуай хариулъя, 89. Асуулт асуугч нь хариулагчаа сонгосон юм байна.

Д.Галсандорж: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Манай энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржээр эхний ээлжид нүүрс, төмөр, жоншны баяжмалыг арилжаална гэж тооцож байгаа. Тэгээд дараа нь 2 дугаар ээлжид нь зэсийн баяжмал, гянт болд бусад бүтээгдэхүүнийг арилжаалахаар энэ шат дараалалтай байгаа. Зүгээр чанарын хувьд манай өнөөдөр экспортод гарч байгаа бүтээгдэхүүн, нүүрсний чанар мэдээж манай өрсөлдөгч Австрали юм уу, Индонезийн нүүрстэй харьцуулахад бага чанартай байгаа. Гэхдээ нүүрсний чанарын ангиллыг сайжруулах талаар УУЯ стандартын газартай сүүлийн 2 жил идэвхтэй ажиллаад, нүүрснийхээ ангиллыг шинэчилсэн байгаа. Энэ ангиллаар бол Хятадын манай худалдан авагч нь Хятад байна шүү дээ. Хятадын зах зээлд нийлүүлэх Хятадын чанарын стандартад ойртож чадсан. Хэрвээ манай нүүрсийг бусад орнууд руу барууны Япон гэдэг юм уу, Солонгос гэдэг юм уу бусад орнууд руу нийлүүлбэл тэр орнуудын стандартад ойртуулах шаардлага байгаа.

Жоншны баяжмалын хувьд манайд ажиллаж байгаа ганц том үйлдвэр чинь Монголросцветмет ТӨК-ийн Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр байгаа. Өнөөдөр гаргаж байгаа 2 төрлийн жонши гарч байгаа металлургийн жонши, флотацын. Флотацын баяжмалын жонши 95 хувийн агуулгатай гарч байгаа. Энэ үйлдвэр ер нь ОХУ-ын зах зээлд зориулагдсан учраас л ийм стандарт Оросууд худалдан авдаг. Оросын химийн үйлдвэрүүд, хөнгөн цагааны үйлдвэрүүд худалдан авдаг. Дэлхийн стандарт бусад орон руу гаргая, Хятад руу, Солонгос, Япон руу гаргая гэвэл үүнийг 97 хувь хүрэх ёстой. Энэтэй холбогдуулаад жишээ нь хүнд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр гэж хийсэн,

флотацын баяжмалын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэх мэтчилэн.

Зэсийн баяжмалын хувьд Эрдэнэт үйлдвэр 40 хэдэн жил экспортолж байна. Бүтээгдэхүүний чанар, баяжмалын чанар Хятадын зах зээлд Эрдэнэт, Оюутолгой, Хятадын зах зээлд худалдаж авч байгаа 22, 24 хувийн агуулга гэдэг чинь ний нуугүй хэлэхэд их бага агуулга шүү дээ. Чилиүд бол 45, 35-45 хувийн агуулгатай баяжуулан нийлүүлж байгаа.

Тэгэхээр 2 дугаарт энэ Оюутолгойн орд газраас нийлүүлж байгаа, хамгийн орчин үеийн технологитой үйлдвэр баригдсан гэж байгаа, харамсалтай нь өнөөдөр Хятадын шаардлагыг хангаж чадахгүй, энд 7 торгуулийн элемент төлөөд хүнцэл төлөөд байж байна шүү дээ, энэ энд чинь бол 0,5-аас жилд жилд 2 сая долларыг торгуульд төлөөд явж байгаа. Энэ харамсалтай нь үүнийг энэ дотор чинь флор, фтор, хар тугалга, цайр гэх мэтчилэн, тэгээд хүнцэл ийм олон торгуулийн юмнууд байгаа. Зүгээр бэлэн түрүүчийн нэг асуудал байна лээ, Хятадын зах зээлийн чанарын шаардлагыг бол хангаж байгаа, цаашидаа техник технологио сайжруулаад чанарын түвшинг дээшлүүлэх шаардлага маш их байгаа тийм.

Зүгээр бэлэн бүтээгдэхүүн зүгээр олон улсын бирж дээр манай экспортын бүтээгдэхүүн арилжаалж болох уу гэж байна. Өнөөдөр жишээ нь олон улсын бирж гээд Шанхайн металлын бирж, Лондонгийн металлын бирж гээд энэ дээр арилжаалах арилжаалж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя, 1 минут.

С.Ганбаатар: Цэрэнпунцаг гишүүний хэлсэнтэй холбогдуулаад хэлье. Та нар чинь уг нь эрх баригчид, Байнгын

хорооны дарга гэдэг бол доороо зөвлөх, ажлын алба, хар мянган мундаг ухаантай хүмүүстэй. Мань мэт нь ерөнхий юм ярьж, үзэл санаа асууж болно. Та нар яг тоо баримт, яг үг үсгээр нь хариулах ёстой. Гэтэл зөрүүлээд би үг үсгээр нь яриад байдаг. Та нар ерөнхий юм яриад байна аа, наадхаа уншаач ээ, хачин гоё ярьж байгаа юм чинь энэ дээр байхгүй байна л гэж хэлээд байгаа юм.

Харин тэгээд сая Бат-Эрдэнэ гишүүн хэллээ шүү дээ, тэр ярьж байсан, энэ юмнуудыг өөрчилчихсөн, энэ үнэхээр болохгүй юм байсан, энэ дээр бид эргэж харсан, энэ бол би хүсэж байгаа зүйл. Тэгэхгүй яг энэ чигээрээ орох юм бол таны ярьж байгаа юм чинь энэ дээр алга байна, бүр 100 хувь эсрэгээрээ ярьж байгаа байхгүй юу. Та бол ерөөсөө гаднынхны гар хөл болчихсон юм шиг л юм болчих гээд байгаа. Таныг аврах гээд байна шүү дээ би чинь.

Г.Занданшатар: Цэрэнпунцаг гишүүн хариулъя, тэгэхдээ өнөөдөр энэ асуудал орж ирээгүй, яг аль нь зөв буруу биш болохоор. Орж ирээгүй байгаа юмыг яриад байхаар би нөгөө аль нь үнэн яриад байгааг ч мэдэх юм алга.

Ц.Цэрэнпунцаг: Ганбаатар гишүүн ээ, та бид 2 чинь сайхан ойлголцдог, тэгээд яах вэ, нэг нь нэг жсоохон шартай л юм шиг байна, ялах, ялагдах яах вэ. Бид нар энэ ажлын хэсэг дээр, ингээд ажлын хэсгийн ахлагч маань бас томилолттой, ажилтай байсан, ажлын хэсэг дээр хувилуулж яриад эхний нь орж ирсэн ажлын хэсэг дээр байсан хувилбаруудыг ярьж байгаад бид нар түрүүчийн Байнгын хороогоор наадахыг чинь бид нар баталж гаргаагүй шүү дээ. Та үүнийг мэдэж байгаа, тийм ээ. Тэгээд энэ ажлын хэсэг дээр гишүүд, ажлын хэсгийнхэн ярилцаж байгаад ингээд хувилбарууд гаргасан юм, одоо дараагийн 7 хоногт хэлэлцэх гэж байгаа Байнгын хороогоор. Тэгээд эцэслэн батлахтай холбогдуулж энэ тогтоолын үндэслэл гаргая гэж байгаа учраас таныг 2

дахийн Байнгын хороон дээр харин идэвхтэй оролцож, энэ санаа оноогоо нарийвчилж хэлээрэй гэж байгаа юм.

Саяын миний гэсэн агуулга бол энд, бүхэл бүтнээрээ байгаа. Одоо энэ сүүлийн хувилбар дээр, та уншаарай. Ард түмэнд тэр эрхийг нь нээж өгөх тэр бололцоог нь, тэр чиглэлийг нь ЗГ-т ... /минут дуусав/

Г.Занданишатар: Ер нь бол өмнөх хэлэлцүүлгийн үеэр манай гишүүд идэвхтэй оролцсон байх гэж найдаж байна. Миний өгсөн чиглэл бол энэ 1072 хувьцаагаа иргэд энэ хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, эндээ хяналт тавих эрхтэй болъё оо, дарга нар гишүүдийн хяналтаас илүү, ард түмний хяналт илүү хүчтэй. Албан тушаалтны хяналтаас, ард түмний хяналт илүү хүчтэй байна. Ийм учраас олон нийтийн хяналтад оруулах л асуудал ярьсан, ил тод бол байлгах асуудал ярьсан.

2 дугаарт нь 2012 оноос хойших төрсөн хүүхдүүдэд Эрдэнэс таван толгой хувьцааг эзэмшүүлэх чиглэл санал өгье өө гэж ярьсан, үүнийг харин тогтоолын төсөл тусгах байх. Тэр болохгүй байгаа юм уу, ядаж тэгээд судалж, энэ асуудлыг судалж зохицуулах бололцоог тэгэхгүй бол энэ нөгөө яг 12 оноор тасалбар болгоод хоёр сая гаруй иргэн үнэт цаасны тооцооны төв дээр чинь бүртгэгдчихсэн байгаа, тийм ээ, түүнийг хэлсэн. Тэгээд энэ олон нийтийн хяналт олон түмний хяналтад оруулах асуудал ярьж байгаа. Түүнээс хувьчлах, ХК болгох, нээлттэй болгох л асуудал ярьж байгаа болохоос биш хаалттай байлгаад байж болохгүй юм л гэсэн ийм асуудлууд яригдсан шүү дээ. Эдийн засгийн либералчлалын агуулгаараа ч гэсэн тэр.

Тэгэхээр үүнийгээ бол эцсийн хэлэлцүүлэгт тэр дагалдаж гарах тогтоол дээрээ гаргаарай, одоогоор орж ирээгүй учраас бид нар яг мэдэж ярих бололцоогүй байгаад байна л даа. Тэгээд

орж ирээгүй юмыг бид нар нөгөө төрөөгүй хүүхдэд төмөр өлгий гэгчээр хэлэлцээгүй байгаа асуудлыг тойрч хэлэлцээд яах вэ.

Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Баярлалаа. Яах вэ, бас ийм хуулийг хэлэлцээд ингээд эцсийн шатанд оруулаад ярилцаж байгаа нь их сайн байна. Цэрэнпунцаг гишүүний Цэрэнпунцаг даргын яриад байгаа бол бас энэ Ардын намынхны үг аманд ярьдаггүй юмыг яриад байх шиг байна, их сайн байна, тийм. Гэхдээ АН-ын үед тэр байрыг хувьчилсан, эзэнд нь өгсөн, малыг хувьчилж, малчдад нь өгсөн иймэрхүү үр дүнтэй ажлууд Хөрөнгийн биржийг бий болгосон, ийм үр дүнтэй ажлууд хийгддэг ээ. Тэр эцсээ хүртэл яваад үр дүнгээ өгөөд ингээд явдаг. Та нарын гараар нэг иймэрхүү юм орчихоороо юу ч биш болоод дуусдаг шүү, юу ч биш болоод дуусдаг.

Одоо энэ уул уурхайн биржийг байгуулаад ажиллуулаад, ингээд эхний ээлжид нүүрсээ борлуулж эхлэх юм байна. Дутуу дулимаг юм их байна шүү. Зүгээр одоо өнөөдөр ард түмний шахалтад ороод нэг зүсээ хувиргаад, ахиад идэх, уух боломжийг үлдээсэн нэг тиймэрхүү л юм хийх гээд байна, та нар. Үүнийгээ бас эргэж хараарай, гэхдээ эцсийн шатанд орчихсон байна. Миний хэлж байгаа, ярьж байгаа энэ протоколд үлдэх байх аа.

Яахаараа дандаа нэг 30 хувь оруулж ирдэг юм бэ? Нэг зэрэмдэг юмнууд. Энэ чинь хяналтаа тавихын тулд үнийг тогтоохын тулд бараг 50-аас доошгүй хувь л байх ёстой шүү дээ. Хөри зэргэлдээ урд талын 4 том компани л худалдаж авч байна гэж байна. Энэ нүүрс чинь дотроо олон төрөл. Тэр компаниуд үгсээд нэг л үнэ тогтоовол яах юм, яаж ч чадахгүй шүү дээ, та нар. Дэлхийн зах зээлийн үнээр өгөөгүй гээд та нар хариуцлагаа хүлээх үү? Бирж чинь дэлхийн зах зээлийн үнэд хүргэж

байж өгч чадаагүй бол энэ хууль чинь юу ч биш болно оо. Тэгээд нэг 30 хувийг нь өгсөн нэр зүүгээд ард түмний амьг хаагаад 1072 хувьцааг нь амь орууллаа гээд тэр чинь 14, 15, зургаахан хувь байгаа биз дээ. Өшөө нэмээд хувьчил л даа. Олон нийтийн хяналтад бүр оруул л даа.

Тэгээд түүнээс гадна энийгээ яаж хийх гээд байгаа юм. Одоо тэр БЭТ томилж байна, өмнө байсан тэр системээ ажиллуулж чадаагүй байна шүү дээ. ТУЗ гээд, тэр чинь компанидаа хяналт тавьж байх ёстой шүү дээ. Тэр Төлөөлөн удирдах зөвлөлийг нь ажиллуулж чадаагүй, яагаад ч ажилладаггүй байсан юм яасан юм, тэр нээрээ.

91 оны хуулиар Үндсэн хууль 92 онд батлагдсан. Бүгд Найрамдах Монгол Ард улс гэж байхад л баталсан хуулиар БЭТ-үүдийг томилж байна. Оюутолгой дээр хэзээ БЭТ томилох гэж байна? Нөгөө төрийн 34 хувь нь байгаа биз дээ? нөгөө талыг нь Рио тинто бүрэн эзэмшигдсэн гэж байгаа, тэрийг хянаж мэдэж чадах уу? энэ болох уу? Энэ чинь гадаадын хөрөнгө оруулалтуудыг шахааж зайлуулж байгаа ч юм уу, үл итгэх байдлыг бий болгож байгаа ч юм уу? Ингэж нөлөөлөхгүй юу? Аман дээрээ гоё сайхан юм ярьдаг, хийж байгаа ажил дээрээ амьдрал дээрээ наадах чинь буухгүй байна. Яг тэр дэлхийн жишигт нийцүүлсэн ийм хуулийг оруулж ирээд батлуулах ийм сонирхол байдаг юм уу, байдаггүй юм уу, та нарт. Зүгээр л энд л яриад байхаас биш, дандаа нэг зэрэмдэг юм, эрэмдэг зэрэмдэг юм хийчихээр чинь энэ чинь ажиллах ч үгүй, дараа нь юу ч биш болоод л хоцорно. Тэгээд л нүүрээ хувиргаад л зүсээ арай өөр хувцас өмсөж гарч ирээд л ахиад нөгөө луйвраа явуулах ийм боломжоо хийгээд л хэн нэг рүү тэрийгээ түлхэн зайлуулсан ийм л үйл ажиллагаа болчих вий гэж эмээж байна. Бараг тэр лүүгээ явна даа, явна. Наадахаа арай гүйцээж хийсэн бол арай дээр

байсан юм. Ийм эрэмдэг зэрэмдэг юм хийхээ боливол яасан юм, ер нь.

Одоо уянгалж өгнө л дөө, ийм гоё гоё юм хийчихлээ гээд.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Хариулъя, гоё яг бодитой хариулъя аа, Ганбат гишүүн ээ, уучлаарай.

Тэр 30 хувь энэ тэр бол хуульд байхгүй шүү, Ганбаа гишүүн ээ. Ганбат гишүүн сонсохгүй гараад явчихсан учраас хуулиа унш энэ тэр гээд янз янзын юм яриад яах вэ. Хуульд бол 30 хувь гэдэг үг, өгүүлбэр байхгүй. Зүгээр эрсдэл байгаа учраас журмаараа бид нар бас 7 сарын 01 хүртэл өнөөдөр Эрдэнэс таван толгой компани дээр Бүрэн эрхт төлөөлөгч томилогдсон байгаа. Тийм учраас ажил нь засагдаад явж байгаа. Өнөөдөр шууд 100 хувийн нүүрсээ биржээр зарах нөхцөл бололцоо байхгүй байна, гэрээний үүргээр гүйцэтгэх гээд олон зүйлүүдийг өмнөх удирдлагууд хийсэн зүйлүүдийг бид нар нэг мөр шууд өнөөдөр чадахгүй ээ гэж хэлж болохгүй байна. Тэгэхээр энэ чинь алхам алхмаар явагдах ёстой. Тэгэхээр бид ширээний ард сууж, нөгөө талтайгаа хэлцлээ хийж, энэ үүргийг ингэж биелүүлнэ, энэ зарчмыг ингэж явна, ийм ийм боломжоор хил дээр аваачиж өгөх үүрэгтэй, тэгэхээр зарж байгаа нүүрснийхээ тодорхой хувийг зарна гэсэн ийм зүйлээр л 30 хувь гэдэг зүйлийг ярьж байгаа юм. Түүнээс биш 30 хувь гэдэг зүйл хаана ч байхгүй байгаа. Үүнийг бас журам дээр ч байхгүй, хууль дээр ч байхгүй.

Эрэмдэг зэрэмдэг гэдэг дээр хэлэхэд бол олон зүйлүүдийг засахын төлөө ЗГ бүх нөхцөл бололцоогоо дайчлаад ажиллаж байна. Харин саад болох гэсэн олон зүйлүүдийг би байгаа гэдгийг түрүүн хэлсэн. Энэ зүйлүүдийг бид нар бас зарим зөв зүйлүүдийг хэлж

байгаа, асуудалд зөв хандаж байгаа зүйлүүдийг бид авч ажиллаж байгаа. Баярлалаа.

Бат-Эрдэнэ гишүүн гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүн тэр Таван толгойн юу юм шиг түрүүн тэгээд хэлчих юм 34 хувь, энд чинь уул уурхайн бүтээгдэхүүний биржийнх нь 34 хувь нь төрийн эзэмшилд байж болно л гэж байна шүү дээ. Тийм асуудал тэр юун дээр яригдаад байсан шүү дээ, наана чинь тийм ээ. Бирж ярьж байхад тэгэхээр Таван толгойн хувь нь тийм болж байгаа юм шиг л тийм болгосон.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би энэ Уул уурхайн биржийн тухай хуулийг дэмжиж байгаа, ажлын хэсэгт ч байгаа. Тийм учраас олон нийтэд бас мэдээлэл өгөх замаар энэ асуулт асуух замаар бас энэ олон нийтэд бас тодорхой мэдээллийг өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Тэгэхээр ХАА-н бирж байгуулагдаад үйл ажиллагаа явуулж байгаа. Тэнд ямар яаж бизнес явдаг вэ гэхээр ХАА-н биржээр орж заавал малчдаас одоо малчид ноолуураа бирж дээр тавингуут нь тэндээс нь нөгөө ААН-үүд худалдаж аваад тэгээд одоо экспортод гаргах ийм зорилготой. Гэтэл харамсалтай нь гажуудсан. Бүх ноолуурын ченжүүд бүх ноолуурын компаниуд бүгдээрээ хөдөө орон нутгаар өөрсдөө ноолуураа явж авчирчхаад тэгээд авчирсны дараа гаалийн бүрдүүлэлт хийх болсон чинь ХАА-н биржийн зөвшөөрөл аваад ир гэдэг. Тэгэнгүүт нь очингуут нь нөгөө нэг бүх ХАА-н бирж дээр явсан ноолуур нь тэнд зарагдсан гээд ийм хуурамч баахан юм хийж бүрдүүлж аваад тэгээд тэрнийхээ төлөө нэг баахан хуурамч бичиг баримт бүрдүүлснийхээ төлөө 1,25 хувийн шимтгэл төлдөг. 1,25 хувийн шимтгэл. Юу ч хийдэггүй, зүгээр цаас өгдөг. Тэгээд

өнөөдрийн жишээ нь 10000 тонн ноолуур энэ жил бэлтгэсэн байлаа гэхэд энэ жил бэлтгэсэн л дээ, тэрний 2000 тонныг нь бол дотооддоо бүтээгдэхүүн болоод эцсийн бүтээгдэхүүн болж байгаа юм. Тэгээд 8000 тонн нь угаасан болон самнаснаар гарч байгаа юм. Тэр гарсан бүтээгдэхүүн болгоныг жишээ нь 1 килограмм ноолуур 90000 төгрөг байлаа гэхэд заавал 110000-аар үнэлнэ ээ гэж байгаад, 110000 болгож байгаад тэгээд түүнийгээ одоо 1,25-аар авах дээр нөгөө зүгээр байж байсан, юу ч хийгээгүй ХАА-н бирж 6600000000 төгрөгийг зүгээр, зүгээр тэр нэг малчдын орлогоос малчдад очих ёстой орлогоос, дээрээс нь компани, ААН-ийн орлого болох ёстой орлогоос тэр ченжүүдийн зовлон үзэж цуглуулж байгаа ченжүүдийн орлогоос дээрэмдэж байгаа байхгүй юу. Ийм юманд л энэ ХАА-н биржийг оруулмааргүй байна. Тэгээд ХАА-н бирж, одоо тэр ХАА-н бирж яаж ноос ноолуур, арьс шир, тэгээд л тэр самар энэ тэр чинь бүгдээрээ яг нөгөө нэг хүн болгонд орлого нь очиж байдаг, хүн болгоныг мөнгөтэй болгож байдаг тийм зүйл байхгүй юу.

Гэтэл өнөөдөр энэ ХАА-н бирж юу, уул уурхайн бирж яах вэ гэх дээр уул уурхайн бүтээгдэхүүн зарна, компани томорно, нийт ард түмэнд очихгүй, татвар маягаараа жоохон очих байх, ийм л юм болох юм. Тийм учраас энэ дээр энэ шимтгэл 0,1 гэж байгаа юм. Энэ 0,1 чинь тэгээд энэ дараа дараагийн энэ бирж чинь томрох тийм боломж байгаа юм уу, жоохон нэмэх боломж байна уу, 0,2 ч юм уу, тийм ээ. Ийм болгох боломж байна уу? Тэгж байж наадах энэ бирж чинь өөрөө хүчтэй, дээрээс нь гадаад харилцаа сайтай байж байж энэ бирж хүчтэй явна уу гэхээс нөгөө нэг ААН-үүд хамгийн хямдхан үйлчилгээ үзүүлнэ гэдэг энэ зарчим дээрээ явах юм бол тэгээд нөгөө нэг төрийн нэг ийм хамгийн бүтэлгүй тогооноосоо гардаггүй тийм л байгууллага болж хувирах гээд байгаа юм. Тийм учраас биржээ хэдэн хувиар, биржийнхээ шимтгэлийг хэдэн хувь болгох юм бэ? 0,1 чинь багадаж байна.

Хэрвээ зарчмын зөрүүтэй санал аваад чиглэл авах юм бол энэ дарга дээр хэлүүлчих хэрэгтэй.

2 дугаарт нь, заавал ААН-үүд, уул уурхайн компаниуд заавал хөөе, Цэрэнпунцаг гуай, уул уурхайн бирж заавал энэ биржээр орох уу? уул уурхайн компаниуд заавал биржээр орж бүтээгдэхүүнээ зарах юм уу, заавал орохгүйгээр бүтээгдэхүүнээ зарах боломж энэ хуульд тусгагдсан уу? Энэ 3 асуулт.

Дээрээс нь бас нэг асуулт чинь. Ийм асуултууд байна. Би тэгээд ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Пүрэвдорж гишүүн их зөв зүйтэй зүйлүүдийг хөндөж байна аа, сүүлийн асуултаас нь хариулъя. Заавал гэдэг зүйл дээр зөвхөн төрийн компаниуд байгаа, хууль ч ялгаагүй байхгүй юу, журам ч ялгаагүй, хувийн компаниудад хамааралгүй ээ гэсэн үг. Энэ дээр шууд хариулт авчихсан байх гэж бодож байна.

0,1 хувь дээр бол зөвхөн журам дээр бид нар зүгээр арилжаанд оролцсон тохиолдолд л авна шүү дээ. Ялсан тохиолдолд 0,1 хувийн шимтгэл авна. Түүнээс биш тэр бичиг баримт гаргаж өгөх дээр бол огт хамааралгүй. Тэгээд 0,1 хувийн шимтгэлийг энэ дээшээ явчхаж магадгүй гэж үзсэн учраас 0,1 хувиас дээш байлгахгүйн тулд л 0,1-ийг журам дээр тавьж өгсөн.

Одоо нүүрсний 1 доллар 2 доллар гээд нэг явчихдаг шиг ингээд нэг хувь тойрсон асуудлаар баахан маргаан үүсээд, ингээд нэг арилжаанаас шимтгэл авах маягаар ингээд асуудал өөр тийшээ явчих вий гэдэг болгоомжлол байгаа учраас яг таны хэлж байгаа зөв. Ер нь биржээ өөрөө цаашидаа ингээд өөрөө өөрийгөө шинэчлээд явдаг чадвартай

болгохын тулд бид бүр 0.01, 0.001 гэдэг тоонууд ажлын хэсэг дээр зөндөө яригдсан. Гэхдээ энэ бирж маань өөрөө бас нэг орж байгаа орлогоороо программ хангамжаа ядаж аптет хийгээд аваад явах тэр боломжийг нь 0,1 хувиа гэж үзсэн юм. Энэ тэгэхдээ зөвхөн журам дээр байгаа. Хууль дээр бол МХБ тогтооно, тэгэхдээ бид бол МХБ-ийн хууль, хэрэгжээд явсан ч гэсэн 0,1 хувиас хэтрүүлэхгүй байх. Энэ зүйлийг бол хэлж байгаа. Түүнээс хууль дээр бол ийм зүйл заалт бол байхгүй ээ гэдгийг хэлье, Баярлалаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: 0,1 хувь чинь арай багадаад байна гэж би танд хэлээд байна. Ингээд бүхэл бүтэн Монголыг тэжээдэг, дээрээс нь хэдийг нь их наядаар нь хулгайлдаг Эрдэнэс таван толгой, энэ жил 12000000 тонн нүүрс гаргасан, тэр нүүрс жишээ нь 70 доллароор гэж бодохоор чинь ойролцоогоор нэг сая орчим долларын шимтгэл энэ биржид төлөх гээд байна шүү дээ. Энэ чинь том бизнест бол бага байхгүй юу даа. Энэ биржийг том байх, илүү гадаад харилцаатай сайтай байх, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа үүгээр орсны хүрээнд бол үйл ажиллагаа нь үргэлж сайн болох юм байна гэдгийг тэр хувийн хэвшилд нь сайн ойлгуулж өгсний үндсэн дээр бирж нь хувийн хэвшлийг ч гэсэн борлуулахад үр дүнтэй юм байна гэдэг тийм зүйлийг хийлгэхийн тулд энэ шимтгэл чинь бас тодорхой хэмжээгээр жосоохон өндөр, тэгэхдээ хувийн компани дээрээ 0,1 байж болно. Төрийн өмчийнх дээр 0,2 хувь болгож тэгэх юм бол илүү сайжирна. Хамгийн гол нь одоо энэ биржээр орох дээр гаалийн бүрдүүлэлт хийнэ шүү дээ. Тэгэнгүүт ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Та энэ ХАА-н биржийн тухай хуультай холиод байна аа. Үнэхээр ХАА-н биржийн тухай хууль бол ХАА-н бүтээгдэхүүн, тэр ченжүүдтэй холбоотой асуудлууд энэ бол арай ондоо асуудал байж байгаа шүү. Энэ арай ондоо асуудал байгаа шүү. Тийм болохоор энэ ажлын хэсэг тэгж яривал ажлын хэсэгт та байхгүй, юу яриад байгаа юм бэ, солироод. Ажлын хэсэгт ч байхгүй, үгүй ээ, харин тэгээд би тэгээд юугаа ярьчихаад байгаа юм. ХАА-н биржээс арай ондоо асуудал явагдаж байгаа юм аа, наадах чинь.

Одоо өнөөдөр төрийн өмчийн компаниудыг бүгдийг нь энэ биржээр оруулах асуудал чинь энэ дотор яригдаж байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүн чинь арай ондоо асуудал шүү дээ. Уул уурхай. Ноолуур та бид хоёрын яриад байгаа тэр ноолууртай холбоотой асуудлууд, ХАА-н биржтэй холбоотой бүтээгдэхүүний биржтэй холбоотой асуудал бол ондоо асуудал шүү дээ, ондоо асуудал. Түүнтэй холиод та тэгж яриад байх юм.

Энэ хууль чинь биржийн чинь асуу
... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураана. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ Галсандорж гуай холбогдох хүмүүс нэг юу, яагаад, Ганбаатар сайд аа, ер нь явж явж бүх юмны үндсэн дээр худалдааны эрх зүйн мянган жилийн түүхтэй. Манай худалдааны салбар бол эрх зүйн зохицуулалт дотроо биржийн арилжаа, экспорт, импорт, гадаад дотоод худалдаа маш олон төрөл хэлбэрүүдтэй байна. Тэгээд тэр юмнуудыг ер нь худалдааны хууль эрх зүйн орчин, худалдааны бодлого гэдэг юм,

нэг тийм мянган жилийн эрх зүйн бодлоготой юм бол байхгүйгээс бас өнөөдрийн манай энэ олон асуудлууд, тэгээд Дэлхийн худалдааны байгууллагын бодлоготой нийцүүлэх, өөрийнхөө бодлогыг хэрэгжүүлэх, дэмпингийн бодлогыг зохицуулах, дотоодын зах зээл чинь яаж энэ үнийн савлагаанд өртөж байх уу, тийм бодлогыг бас энэ холбогдох яамд хамтран боловсруулж өргөн барих шаардлагатай байгаа юм даа.

Ингээд тэгээд бирж бол зүгээр ЗГ-ын журмаар бараг хийчихэж болохоор зүйл байхгүй юу, худалдааны хуультай бол.

Ингээд эцэслэн батлах бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

12.21 цаг

Ингээд дараагийн асуудалд оръё.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооноос санаачилсан хууль учраас шууд явуулж байгаа. Энэ болбол ганцхан заалттай хууль юм л даа.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Түр хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны

өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дээрх хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дэмжигдсэнтэй холбогдуулан Зөвшөөрлийн тухай хууль шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дөчдүгээр зүйлийг баримтлан Эдийн засгийн байнгын хорооноос боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул УИХ-ын гишүүн Ц.Цэрэнпунцаг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах тухай горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд орсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух УИХ-ын гишүүн байна уу, алга байна.

Энэ ганцхан заалтай хууль юм.

Байнгын хороо Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэнэ үү.

Санал хураалт явуулна. Асуулт хариултын цаг дууссан. Гишүүд санал хураалтад бэлтгэнэ үү.

Өнөөдрийн анхны санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт явуулж, үүнийг бараг стандартчилал, хэмжил зүй, Зөвшөөрлийн хуультайгаа хамт нэг яачихмаар ч хуулиар зөвшөөрөл нэмэхгүй гэж нэг өгүүлбэр орчихсон л байгаа даа. Зөвшөөрлийн хууль дээр чинь.

Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлнэ. Тэгээд санал хураалт явуулъя.

Х.Ганхуяг: Яг одоо энэ зөвшөөрлийн хуультай холбоотойгоор нэмэлт, өөрчлөлтүүд гээд нийтдээ 91 хууль дээр нэмэлт, өөрчлөлтүүд ороод явж байгаа, хэлэлцэхдээ явж байгаа. Өнөөдөр анхны хэлэлцүүлгээр орно. Тэгээд энэ орж ирсэн 91 хууль нь ямар шалтгаантай орж ирж байгаа вэ гэхээр одоо энэ зөвшөөрлийн хууль дээр болон зөвшөөрлийн процессыг бол бүгдийг нь хуульчилна гэж заасан байгаа шүү, Зөвшөөрлийн хуульд. Тэгэхээр энэ зөвшөөрлийг хэрхэн яаж олгох вэ, яаж өргөдөл гаргах вэ, ямар хугацаанд шийдэх вэ. Энэ асуудлууд чинь энэ нөгөө салбарынхаа хуульдаа тусгагдсан байх ёстой, тэгээд энд тусгагдаагүй байна шүү. Энэ 2-т зөвшөөрөл нэмэх асуудлыг бол яах вэ, дэмжиж байна. Тэгэхдээ энэ нь цаашидаа бол ингээд зөвшөөрлийн яг юуг тоог нэммээргүй байна.

Зөвшөөрөл гэдэг чинь бол эрсдэлтэй үйл ажиллагаа, үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд, эрүүл ахуй үүнтэй л холбоотой асуудлууд дээр

зөвшөөрөл бий болгож байгаа юм. Тэгэхээр бид нар үйл ажиллагаа болгон дээр нь зөвшөөрлийн тоо бол нэммээргүй байгаа, тэгэхдээ яах вэ, энэ 2-ыг бол дэмжиж байна. Гэхдээ энэ хууль дээрээ тэгээд та нар энэ процессоо оруулж өгөхгүй бол журмаар зохицуулах боломжгүй болж байгаа шүү. Тэгээд нэг ёсондоо та нар үйлчлэх боломжгүй, ийм юугаа орхигдуулчихаад байна гэсэн үг. Тэгээд энэ дээр анхаармаар байна.

Тэгээд энэ дээр Их Хурлын дарга та энэ найруулгын юу чиглэл өгдөг юм уу, яадаг юм. Тэнд нэмж юу оруулахгүй болохгүй юм байна шүү гэдгийг л хэлэх гэсэн юм.

Г.Занданиатар: Энэ дээр биш, нөгөө стандартчилал тусгай зохицуулалтын тухай хуулиа хэлэлцэхдээ тэр үеэр л энэ асуудал шинээр нэмэгдэж байгаа учраас гэж уялдуулж авч үзэх л шаардлагатай юм байна, тийм ээ.

Одоо санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Өнөөдрийн анхны санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт. Ажлаа л хийж байгаа шүү дээ. Болорчулуун, Ганибал, Ганбат, Даваасүрэн, Дамдинням, Доржханд, Мөнх-Оргил, Наранбаатар, Пүрэвдорж, Сүхбаатар, Туваан, Хүрэлбаатар, Цогтгэрэл, Чинзориг. Адъяаа гишүүн ороод ирлээ. Батболд гишүүн.

Санал хураалт.

Түрүүн бол бүртгэлийн санал хураалт явуулсан. Энэ санал хураалт бол туршилтын санал хураалт. Энэ санал хураалт туршилтын санал хураалт явуулаа. Бүртгэлийн санал хураалт, туршилтын санал хураалт дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар гаргасан горимын саналыг анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор

санал хууралт. Гишүүд анхааралтай байя.

29 гишүүн дэмжиж, 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

12.30 цаг

Дараагийн асуудалд орно.

Гурав. “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, УИХ-ын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхболд: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд заасан төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоог хангах зорилгын хүрээнд олон талт мэдээллээр тэгш хангах, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, ТББХ 2022 оны 12 сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тогтоолын төсөлд улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор “зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулахаар тусгасан бөгөөд Зөвлөлдөх санал асуулгын үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын ЗГ-т даалгах, Зөвлөлдөх зөвлөл байгуулах, Зөвлөлдөх санал асуулгын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөө баталж, Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулахыг ТББХ, Монгол УИХ-ын Тамгын газарт тус тус үүрэг болгохоор тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Ганболд, Энхболд нар УИХ-ын тогтоолын төслийн 2 дахь заалтын талаар асуулт асууж, хариулт авсан болно. Мөн УИХ-ын гишүүн Раднаасэд Зөвлөлдөх санал асуулгын оронд улс төрийн нам, хувийн хэвшил, иргэний байгууллагуудын төлөөлөл, шат шатны ИТХ-ын төлөөлөгчдийг оролцуулсан олон талт хэлэлцүүлэг зохион байгуулах нь үр дүнтэй талаар, УИХ-ын гишүүн Занданшатар иргэдийн жагсаал, цуглаан, нийгэмд шударга ёс тогтоох, авлигатай тэмцэх, авлига, хээл хахуулиас ангид байх, нүүрсний хулгайтай тэмцэх хэлбэрээр илэрч, бодит шаардлагуудыг тавьж эсэргүүцлээ илэрхийлж байна. Нийгмийн бухимдлын учир шалтгааныг хамтдаа тодорхойлж, нийгэм, эдийн засаг, улс төрийн тулгамдсан асуудлыг бүгдээрээ шүүн хэлэлцэж, гарц, шийдэл олох зорилгоор нийгмийн зөвшилцлөөр үндэсний хэмжээнд асуудлаа хэлэлцэн, шийдэл гаргах хэрэгцээ, шаардлагын хүрээнд зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах, нийгмийн бүлгүүдийн төлөөллийг түүврийн аргаар сонгон шалгаруулж оролцуулах, олон нийтэд мэдлэг, мэдээллийг тэгш зарчмаар хүргэж, эрдэмтэн судлаачдын оролцоог ханган, тэдний үг, байр суурийг сонсож, бэрхшээлийг даван туулах гарц, шийдлээ олох нь ач холбогдолтой.

Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн асуудлаар мэргэшсэн, хараат бус, мэдлэг, туршилага бүхий иргэн, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн болон ТББ-ын төлөөллөөс бүрдүүлж, зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх асуудлыг 7 хоногийн хугацаанд товлон явуулж, шуурхай бүрдүүлэх нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь УИХ-ын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, УИХ-ын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Тогтоолын төслийг тараасан байгаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд байна уу. Доржханд гишүүнээр тасаллаа, Тогмидын Доржханд гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Мөнххөөгийн Оюунчимэг асуулт асууна.

М.Оюунчимэг: Энэ зөвлөлдөх санал асуулга явуулахыг бол дэмжиж байгаа юм. Иргэдтэйгээ уулзаад явж байхад өмнө нь нөгөө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед Зөвлөлдөх санал асуулга бол маш зөв хэлбэрээр явагдсан, олон талын оролцоог бас шударгаар, бас дуу хоолойг нь сонсож, эрдэмтэн судлаачдаас өгсүүлээд мэргэжлийн хүмүүс иргэдийг сонгохдоо хүртэл их зөвөөр явуулж байсан. Тийм учраас энэ зөвлөлдөх санал асуулгыг УИХ тогтмол бас чухал асуудлуудаар явуулж байх нь хэрэгтэй гэсэн байр сууриа олон

хүмүүсээс илэрхийлж байсан. Тийм учраас үүнийг бас дэмжиж байгаа.

Гэхдээ өнөөдөр бид хамгийн гол нь зохион байгуулалтын асуудлууд дээрээ их ухаантай хандах хэрэгтэй байна. Юуны төлөө тэр гэж байгаа билээ, өчигдрийн жишээ нь энэ хяналтын сонсгол өөрөө дэгийн тухай хуулиар ямар зорилготой байдаг вэ, зөвлөлдөх санал асуулга гэж юуг хэлдэг вэ, энд иргэдийн оролцоо, мэргэжлийн салбарын эрдэмтэн мэргэдийн оролцоо ямар байх вэ, Их Хурлын гишүүд нь өөрсдөө ямар оролцоотой байх вэ гэх мэт энэ тэрээ ард иргэддээ оролцох гэж байгаа хүмүүстээ маш сайн мэдээлэл хийж, тэр танин мэдэхүйн ажиллагааг бол УИХ, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтраад хийх нь их чухал байна.

Өнөөдөр нийгэмд бухимдал бол үнэхээр их байгаа. Энэ нь юу юм гэхээр энэ авлигал, хээл хахууль, шударга бус байдал, энэ нийгмийн ажилгүйдэл, ядуурлын түвшин яаж юунд хүрч байна, энэ нь өөрөө эдийн засгийн нөхцөл байдал ямар байна, хил гааль гээд энэ нүүрсний энэ хулгайтай тэмцсэн тэмцлээс бид нар бас харж болохоор байна шүү дээ. Хэдийгээр энэ дотор улс төржүүлээд л, янз янзын явуулгууд оруулаад л үймээн самуун дэгдээх гээд л иргэдийн шударга, яг тэр оргиналаар явж байгаа тэмцлийг өөр өөр группүүд нь бараг нүүрсний хулгайчид нь өөрсдөө хүртэл дотор нь янз янзын хүмүүс оруулаад үймүүлэх тал руугаа хүртэл орж явж байна шүү дээ. Тэгэхээр юуны төлөө тэр байгаа билээ. Үнэхээр тэр буруутай хүмүүст нь хариуцлага тооцож чаддаг байх, ард иргэдийн дуу хоолойг тэдний саналыг тусгахдаа маш өндөр зохион байгуулалттайгаар, яг хуулийн хүрээнд нь явуулдаг байх энэ тэр асуудлууд бол маш их чухал байна.

Өчигдрийн тэр хяналтын сонсголоос харж байхад уг нь сөрөг хүчин маань энэ дээр маш зөв хамтран оролцоод зохион байгуулах ёстой байхад

жишээ нь үймүүлэх юмнууд дотор хүмүүсээ оруулаад л, бас ингээд л залуучуудыг буруу зам руу уруу татах ажлууд энэ тэр хийж байгаа байхгүй юу. Би бол энэ дээр өчигдөр оролцоод байж байсны хувьд үнэхээр харамссан. Гэтэл ард түмэн тэрийг хараад сууж байгаа байхгүй юу. Хэн ямар мэдээлэл өгөх нь үү, хууль хүчний байгууллагынхнаар хэн үнэхээр шалгагдаж байгаа юм, энэ бодит байна уу, үгүй байна уу гээд тэр мэдээллийг тэр болгон авч чадаагүй, өчигдөр. Тийм учраас би өмнө нь бас энэ УИХ-ын чуулганы энэ 7 хоногийн юм уу, ирэх 7 хоногийн хэлэлцэх асуудлын жагсаалтад яг энэ өчигдрийн хяналтын нийтийн сонсголыг яг хууль журмынх нь дагуу УИХ-ын чуулган дээр дахин явуулж, УИХ-ын гишүүд, тэр эрх мэдэлтнүүд, хууль хүчнийхнээс асуултаа асууж тодруулга авах, иргэдэд бас зөв олон талын мэдээлэл өгөх энэ ажил хийх хэрэгтэй байна. Тийм учраас даргын дэргэдэх зөвлөл бас энэ асуудлыг анхааралдаа аваасай гэж хүсэх байгаа.

Тиймээс энэ зөвлөлдөх санал асуулгыг бид бас маш сайн зохион байгуулалттайгаар олон нийтийн санал, тэр салбарын мэргэжилтэн, эрдэмтдийн санал, хуульчдын санал, олон талын оролцоо, улс төрийн намуудын энэ тэрийг хангаад сайн зохион байгуулах нь бол чухал байна гэсэн санал хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэлчихсэн байна. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” УИХ-ын тогтоолыг УИХ хэлэлцэж байна. Нийгэмд үүсээд байгаа нөхцөл байдал гэдэг ч юм уу, өнөөдрийн улс төрийн системийн гажуудлыг засах асуудал бол энэ Монгол төрийн засах ёстой асуудал мөн. Үүнийг шийдэх шийдэл нь өөр арга замаар явах ёстой гэж бодож байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд бид 19 онд Үндсэн хуульд

өөрчлөлт оруулсан, өөрчлөлт оруулсан. Ингээд 3 жилийн дараа дахиад Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хөндөж, УИХ өнөөдөр тогтоолын төсөл оруулж ирлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Монгол Улсын Ард нийтийн санал асуулга явуулах тухай хууль гээд өнөөдөр энэ Үндсэн хуультай холбоотой үндсэн баримт бичиг байдаг аа. Монгол Улсын Үндсэн хууль гэдэг бол үндэсний зөвшилтийн бичиг баримт, үндэсний зөвшилтийн бичиг баримт. Энд бол улс төрийн намууд, парламент суудалтай, суудалгүй нийт Монголын ард иргэд энд оролцох ёстой. Энэ асуудлыг шийдэхийн тулд Монгол Улсын Үндсэн хууль болон Ард нийтийн санал асуулгын тухай хуульд заасны дагуу ард нийтийнхээ санал асуулгыг хийчихье. Ард түмэн өнөөдөр энэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, тэр сонгуулийн тогтолцооны өөрчлөлт, Их Хурлын гишүүдийн тоог нэмэх асуудлыг дэмжинэ ээ гэх юм бол бүгдээрээ үүнийг хэлэлцүүлье.

Бид өнөөдөр энэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, ард нийтэд санал асуулга явуулах гэдэг энэ зөвлөлдөх санал асуулга гэдэг ийм юмыг зохион байгуулах нь хэдийгээр хуулиар олгосон эрх ч гэсэн ийм байдлаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нь өнөөгийн нөхцөл байдалд улам муу үр дагавар авч ирнэ шүү гэдэг ийм бодолтой байна. Тийм учраас УИХ яаралтай хууль гаргаж, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн дагуу ард түмнээсээ саналаа л асууя. Үүнийг би зөв бурууг бид ард түмнээр шүүлгээ гэсэн ийм байр суурьтай байна.

Энэ зөвлөлдөх санал асуулга гэдэг энэ тогтоолын төслийг оролцож байгаа энэ субъектүүд, оролцож байгаа энэ хүмүүс өнөөдөр зөвхөн энэ ард түмний хүсэн хүлээгээд байгаа төрийн тогтолцооны болон бусад асуудлыг шийдэх шийдэл нь зөв үү, буруу юу гэдэг дээр энэ ард түмнээс л асууя, зөв бол энэ

ард түмэн бол шийдье ээ, зөв байна аа, ингэе ээ гээд өгөх ёстой, үгүй бол ингэж өнөөдөр энэ Ард түмний зөвлөл санал асуулга гэдгийн нэрийн дор ийм юмыг зохион байгуулах нь маш муу үр дагавартай шүү гэдгийг би энд хэлье.

Яагаад гэхээр би өнөөдөр ард түмний төлөөллийн өмнөөс энэ үгийг хэлэх ёстой гэж бодож ийм байр суурьтай байгаагаа хэлж байна. Анхаарал тавьсанд баяр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн. Байнгын хороон дарга бол Жамъянгийн Мөнхбат, ТББХ-ны дарга

Ж.Мөнхбат: Адъяаа гишүүн энэ хэлэлцээж байгаа асуудлаа жосохон танилцаагүй л юм шиг байх юм, эсвэл буруу ойлгосон юм болов уу. Энэ Үндсэн хууль тогтолцоо өөрчлөх асуудал энэ дээр ерөөсөө яригдаагүй юм. Монгол УИХ-ын тогтоолын энэ нэгдүгээр зүйл дээр байгаа шүү дээ. Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор “зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг явуулсугай гэж байгаа юм.

Тэгээд энэ Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйл дээр зөвлөлдөх санал асуулгын зорилго гээд ийм 4 зүйл байгаа. Зөвлөлдөх санал асуулгыг дараах үндсэн зорилгоор зохион байгуулна. 1 дүгээрт, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлэх, 4.1.2 дээр тухайн асуудлын эрэмбэ, түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, тэгээд иргэд, олон нийтэд тулгамдсан асуудлын талаар мэдээлэл, мэдлэг өгөх, Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд заасан төрийн үйл үүрэгт оролцох,

иргэдийн оролцоог хангах гэсэн ийм 4 заалт байгаа.

Тэгэхээр энэ удаагийн энэ “зөвлөлдөж шийдье” энэ улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулга юу вэ гэхээр өнөөдөр нийгэмд үүсээд байгаа, ард иргэдийн жагсаал цуглаан хийж байгаа, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллээр тавьж байгаа шаардлага, энэ нийгэм, эдийн засаг, нийгмийн асуудал үүссэн, эдийн засгийн асуудал ч үүссэн, өөрөөр хэлэх юм бол энэ үнийн өсөлт, инфляцын асуудал, валютын ханшийн өсөлт, ажилгүйдэл, ядуурал, эдийн засгийн өсөлт буурсан гээд энэ олон асуудлыг энэ жагсаал цуглаан, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллээр иргэд, олон нийт ярьж байгаа. Тийм учраас энэ Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлж, 4.1.2-т заасан тухайн асуудлын эрэмбэ, түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэйгээ зөвлөлдөхөө л гэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол энэ дээр бол зөвлөлдөх санал асуулга явуулаад л шууд тогтолцоо өөрчилж, шууд Үндсэн хууль өөрчилж гэдэг асуудал яригдахгүй ээ. Энэ дээр иргэд энэ асуудлыг энэ эрэмбэ дарааллуудыг яаж эрэмбэлж байгаа юм, энэ тулгамдаад байгаа асуудлуудыг шийдэх шийдэл, гарц алхмууд нь юу байгаа юм бэ гэдгийг энэ зөвлөлдөх санал асуулгаар тодорхой болгоё оо л гэсэн ийм л зүйлийг ярьж байгаа юм.

Тийм учраас бол энэ удаагийн одоо тогтоолын төслийн бас нэг зохион байгуулах ажил байгаа. Энэ 6 дугаар зүйлийн 1 дээр нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал, гарц шийдэл, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахыг УИХ-ын Тамгын газар, Монгол Улсын ШУА-д даалгаж байгаа. 6.2 дээр улс төр, эдийн засаг, эрх зүйн шийдэл, нийгмийн зөвшилцөл, чуулга уулзалт зохион байгуулахыг ТББХ-нд

даалгаж байгаа. Энэ 1 дүгээр сард болох ийм ажлууд зохион байгуулагдана.

Тийм учраас бол энэ дээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулъя, тогтолцоог өөрчилж ч гэдэг юм уу, шууд ингээд зөвлөлдөх санал асуулга зохион байгуулж байгаа асуудал биш шүү. Өөрөөр хэлэх юм бол нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар олж илрүүлж, түүнийгээ шийдэх арга зам, эрэмбэ дарааллыг нь тогтооё оо л гэсэн ийм зөвлөх санал асуулгыг зохион байгуулж байгаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн. Энэ асуулт уг нэг тогтоолын төсөл учраас нэмэлт 1 минут байхгүй юм байна, сая 5 минутаар явсан.

С.Чинзориг: Минийх эхнээсээ авъя дарга аа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн эхнээс уг хэлье.

С.Чинзориг: Эхлэхгүй бол энэ бүр хориод секунд явчхаж.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: ТББХ-ноос Их Хурлын тогтоолын төсөл оруулж ирж байгаа юм байна. Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай гээд. Тэгэхээр энэ иргэдтэйгээ зөвлөлдөж, иргэдийнхээ оролцоотойгоор, улс орны өмнө тулгамдаад байгаа нийгэм, эдийн засгийн асуудлыг тодорхойлох, гарц шийдлээ ярих бол бас асуудал бас байж болох юм аа, зөв болов уу гэж л бодож байгаа юм. Тэгэхээр энэ зөвлөлдөх санал асуулга явуулахтай холбоотойгоор хэд хэдэн бас тодруулмаар юмнууд бол байна.

Бид нар өчигдөр Их Хурлаас зохион байгуулсан нүүрсний асуудлаарх ерөнхий хяналтын сонсгол зохион

байгуулсан. Иргэд тэнд чинь 2 л юм нэлээн яриад байна лээ л дээ. Энэ хулгайтай холбоотой асуудлыг ямар хугацаанд богино хугацаанд яаж шийдэх юм, хариуцлага яаж тооцох гэж байгаа юм, 2 дахь асуудал нь иргэдийн амьжиргааны түвшин нэлээн бас дордож байна, хүндэрч байна. Энэ дээр төр засгаас ямар арга хэмжээ авах вэ, энэ тэр гээд, 3 дахь асуудал нь цаашидаа энэ төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд гарч байгаа энэ хулгай луйврыг таслан зогсоох талаар, иргэдэд нээлттэй ил тод болгох талаар, иргэдийн нөгөө 1072 хувьцааг амь оруулах, ногдол ашиг хуваарилах энэ тэр гээд, тэгээд компанийн засаглалыг сайжруулах энэ тэр гээд ийм юмнуудыг нэлээн их яриад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бид нэлээн Их Хурал нэгэнт тогтоол гаргаад шийдвэл нэлээн бас бэлтгэл хангах талаар нь онцгой анхаармаар байна. Мөнхбат даргаас би 2, 3 юм тодруулмаар байна.

1 дэх асуудал, энэ зөвлөлдөх санал асуулга явуулбал хэчнээн хүний бүрэлдэхүүнтэй, хэчнээн хүний оролцоотойгоор хийнэ гэж та бүхэн тооцоод байгаа юм бэ? Мөнхбат дарга аа, би танаас асуулт асуугаад байна, Адьшаа гишүүн ээ, хөвө Адьшаа гишүүн би асуулт асуугаад байна. Хэчнээн хүний бүрэлдэхүүнтэй энэ зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах гээд байгаа юм, төлөөллийг яаж сонгох юм, яаж бүрдүүлэх юм, сум болгоноос ч юм уу, төлөөлөл оролцох тэр боломжийг нь яаж хангаж өгөх юм, салбар бүрийн төлөөлөл оролцох тэр боломжийг нь яаж хангаж өгөх гэж байгаа юм.

3 дахь асуудал нь, зөвлөлдөх асуулга явуулбал ямар сэдвүүдээр иргэдийн саналыг сонсъя гэж та бүхэнд тооцож байгаа юм. Иргэдээр хэлэлцүүлэх сэдвүүд нэлээн урьдчилж гарсан байх хэрэгтэй болов уу гэж би бодож байна.

4 дэх асуудал нь, энэ хэлэлцэх гэж байгаа иргэдээс санал асуух гэж байгаа энэ сэдвүүдээрээ урьдчилж олон түмэнд, иргэдэд мэдээлэл өгөх, ойлголттой болгох ямар арга хэмжээ авах юм? Энэ зөвлөлдөх санал асуулгыг та бүхэн хэд хоногийн дотор зохион байгуулах гэж байгаа юм, төлөвлөж байгаа эд нар гээд ийм асуудлууд дээр бас Байнгын хороо хариулт өгөөч.

Ер нь зөвлөлдөх санал асуулга явуулахыг би дэмжиж байгаа юм. Хамгийн гол нь бэлтгэл насаа хангах хэрэгтэй, төлөөллийг нь маш сайн хангах хэрэгтэй. Хэлэлцэх санал авах тэр сэдвүүд маш тодорхой байх хэрэгтэй, эхнээсээ. Энэ сэдвүүдээрээ иргэдийг мэдээллээр хангасан байх, ирсэн хойноо нэг өдөр өглөө нь нэг цаас аваад саналаа илэрхийлэх тийм бол боломжгүй болно шүү дээ. Тийм учраас иргэд энэ сэдвүүдээ мэдэж байх, энэ сэдэвтэй холбоотой урьдчилсан бас мэдээлэл авсан байх, энэ нөхцөл боломжийг нь та нар яаж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жамъянгийн Мөнхбат ТББХ-ны дарга.

Ж.Мөнхбат: Энэ Чинзориг гишүүний яриад байгаа энэ асуудлыг би түрүүн бас ерөнхийд нь хэлсэн. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 4.1.1 дээр энэ нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлэх, тухайн асуудлыг эрэмбэ түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөнө өө гэж байгаа юм. Тэгээд энэ дээр яригдсан асуудал дээр зөвлөлдөх зөвлөлийг бид нар бол байгуулна, өөрөөр хэлэх юм бол 7 хоногийн хугацаатай 5-11 хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөлдөх зөвлөлийг байгуулдаг. Энэ зөвлөлдөх санал асуулга энэ дээр яригдсан, энэ саяын энэ сэдвээр яригдсан зүйлийг нь Зөвлөлдөх зөвлөл маань бол одоо санал асуулга явуулах одоо сэдвүүдээ бол боловсруулдаг.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ингээд Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 11 дүгээр зүйл дээр байгаа энэ зөвлөлдөх санал асуулгаар санал авах журам байгаа. Үүнийг бол энэ зөвлөлдөх санал асуулгаар санал авах ажлыг энэ хуулийн 10.3-т зааснаар бол статистикийн байгууллага зохион байгуулж явуулдаг. Бид нар 2017 оны хавар бас нэг зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж байсан туршлага байгаа, энэ хуулийн дагуу.

Тэгээд санал асуулга нь 2 шаттай байна. Тэгээд Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд энэ Чинзориг гишүүн ээ, Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн оролцох эрхтэй бөгөөд энэ оролцох иргэний тоог зөвлөлдөх санал асуулгын сэдэв, хамрах хүрээг харгалзан ҮСХ-оос баталсан аргачлалын дагуу нөгөө Зөвлөлдөх зөвлөл маань тогтооно. Энэ манай Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 11.5 дээр байна.

Ингээд 11.6 дээр зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд оролцох иргэнийг энэ хуулийн 11.5-д заасан тоонд багтаан хамгийн сүүлийн удаа явагдсан УИХ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар гаргасан сонгогчдын нэрсийн жагсаалтаар тохиолдлын зарчмаар сонгож явуулна гэсэн ийм хуультай. Энэ хуулийг бол бид нар 2016 онд баталсан, 2017 онд бол энэ хуулиар бид нар анх удаагаа Монгол Улсад бас энэ зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж байсан. Энэ 2 дахь удаагаа энэ хуулийг хэрэглэж, бид нар энэ нийгэм, эдийн засгийн өмнө тулгамдаад байгаа энэ асуудал, түүнээс гарах гарц, шийдэл хэрхэн шийдвэрлэх, боломж бололцоо байгаа эрэмбэ дарааллынхаа асуудлыг ярьж л гэсэн. Өөрөөр хэлэх юм бол энэ зөвлөлдөх санал асуулгын энэ асуудлыг бол хуулийн дагуу бол Статистикийн ерөнхий газар зохион байгуулна.

ҮСХ-оос баталсан энэ аргачлалын дагуу энэ Зөвлөлдөх зөвлөлийн санал асуулгын сэдэв, хамрах хүрээг Зөвлөлдөх

зөвлөл тогтооно. Зөвлөлдөх зөвлөлийг бид ТББХ, УИХ байгуулж өгнө.

Зөвлөлдөх зөвлөлд орох энэ 5-11 хүний бүрэлдэхүүнийг 7 хоногийн хугацаатай бол сонгон шалгаруулалт маягийн зарлаад, ингээд энэ Зөвлөлдөх зөвлөлийг байгуулж, энэ ажлыг зохион байгуулна гэдэг ийм хариултыг өгье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Тогмидын Доржханд.

Т.Доржханд: Баярлалаа. Тогтоолын төслийг бол дэмжиж байна. Одоо бид нар олон жил ингээд ярилаа, үйлдэл хэрэгтэй байхгүй юу. Тэгээд энэ үйлдэл нь гарч ирж байна гэж бодож байна. Тэгээд сая Мөнхбат гишүүн ээ, ТББХ-ны дарга аа, нэг зүйлийг би хэлчихье ээ, энэ иргэд чинь яагаад ийм олон хоног энэ гадаа жагссан юм бэ? Өчигдөр яагаад бид нар ийм хяналтын ерөнхий сонсгол хийсэн юм. Хяналтын ерөнхий хорооны сонсголоор иргэд юу ярьсан юм, сонсооч ээ, наад хажууд чинь сууж байгаа Чинзориг гишүүн өчигдөр даргалсан юм. Тэнд байгаа Ганболд түр хорооны дарга нь байна. Тэр хүмүүс чинь энэ гарц, шийдэл нь бол тогтолцооны өөрчлөлт хийхгүй бол болохгүй юм байна гэдэг дээр иргэд чинь нэгдээд байна шүү дээ. Талбай дээр байгаа иргэд чинь нэгдээд байна. Хяналтын хорооны хүмүүс чинь бол нэгдээд байна. Ийм болохоор энэ хулгайг углуургаар нь, үндсээр нь өөрчилж өө гээд тэгэх юм бол Монгол Улс сонгуулийнхаа тогтолцоог өөрчлөх хэрэгтэй. Парламентынхаа ардчиллыг бэхжүүлэх хэрэгтэй. Энэ давжаа парламент дотор чинь эрүүл агаар оруулж ирэх хэрэгтэй байна гэж. Үгүй ээ, энэ чинь 1 нам багтахаа болчихоод байна шүү дээ, энд чинь. Тийм байгаа биз дээ. Үгүй ээ, тэгээд нэг нам дараалан ингэж засгийн эрхэнд гарсных энэ парламентыг дүүргэсний үр дүнд юу болж байгааг бүгдээрээ хараад байна шүү дээ. Болохгүй байгаа биз дээ, иргэд хэлээд байна шүү дээ.

7 сарын өмнө бид нар иргэдтэй уулзаж байхад 180000 гаруй иргэдтэй Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргээр явж уулзаж байхад зуугаад мянган хүн гарын үсгээ зурж өгч байхад бол тэд бол дэмжиж байсан, эргэлзэж байсан үнэн, зарим нь. Яахаараа парламентын гишүүдийн тоог өсгөх гээд байдаг билээ гээд. 76-гаа яая гэж байхад үүнийг чинь өсгөх юм бол болохгүй шүү дээ, хүү минь гэсэн ийм харцтай хүмүүс байсан. Одоо иргэд ойлгосон байна. Парламентын гишүүдийн тоог өсгөнө өө гэдэг бол хулгай хийж байгаа хүмүүсийг харин хязгаарлах юм байна. Кнопны хүчин чадлыг бууруулж байж, ардчиллыг бий болгож байж, харилцан хяналттай байж байж, энэ парламент, энэ ЗГ чинь үйл ажиллагаа явах юм байна, үр дүнд нь хулгай хязгаарлагдах юм байна гэдгийг иргэд ойлгож байсан.

Ийм тохиолдолд энэ Зөвлөлдөх ардчиллынхаа үндсэн сэдвүүд дээрээ энэ тогтолцооныхоо өөрчлөлтийг тойрч ярих нь зүйтэй шүү. Яагаад вэ гэхээр та мэдэж байгаа, улс төрийн намууд 3 удаа зөвлөлдсөн, бүгдээрээ энэ тогтолцооныхоо өөрчлөлтийг хийе гэсэн, иргэд ч гарын үсэг цуглуулсан. ХҮН намын удирдлагын хувьд хүн намын залуучууд ч гэсэн эндээс саналуудаа аваад явсан, энэ дээрээ бид нар 2 жил ажиллаж байгаа. Шахаж байгаа юм биш, гэхдээ иргэд чинь талбай дээр гараад шахаад эхэллээ шүү дээ. Хулгайгаа дийлэхгүй байна аа, энэ нүүрсний хулгай, цаана нь өөр ямар хулгай байгаа юм, 40 их наядын орлогоо бид нар алдчихсан, хилийн цаана ингээд гаргаад хаячихсан. Тэгээд цаашаа ингээд явах юм бол Монгол Улс хөгжихгүй юм байна. Энэ чинь өөрөө эрх мэдэлтэй хүмүүсийн хулгай байна гэдгийг мэдчихээд байна шүү дээ. Ийм болохоороо парламентаа амьд байлгах, тэгээд хариуцлага тооцох, хяналт тавих, цаашаагаа бэхжүүлэх нь бол Монгол Улсын үндсэн эрх ашиг юм гэдэг дээр иргэд нэгдчихээд байна.

Өнөөдрийн системээр хэчнээн сонгууль хийгээд дараагийн хулгайч нар гарч ирэх юм байна гэдгийг иргэд ойлгож байсан байна, ийм болохоор үүнийг үндэс углуургаар нь өөрчилж өө гэж иргэд жагсаад байгаа шүү. Үүнийг бол би бас энэ талбай дээр гарч уулзсан хүний хувьд бол нэлээн олон хэлэлцүүлэгт тэд нартай орж мэдээлэл өгсөн хүний хувьд бол бас дамжуулж хэлж байна.

Үүнтэй холбоотойгоор энэ хугацаагаа наашилуулж болохгүй юм уу. 1, хугацаагаа. Зөвлөлдөх уулзалтын хугацаагаа 2 сарын 20-ны дотор гэсэн байна аа, үүнийгээ наашаагаа, иргэд бол цаг хугацаа шахуу байна аа, үүнийгээ хурдан шийдээч ээ гээд байгаа шүү дээ. Хугацаагаа наашилуулж болох уу.

2 дугаарт, заавал үүнийг хийснээрээ энэ тогтолцооны өөрчлөлт явах юм уу ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жамъянгийн Мөнхбат гишүүн.

Ж.Мөнхбат: Доржханд гишүүн ээ, өчигдрийн энэ нээлттэй сонсголыг би бүтэн сонссон. Түүн дээр энэ авлигал, хариуцлагын асуудал ярьж байна лээ, Төрийн хариуцлагын асуудлыг ярьж байна лээ, 1 дүгээрт, 2 дугаарт бол энэ ТӨК-уудын засаглалын чадамж алдсан тогтолцоо гэдгийг ярьж байна лээ, 3 дугаарт, энэ төрийн тогтолцооны асуудал, бас зарим хүмүүс ярьж байна лээ. Тэгэхээр энэ ТББХ-ноос орж ирж байгаа асуудал бол яг энэ өчигдрийн ярьсан асуудалтай л уялдаж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бид нарын энэ улс орны нийгэм, эдийн засаг, нийгмийн болон эдийн засгийн өмнө тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлж оо, онош тавья аа. Тэгээд энэ асуудлынхаа эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гарах шийдвэрийн талаараа ярилцъя л гэж байгаа юм. Энэ дээр тэр жагсаал цуглаанд оролцсон хүмүүсийн төлөөллийг оролцуулна, Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулна, улс

төрийн намуудын төлөөллийг оролцуулна, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулна, хуульчид, эдийн засагчдын төлөөллийг оролцуулна. Тэгээд ингэж л энэ асуудлыг ярьж шийдье л гэдэг ийм зүйлийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос оруулж ирж байгаа.

Дээрээс нь эрдэмтэн судлаачдынхаа үгийг сонсъя гээд энэ нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал, гарц шийдэл гэсэн эрдэм шинжилгээний хурлыг ШУА, УИХ-ын Тамгын газар хамтарч зохион байгуулъя гэж байгаа юм. Энэ хүрээнд. Улс төр, эдийн засаг, эрх зүйн шийдэл, нийгмийн зөвшилцөл, чуулга уулзалтыг ТББХ I сар гараад зохион байгуулъя гэж байгаа юм. Саяын энэ ярьсан дурдсан иргэний нийгмийн байгууллагууд, жагсаал цуглаанд оролцогчид, нийгмийн салбар бүрийнхний төлөөллүүд оролцоно. Тэгээд энэ дээр л юмнуудаа ярилцъя гэж байгаа байхгүй юу, нээлттэйгээр.

Тэгээд энэ дээр ярилцсан асуудлыг энэ Зөвлөлдөх зөвлөл байгуулаад ямар сэдэв, ямар хүрээнд зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах вэ гэдэг бол өөрөө Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулиараа ингээд зохицуулагдаад хуульчлагдсан зүйл. Тийм учраас энэ хуулийнхаа дагуу цаашдаа бол явна.

Цаг хугацааны хувьд бол Доржханд гишүүн ээ, ийм юм байгаа юм. Цаг хугацааны хувьд бол бид нар энэ Зөвлөлдөх зөвлөлийг байгуулахад 12 сарын 30-наар 7 хоногийн хугацаатай нэр дэвшүүлэлт хийж байгаа, 5-11 хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөлдөх зөвлөлийг байгуулна. Энэ байгуулагдсан Зөвлөлдөх зөвлөл чинь энэ хамрах хүрээ, сэдэв бүх юмаа тогтоно, бас цаг хугацаатай. Ингээд Статистикийн ерөнхий газар энэ хүрээнд хамгийн сүүлд явагдсан УИХ, Иргэдийн хурлын сонгуульд санал өгсөн, сонгогчдын нэрсийн жагсаалтаар түүврийн аргаар сонгож, ингэж энэ санал асуулгад оролцох хүмүүсийг сонгоно, товлон гээд. Ингээд энэ бүхэн

хамгийн хурднаараа хуулийн хугацаагаараа хөөхөд 2 сарын 20 болж байгаа юм. Түүнээс наана бол болох ямар ч боломж байхгүй, хамгийн хурдан, хуульд заасан энэ хугацаануудыг шахаж гаргаад энэ 2 сарын 20 гэсэн энэ цаг хугацааны товьыг бол бид нар бол бас гаргаж ирсэн юм гэдгийг хэлье.

Тэгээд эцэст нь бол нэг зүйлийг Доржханд гишүүнд хэлэхэд бол энэ улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагууд, олон улс төрийн намууд, бас санамж бичиг энэ тэр гарын үсэг зурж, тэр байтугай Үндсэн хууль тогтоогчдын холбоо, хуульчид, судлаачид, эрдэмтэд олон олон санал ирүүлсэн. Ялангуяа энэ асуудлыг, бас таны тэр түрүүний яриад байгаа улс төрийн намуудын санамж бичиг гарын үсэг зурсан энэ тэр гэдэг энэ асуудлыг хариуцдаг гэдэг агуулгаараа ТББХ-нд бол маш их санал хүсэлт бол ирж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг энэ юуны зөвлөлдөх санал асуулгын хүрээнд бүгдээрээ л нээлттэй л ярья гэж байгаа юм. Тэгээд энэ яриад ямар онош тавих юм, юунаас болоод байгаа гэж оношлох юм, юугаа яана ... /минут дуусав/

Г.Занданшатар: Адьшаа гишүүнд өгөөгүй байгаа. 1 цаг болчихсон.

Хариулт уу. Нямаагийн Энхболд гишүүн нэмж хариулъя, гүйцээж хариулъя, ажлын хэсгийн дарга.

Н.Энхболд: Хугацааны хувьд бол сая Мөнхбат дарга тодорхой хэлчихлээ. Энэ ажлыг бид нар 17 онд зохион байгуулахад бараг 4 сар болсон юм, хавраас эхлээд 10 дугаар сар хүртэл явж байгаад тэгээд үүнийг хийсэн юм. Тэр үед анх удаа хийж байсан, бас дутуу хөтүү юмнууд байсан, тэгээд одоо бол нэг, 2 сард багтчих байх гэж тооцож, бас түрүүчийн явуулж байсан бүх юмнуудаа үзэж байгаад ингээд хийчихэд нэг 2 сарын 20-доор гэхэд болох болов уу гэсэн ийм тооцоо гарсан байгаа юм.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ер нь зүгээр энэ зөвшилдөх санал асуулга гэдэг бол манай улс төрчид бүгдээрээ мэдэж байгаа даа, энэ төлөөллийн ардчиллын зарчмаасаа шууд зөвлөлдөх ардчилал, шууд ардчилал руу шилжиж байгаа, тэрний элементүүдийг хэрэглэж байгаа ийм л алхам шүү дээ. Тэгэхээр заавал ингэж ярьж байх ёстой юм байна лээ, 1 дүгээрт хуультай.

2 дугаарт, ерөөсөө ардчиллын энэ хөгжлийнхөө дагуу энэ цэг рүүгээ явах нь зүйтэйг бусад олон улсуудын туршилага харуулж байгаа юм. Хэлэлцэх асуудлуудын хувьд бол олон юм орох байх аа. Тогтолцоо ч орох байх, тэр ч байтугай нийгмийн зүгээс гарч байгаа бүхий л асуудлуудыг оруулж байгаад л эцсийн дүндээ яг зөвлөлдөх санал асуулгын дүнд юу гарах нь вэ, түүн дээрээ төвлөрөөд, тэгээд үүнийг ердийн хуулиараа зохицуулаад явах нь уу. Шаардлагатай гэж үзвэл үнэхээр хүн амын дийлэнхийн санаа оноо гараад ирвэл Үндсэн хууль руу орох нь уу гэдэг юмнуудыг тэр үед нь тодорхойлно, одоо үр дүнг нь таашигүй.

Тогтолцооны хувьд бол зүгээр, миний ойлгож байгаагаар үүний түрүүчийн цэцээс гарсан шийдвэр, бусад асуудлуудаас ингээд үзэхэд бид нар заавал өнөөдөр Үндсэн хуульд хүрэлгүйгээр үүнийг бас хийчих боломж гэж байж байгаа. Үүнийгээ бас би, тухайлбал тэр зөвлөлдөх зөвлөлийн гишүүд, ард түмнээс санал авах асуултуудынхаа дунд энэ юмнуудыг бүгдийг нь адилхан оруулж байгаад л үзээд л хэн нь аль нь хамгийн их санал авах нь вэ, үүгээр нь хийгээд явчих нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна, Байнгын хорооноос ч тэгж зохион байгуулах болов уу гэж бодож байна аа.

Энэ 17 онд бид нар энэ зөвлөлдөх санал асуулга гээд явуулаад, тэгээд энэ чинь 19-нд болсон нэг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхэд маш том легитим тийм чанарыг хангасан арга хэмжээ болсон байхгүй юу. Тэгэхээр бид

нар бас энэ удаагийнхаа хэдийгээр өчигдөр ТББХ дээр, энэ бол яг Үндсэн хуулийг өөрчлөх гэж бид нар ийм зүйл ярьж байгаа юм шүү гэж яригдаагүй ч гэсэн санал асуулга, бусад арга хэмжээний үр дүнд цаашаа яаж явах вэ, ямар арга шийдэл байна гэдэг юман дээр гараад ирвэл тэгээд түүнийг бас оролдоод үзэхээс өөр аргагүй л болох байх гэж бодож байна. Тэгээд дахиад хэлэхэд зүгээр ингээд нэг санал асуулга маягаар хийснээс яг хуулийн дагуу шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлалаар яваад энэ дүнг нь гаргаад ирэхээр хэрүүл маргаан харьцангуй бага гарсан. Энэ нь өөрөө энэ зөвшилцөх санал асуулга болбол, тэр дараа дараагийн гарч байгаа шийдвэрүүдийн легитим чанарыг баталгаажуулахад үнэхээр хэрэгтэй юм байна гэдгийг нотолсон ийм л арга хэмжээ болох юм байгаа юм.

Г.Занданшатар: Тогтоол болохоор асуулт үг, хамт явчихсан.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Горимын санал байдгийг Тамгын газар хэлээд өгчих, тайлбарлачих.

Санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн санал хураалтдаа бэлдье.

Ингээд Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 62,3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

“Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулга дээр Пүрэвдорж гишүүн эцсийн найруулгатай холбоотой л үг хэлэхийг хичээгээрэй.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр “Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг баталж байна. Тэгэхээр энэ бол Үндсэн хуульд өөрчлөлт хийх оришил мөн л дөө. Тэгээд үүнийхээ дагуу бас тодорхой санал асуулгыг орон даяар явуулах, илүү энд хамгийн чухал мэдлэгтэй, Үндсэн хуулийн өөрчлөлтийн агуулгыг бүрэн мэддэг, тэр хүмүүсийг татаж оролцуулах энэ асуудлыг шийдэж байгаа. Тэгэхээр түрүүчийн зөвлөх санал асуулга 17 оны, 19 онд зөвлөх санал асуулга явсан, 17 онд харамсалтай нь энд хүмүүсийн оролцоо маш бага байсан, тийм ч учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг маш богино хугацаанд дахин явуулах тухай яригдаж байна шүү дээ.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг энэ дахиад л энэ ҮХЦ дүгнэлт гаргасан гээд манай 2 нөхрөөр нэг ийм хогийн юм бариулаад ингээд хийсэн. Яг энэ дахин сонгогдохгүй гэж байгаа тэр хүмүүсийн сайд болох тэр хүсэл шунал дээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг 8 сард хийсэн л дээ. Тэгээд АН-ын нэг 6 гишүүнийг сайд өгье гэж амлаж байгаад худлаа ярьж байгаад яг тэр нөгөө Үндсэн хуулийн өөрчлөлт дээр гарын үсэг зурахад Мөнхбат, Тогтохсүрэн нар нэг манжийн амбан гарын үсэг зуруулж байгаа юм шиг нэг тийм муухай дүр зураг яг энэ манай бүлгийн хурал явж байхад орж ирж зуруулж байсан л даа. Яг л ийм л юм байгаа юм. Тийм учраас би нэг зүйлийг л хэлж байгаа. Та нар надыг дайрч болно оо, микрофоныг минь хааж болно, ямар ч асуудал алга. Энэ Үндсэн хууль, Үндсэн хууль бол Монгол Улсын ... /минут дуусав/

Г.Занданшатар: Найруулгын санал биш байна. Тогтоолын төсөл батлагдсан. Тэгэхдээ энэ ардчилал, зах зээлийн нийгэм байгуулах өнгөрсөн Пүрэвдорж гишүүн ээ, ардчилал, зах зээлийн нийгэм байгуулах өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид багагүй амжилтад хүрсэн, ялангуяа үг хэлэх эрх чөлөө, ардчилал, улс төрийн чиглэлд багагүй амжилтад хүрсэн. Гэхдээ ажилгүйдэл, ядуурал, авлига, хээл хахууль, ёс суртахууны доройтол гээд нийгмийн бухимдлын шалтгаан, алдаа гэжгийг засах шаардлагатай гэж ард түмэн шаардаж байна. Тогтолцооны шинэчлэл хийх шаардлагатай гэж үзэж байна.

Хөгжил дэвшлийн шинэ ирээдүйг тодорхойлох асуудлыг бол ард түмэнтэйгээ ярьж хийхгүйгээр АН сөрөг хүчний үүргээ гүйцэтгэж чадахгүй, ард иргэд төрд итгэх итгэл суларчихсан энэ үед бол ард иргэдийнхээ санал бодлыг сонсож, тэднийг мэдлэг мэдээлэлтэй болгож, хамтран хэлэлцэж шийдүүлэхийн тулд зөвлөлдөх санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг сая бид баталлаа. Түүнийгээ очиж үзээ ч үгүй байгаа, Пүрэвдорж гишүүн энэ ардчилалдаа итгэж сур аа. Асуудлыг хүчирхийлэл, захиргаадалтын арга замаар биш, харин ардчиллын зарчмаар зөвлөлдөж шийдье ээ гэсэн ийм тогтоолыг гаргаж байгаа юм. Ардчиллынхаа үнэт зүйлд үнэнч байх хэрэгтэй, энэ зарим улсууд. Хямралыг зөвлөлдөх ардчиллын зарчмаар хэлэлцэж шийдвэрлэе гэсэн санал санаачилгыг УИХ, ЗГ, эрдэмтэн судлаачид, иргэд, олон нийтийн байгууллагуудтай хамтран хэлэлцэж шийдвэрлэе ээ л гэж байна шүү дээ.

Болохгүй байна гэдгийг чинь ард түмэн хэлээд байна, шаардаад байна. Энэ нийгмийн бухимдал чинь энэ нүүрсний хулгайгаар илэрч байна. Улс орны нийгэм, эдийн засгийн өмнө тулгамдсан хуримтлагдсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга зам,

эрэмбэ дарааллаа гаргах шийдвэрийн талаар зөвлөлдье ард иргэдтэй. Үүнийг яагаад эсэргүүцээд байгаа юм, ард түмнээсээ асуухыг. Ингэхдээ нийт ард иргэдийг төлөөлөх чадвар, мэргэжил, сонирхлын бүлгийг төлөөлөх чадвар, оролцоог хангах хэрэгтэй. Бүх сумыг төлөөлнө гэвэл энэ нутаг дэвсгэрийн төлөөлөл болж байгаа юм. Харин хэчнээн 3.4 сая хүнийг төлөөлж чадахуйц хэчнээн мянган малчин байна, 300000 малчны төлөөлөл, багш, эмч нарын төлөөлөл ийм төлөөлөл авах хэрэгтэй. Ингэж тэгээд тэднийгээ тэнцвэртэй мэдээллээр хангаж, мэдлэг мэдээлэлтэй болгож байж зөвлөлдөх санал асуулга явуулъя. Ингэж байж асуудлаа тодорхойлъя гэж байна.

Энэ авлигын улмаас төрд итгэх иргэдийн итгэл, төр, ард түмний хэлхээ суларч байна. Төрд итгэх, ард иргэдийн итгэл сулрахад гадаад, дотоод олон хүчин зүйл нөлөөлж байна, өнөө маргаашаа аргалсан хэсэг бусад шийдвэр гаргаж, өдөр хоногийг аргацааж өнгөрөөж сууж бүр болохгүй болчихсон ийм цаг үе. Нийт нийгэм даяараа ард иргэд бухимдаж тэсэрч, тэр дотроо худал, үнэн нь мэдэгдэхгүй попролт, үнэн бодит байдлын үнэнийг олохыг ард түмэн бас хүсэж байна. Хулгайлсныг олж шийтгэхийг шаардаж байна. Иймээс ард түмний засаглах эрхийг хангасан Үндсэн хуулийн 3.1-д заасан заалтын дагуу тэдэнтэйгээ хамтарч, ард иргэдийн төлөөлөлтэй уулзаж хэлэлцэхийг юундаа эсэргүүцээд байгаа юм. Буруудсан, уруудсанаа засаж, авлига, хулгайн үндсийг тасалж, хууль засагладаг ардчилсан төрийн тогтолцоогоо аварч, хөгжлийн шинэ ирээдүйг тодорхойлох энэ түүхэн боломжийг бид олж болохгүй.

Яагаад ардчиллын үнэт зүйлээс урваад байгаа юм. Тиймээс энэ зөвлөлдөх санал асуулгыг ард түмнийхээ төлөөлөх чадварыг хангаж, оролцоог хангаж, шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит тооцоо арга зүйд түшиглэж үр дүнтэй

чанартай зохион байгуулах талаар УИХ-ын гишүүд онцгой анхаарч, идэвхтэй оролцож ажиллах чухал байна.

Өөр нэг анхаарах нэн чухал асуудал бол зарим УИХ-ын гишүүд нь ч гэсэн ардчиллынхаа талаар энэ ард иргэд маань тэнцвэртэй, бодитой мэдээллээр хангагдаж байж энэ төрийн үйл хэрэгт оролцох ёстой юм гэдгийг ойлгож дэмжмээр байгаа юм. Зөв мэдлэг, мэдээлэлтэй хүн л зөв шийдвэр гаргаж чадна, сэтгэлийн хөдөлгөөнөөр, уур бухимдлаар аль эсвэл үзэн ядалтаар асуудлыг шийдэхгүй, улам байдлыг хүндрүүлнэ. Иймээс энэ эрдэмтэн мэргэдтэйгээ ярилцаж, судалгаа шинжилгээ дүгнэлтийг нь авах ёстой. Ийм учраас эрдэмтэн мэргэдээ оролцуулсан эрдэм шинжилгээний бага хурлыг ШУА-тай хамтран зохион байгуулна. Нийгмийн зөвшилцлийн үндэсний хэмжээний чуулга уулзалт зохион байгуулж, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдтэйгээ зөвлөлдөнө. Ингээд асуудлыг бүх түвшинд ил тод, нээлттэй, илэн далангүй аль болох олуулаа хэлэлцье.

Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэдэг. Засаж сайжруулах, бурууг зөв болгох, шинэ замын эхийг тавих, энэ асуудалд Монгол хүмүүс сэтгэлээ шингээж, оюун ухаанаа уралдуулж, байр сууриа илэрхийлж, олон талаас нь шүүн хэлэлцэх ёстой. Гэтэл мэдээж 3,4 сая хүнийг нэг дээвэр дээр цуглуулаад хэлэлцүүлэг өрнүүлж хийж чадахгүй, мэдээж. Бас тэр хүмүүсийг бүгдийг нь эдлэг, тэнцвэртэй, бодитой мэдээллээр хангаж чадахгүй, хүн болгон эдийн засагч, үндсэн хуульч, хуульч, эрдэмтэн байх албагүй, боломжгүй. Ийм учраас эх олонлогоос бага олонлогийг бүрдүүлэх статистик, социологийн шинжлэх ухааны аргачлалыг ашиглаад Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу энэ арга хэмжээг зохион байгуулахад манай УИХ-ын гишүүд, сөрөг хүчин, намуудын төлөөлөл, УИХ-ын Тамгын газар, Үндэсний статистикийн газар онцгой

чухал үүрэг оролцох ёстой шүү. Хяналт тавьж энэ легитим чанарыг нь хангах ёстой шүү. Үүнийг нь дарга нар зохион байгуулахгүй ээ, тэгвэл легитим чанар алдагдана.

Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд Зөвлөлдөх зөвлөл зохион байгуулна. Зөвлөлдөх зөвлөлд нэр дэвшүүлэх ажлыг 23-аас 7 хоногийн хугацаатай зарлаж байна. Энд нийгэмд нэр хүндтэй эрдэмтэн судлаачид улс төржиж биш ухаанаа гаргаж, энэ асуудлыг шийдвэрлэх чадвартай, боломжтой, мэдлэгтэй, мэдээлэлтэй хүмүүсийг нэр дэвшүүлэхийг иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, нийгмийн төлөөллүүддээ уриалж байгаа юм.

Ингээд энэ Зөвлөлдөх зөвлөлийг 30-ны дотор нэрээ авна, энэ нэрийг үндэслээд ирэх онд он гарангуут 30-наас хойш Зөвлөлдөх зөвлөлөө байгуулна. Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн асуудлаар мэргэшсэн, хараат бус, мэдлэг туршилагатай Монгол Улсын иргэн, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн болон тухайн чиглэлийн ТББ-ын төлөөлөл 5-11 хүнтэй байхаар хуульд заасан. Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнд бол улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан байх ёсгүй. Иймээс Зөвлөлдөх зөвлөлд нэр дэвшүүлж, Монголын энэ маргаашийг тодорхойлох чухал үйл хэрэгт идэвхтэй оролцохыг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийн мэргэжлийн холбоо, ХАҮТ, иргэний нийгмийн байгууллагынхандаа уриалж байна. Иргэд хүсвэл өөрийнхөө нэрийг ч дэвшүүлж болно. Дэвшүүлэх ажиллагаа энэ сарын 23-аас буюу маргаашаас эхэлнэ.

Бид бол Монгол хүмүүс Монголоо гэсэн сэтгэлээр Монголынхоо ирээдүйн төлөө, Монгол эх хэлээрээ хэлэлцэн ярилцаж, зөвлөлдөж асуудлаа шийдье ээ гэж байгаа юм. Бид чадах ёстой. Нэг

үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэдэг ч гэсэн төрд дандаа бурууг хийж байгаа хүмүүс байхгүй, сөргөлдөн тэмцэлдэж, сөрөг хүчин байхын тулд биш шахалдан бутарч, эвээ алдаж, аюулгүй байдлаа муутгахын тулд биш, эвийг хичээж, зөвийг олж, шударга ёс, эрүүл тогтолцоог төлөвшүүлэхийн төлөө зөвлөлдөж шийдье ээ гэсэн ийм л тогтоолыг УИХ баталж гаргалаа.

Үүнийг дэмжиж ажиллахыг хүсье.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул үдээс өмнөх чуулган завсарлаж байна.

13.18 цаг

14 цагаас чуулган үргэлжилнэ.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Г.Занданшатар: УИХ-ын эрхэм гишүүдийн өдрийн мэндийг айлтгая.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үдээс хойших хуралдаанаар хэлэлцэнэ.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны 12 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудалд орсон учраас гишүүдийг чуулганы танхимд дуудна.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Дөрөв.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, УИХ-ын гишүүн Хишигээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар танилцуулъя.

Монгол УИХ-ын 2015 оны нэгдсэн чуулганаар Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийг баталж, түүнд нийцүүлэн 2016 онд Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар төрийн цэргийн байгууллагатай холбогдох харилцааг хуульчилсан нь цаг үеийн шаардлагад нийцсэн ач холбогдол бүхий зохицуулалт болсон юм. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Монгол Улсын төрийн цэргийн байгууллагын тогтолцоо нь тайван цагт Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь хэсэгт цэргийн байгууллага нь Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэгтэй, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр үйл ажиллагаагаар зохицуулагддаг, цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг ойлгохоор тус тус заажээ.

Дотоодын цэргийн тухай хуулиар дотоодын цэргийн чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд алба хаагчдын үүрэг, гүйцэтгэх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, улсын онц чухал болон бусад объектын хамгаалалттай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна гэж, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасан мэргэвшсэн, тогтвортой байх гэж, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад заасан албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдана гэж заасан зохицуулалт хангагдах юм аа.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг шинээр тусгасан.

1. Дотоодын цэргийн тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдал. Дотоодын цэргийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар дотоодын цэргийн тогтолцоо, алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрдэж, улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаа болон бусад чиг үүргийн хэрэгжилт сайжирна. Тухайлбал, 1 дүгээрт, дотоодын цэргийг дотоодын цэргийн байгууллага Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн гэж тодорхойлсон, төрөлжсөн болон дэмжлэг үзүүлэх, энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох нэгжтэй байхаар зохицуулна гэж,

2-т, Дотоодын цэргийн штабыг дотоодын цэргийг удирдах мэргэжлийн төв байгууллага болгон штабын даргад Штабын даргын албан тушаалд тавигдах шаардлагыг хуулийн төсөлд

цагдаа болон дотоодын цэргийн аль нэг байгууллагад эс үгүй бол 2 байгууллагад нийт 18-аас доошгүй жил ажилласан байхаар тусгаж, дотоодын цэргийн командлагчийн эзгүйд тодорхой эрхийг итабын дарга хэрэгжүүлэхээр тусгалаа.

3. Дотоодын цэргийн алба хаагчдын үүргээ гүйцэтгэх нөхцөлийг сайжруулах зорилгоор Цэргийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх заалтад заасан хот суурин болон дотор такси үйлчилгээнээс бусад нийтийн тээврийн үйлчилгээгээр үнэ төлбөргүй зорчих гэж, 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон НДШ-ийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно гэж, 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт заасан аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг ЗГ батална гэж заасан нийгмийн баталгааг дотоодын цэргийн албан хаагчид нэгэн адил эдлүүлэх зохицуулалтыг бий болголоо.

4. Дотоодын цэргийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэж байх үед дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглох бөгөөд хараат бус байдлаар албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж, бусад төрлийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдын адил ажилласан хугацааг тооцохоор боловсрууллаа.

Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт улсын онц чухал объектод үүссэн цагийн байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт хэрэгсэл хэрэглэх, дайчлах, объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник технологийн ололтыг нэвтрүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг зохицуулалтуудыг бий болголоо.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Төслийн талаар ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

Ц.Мөнхцэцэг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч улсын онц чухал болон бусад объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа уялдуулах, дотоодын цэргийн алба хаагч, нийтийн тээврийн хэрэгслээр үнэ, төлбөрүүд зорчих, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах зорилгоор холбогдох өөрчлөлтийг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр чиг үүрэг бий болгохгүй, нэмэлт зардал бий болгох

зохицуулалт байхгүй тул хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооллыг хийх шаардлагагүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг Ди парламент цэг мн цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Адьшаа хуулиар халдашгүй байдлыг тогтоох, зөв эсэх талаар, УИХ-ын гишүүн Энхбаяр дотоодын цэргийн төрөлжсөн болон дэмжлэг үзүүлэх, энхийг дэмжих, террорист үйлдлийн эсрэг сөрөг туслан ажиллагаанд оролцох мэргэжлийн нэгжтэй байхаар хуулийн төсөл тусгасан байх бөгөөд тусгай салааг хугацаат цэргээс бүрдүүлэх эсэх, Дотоодын цэргийн штабын дарга нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 18-аас доошгүй жил ажилласан байх шалгуурын талаар, мөн штабын дарга нь дотоодын цэргийн командлагчийг түр эзгүйд түүнийг орлох зохицуулалтын талаар, хот суурины дотор такси, үйлчилгээнээс бусад нийтийн тээврийн хэрэгслээр үнэ, төлбөргүй зорчих шаардлагын талаар, мөн дотоодын цэргийн албан хаагчид халдашгүй эрх олгохоор заасан зохицуулалтын талаар, УИХ-ын гишүүн Сандаг-Очир хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд хууль хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх зардал 2023 оны улсын төсөвт тусгасан эсэх талаар, цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын дундаж цалингийн ялгаа, ажилласан хугацааны нэмэгдэл урамшууллын талаар, мөн газар зүйн байдлаас шалтгаалан алслагдсан дүүргүүдэд ажиллаж байгаа албан хаагчид нийгмийн баталгааг шийдүүлэх асуудал орхигддог, 5 жил тутам 30 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд хамрагдах боломж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

УИХ-ын гишүүн Дэлгэрсайхан хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд цалин хангамж, нийтийн тээврийн хэрэгслээр үнэ, төлбөрүүд зорчихоос гадна орон тоо нэмэх, бие даасан байдлыг хангах асуудлыг нэг мөр шийдүүлэх шаардлагатай талаар, УИХ-ын гишүүн Сандаг-Очир нийгмийн аюулгүй байдал, дэг журмыг сахиулах, албан хаагчдын нийгмийн асуудал, цалин урамшууллыг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллах баталгаа, техник, хэрэгслийг сайжруулах асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх талаар, УИХ-ын гишүүн Цогтбаатар хуулийн төслийг зарчмыг дэмжиж байгаа бөгөөд цаашид хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад иргэдийн эрх, эрх чөлөөг эдгээр байгууллагууд хамгаалахад анхаарах, мөн хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах эрх зүйн сургуулийг тогтмол хамруулдаг байх талаар, УИХ-ын гишүүн Раднаасэд цэрэг, цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид ажиллах нөхцөл, нийгмийн баталгаанаас шалтгаалан ажлаас гарах болсон бөгөөд энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад цалин хангамж, хариуцлага нөхцөлийг сайжруулах талаар, УИХ-ын гишүүн Мөнхбаатар гишүүдээс гарсан дотоодын цэргийн цалин, хангамж, хууль зүйн болон нийгмийн баталгааны талаар хэлэлцүүлгийн шатанд судлан үзэж шийдвэрлэх боломжтой талаар тус тус санал хэлсэн болно.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 70 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүн байна уу, алга байна.

Ажлын хэсгийг танилцуулчихъя.

Нанзадын Наранбаатар гишүүнээр тасаллаа. Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Асуудал нэмэхгүй шүү.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Бямбабаярын Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал Рэнцэндоржийн Чингис, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Лхамдоржийн Нямдаваа, Дотоодын цэргийн штабын орлогч, харуул хамгаалалтын хэлтсийн дарга, дэд хурандаа Нэргүйн Мөнх-Итгэл.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүдийг энэ 7 гишүүнээр таслалаа.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Би зүгээр хууль санаачилгын зүгээс энэ Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулаад нэг 2, 3

асуудлыг нь бас тодруулж асуух гэсэн юм.

Энэ 36.6 дээр дотоодын цэргийн алба хаагч нь Цагдаагийн албаны тухай хуулийн 87.3, 89.2-т заасан баталгаагаар цагдаагийн албан хаагчийн нэгэн адил хангагдана гэсэн нэг ийм заалт орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ 87.3 болоод 89.2 дахь заалтууд нь яг ямар баталгаанууд байгаа юм бол оо. Цагдаагийн албан хаагч нар дээр олгогддог эдийн засгийн баталгаатай холбоотой л гол асуудлуудыг хөндөж тавьж байх шиг байна л даа. Тэгэхээр дотоодын цэрэг дээр бас яг энэ цагдаагийн нэгэн адил энэ эдийн засгийн баталгааг хангана гэдэг асуудлыг тавьж өгч байгаа юм шиг байгаа юм. Тэгэхээр саяын тэр дурдагдсан 87.3, 89.2 гэдэг энэ 2 асуудал маань ямар асуудлыг та хэд хөндөж оруулж ирж байгаа юм бэ. Энэ хууль батлагдсантай холбогдуулаад ямар нэг байдлаар юу гэдэг юм, Төрийн хяналтын тухай хууль болоод төсвийн тухай хуулиудтай зөрчилдөх нэмэлт, өөрчлөлтүүд орж ирсэн үү, эсвэл юу гэдэг юм, төсөв батлагдсан байгаа, төсөв дээр ямар нэг байдлаар ачаалал зардал болох ч гэдэг юм уу, нэмэлт санхүүжилт үүсэх гэдэг юм уу, ийм асуудал байгаа юу.

38.4 дээр хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилтийг авч болно оо гэсэн зүйл байгаад байгаа юм. Мөн 38.3 дээр нь болохоор улсын төсөвт холбогдох шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн санхүүжилтийг тусгаж бас санхүүжүүлнэ ээ гэсэн нэг асуудлууд байгаа юм. Энэ асуудлууд бол зүгээр ерөнхий тунхгийн зүйл заалтаар орж байна уу, эсвэл яг тодорхой, юу гэдэг юм ирэх оноос эхлээд 24 оноос бид нар зайлигүй тавигдах шаардлагатай ийм төсвийн асуудлууд байна уу, үгүй юу, техник тоног төхөөрөмж, санхүүжилтийг бүрдүүлэхтэй холбоотой, ямар ер нь зүгээр төсвийн үүрэг хариуцлага энэ хуулийн хүрээнд

хүлээлгэж байгаа ийм зүйлүүд байгаа юм бэ. Энэ дээр нэг тодруулж хэлээч.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Би Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Энэ 87.3 гэдэг заалт бол цагдаагийн албан хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалж эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон НДШ-ийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно оо гэдэг энэ Цагдаагийн байгууллагын албан хаагч Цагдаагийн байгууллагын тухай хуулиар эдэлж байгаа, энэ тогтвор суурьшилтай ажиллах хөдөө орон нутагт, шилжин ажиллаж байгаа хүмүүст гэр бүлийн гишүүдийг нь ажилтай байлгахтай холбоотой ийм зохицуулалт гэж товчхондоо ойлгож болно.

Тэр хот, суурин газрын асуудлыг бол яриагүй гэж бодож байгаа. 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг бол аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 5 жилд нэг удаа олгодог энэ зохицуулалт одоо ч гэсэн хүчин төгөлдөр байгаа. Тийм учраас дотоодын цэргийн алба хаагчдыг дотоодын цэргийн байгууллагыг ер нь бэхжүүлэх тал дээр Монгол Улсын ЗГ-аас 2017 оноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ бид нар улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг бүхэлдээ дотоодын цэрэг рүү шилжүүлэх ийм шат дараатай ажлууд хийгдэж байгаа. Ялангуяа сум суурин газруудын ундны усны хамгаалалт, онц чухал объектын хамгаалалт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллагад дэмжлэг

үзүүлэх гэсэн ийм үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байгаа.

Сая таны асуулт тэр хамгаалуулагч байгууллагын санхүүжилтийг авч ажиллаж болно оо гэдэг дээр жишээ авч хэлбэл, жишээлбэл бид нар Таван толгойн бүлэг ордын хүрээнд Монгол Улсын ЗГ-аас томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Эрдэнэс таван толгой компанийн харуул хамгаалалтыг дотоодын цэргийн байгууллага гүйцэтгэхээр ЗГ тогтоол гаргаад өнгөрсөн жил дотоодын цэргийн 810 гэдэг шинэ ангийг байгуулсан юм. Нөхцөл байдлын тухайд ер нь томоохон объектуудын гэрээт харуул хамгаалалт дээр хүний нөөцийн дутагдалтай асуудал их байна. Зарим байгууллага, улсын онц чухал объект, улсын компаниудыг хамгаалж байсан гэрээт харуул хамгаалалтын компаниудын бараг 50 орчим хувь нь урьд өмнө нь ял шийтгэл эдэлж байсан хүмүүс энэ тэр хамгаалалтын үүрэг гүйцэтгэж суларсан зөрчил энэ тэр гарсан. Ийм асуудлууд үүссэн учраас бид нар дотоодын цэргийн байгууллагыг нөгөө хамгаалуулагч байгууллагынх нь зардлаар урсгал зардлыг нь гаргуулаад дотоодын цэргийн байгууллага, объектын харуул хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байгаа.

Мөн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед шилжиж ажиллах ийм бас давхар чиг үүрэгтэйгээр ингээд зохион байгуулалт хийж байгаа. Мэдээж хэрэг тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хувьд бол энэ цагдаа, дотоодын цэргийн байгууллага гэдгийг салгаж ойлгож болохгүй. Энэ өнөөдөр цагдаа, дотоодын цэргийн командлагч гэдэг нэг командлагчтай. Цагдаагийн байгууллагын тухай хуулиар заасан үүргээ цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ, мөн ЭХХШТХ-д заасан хэрэг бүртгэлд мөрдөн шалгах ажиллагааг мөн цагдаагийн байгууллага гүйцэтгэж байгаа юм.

Дотоодын цэргийн байгууллага бол 2 үндсэн чиг үүрэгтэй. Цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, нөгөө талдаа улсын онц чухал объектыг хамгаалах ийм 2 үүрэгтэй байгаа. Тэр утгаараа төрийн байгууллагын тоног төхөөрөмжийн шинэчлэл нь өөрөө орчин цагийн энэ мэдээллийн технологийн ололт амжилттай цаг үеэ олж нийлж явах ёстой. Ийм учраас энэ зохицуулалтыг оруулж ирсэн.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Дотоодын цэргийг бэхжүүлэх тал дээр бүх талаас нь дэмжлэг үзүүлнэ ээ. Их чухал асуудал байгаа юм. Энэ олон жилийн туршилагаас харахад бол голцуу л үлдэгдлийн зарчмаар, эсвэл санхүүждэг, эсвэл эрх зүйн зохицуулалтаар нь явж байдаг. Тэр утгаараа дотоодын цэргийн албан хаагчдыг төрийн цэргийн, цагдаагийн болон бусад хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын нэгэн адил нийгмийн хамгаалал, цалин хөлс, сая Нямбаатар сайдын ярьж байгаа тэр гэр бүлийн хүмүүсийн НДШ төлөх гэх мэт нийгмийн хамгааллын чиглэлүүдийг нь дэмжиж байгаа юм.

Энэ дээр Байнгын хороон дээр нэлээн ярьсан л даа. Тэгээд бас тодорхой гүйцэд хариулт авч чадаагүй 2, 3 асуудал байгаа юм. Үүнийг би нэгдсэн хуралдаан дээр бас хөндөж ярьж, бас тал талдаа бодож үзмээр асуудлууд байгаа юм.

1 дүгээрт байна шүү дээ, энэ дотоодын цэргийн бүтэц бүрэлдэхүүн дээр энэ төрийн энэ бүх объектуудыг хамгаалалтад авна гэвэл нэг том асуудал гарч ирж байгаа юм. Энэ хувийн хамгаалалтын байгууллага, компаниуд чинь бол нэлээн том ачаа үүрээд явж байгаа байхгүй юу. Тэгээд бас их ажлын байр бий болгож байгаа юм. Тэгээд уул нь төрийн бодлогоороо бид нар болж л өгвөл энэ ажлын байрыг хадгалуулаад баймаар байгаа байхгүй юу. Хувийн

сектор үүрэг ном журмынхаа дагуу ажлаа гүйцэтгээд явж байвал тэр хувийн секторыг нь дэмжээд, шаардлагыг нь тавиад, тэр ажлын байраа хадгалаад явах нөхцөлийг бүрдүүлмээр байгаа юм. Тэгэхгүй бол энэ чинь нөгөө бидний төрийн бодлогоор дэмжиж байх ёстой юм, аль болохоор л хувийн секторын бий болгосон ажлын байруудыг л бид нар хадгалж үлдмээр байгаа байхгүй юу. Жишээ нь хамгийн том жишээ гэхэд л энэ сая энэ Улаанбаатар хотод чинь юу болчихлоо шүү дээ энэ олон нөгөө Си Ю, Жи 25 гээд л нөгөө олон сүлжээнүүд гарч ирээд маш олон жижигхэн, 8 нэрийн барааны дэлгүүрүүд, хоол ундааны газрууд гээд эд нар чинь хаагдахад хүрээд маш олон хүн ажлын байргүй болж байгаа байхгүй юу. Үүнийг хүртэл бид нар бодолцооор байгаа байхгүй юу. Тэр том сүлжээний шаардлагыг хангаад, тэр сүлжээний Фрэнчайзинг авч чадах хүн хэд байна, гэтэл авч чадаагүй хүмүүсийн цаана хэдэн хүн аж амьдралгүй болж байна, хэдэн хүний орлого хаагдаж байна, хэдэн хүн ажлын байргүй болж байна гээд алхам тутамдаа бид нар тооцож үзэж баймаар байгаа юм. Тэгээд үүнийг хэдүүлээ бас их бодмоор байгаа юм. Гарцаагүй шаардлагатай юмаа л дотоодын цэргээрээ хамгаалуулдаг, үлдсэнийг нь бол тэр хувийн сектортой гэрээ байгуулаад, шаардлага тавиад үйл ажиллагаа нь явж байвал нэг их айхтар хөндмөөргүй байгаа юм уу. Яагаад гэвэл тэнд чинь маш олон хүн, ялангуяа энэ залуучуудын ажлын байр байгаа шүү.

2 дугаарт, энэ хуульд байна шүү дээ, энэ дотоодын цэргийн албан хаагчдыг дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албан үүргээ гүйцэтгэж байхад нь ямар нэгэн байдлаар цагдан хорихгүй, ер нь бол яг л УИХ-ын гишүүний халдашгүй байдалтай адилхан аваачиж очиж байна. Энэ миний бодлоор ингэж явж болохгүй ээ. Тэр хууль хяналтын байгууллагуудад ажиллаж байна уу, дотоодын цэргийн алба хааж байна уу, энэ халдашгүй

байдал гэдэг чинь зөвхөн парламентдаа л хадгалагдаж байдаг. Тэгэхдээ хадгалагдах хадгалагдахдаа зөвхөн ард түмний элч төлөөлөгч учраас, ард түмний элч төлөөлөгч учраас төрийн эрх байгууллагын дээд эрх барих дээд байгууллагын гишүүн учраас нь хамгаалж явж байгаа юм шүү дээ. Үүнийг бодолцмоор байгаа юм.

3 дугаарт, энэ сая Тэмүүлэн гишүүн асуугаад яачихлаа. Бас тодорхой хариулт авч чадсангүй, энэ хар аа. Хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт хүч хэрэгсэл дайчилна гэж байгаа юм. Тэгээд нөгөө хамгаалуулж байгаа байгууллагаасаа шаардлагатай бол нэмэлт санхүүжилтийг авч ашиглах гэж байгаа юм. Ийм open эндид буюу эхлэл нь хаана байгаа юм, хаана дуусаж байгаа нь ойлгомжгүй, эрх дарх бас олгож болохгүй байх аа ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Би Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт хувийн сектортой ажлын байр булаацалдамгүй байна аа, би яг 100 хувь санал нэг байгаа. Мөнх-Оргил сайд бид нар энд бас нэг бүтэн том дэлгэрэнгүй зураглал яримааргүй байгаа юм. Бид нар бүсчилсэн байдлаар дотоодын цэргийн 1-2 анги байгуулах ийм төлөвлөлт байгаа. Өнөөдөр төсөв дээр мөнгө байхгүй, тэгээд хамгаалуулагч байгууллагын хүсэлт буюу төрийн өмчит хамгийн томоохон компаниудын өөрсдийнх нь хүсэлтийг үндэслээд энэ дотоодын цэргийн анги байгууллагуудыг байгуулж байгаа юм. Үүнийг би товчхондоо л тэгж хэлье. Цаашид бид нар Дорноговь, энэ Сайншанд энэ нефтийн шинэ боловсруулах үйлдвэр хавьд түшиглэсэн ийм дотоодын цэргийн 1 анги бас байгуулахаар төлөвлөж байгаа юм.

Бусдаар таны ярьж байгаа шиг тэр жижиг ААН байгууллагууд, сүлжээ дэлгүүрүүдийн харуул хамгаалалтын

тухай, ерөөсөө огт ойлголт, дотоодын цэрэг хамгаалах тухай ойлголт байхгүй. Нэг үед хамгаална, тэр нь хэдийд вэ гэвэл нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед дотоодын цэрэг, нэн шаардлагатай хүнсний болон бусад энэ олон нийтийн үйлчлүүлдэг цэг, салбаруудыг хууль бус тэр үйлдэл халдлагаас хамгаалах ийм цаг үеийн шаардлагатай хамгаалалтыг л хэрэгжүүлнэ. Түүнээс биш бусдаар хувийн сектортой ажлын байр булаацалдаж байгаа зүйл байхгүй.

Бид нар баруун бүсдээ үндсэндээ юуны Говь-Алтай аймаг руу татаж байгаа, Тайшираас татаж байгаа УЦС-ын хамгаалалт, Ховд, Баян-Өлгий, одоо Увс, Архангай гэсэн нэг ийм тодорхой чиглэлүүдээр бид нар ундны усны аюулгүй байдлыг хамгаалах ийм төлөвлөлтүүд гаргаад явж байгаа.

Зүүн бүсдээ Дорнодоос салбар татаж, Хэнтийн болон Бор-Өндрийн ундны усны хамгаалалт дээр ийм жижигхэн нэгж үүсгэхээр, Дорноговь гэсэн нэг ийм чиглэлтэйгээр бид нар төлөвлөлт хийж явж байгаа. Тийм учраас хувийн сектортой ямар нэгэн ажлын байр булаацалдсан зүйл байхгүй.

Таны 3 дахь асуулт энэ 1 дүгээр асуулттайгаа уялдаж байгаа юм. Жишээлбэл, бид нар Эрдэнэс таван толгойтой хамгаалалтын үүрэг гүйцэтгэх гэрээндээ тодорхой тоног төхөөрөмжийг авах эрх зүйгээ үүгээр үүсгэхгүй бол яг өнөөдөр та өөрөө дотоодын цэрэгт та өөрөө Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан хүний хувьд ямархуу хөрөнгө мөнгө төсөвлөдгийг мэдэж байгаа. Тийм учраас бид нар гэрээний үндсэн дээр санхүүжилтийнхээ тодорхой хэсгийг тоног төхөөрөмж байдлаар авах эрх зүйн үндэслэлээ энд гаргаж ирж байгаа л гэдгийг ойлгож болно. Түүнээс бид нар ингээд хамгаалуулагч байгууллагаасаа тоног төхөөрөмж, бүх зүйлээ аваад энэ талаас улсын төсөв дээр давхар, хөрөнгө

мөнгө аваад байгаа, ийм давхардсан төсвийн үрэлгэн зохицуулалтын тухай ерөөсөө огт дурдаагүй ээ гэдгийг хэлье.

2 дахь асуудал дээр энэ манай бодлогын газрынхан томъёолохдоо гишүүдэд буруу ойлгогдохуйцаар томъёолчихсон байгаа. Бид нар үүнийг Байнгын хороон дээр уг нь ярьсан, үүнийг Цолмон, хэн Анхбаяр 2 хэдүүлээ хэлэлцүүлгийн шатанд эргээж хармаар байгаа юм. Үүнийг ганцхан л өгүүлбэр болгочихъё. Улсын онц чухал объектыг хамгаалж байхад хамгаалж байгаа этгээдийг баривчлах, цагдан хорих ийм нөхцөл байдал үүссэн үед дотоодын цэргийн командлагчид мэдэгдээд, орных нь хүнийг уг объект дээр томилж үлдээгээд, цааших процессын ажиллагаа үргэлжилж болно гэдэг агуулгаар уг нь бид нар бичиж орж ирсэн. Гэтэл ингээд бичилтийн явцад явсаар байгаад халдашгүй дархан эрх рүү оччихсон юм. Улсын онц чухал объектыг хамгаалж байсан 2 объектыг хамгаалж байсан 2 постын харуулыг одоо юу гэдэг юм танхайрсан, бүлэглэж хүн зодсон ч гэдэг юм уу ийм асуудлаар хойшлуулжгүй баривчлах, цагдан хорих асуудал үүссэн тохиолдолд объект эзгүйрчих гээд байгаа юм аа. Тэр тохиолдолд нь дээд удирдлагад нь мэдэгдээд, орных нь хүнийг томилуулаад дараагийн процессын ажиллагаа үргэлжилж болно оо гэсэн ийм агуулгаар зохицуулалтыг нь оруулж ирье. Бид буруу ойлгуулж томъёолол бичсэн бол бас гишүүдээсээ хүлцэл өчье өө гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулъя, 1 минут.

Ц.Мөнх-Оргил: Албан үүргээ гүйцэтгээд харуул хамгаалалтад зогсож байхад нь баривчлахгүй байх л хэрэгтэй л дээ. Тэгэхдээ тэрийг энэ хуульдаа биш бараг процессын хуульдаа оруулчихвал илүү зохимжтой байж магадгүй л юм шиг байна. Тэр эхний асуудал Нямбаатар сайд аа, Та нар маань сайн бодоорой, жишээ нь Эрдэнэс таван толгой, нэг

хувийн компанитай гэрээ хийгээд ажиллаад явж байсан бол дотоодын цэрэг очих юм бол тэр чинь бас л нөгөө тэр юутай нь хувийн сектортой бизнес булаацалдах л юм руу л орно шүү дээ. Тэрийг сайн хараарай.

Зүгээр хамгийн гол юм бол ерөөсөө л ийм л надад харагдаад байгаа юм. Энэ дотоодын цэргийн яг үүрэг функц нь яг юу байх юм бэ. Яг цагдаагаасаа юугаараа ялагдах юм. Цагдаа, дотоодын цэрэг 2 яг хаана яаж холбогдох юм, хаана яаж команд бүтэц, төсөв мөнгө нь яаж салах юм, салах юм уу, салахгүй юм уу, хувийн хамгаалалтын компаниудтай ямар хамтын ажиллагаатай байх юм, ямар харил ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд эхлээд хариулна.

Х.Нямбаатар: Мөнх-Оргил сайд аа, энэ нөгөө Эрдэнэс таван толгой дээр нэг компани байсан юм. Их л ар өврийн хаалгатай юм. Тэр компанийг бид нар үнэхээр бас болохгүй байна аа, саяын нөгөө хулгайн нүүрс гэдэг асуудал ч яригдаад ингээд өөрчлөх зүйл болсон юм. Тэгээд бид нар ер нь юмыг аягүй хурдан мартаж байгаа юм. Сая бид нар оны эхний 4 сарын байдлаар Цагаан хаданд 12000000 тонн нүүрс овоорчхоод байна аа, шинэ нүүрсээ зарж чадахгүй нь ээ, төсвийн орлого бүрдэхгүй нь ээ, тасарлаа гээд хүнд байдал үүсээд манай Наранбаатар гишүүн эд нар мэдэж байгаа, энэ шинэ байгуулагдсан анги чинь өнөөдрийн энэ 30 сая тонн нүүрс гарах энэ онд бид нар бараг рекорд тогтоож байгаа шүү дээ. Энэ хэмжээнд халдвар хамгааллын дэглэм журмыг сахиулж чадсан юм аа. Тэгэхээр дотоодын цэрэг энэ бас улсын экспортын томоохон хэсгийг бүрдүүлдэг томоохон ААН-үүд дээр төрийн бодлоготой уялдаад энэ хулгайн нүүрснээс сэргийлэх энэ чиглэл дээр илүү их үр дүнгүүд гаргаж эхлээд байгаа юм гээд ... /минут дуусав/

Г.Занданшатар: 82 Нямдаваа цагдаагийн хурандаа.

Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя, ЦЕГ Нямдаваа. Гишүүний түрүүний дурдаад байгаа нөгөө бүх хувийн хэвилийн байгууллагуудын харуул хамгаалалтыг авах гээд байна гэсэн ойлголт байгаад байх шиг байна. Дотоодын цэргийн тухай хуулийн 5.1.4 дээр улсын онц чухал болон шаардлагатай бусад объектуудын жагсаалтыг бол ЗГ тогтоохоор байгаа. Тэгэхээр дотоодын цэргийн командлагч гэдэг юм уу, дотоодын цэргийн байгууллага маань дураараа бол ямарваа нэгэн хуулийн этгээд, ААН, объектыг бол авахгүй. Заавал ЗГ-ын тогтоолоор заасан жагсаалтад орсон байгууллагыг авна гэсэн үг.

2 дугаарт нь, дотоодын цэргийн үндсэн чиг үүрэг нь юу байх вэ гэж асууж байна. Дотоодын цэргийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд үндсэн чиг үүргийг бол дараах зургаагаар бол тогтоосон байгаа.

1 дүгээрт нь, улсын онц их л объектыг хамгаалах,

2 дугаарт нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх,

3 дугаарт нь гамшиг, аюулт үзэгдэл, осол аюул тохиолдсон тохиолдолд аврах, хор уршигийг арилгах, хойшлолгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх буюу гамшигаас хамгаалах байгууллага ... /минут дуусав/

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Дотоодын цэргийг төрийн цэргийн байгууллага болгосон, тэгэхээр энэ талаас нь аваад үзвэл тухайлбал цагдаатай адилхан эрхтэй,

үүрэгтэй, хангамжтай байх энэ асуудлуудыг нь зарчим хувьд дэмжиж байна. Саяын яамны танилцуулсан нь дээр нэмэгдээд энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, мэргэжлийн ажиллагаанд оролцох гэсэн ийм эрх үүрэг нэмэгдэж байна гэж ойлголоо. Энэ юмнуудаа дотоодын цэргийн үүрэг дотор нэмж тусгасан уу. Урьд нь энэ байхгүй байсан үгнүүд санагдаад байх юм. Хэдийгээр яг практик дээр, дотоодын цэргээс ч гэсэн хүмүүсийг энхийг дэмжих ажиллагаанд тодорхой тоогоор явж байгаа ч гэсэн. Тэгэхээр хуульдаа үүнийг оруулсан уу, үгүй юу гэдгийг нэг тодруулъя.

2-т, Мөнх-Оргил гишүүнтэй ярьж байгаа юмнууд ерөнхийдөө давхцаад байна аа, би сая бас Байнгын хороон дээр яригдсан асуудлаар сайдтай асууж үзсэн, яригдаж үзсэн. Энэ гэмт хэрэг үйлдэж байхад нөгөө хэргийн газраас үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилбал энэ ойлгомжтой. Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ энэ дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдаж хорих, баривчлахад нь бас тодорхой хязгаарлалт тавьж би бол болно гэж бодож байна. Гэхдээ үүнийг харин заавал ерөнхий командлагчийн хэмжээнд очиж хэрэг шийдэж байх шаардлага байна уу. Эс үгүй бол яг тухайн харуулыг тухайн үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг тодорхой хугацаанд томилдог тэр нэгжийнх нь удирдлага хурдан шийдээд солиод баривчлуулаад явуулдаг юмыг нь хийхгүй бол анги дээр очно, дээшээ явна, штаб дээр очно, тэгээд командлагчид хүрнэ. Тэгсээр байтал энэ хооронд чинь бас асуудал гарах юм биш биз дээ. Заавал командлагчид хүрч байх хэрэг байна уу, үгүй юу, яагаад ингэж хийсэн юм. Үүнийгээ нэг бодолцох хэрэгтэй юм байж байна.

Түүнээс орон байр, албан тасалгаа, тэр үзлэг нэгжлэг хийх энэ

тэр бол арай болохгүй юм орчихсон байна лээ, тэгээд буруу томъёолсон юм байна, тэрийг ойлголоо. Энэ дээр нэг тайлбар өгөх хэрэгтэй байна.

Энэ дагалдаж явж байгаа хууль дотор нэг ийм зүйл байгаа юм. Зөрчлийн дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект гэсэн ойлголт байгаа. Түүнд нь яг юу орох юм бэ гэдгээ бас аль хууль дээр юм нь тодруулж өгөх хэрэгтэй байна, жишээ нь томоохон ААН-үүд юу гэдэг юм, уурхай байдаг юм уу. Яг үндсэн үйл ажиллагаа явуулж байгаа үйл ажиллагаанаас гадна тэндээсээ хол зайтай газар нэг юу гэдэг юм, туслах аж ахуйн ч байдаг юм уу, аж ахуйн хашаа нь ч байдаг юм уу, нэг ийм юм байж байвал түүн дээр заавал дотоодын цэргийг аваачиж цэргийн албан хаагчаар хамгаалуулж байх хэрэг байна уу, үгүй юу. Тэнд хувийн хэвилийнхэн хангалттай хийчихнэ шүү дээ, бүрэн хангалттай хийчихнэ. Гэрээгээ байгуулаад л үүрэг хариуцлагыг тодорхой болгоод л хийчихнэ биз. Тэгэхээр энэ дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект гэдгээ бас тодруулмаар юм шиг санагдаж байна надад. Бүх юмыг дотоодын цэрэг нэртэй л байвал тэрийг нь дотоодын зэрэг хамгаалуулах гэж оролдож бид нар угаасаа хэрэггүй шүү дээ. Зардал мөнгө талаасаа ч, ачаалал талаасаа ч тэр, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагууд, хувийн хэвилийн байгууллагууд хэрэгжүүлж байх ёстой гээд энэ төрийн бодлого яваад байгаа бол үүнийхээ хүрээнд энэ асуудлаа тодруулмаар байна, эсвэл ядаж дүрэм журам гарвал, эсвэл болж өгвөл энэ хууль дээрээ яг ямар ямар хэсгүүд байна гээд тодорхой заагаад өгчихвөл саяын Мөнх-Оргил гишүүний яриад байгаа шиг, сая миний тавиад байгаа шиг ийм асуудлууд гарахгүй. Объектынх нь заагийг ач холбогдлоор нь хийгээд өгчих хэрэгтэй юм байна аа. энэ дээр ямар бодолтой байна вэ. Зарчмын хувьд бол хэлэлцэхийг нь дэмжинэ ээ, тэгээд шаардлагатай бол би хэдийгээр яг энэ Байнгын хороонд нь байдаггүй ч гэсэн

саналын томъёолол оруулаад хэлэлцүүлэгт нь оролцож болно оо гэж бодож байна.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Энхболд гишүүний асуултад би хариулъя. Төрийн цэргийн байгууллага гэдэг утгаараа дотоодын цэрэг нь төрөлжсөн болон дэмжлэг үзүүлэх, энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны гэсэн ийм нэгжүүдтэй болгож, төрийн цэргийн байгууллагын нэг нэгжийнхээ хувьд саяын дурдсанчлан ийм нэгжийн хэлбэрээр зохион байгуулагдаж ажиллахаар энэ хуульчилж өгч байгаа юм. Ингэж хуульчилж байгаагийн гол агуулга нь цагдаа, дотоодын цэргийн байгууллага энхийг сахиулах ажиллагаанд оролцох эрх зүйн үндэс нээгдсэн. Саяхан бас Монгол Улсын ЗГ-ын хуралдаанаар энэ асуудал дэмжигдсэн, цаашид Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн тэр чиг үүргийг гүйцэтгэхээр бас оролцох бэлтгэлээ Монгол Улсын цагдаа, дотоодын цэргийн байгууллага бэлтгэж байгаа. Үүнийхээ хүрээнд бид нар энэ нэгжээ тусгайлан энэ хуульд заасан энэ хэлбэрээр нь зохион байгуулж байгаа гэж ойлгож болно. Өмнө нь яг таны хэлж байгаачлан Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагаанд ордог энэ нэгжид багтаж цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас цөөн тооны төлөөлөл явдаг байсан бол Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд тусдаа цагдаагийн корпус явах ийм боломж нөхцөл бүрдэж байгаа. Энхийг сахиулах ажиллагааны үеэр цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх, энэ хүрээнд дотоодын цэргийн байгууллага нэгдэхээр болж байгаа гэдгийг хэлье.

Дараагийн дугаарт, ер нь бол дотоодын цэрэг, тэр хувийн секторын объектуудыг ер нь хамгаалах эрх зүйн орчин хуулиараа хаалттай гэж ойлгож

болно. Монгол Улсын ЗГ-ын тогтоолоор онц чухал объектын жагсаалтыг баталдаг, ингэхдээ энэ онц чухал объектын жагсаалтад нэр нь дурдагдаад ЗГ-ын тогтоол батлагдсанаар тэр тухайн төрийн болон орон нутгийн өмчит компанийн тодорхой, хамгаалалтын хамгаалуулагч гэдэг тэр томъёоллоор онц чухал объектын жагсаалт багтдаг учраас ер нь бол цаашид хувийн сектортой ноцолдож, ажлын байрыг булаацалдах ийм ойлголт бараг байхгүй ээ.

Би түрүүн ерөнхийдөө товчхон хэлсэн, одоо бид нарт нэг 2 бүс нутагт тусдаа дотоодын цэргийн томоохон нэгжүүдийг байгуулах ийм шаардлага байгаа. Энэ нь дотоодын цэргийн байгууллагын цаашидын хөгжлийн тэр тодорхой баримт бичгүүдэд бид нар тусгалаа олсон. Нөгөө талдаа нийгмийн дэг журмыг сахиулах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх байдлаар ийм төлөвлөлтөд тусгасан байдлаар бид нар томъёолж байгаа гэдгийг түрүүн хэлсэн байгаа.

Таны хэлсэн тэр би саналыг бүхэлдээ хүлээж авч байна. Тэр юутай холбоотой, заавал командлагчийн түвшинд асуудал, шийдэлгүйгээр тухайн нэгжийн удирдлагад нь танилцуулаад, орных нь хамгаалах, Дотоодын цэргийн алба хаагчийг томилуулаад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашид ердийн журмаараа үргэлжилнэ ээ гээд. Мөнх-Оргил гишүүний хэлж байгаачлан юуны ЭХХШТХ-д дурдах юм бол бүх ийм халдашгүй болон тодорхой зөвшөөрөл авдаг нэгжүүдийг энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд бичих юм бол энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль бол бас боломжгүй ээ гэж хууль зүйн техникийн хувьд бол би боломжгүй гэж ойлгож байгаа. Тийм учраас дотоодын цэрэг дээр нь яг саяын байдлаар үгчлээд, тэгээд дээр нэгжийн удирдлагад нь мэдэгддэг байдлаар ингээд

процесс үргэлжлүүлэхээр хуульчилж өгөх нь зөв юм байна гэж ойлголоо.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя, 1 минут.

Н.Энхболд: Тийм, миний эхний асуулт нь нөгөө одоо хуулиар дотоодын цэргийн чиг үүрэг гээд заачихсан юмнууд дотор энэ энхийг дэмжих, террорист үйлдлийн эсрэг тусгай ажиллагаанд оролцох гэдэг үг чинь байгаа юу, үгүй юу гэдгийг л тодруулж байгаа юм. Байгаа бол хамаа алга, тэнд байгаа бол нэгжээ хийгээд явчих, байхгүй бол чиг үүргээ хуульдаа тусгаж байгаад дараа нь тэрийгээ гүйцэтгэх нэгжийнх нь тухай асуудал нь зөв байх гэж бодож байгаа юм.

Тэр хамгаалагдах объектын хувьд яах вэ, жагсаалтаар нь ингээд гаргачихна л даа, одоо юу гэдэг юм Эрдэнэс таван толгой ч гэдэг юм уу. Оюутолгой ч гэдэг юм уу. Тийм ээ, тэгэхдээ түүн дотор чинь түрүүн би хэлсэн шүү дээ, нэг нөгөөдхөөсөө нэг арваад километр газар байж байгаа аж ахуйн хашаа ч байдаг юм уу, нэг хэдэн малтай туслах аж ахуйнхаа юмыг заавал цэрэг очиж хамгаалж байх хэрэг байна уу, үгүй юу. Тийм учраас энэ ЗГ-ын объект, ЗГ-аас объектынх нь нэр гарлаа ч гэсэн тэр объект дотор энэ энэ хэсэг нь ерөнхий юмнудаар зааж байна шүү дээ, заавал цэрэг хамгаална, энэ нь хувийн компаниуд байж болно оо гэсэн юм яачихвал саяын ... /минут дуусав/

Г.Занданшатар: Нямдаваа 82.

Эрхэм гишүүний асуултад хариулъя, ЦЕГ-ын Нямдаваа. Дотоодын цэргийн гүйцэтгэх үндсэн чиг үүрэг дээр нь террорист сөрөг тусгай ажиллагаанд оролцох, тусгай ажиллагаанд оролцох гээд үндсэн чиг үүргийг нь бол заагаад өгчихсөн байгаа. Энэ үйл ажиллагааны хүрээнд юуг ойлгох вэ гэвэл 16.1 дээр нь цагдаагийн байгууллагатай хамтран террорист сөрөг тусгай ажлыг таслан зогсоох ажиллагаанд бол оролцоно оо

гэдэг ерөнхий чиглэлийг нь заачихсан байгаа.

Түрүүн нөгөө нэг ЗГ-ын тогтоолоор объектын нэрийг авчхаад хүрээ хязгааргүй авчих юм биш биз дээ гэдгийг бол дотоодын цэргийн нөгөө алба ажиллагааны журмаараа бол ЗГ-аас баталсан ийм албан усалгааны журам гардаг, энэ журмынхаа дагуу улсын онц чухал объектыг хамгаалах тэрний хүрээ хязгаарыг нь бол тогтоож өгдөг болно оо, тийм болно. Энхийг дэмжих болохоор энхийг дэмжих, нөгөө сахиулах ажиллагааны хуулиараа зэвсэгт хүчин, бусад цэрэг гэсэн байдлаар ингээд зохицуулагдаад тэр хуулиараа явчхаж байгаа гэсэн үг.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Дотоод цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ерөнхийд нь утгаар нь дэмжиж байна аа. Энэ дээр би нэг 2 гуравхан нэг санаа нэмье гэж бодоод, тэгээд та хэд бас ажлын хэсэг дэмжигдээд хэлэлцэх ажлын хэсэг дээр энэ санааг бас оруулаасай гэж хүсэж байна. Тэр юу байна вэ гэхээр, ер нь бол бид энэ цэрэгжилтийн бэлэн байдал, иргэдийнхээ давтан сургалт, энэ бэлэн байдлыг хангах энэ чиглэлээр нэгэнт энэ хуулийг хөндсөн юм чинь эндээ бас тусгаж, төсөв энэ тэр суулгаж өгч баймаар байх юм. Жишээлэх юм бол бид 10 жилд байхдаа бол цэрэгжилтийн хичээл гэж ордог байлаа, одоо 10 жилийн сургуулиуд тэрийг үзэж байна уу, үгүй юу. Автомат АК энэ тэрийг чинь задлаад буцаагаад угсраад гар буу энэ тэрийг чинь магазин энэ тэр цэнэглэдэг энэ тэр, тэрийг чинь сурдаг байлаа шүү дээ. Ялангуяа энэ дээд боловсролтой болж байгаа залуучууд, тэр дотроо эмч, эмнэлгийн ажилчид энэ цэрэгжилтийн сургалтын юм байхгүй, нөгөө цэрэгт явдаггүй учраас энэ чиглэлээр мэдлэг их дутмаг, тэгээд одоо дэлхийн нөхцөл

байдал бас тийм амаргүй байгаа энэ нөхцөл байдалд, ер нь бол Швейцарын иргэдээ цэрэгжилтэд бэлтгэдэг бага зардлаар тогтмол жил болгон одоо ээлж дараалуулан 14-21 хоногоор байршуулан цэрэгжилтийн бэлтгэл хийлгэдэг энэ технологи нь өөрөө их зөв юм гэдгийг бас олон хүмүүс яриад байдаг. Зардал багатай, тэгээд иргэдээ цэрэгжилтэд сургадаг бэлтгэдэг. Тэгэхээр энэ дотоодын цэргийн энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ зүйлийг тусгах боломж бий юү. Мэдээж энэ Батлан хамгаалах хуульдаа орох л байх, гэхдээ үүнийг эндээ тусгаж оруулж өгч, ер нь иргэдээ цэрэгжилтэд бэлтгэх, боловсрол олгох чиглэлд, бас дотоодын цэргийн хүчийг бас дайчилъя гэсэн энэ санааг оруулж өгөөсэй гэж хүсэж байна. Энэ дээр хариулт өгөхгүй юү.

Г.Занданшатар: Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Би Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа Үндсэн хуулийг дагаж хэд хэдэн том бодлогын баримт бичгүүд батлагдсан юм. 1994 онд шиг санаж байна, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Батлан хамгаалах үзэл баримтлал, Цэргийн номлол, Гадаад бодлогын үзэл баримтлал гэсэн ийм Үндсэн хуулийг дагасан бодлогын томоохон баримт бичгүүд батлагдсан юм. Энэ дотор батлан хамгаалах тэр бодлогын баримт бичиг дотор цэрэг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх саяын таны хэлдэг энэ бүх зорилтууд үндсэндээ тусгагдсан. Тэгэхээр энэ бодлогын баримт бичиг нь өөрөө батлан хамгаалах энэ салбарын хууль тогтоомж болж, сүүлд 2015 онд шинэчлэгдсэн. Цаашид таны хэлж байгаа энэ асуудал бол үндсэндээ энэ батлан хамгаалах салбарын бодлогын баримт бичгүүд дээр илүү детальчилж тусгагдаж явах ёстой. Швейцар болон бид нарын үлгэр жишээ авдаг улс орнууд, БНСУ гэх мэт энэ улс

орнуудад бол хүн болгоныг цэрэгт татаж нэг талдаа төлөвшил олгох, цэрэг эх оронч хүмүүжил олгох ийм агуулгаар явдаг. Бид өнөөдөр бас төсөв санхүүгийн нөхцөл байдлаасаа шалтгаалж нийт цэргийн насныхаа залуучуудын тодорхой хувийг л зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэгт хугацаат цэргийн албан хаагчаар татаж, цэргийн боловсрол эзэмшүүлэх ийм чиглэлээр ажиллаж байгаа юм. Зүгээр бид нарын тэр хамгийн их хардаг Израил гэх мэт энэ улсад бол бүр эрэгтэй, эмэгтэйгүй цэрэгт татдаг, хүн болгоныг яг адилхан, нэг орчинд байлгаж, нөгөө хүнийг үзэх үзэл, ертөнцийг үзэх үзэл нь яг адилхан гэдэг тэр төлөвшил олгодог ийм тэргүүн туршилагууд бий. Тэгэхээр үүнийг бол цаашид батлан хамгаалах салбарын энэ бодлогын баримт бичгүүдэд тусгаад, цаашидаа үе шаттайгаар залуучуудыг ялангуяа бүхэлд нь цэрэг татаж, тийм ээ, хуарангийн амьдрал үзүүлээд хүн болгон хөрөнгө чинээ бүх байдлаараа ялгаатай хэдий ч хүн адилхан гэдэг тэр суурь тэр хүмүүжил, ухагдахууныг өгөх чиглэл дээр бид нар бас бодлого барьж ажиллах л ёстой гэж би яг тантай адилхан бодож явдаг хүний нэг ээ.

Г.Занданшатар: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Одоо байгаа хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд дотоодын цэргийн албан хаагчдын нийгмийн асуудал, энэ юмнууд нь ер нь ямархуу байдаг юм, бодвол бусад цагдаа, онцгой, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудтай харьцуулахад нийгмийн асуудал хангамж нь бага байдаг юм байна гэж ойлгож байна, тийм. Тийм учраас энэ бусад энэ байгууллагуудтайгаа ижил түвшинд аваачих бол зайлиггүй шаардлагатай байгаа нь тодорхой байгаа байх гэж бодож байна.

Тэгээд энд хэдий хэмжээний төсөв, ер нь хэдэн хүн одоо энэ юунд

хууль батлагдсанаар хамрагдах болох юм, хэр их хэмжээний төсөв энэ улсын төсөв дээр нэмэгдэж орж ирэх юм бол, тийм хууль нь хэзээнээс эхэлж хүчин төгөлдөр болоод ингээд явах бол оо гэсэн нэг ийм багцаа авчихмаар байгаа юм.

2-т нь, гэвэл тэр хувийн хэвшлийн хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагааны урдуур ороод төр бүх юмыг хийж байна гэдэг нэг талаасаа, нөгөө талаасаа бас зайлиггүй, бас энэ дотоодын цэргээр хамгаалуулах зайлиггүй шаардлага гардаг л даа, тухайлбал, тэр хилийн боомтын асуудал, төрийн өмчит томоохон ААН объектуудыг хамгаалуулах гээд ийм асуудлууд бол гардаг аа. Тэгээд үүнийг бол би ойлгохдоо энэ ЗГ-аас баталж гаргадаг жагсаалтуудаасаа хязгаарлаад өгчих юм байна шүү дээ. Тэгэхээр зэрэг нөгөө бусад хувийн ААН-үүд рүү хамаагүй ороод ингээд хүсэлт өгсөн болгон дээр очоод ажиллаад байх боломж нь үүгээр бол хязгаарлагдчих юм байна гэж ойлгож байна.

Ер нь энэ, ялангуяа энэ суманд, хөдөө орон нутагт бол энэ дотоодын цэргийн энэ орон тоо, төсөв нь хүрэлцээгүй байдгаас болоод зайлиггүй хамгаалуулах шаардлагатай тухайлах юм бол энэ сумдын цэвэр усны эх үүсвэр энэ тэр одоогоор хамгаалалт муутай л, эзэнгүй л байдаг байх гэж бодож байгаа юм. Тийм, тэгэхээр энэ дээр та бүхний өнөөгийн байгаа энэ орон тоо юмнууд хэр байна вэ. Цалин хангамж, нийгмийн баталгаа муу учраас тэнд ажиллах сонирхолтой залуучуудын тоо бас бага байдаг болов уу гэж бодож байгаа юм.

Тэгэхээр энэ хууль батлагдсаны дараагаар бас тодорхой хэмжээгээр, ялангуяа хөдөө орон нутагт ажиллах энэ залуучуудын энэ сонирхол нэмэгдэж, зарим энэ шаардлагатай ундны цэвэр усны эх үүсвэр гэх мэтийн зүйлүүд бас хамгаалалттай болох болов уу л гэсэн л ийм л зүйлийг би харж байна.

Тэгээд ер нь энэ хуулийн төслийг дэмжиж байгаа, тэгээд сүүлийн үед, ялангуяа дотоодын цэрэг ч биш төрийн албанд ажиллах хүн байхгүй болсон, ялангуяа хөдөө орон нутаг ажиллах хүн байхгүй болсон. Тэгээд хувийн ААН-үүд, ялангуяа уул уурхайн бүс нутагт бол уул уурхайн компаниуд руу л ороод шилжээд ингээд явчихдаг учраас бас энэ хууль зайлшгүй бас гарах шаардлагатай болов уу л гэж бодож байна.

Тэгээд миний түрүүний асуусан асуулт, одоогийн байгаа байдал, цалин хангамж нь ямар байгаа юм, тэгээд үүнийг ингээд энэ хууль батлагдаад нэмэгдсэнээр хэдий хэмжээний төсөв хөрөнгө улсын төсөвт шаардлагатай болох юм, тэгээд ямар шинэ эерэг зүйлүүд гарч ирэх юм бол оо л гэсэн ийм зүйлүүд

Г.Занданшатар: хэн хариулах уу. 80 Чингис бригадын генерал, Дотоодын цэргийн штабын дарга.

Наранбаатар гишүүний асуултад хариулъя, Дотоодын зэргийн штабын дарга, бригадын генерал Чингис байна. Тантай бол ямар нэгэн санал нэгтэй байна. Ерөнхий байдлаар бол 14 онд анх Дотоодын цэргийн хуулийг хүчингүй болгоод буцаад 17 онд шинээр байгуулахад бас авсан ч юм байгаа, алдсан ч юм байгаа. Энэ дээр бид нар бол ерөнхийдөө төрийн цэргийн байгууллага гэж тооцогддог. Цагдаагийн байгууллагынхаа алба хаагчтайгаа нэгэн адил, бас төсөв санхүү нь явж байгаа. Энэ дээрээ зарим тохиолдолд Цагдаагийн албаны тухай хуульд заасан зарим эдийн засгийн болон нийгмийн баталгаа нь хаягдсан байгаа, яагаад гэвэл бид нар бол цагдаагийн байгууллагын ажилтан биш, төрийн цэргийн байгууллагын ажилтан, дотоодын цэргийн байгууллага. Цагдаатайгаа яаж нэгддэг вэ гэхээр бид нар бол зарим тохиолдолд цагдаагийн хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд дэмжлэг үзүүлэх байдлаар хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг

хангах, гэмт хэргийг таслан зогсоох, террорист сөрөг ажиллагааг гэх мэтчилэн байдлаар ихээр оролцдог. Тийм учраас бид нарын саяын энэ хуульд хаягдсан байгаа зарим эрх зүйн байдал, зарим энэ нэмэгдлүүдийг нөхөх байдлаар энэ хуульд оруулж байгаа.

Бусад төрийн цэргийн байгууллагатай бодоход бас ерөнхийдөө цалин ижил, гэхдээ онцгой байдал, шүүхийн шийдвэр, ерөнхий газар чинь бас төрийн цэргийн байгууллага гэж тооцогдож байгаа. Түүн дээр бас энэ зарим нийгмийн асуудал тэр хуулиуд руу орчихсон байгаа. Дотоодын цэргийн хуульдаа энэ юм нь хаягдсан болохоор бид нар нөхөх байдлаар л орж байгаа. Энэ нөхсөнөөр бид нар бас нэлээн олон асуудал шийдэгдэнэ. Түүний нэг нь бол таны хэлээд байгаа энэ тогтвор суурьшилтай ажиллах тэр нөхцөл байдлаар бид нар хангагдана. Яагаад гэвэл өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллага, ер нь дотоодын цэргээс хүн хүчээ авах аягүй их дуртай, яагаад гэвэл нэлээд бэлтгэгдсэн хүчин, цэргийн алба хаасан улсуудаас бид нар дотоодын цэрэг цагдаагийн албанаас нөөцөө хангадаг, дээрээс нь бэлэн ажиллаж байгаа дотоодын цэргийн албан хаагч нар цагдаагийн байгууллагад шилждэг, яагаад гэвэл тэнд бол давхар, зарим тохиолдолд илүү нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгаатай болохоороо ордог. Эсрэгээрээ цагдаагийн байгууллагаас дотоодын цэргийн байгууллагад орох сонирхолтой хүмүүс байдаггүй ээ. Тийм учраас бид нар энэ хуулийг батлаад хэрэгжүүлбэл энэ асуудал аяндаа арилаад дотоодын цэрэгт алба хаагч нар маань тогтвор суурьшилтай ажиллана гэж ойлгож болно. Баярлалаа.

Бусад таны асуусан 2 дахь асуудал нэг уучлаарай, төсөв санхүүтэй холбоотой асуудал, тэр бол орон тооны асуудалтай холбогдолтой байгаа. Энд бол төрийн цэргийн байгууллагын энэ нийт хүн хүч, эд нар нь бол төрийн

нууцын жагсаалтад багтсан байгаа болохоор бол энд бол танд нээлттэй хийх боломжгүй байна. Гэхдээ тусад нь таны асуултад бас хариулахад бол бэлэн байна аа. Баярлалаа.

Төсвийн талаар ямар нэгэн өнөөдрийн байдлаар нэг дарамт бид нар төсөв дээр нэг нэмэлт төсөв одоогоор шаардагдахгүй. Хариулт дууслаа.

Г.Занданшатар: 1 асуулт, хариултын дараа санал хураалт явуулна. Асуулт хариултын цаг дуусна. Гишүүд чуулганы танхимд санал хураалтад цуглаарай.

Одоо Төмөртөгоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Хуулийн өөрчлөлтийг бол дэмжиж байна. Тэгээд хамгийн гол асуудал бол энэ онц чухал объектын жагсаалтаа л яаралтай батлах ёстой юм байна. Энэ жагсаалт ер нь хэзээ батлагдах вэ гэдэг дээр нэг асуулт асууя.

2 дахь асуудал бол түрүүн бас Нямбаатар сайд бас ярьчих шиг боллоо. Дорноговь аймаг дээр нефть боловсруулах үйлдвэр, Бор хуурын говиос 60 километр усан сан татагдсан байж байгаа. Тэгээд энэ дээр дотоодын цэргийн хамгаалалт зайлшгүй хэрэгтэй. Тэгээд Дорноговь аймаг дээр нэг цэргийн анги байгуулна гэсэн. Энэ хэзээ байгуулагдах вэ. 2023 ондоо багтааж байгуулагдах уу гэж.

Дараагийн асуудал бол яах аргагүй энэ аймгууд дээр байж байгаа дулааны станцын асуудлууд байж байна. Аймгийн төвийн ундны усан хангамжийн сангууд байж байна. Тэгээд бүгд юу гэдэг юм хувийн хэвшлийн хамгаалалттай байгаад байдаг. Тийм учраас үүнийг дотоодын цэргийн хамгаалалтад авах энэ асуудал бол зайлшгүй байх гэж бодож байна. Хэрвээ хандвал танай байгууллагад хандаж болох уу. Түрүүн хөрөнгө

мөнгөтэй холбоотой асуудал ярилаа шүү дээ. Хэрвээ хөрөнгө мөнгөнийхөө асуудлыг шийдэх юм бол гэрээ хийгээд дотоодын цэрэг бас хамгаалж болохоор нэг иймэрхүү тайлбар хэлсэн. Тэгээд энэ асуудал дээр одоо юу гэдэг юм, дулааны станц энэ усан сангуудын энэ асуудал дээр хэрвээ танай байгууллагад хандах юм бол гэрээ байгуулаад хөрөнгө санхүүгийн тухайн юу гэдэг юм ТӨК гаргах юм бол хамгаалах бололцоо боломж бас байгаа юу гэдгийг энэ асуулт тавья. Ийм 3 асуулт дээр хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах уу. Нямбаатар сайд хариулъя, Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Би Энхтүвшин гишүүний асуулт маш товчхон хариулъя. Хэрэв Дорноговь аймгийн ЗДТГ, ИТХ 2023 онд Хууль зүй, дотоод хэргийн яамтай тодорхой энэ яг дотоодын цэргийн нэг нэгж анги байгууллага дээр хамтарч ажиллах, ялангуяа урсгал тал дээр дэмжлэг үзүүлэх ийм боломж байгаа тохиолдолд бид нар энэ ангийг 23 онд байгуулах бүрэн боломж, хүн хүчний нөөц байгаа гэдгийг танд товчхондоо хэлье.

Бид нар хувийн секторуудын хийж хэрэгжүүлэх боломжтой энгийн харуул хамгаалалтын ажлууд дээр үндсэндээ дотоодын цэрэг огт харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхгүй. Улсын онц чухал объектын жагсаалтыг Монгол Улсын ЗГ-ын тогтоолоор баталчихсан явж байгаа. Тэр тогтоолд зөвхөн нэмэлт оруулах л асуудал яригддаг. Сүүлийн үед энэ төрийн тусгай хамгаалалтын хамгаалж байгаа объектын цар хүрээ, одоо байгаа хүний нөөц 2 хоорондоо таарахгүй байна гэдэг ийм асуудлаар Төрийн тусгай хамгаалалтын газраас удаа дараа манайд мэдэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл зарим яам, агентлагуудын харуул хамгаалалтыг дотоодын цэрэгт шилжүүлж ээ гэдэг ийм бас шаардлагууд

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тавигдаж байгаа юм. Тэгэхээр энэ бол тухайн цаг үедээ тухайн батлагдсан төсвийнхөө хүрээнд хийгддэг асуудал.

Дорноговь аймаг бол улсын онц чухал объектууд шинээр хэд хэд байгуулагдаж бий болж байгаа бас онцлогтой. Тэр утгаараа бид нар яг энэ шинээр бий болж байгаа онц чухал объектын харуул хамгаалалтыг орон нутагтай хамтраад эхний ээлжид байгуулах боломж бий. Энэ талаар 2-улаа эргэж холбогдоод ярилцъя.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно, үг хэлэх гишүүн байна уу. Алга байна.

Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлтгээрэй, гишүүд. Санал хураалт явуулна.

Санал хураалт явуулна. Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

28 гишүүн дэмжиж, 58,3 хувийн саналаар Байнгын хорооны саналыг дэмжлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул

төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлж байна.

15.07 цаг

Дараагийн асуудалд орно.

Тав.Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ХЗБХ-ны танилцуулгыг УИХ-ын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч Бат-Амгалан танилцуулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүн байна уу. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүнээр таслалаа. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Би бас энэ чухал асуудал орсон учраас, бас үүнийгээ бас чанартай сайн болгох зорилгоор шүүхийн шинжээчийн ажлын дэд хэсэгт нь, бас Эмгэг судлалын багш Баярмаа багшийг бас оруулсан. Тэгээд зарим зарим асуудлуудаа тавьсан боловч бас ажлын хэсэг бас энэ асуудлыг дэмжилгүйгээр ороод ирсэн байгаа. Тухайлах юм бол энэ дээр маш чухал зүйл бол энэ шинжээч томилогдоод, шинжээчээр ажиллаж байгаа хүний нууцлалын асуудал ер нь хамгаалагдахгүй байна. Тухайлах юм бол эмч, эмнэлгийн ажилчдын хохирол учруулсан ч байдаг юм уу, үүнтэй холбоотойгоор ямар нэг тийм маргаан үүслээ гэж бодъё. Тэр маргааныг шийдвэрлэх зөвлөх зэргийн эмчийг ЭМЯ, Хууль зүйн яам 2 хамтдаа батална. Ингээд нэг хүн томилдог, тэр томилсон хүнийг нь нөгөө хэрэг шалгаж байгаа цагдаа маань хавтаст хэрэг дотроо хийгээд л, тэгээд л энд тэнд очоод л энэ хүн шалгаж байгаа, энэ хүн зөвлөгөө өгөх ёстой гээд л нөгөө үнэлгээ өгөөд тэр зөв, буруу байсныг шийдэх, зөвлөх хүний нууцлалыг хангахгүй байх нь өөрөө зөв мэдээлэл, зөв шийдвэр гаргахад

бас буруугаар нөлөөлөх талтай. Тийм болохоор та бүхэн энэ дээр яаж орж байгаа вэ гэдгээ нэг надад хэлээч.

2 дахь зүйл нь болохоор энэ шүүхийн шийдвэрийн энэ шүүхийн шинжилгээ, үнэлгээний ажилтан жишигээр юм бол яг анагаахын эмч мэргэжилтэй хүн эмч болох гэж бараг л арваад жил сурдаг. 10 жил сураад л, тэгээд л дараа нь бас нэг хүүхэд төрүүлээд л, тэгээд л нэг эмч болоод л танай байгууллагад орлоо гээд л яахад бараг 30 насандаа орж байгаа байхгүй юу. Тэгээд 30 насандаа ороод нөгөө цагдаа нар шиг тэтгэвэртээ гарахаар 47, 48 насандаа гарчихдаг, ингээд 17, 18 жил ажиллаад тэтгэвэрт гарчихна аа. Тэгээд нөгөө ажлын хүч боловсон хүчний дутагдалд орох эрсдэл их өндөр байна гэсэн ийм шүүмж яваад байгаа юм. Энэ дээр та бүхэн бас юу гэж бодож байна вэ.

Ер нь бол яг энэ шинжээчээр ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжлийн улсуудыг болохоор тэр нөгөө тусгай нөхцөл, нөгөө дүрс оношилгоо, эмгэг судлаач эмч энэ тэр гэдэг шиг лабораторийн эмч энэ тэр шиг нөгөө тусгай хүнд нөхцөл, хорттой нөхцөл гэдгээр нь тэтгэвэрт гарах тэр нөхцөлийг нь энд нь оруулж өгч болохгүй юм уу. Энэ дээр ямар байр суурь барьж хуулийн эцсийн хувилбар орж ирж байгаа вэ. Энэ 2 асуултад хариулж өгөхгүй юу.

Г.Занданшатар: Байнгын хороо хариулна. Байнгын хороо ажлын хэсэг хариулна. Төсөл санаачлагч хариулахгүй. Байнгын хороонд танилцуулгатай холбогдуулж эхний хэлэлцүүлэг дээр хэлэлцэх эсэх биш энэ. Ажлын хэсгийн дарга нь хэн юм. Ажлын хэсэгт нь хэн орсон юм, ажлын хэсэг нь оруулаагүй гэсэн асуудал ярьж байна шүү дээ. Хууль зүйн яам хариулахгүй, ажлын хэсэг нь яагаад оруулаагүй юм бэ гэж асууж байна шүү дээ.

Энхтайваны Бат-Амгалан гишүүн хариулна.

Э.Бат-Амгалан: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шинжээч нарын маань нууцлалын асуудал байгаа. Энэ дээр бол бид нар бас хуулийн төсөл санаачлаад, энэ ажлын хэсгийнхэн, ер нь төсөл санаачлагч нар анх орж ирэхдээ гэмт хэрэгтэй холбоотой энэ хэргүүдийг цахимаар тохиолдлын маягаар, цахимаар ишилжүүлэхээр ингэж оруулж ирсэн. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр урьд нь бол зүгээр байгууллагын дарга, жишээ нь тэр хэргүүдийг хуваарилж өгдөг байсан бол энэ хууль батлагдсанаар цахим системээр буюу тохиолдлын байдлаар шинжээч нарт хэргүүд ишилжиж хуваарилагдах ийм давуу талтай, хуулийн төсөл орж ирж батлагдаж байгаа.

Г.Занданшатар: Энэ ажлын хэсэг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Нармандахын Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Жаргалын Буянбат, Шүүхийн шинжилгээний дүн, бүртгэл мэдээллийн газрын захирал, цагдаагийн хурандаа Даваацэрэнгийн Мөнхбат, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Лхамдоржийн Нямдаваа, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга Идэрийн Батчулуун, ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Батсүхийн Эрдэнэ-Очир, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Агваанцэрэнгийн Амгаланболд.

Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо. Ямар 2 асуулт. 2 дахь асуултын

хариултыг хэн өгөх юм бэ. Жаргалын Буянбат дарга 80.

Ж.Буянбат: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ одоо яг энэ байгууллагын, ялангуяа анагаахын чиглэлийн, шүүх анагаахын чиглэлийн шинжилгээ хийдэг мэргэжилтнүүдийн хувьд тулгамдсан асуудал болчхоод байгаа юм. Сүүлд төрийн тусгай албан хаагч болоод тэгээд төрийн тусгай алба хаагчтай холбоотой хуулиараа эмэгтэй бол 47, эрэгтэй бол 55 гээд ингээд хүндрэлүүд гарсан. Үүнийг нь хуулийн шинэчилсэн найруулгад бол бүрэн гүйцэд шийдэхээр 75.2 дээр энэ байгууллагад юу 5 хүртэл жил, 5-аас дээш жил ажилласан бол урьд нь ажиллаж байсан эмнэлгийн байгууллагад ажиллаж байсан тэр жилүүд нь төрийн тусгай албанд ажилласнаар тооцогдохоор ингэж тусгагдаж орж ирсэн.

Дахиад насны хязгаар нь эмэгтэй 47-оос 5, эрэгтэй 55-аас 5 жил сунгагдах тийм боломжтой байхаар хуулийн зохицуулалт орж ирсэн байгаа юм.

Г.Занданшатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулж асууна, 1 минут.

Ж.Чинбүрэн: Ойлголоо, ямар ч байсан тэтгэвэрт гарах нас нь болсон ч гэсэн 5 жилээр бас сунгаад ажиллах. Яагаад гэхээр энэ эмч мэргэжил чинь өөрөө ажилласан жилээрээ туршилага нь нэмэгдэж байдаг. Дээрээс нь тэр хүний үнэ цэн улам их нэмэгдэж байдаг ийм мэргэжил байхгүй юу. Түүнээс бол зүгээр л 47 хүрчихлээ, та амар гэж ерөөсөө болохгүй, энэ бол тэгэхээр их зөв байна аа, 5, 5 жилээр сунгаад явчхаарай.

2-т, ер нь бол энэ салбарын бас нэг томоохон чухал зүйл бол энэ тоног төхөөрөмжийн шинэчлэл байгаа юм аа. Тэгэхээр бас би энд нэгэнт үг олдсон дээр Хууль зүйн сайдад бас нэмж хэлмээр байгаа юм. Ер нь бол энэ шинжилгээ хийдэг компьютер томограмм, имрай

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тусгай нарийн генетикийн шинжилгээ хийх, тэр боломжуудыг хангах чиглэлд бас Хууль зүйн сайд та, анхаарч өгөөрэй. Энэ салбар бол өөрөө маш нарийн, шийдвэр гаргадаг салбар учраас энэ дээр хөрөнгө оруулалтыг нь бас та анхаараарай гэж хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ерөнхийдөө үг хэлчихлээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт бэлэн байна уу.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүлж байна.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалд оръё.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр. Маргааш хууль эцэслэн батлагдах байх. Маргааш эцэслэн батлах санал хураалт бэлтгэх.

15.18 цаг

Дараагийнх.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн

мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Ажлын хэсгийн гишүүд түрүүчийнх дээр нэр, албан тушаал, овог нэр нэг мөр адил.

Э.Бат-Амгалан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 55 дугаар зүйл 55.1.3 шинжилгээний байгууллага шүүх шинжилгээний үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах хүрээнд шинжилгээний байгууллагыг шинжилгээний лабораторийн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, урвалж бодисоор шуурхай хангаж, урвалж бодисын нөөцийг бүрдүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу шууд худалдан авах ажлыг зохион байгуулах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль хоорондын зөрчил үүсгэхгүй байх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалтыг шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батална гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох, санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөлийн саналыг үндэслэн шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Шүүх шинжилгээний төв байгууллагын даргын шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно гэсэн зохицуулалт дэмжигдсэнтэй холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

ХЗБХ 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүн Раднаасэд шүүх шинжилгээний байгууллага 1 жилийн хугацаанд зохион байгуулагддаг худалдан авах ажиллагааны талаар, УИХ-ын гишүүн Сандаг-Очир шууд гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулснаар байгууллагын эрх бүхий албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар, УИХ-ын

гишүүн Ганбат шүүх шинжилгээний байгууллагад хэрэгжиж байгаа төсөл болон аймгууд дахь салбар, техник, тоног төхөөрөмж, ажиллах боловсон хүчний талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул УИХ-ын гишүүн Бат-Амгалан монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66,7 хувь дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу. Хассуурийн Ганхуяг гишүүнээр тасаллаа.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ зөвшөөрлийн тоог нэмэхээр оруулж ирсэн байна л даа. Тэгээд зөвшөөрлийн ажлын хэсэг гээд сүүлийн 2 жил энэ УИХ дээр ажиллаж байгаа. Энэ зөвшөөрлийг нэмэгдүүлэх тал дээр надад ерөөсөө санал ч аваагүй, мэдэгдээ ч үгүй. Зөвшөөрлийн тоог нэмэхтэй холбоотой, аль аль зөвшөөрлийг байх тал дээр хийсэн судалгаа нь ч хамрагдаагүй, ингээд ийм зөвшөөрөл нэмэх гээд л ороод ирсэн байна л даа. Өнөөдөр бид нар ингээд 3

дахь зөвшөөрлөө нэмэх гэж байна. Нөгөө бид нарын сүр дуулиан болоод л баталсан Зөвшөөрлийн хууль чинь 362 зөвшөөрөлтэй байсан, ингээд өнөөдөр энэ ороод ингээд 365 зөвшөөрөлтэй болох юм байна. Өдөрт 3 зөвшөөрөл нэмж байна шүү, өдөрт шүү дээ, 1 өдөрт бид нар 3 зөвшөөрөл нэмэхээр ингээд хуулийн төслүүдийг ингээд цаашаа хэлэлцэхээр баталж л байна л даа.

Ямар нэгэн үйл ажиллагаа заавал ч үгүй зөвшөөрөлтэй болох гээд байдаг шалтгаан нь яг юу юм бэ. Зөвшөөрлийн хуулийн үндсэн зорилго, агуулга нь бүгдээрээ тэр маш сайн ойлгож авсан гэж бодсон шүү дээ, гишүүдийгээ. Үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, хүний эрүүл мэнд, амь нас, төрийн нийт өмчийг ашиглахтай холбоотой зөвшөөрлийг нэмье гээд Зөвшөөрлийн хуулийг бид нар баталсан шүү дээ. Энэ зүгээр бүртгэлээр хийж болох ажлыг ингээд л зөвшөөрүүлээд байгаа байхгүй юу. Харамсалтай байна. Ичмээр байна аа, одоо болимоор байна. Үүнийгээ бүртгэл болго оо. Энэ чинь арай дэндэж байна, ингээд л яана, маргаашаас ямар нэгэн үйл ажиллагаа болохоор заавал ч үгүй нэг зөвшөөрөл, заавал ч үгүй хүний зөвшөөрөл энэ зөвшөөрөл болгон чинь бүгдээрээ авлигатай байдаг шүү.

Бид нар нийтийн үйлчилгээний зөвшөөрлүүдийг цуцалснаар маш их олон хэмжээний авлигыг байхгүй болгосон. Тэгсэн чинь зөрүүлээд яасан бэ гэхээр архийг худалдах зөвшөөрөл 20 сая төгрөгийн ханштай болчихсон байгаа байхгүй юу. 20 сая төгрөг тэр хуучин 3 юм уу 4 сая төгрөг байсан. 8 нэрийн барааны дэлгүүр авахад 8-25 зөвшөөрөл авдаг байсан. Зөвшөөрөл болон саяас хоёр сая төгрөгийн ханштай байсан. Тэр бүх зөвшөөрөл авлига байхгүй болонгуут ганц үлдээсэн тэр архины зөвшөөрөл дээр нь 20 сая төгрөгийн ханштай болчхож байгаа байхгүй юу.

Тэгээд энэ ХЗБХ-ноос ингээд ийм асуудал орж ирэх юм аа. Энэ үнэхээрийн харамсалтай байна аа, хэлэх ч үг олохгүй байна. Асуух ч зүйл алга, энэ дээр. Яг ний нуугүй хэлэхэд.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Ганхуяг гишүүн энэ өөрөө батлуулсан хуулийнхаа 9.6 дугаар зүйлийг өөрөө унш л даа. Тэгээд камер харахаараа нэг гоё тийм популизм хийх гээд байх юм. Таны батлуулсан хуулийн 9.6 дээр энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө УИХ-д өргөн мэдүүлсэн, эс үгүй бол хуулийн төслийг хэлэлцэн батлах үе шатанд байгаа зөвшөөрөлтэй холбоотой хуулийн төсөлд энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5.3 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт хамаарахгүй гээд байгаа шүү дээ. Нэгд.

2-т нь, та энэ шүүх шинжилгээний байгууллага, зарим нарийн мэргэжил шаардсан шинжээч, бактериологийн шинжилгээ, эрүүл мэндтэй холбоотой нарийн шинжилгээнүүдийг шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргахын тулд тэр хүмүүст шинжээч дүгнэлт гаргах энэ эрхийг зөвшөөрөл өгөхөөс өөр аргагүй шүү дээ. Хэн шүүхэд эрүүгийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхэд захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх шийдвэр гаргахаас өмнө шинжлэх ухааны нарийн мэдлэг бүхий тэр мэдлэгт суурилсан дүгнэлтийг гаргахын тулд гудамжинд явж байгаа дурын хүнээр дүгнэлт гаргуулж болохгүй биз дээ. Ямар юмных нь авлига, элэнцгийнх нь ийм юм яриад байгаа юм бэ.

2 гэвэл наадах чинь шүүх шинжилгээний байгууллага, зарим шинжилгээг эрүүл мэндийн байгууллагаар эрхээ шилжүүлж хийлгээ. Хөдөө орон нутгуудад шүүх эмнэлгийн шинжээчид очихоо больчихоод байна аа. Тийм учраас Нэгдсэн эмнэлгийн дүүрэг,

аймгийн нэгдсэн эмнэлгийн их эмч нараар шүүхийн шүүх эмнэлгийн шинжээчийн тусгай зөвшөөрлийг олгоё оо гэдэг ийм л юм ярьж байгаа шүү дээ. Энэ дандаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, шүүхэд төлөөлөх эрхтэй хүмүүс дээр л зөвшөөрлийн энэ эрх ярьж байгаа шүү дээ.

Тэгээд таны батлуулсан хуулиас л би сая иш авч хэллээ шүү.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Тийм, та Зөвшөөрлийн хуулийн 9.1-ийг дурдаж л байна л даа. Яагаад тийм гарц үлдээсэн бэ гэхээр УИХ-ын шатанд газрын багц хууль, тийм газрын багц хууль ороод ирчихсэн байсан болохоор тийм гарцыг үлдээсэн юм. Яагаад гэхээр газрын багц суурь бол эдийн засгийн суурь хууль. Тэгээд түүнтэй холбоотой маш олон зөвшөөрөл байдаг. Тийм учраас газрын багц хууль ороод ирсэн байсан болохоор бид нар энэ 12 сарын 31 хүртэл энэ хэлэлцэгдэх шатанд байгаа юмнуудыг авъя гэж ярьсан юм аа. Түүнээс биш бол нөгөө энэ тэр судалгаанд хамрагдаагүй, эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй ийм зөвшөөрлүүдийг бол болж өгвөл танай яам, энэ бүртгэл эд нар руугаа оруулаач ээ гэдгийг бол хэд хэдэн зөвшөөрөл дээр бол яг тийм асуудал ярьсан шүү дээ, цөмөөрөө. Нөгөө барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ дээр бас зөвшөөрөл нэмье ээ гэхэд нь бид нар наадах чинь бүртгэл байж болох юм гээд сүүлдээ бүртгэл болгосон шүү дээ. Тэгээд уг нь бол шаардлагыг нь өндөрсгөөд бүртгэл болгочхож болно шүү дээ бас. Түүнээс би бол танайхыг би авлигал авдаг гэж хэлсэнгүй, би зүгээр зөвшөөрөл өөрөө авлигыг бий болгоод ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Болорчулуун гишүүн санал хураалтад, Болорчулуун дарга түр хүлээж бай. Сайдынхаа хажууд сууж байгаад ажлаа ярь. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд картаа уншуул. Карт чинь сугалсан байна.

Санал хураалт явуулна. Тогтохсүрэн дарга аа, санал хураалт явуулъя.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэж явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт.

55,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ дээр хариуцлага, хяналтын механизмаа сайн тавиарай. Зөвшөөрөл олгохоос авхуулаад тэгээд худалдан авах ажиллагааны процессыг хөнгөвчилснөөрөө ингээд ард түмэн нүдтэй, хяналттай болсон шүү. Хэвтээ хариуцлага, хэвтээ хяналтын тогтолцоог л илүү сайн хангах хэрэгтэй юм байна лээ.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ажлын хэсэгт баярлалаа. Одоо явж болох юм байна.

Одоо “Монгол Улсын хилийн зурвасын газрыг тогтоож, улсын тусгай хэрэгцээнд авах тухай” УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Монгол УИХ-ын тухай хуулийн 22.2-т хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасан.

Одоо хэлэлцэх гэж байгаа асуудал төрийн нууцтай холбоотой учир нэгдсэн хуралдааныг хаалттай хэлэлцүүлгийн горимд шилжүүлбэ.

15.32 цаг

Дараагийн асуудалд орно.

Нээлттэй горимд шилжсэн үү.

Долоо.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Х.Ганхуяг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 2022 оны 11 дүгээр

сарын 21-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

УИХ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 38 дугаар захирамжаар байгуулагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг дээрх хууль, тогтоолын төслүүд дээр ажиллалаа.

Тус Байнгын хороо хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Зөвшөөрлийн тухай болон холбогдох хуульд нийцүүлэх чиглэлээр бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналууд болон УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулийн төслүүд дэх зөвшөөрлийн харилцаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар зохицуулах зорилгоор Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези, газар зүйн тухай хууль, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураг ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орох тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах тухай зарчмын зөрүүтэй саналын

томъёоллуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Түүнчлэн УИХ-ын гишүүн Энхбаяр дээрх хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах тухай зарчмын зөрүүдээс саналын томъёолол бол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Ням-Осорын Учрал гишүүн асууя.

Н.Учрал: Би бас бодитой санал хэлмээр байна. Тэгээд Ганхуяг гишүүн бас анхаарч үзнэ биз ээ. Энэ зөвшөөрлийн хууль бол тэр 1600, 700 зөвшөөрлийг

багасгаад энэ төрийн хүнд суртлыг бууруулахад их чухал хувь нэмрээ оруулж байгаа хууль. Ингээд зөвшөөрлийн хуулийн дагуу бизнесийг нөгөө коджуулах ажил Эдийн засгийн яамны ажил, ингээд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эдийн засгийн яам хамтраад ажлын хэсэг байгуулаад энэ зөвшөөрлийг цахимжуулах ажлыг хийж байгаа. Ингээд энэ хугацаанд маш олон хуулиуд дээр энэ мэдээллийн сантай холбоотой, цахим технологитой холбоотой заалтууд орсон. Их Хурлын дарга ч гэсэн энэ 1072 хувьцааг амилуулъя, дээрээс нь тэр нүүрсний биржийг технологид суурилж хийе гээд Их Хурлын тогтоол дээр хүртэл саналаа оруулах гээд явж байна. Дээрээс нь энэ Их Хурлын Мэдээлэл технологийн хэлтсийнхэн хүртэл хэлж байгаа. Эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитын журмаа хурдан гаргаж өгөөч ээ, бид нар ажлаа хиймээр байна гэж. Бүх салбарт хүний оролцоог багасгаад технологид суурилуулж чадах юм хүнд суртал буурна, цаашилаад авлигал, хээл хахууль, хулгай чинь зогсоно оо. Хүн ам оролцоогүй цагт. Гэтэл технологи нь ямар байгаа вэ гэдгийг үнэлэхгүйгээр ерөөсөө ямар ч дэвшил гарахгүй.

2019 оны харилцаа холбооны хуульд энэ тодорхой заалтууд туссан энэ 2019 оны харилцаа холбооны нэмэлт, өөрчлөлт дээр. Мэдээллийн технологийн аудит, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх агуулга орсон. Дээрээс нь сая өнгөрсөн 2021 онд баталсан энэ цахим хөгжлийг дэмжих хуулиуд дээр бас энэ агуулга орсон. Тэгэхээр манай яам бол энэ кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, кибер аюулгүй байдлын аудит хийх журмыг ЗГ-аар оруулж байгаа юм. Гэтэл энэ зөвшөөрлийн хууль дээр зөвшөөрөл нь энгийн бүртгэл гэж үзээд энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдүүдийг нь заасан мөртлөө өнөөдөр энэ аудит хийх, эрсдэлийн үнэлгээ хийх энэ энгийн зөвшөөрлийн асуудлыг энд огт тусгасангүй.

Тэгэхээр цаашидаа ЗГ-ын зүгээс энэ төрийн байгууллагууд дээр мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх, эрсдэлийн үнэлгээ хийх, харилцаа холбоо, мэдээлэл технологийн аудит хийх эрх байхгүй болчихож байгаа юм. Тэгээд юу гэж мэдээж ажлын хэсэг тайлбарлаж байна вэ гэхээр бүртгэсэн юм чинь заавал зөвшөөрөл хэрэггүй гэж. Тэгэхдээ энэ хуулийн чинь агуулга нь бүр зүгээр бүртгэж байвал түүнийг энгийн зөвшөөрөл гэж үзнэ ээ гэж байгаа шүү дээ. Гэтэл энэ зөвшөөрлийн хуулийн 3 дээр зөвшөөрөл, лиценз, бүртгэл, хуульд зааснаас бусад тохиолдолд явуулахыг хориглоно гээд заачихсан. Тэгээд бүртгэхээс ч болохгүй болчихож байгаа байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр хүртэл Их Хурлын Мэдээлэл технологийн хэлтсийнхэн бид нар энэ систем дээр мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэмээр байна аа, аудит хийлгэмээр байна гээд хэлээд байдаг. Гэтэл энэ хууль дээрээ зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно гээд заачихсан. Тэгээд цаашидаа бид нарыг яаж ажил хийгээд байгаа юм, тэгээд ингээд хамгийн чухал асуудлыг ингээд хаячхаад хэтэрхий их зөвшөөрөл болох гээд байна гээд. Би ерөөсөө зөвшөөрөл авъя, зөвшөөрөл олгодог болъё гээгүй шүү дээ. Энэ чинь хуульд заачихсан харилцаа холбооны хуульд байгаа үг үсэг шүү дээ. Эрсдэлийн үнэлгээ хийх, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрхийг нь ядаж та нар хуулиар хориглож болохгүй шүү дээ. Та нар юу гэж хариулах вэ гэхээр үүнийг та нар бүртгэл гээд үзчих ээ гэж хэлнэ. Тэгвэл та нар хуулийнхаа 3 дугаар заалтыг хар, хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно оо гээд заачихсан.

Тэгээд дараа нь энэ олон энэ биржүүд чинь энд олон технологи суурьтай ажлууд чинь энэ олон мэдээллийн сангууд чинь кибер аюулгүй байдлыг нь хэн хангаж, хэн хариуцаж,

ямар байгууллага хариуцах нь огт тодорхойгүй байгаа шүү. Тийм учраас энэ 2 заалтыг оруулж өгөөч ээ гэж Их Хурлын дарга бас чиглэл өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Холбогдох санал дээрээ үүнийг яриарай.

Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.3-т зааснаар бол ямар нэгэн зөвшөөрлийн шинж чанартай зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглосон. Зөвшөөрлийн шинж чанартай шүү. Хуульд бол зөвшөөрлийн шинж чанаргүй бүртгэлийг бол явуулах бол чөлөөтэй эрхэлж болж байгаа. Тэгээд тийм учраас яах вэ, кибер аюулгүй байдлын хуульд бүртгэлийн шинжтэйгээр энэ угаасаа асуудал нь зохицуулагдсан байгаа байхгүй юу. Тийм учраас үүнийг нь бүртгэлээр нь үлдээчихсэн юм.

Ер нь яах вэ, одоо ингээд ажлын хэсгийн даргын хувьд бол би Учрал сайдын хийж байгаа ажлыг маш ойлгож байна аа, хүндэлж байна. Энэ асуудлыг ч гэсэн хийх ёстой асуудал гэж харж байгаа. Гэхдээ бид нар энэ 362 зөвшөөрлийг авч үлдэхдээ нийтдээ 10 гаруй судалгаа хийж байж авч үлдсэн юм. Эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн юм. Ер нь яг ямар ямар салбаруудад, ямар ямар эрсдэл байна тэр эрсдэлтэй нь дөрөөлж байж бид нар үндэслэж байж бид нар зөвшөөрлийг нь авч үлдсэн байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ яг энэ ярьж байгаа 2 зөвшөөрөл дээр нь ямар нэгэн судалгаа хийгээгүй. Тэгэхээр энэ зөвшөөрөл байх ёстой, байх ёсгүй гэдгийг Ганхуяг гишүүн шийдэж болохгүй байхгүй юу. Одоо энэ шинэ зөвшөөрлийн хуулиар болохоор ЗГ зөвлөл байгуулагдана, нээлттэй сонсгол явна, түүнийх нь дараа зөвшөөрөл нэмэх эсэхийг хуулиар буюу УИХ-аар оруулж танилцуулагдсаны дараа зөвшөөрлийг нэмдэг болъё оо гэдэг хууль батлагдчихсан юм байгаа юм. Тэгээд

одоо үүнийг бид нар бүгдээрээ маш сайн мэдэж байгаа.

Сая яг 1 цагийн өмнө бид нар 3 зөвшөөрөл нэмэхээр сая хууль баталчихлаа. Тэгээд яг ийм байдлаар бид нар нөгөө зөвшөөрлийн тоог нэмээд яваад байвал энэ зөвшөөрлийн хуулийн утга агуулга нь алдагдах гээд байгаа юм л даа. Түүнээс бол би бол хувь хүний хувьд бол оруулчихмаар л байна. Тэгэхдээ би үүнийг өөрөө биччихсэн юмаа өөрөө зөрчиж болохгүй шүү дээ л гэдэг л байрнаас хандаад байгаа юм.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн тодруулъя, 1 минут.

Н.Учрал: Ганхуяг гишүүн ээ, энэ ерөөсөө зөвшөөрөл биш байхгүй юу. Энэ чинь зөвшөөрөл биш. Одоо ЗГ-аас гарч байгаа бүх шийдвэр дээр нийтийн мэдээллийн системтэй уялдаж байна уу, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байна уу, та нар дүгнэлт гарга гээд манай яаманд өгөөд байна шүү дээ. Гэтэл энэ олон компаниуд чинь аль нь мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрхтэй юм, аль нь эрсдэлийн үнэлгээ хийх эрхтэй юм бүү мэд, тэгээд ингээд жишээ нь уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжаалаад эхэлтэл, тэр систем дээр нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хий гээд, бид нарт эрх нь байхгүй. Тэгэхээр цаашидаа яах юм, тэгэхээр ийм асуудлыг ойлгохгүйгээр энэ чинь зөвшөөрөл энэ дээр зөвшөөрөл авах гээд байгаа биш. Энэ төрийн ажил чинь зөв явахад туслах гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ бол тэр бусад шиг хэн нэгэнд зөвшөөрөл өгөөд тийм юм байхгүй. Энэ чинь зүгээр туслацаа үзүүлэх гэж байна.

Тэгвэл энэ 3 дугаар зүйлээсээ та нар энэ зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно гэдэг үг авах ёстой шүү дээ. Хуулийн давхардал, хийдэлтэй энэ хууль чинь жаргал зовлон 2 чинь энэ чинь зөрчилдөөд байна шүү дээ энд.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Бүртгэл гэдэг маань энэ хуульд зөвшөөрлийн хуульд орчихсон байгаа, хориглочихсон гээд байгаа бүртгэл бол зөвшөөрлийн шинж чанартай бүртгэлийг л хэлж байгаа юм. Яагаад үүнийг оруулах болсон бэ гэхээр бид нар энэ ЗГ-ын тогтоол байдаг юм уу, энэ орон нутгийн тогтоол, энэ тэр ЭМЯ дээр хүртэл лиценз гэдэг нэртэй, тэгэхдээ зөвшөөрлийг ингээд лицензгүй, өөр нэрээр ингээд нэрлээд явчихсан, эсвэл бүртгэлийг зөвшөөрүүлчихсэн ийм асуудлууд аягүй их байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас зөвшөөрлийн шинж чанартай бүртгэл явуулахыг л хориглочихсон байгаа.

Зөвшөөрлийн шинж чанаргүй бүртгэл бол явж болж байгаа. Одоо нөгөө барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ дээр бид нар бүртгэл гээд оруулсан, тэр бүртгэлээрээ явж болж байгаа шүү дээ.

Г.Занданшатар: 85.

ЗГХЭГ Саруул. Учрал гишүүний асуултад хариулъя. Энэ Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.5 дээр юу гэж заасан гэхээр хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно гэсэн. Тэгэхээс биш Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд бүртгэл явуулахыг хориглоно гээгүй. Тэгэхээр хуульд зааснаас бусад тохиолдолд гэж байгаа учраас танай өөрөөр хэлбэл кибер аюулгүй байдлын тухай хууль дээр бүртгэл явуулна гээд заасан учраас түүгээрээ бүртгэлээ явуулчихаж болно. Гэхдээ тэр бүртгэлээ явуулахдаа энэ хуулийн 1.3 дугаар зүйлд юу гэж заасан гэхээр энэ зөвшөөрлөөс гадуурх энэ үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлж болох боловч хууль тогтоомжид нийцүүлж эрхэлнэ ээ гэж байгаа юм. Тэгэхээр тэр хууль дээрээ нөгөө бүртгэлд хамрагдаж байгаа этгээдүүдэд ямар шаардлага тавих вэ гэдгийг тогтоож болно.

Тэгэхээр Кибер аюулгүй байдлын тухай хууль дээр тухайн тэр аудитын үйл ажиллагааг хийх этгээдэд тавигдах шаардлагыг ЗГ-ын тогтоолоор батлахаар зохицуулалт байсан. Тийм учраас түүгээрээ зохицуулагдаад явах боломжтой гэж.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн тодруулъя, 1 минут.

Н.Учрал: Жишээ нь, СЗХ дээр бүртгэлийг энгийн зөвшөөрөл гэж үзсэн тохиолдол байгаа. Миний тэр ажлын хэсгийг ахалсан тэр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль дээр зөвшөөрөл олгодоггүй шүү дээ, бүртгэдэг. Гэтэл бүртгэдэг дээр та нар СЗХ-ныхыг болохоор энгийн зөвшөөрөл гэж үзээд энгийн зөвшөөрлийг олгох эрх бүхий байгууллага нь СЗХ гээд үзчихсэн шүү дээ. Яг энэ ижилхэн кэйс дээр. Илүү хөөцөлдлөгөөтэй нь ийм ажлыг нь аваад хөөцөлдлөгөө муутай нь ингээд байгаад ингээж хандаад байгаа юм уу.

Дээрээс нь банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журмыг батлах СЗХ-ны энэ тогтоол дээр жишээ нь СЗХ-ноос финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагын 4.4 дээр кибер аюулгүй байдлын бүртгэл хийлгэсэн, эрсдэлийн үнэлгээ хийлгээж баталгаажуулсан гээд үүнийг хүлээгээд өнөөдөр энэ банк бусын журам батлагдахгүй байгаа шүү дээ. Энэ хууль чинь гарах юм бол манай яам үүнийг хийж чадахгүй шүү. Та нар энэ хуулийг хийчихвэл.

Г.Занданшатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн

Ж.Чинбүрэн: Эмнэлгийн мэргэжилтэн буюу эмч, сувилагч нар энэ эрүүл мэндийн тухай хуулийн 28.4.3-т зааснаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэлтээ стандарт, технологи мөрдөж ажиллах үүрэгтэй байдаг. Харин эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж байгаад ямар нэгэн осол гэмтэл хохирол

учруулсан тохиолдолд хууль хяналтын байгууллагын танай байгууллагаас гаргасан энэ стандартын дагуу ямар нэгэн энэ стандартаа барьсангүй гэдгээр ял шийтгэл ногдуулдаг юм.

ЭМД-ын тухай хууль дээр энэ 14.8.7-д тусламж үйлчилгээ, худалдаж авах удирдамжаа автодет гэдэг энэ платформыг болгочихсон. Энэ бол байнга шинэчлэгдэж байдаг эмчилгээ үйлчилгээний шинэ технологиудыг оруулж явдаг ийм стандарт. Тэгэхээр нэг ийм ойлгомжгүй асуудал үүсээд байгаа юм. Бид Стандарт хэмжил зүйн газраас баталсан стандарт нь хэдэн зөвлөх эмч нар суугаад гаргаад тэр нь 1, 2 бүр зарим нь бүр 10 жил хүртэл хоцорчихсон яваа. Тэгэхээр миний асуух гэж байгаа асуулт бол энэ дээрх хуулийн зөрчлийг хэрхэн шийдвэрлэж болох боломжтой вэ? Тусламж үйлчилгээ худалдаж авч байгаа стандарт нь автодет буюу олон улсын стандарт байна. Хүн эмчилж байгаад ямар нэгэн алдаа эндэгдэл гарах юм бол Стандарт хэмжил зүйн байгууллагаар баталсан стандартыг баримтална гээд байдаг. Тэгэхээр энэ 2 зөрчлийг яах ёстой вэ?

2-т, тухайн хүний биеийн байдал, өвчний онцлогт тохирсон эмчилгээг эмч өөрөө сонгож хэрэглэх ёстой байтал танайхаас баталсан зарим стандартууд хэт нарийн заасан, цаг үеийн шаардлагаар хоцрогдсон байдаг. Тэр нь орчин цагийн шаардлагад нийцээгүй байх жишээтэй. Энэ бас их чухал асуудал шүү, тийм учраас ер нь энэ анхны хэлэлцүүлэг орж байгаатай холбоотой энэ эрүүл мэндийн салбарт байгаа, хэрэгжүүлж байгаа удирдамж стандартаа бид ер нь юуг нь барих ёстой вэ? Энэ дээр ямар бодлого барих ёстой вэ? Хариулт өгөөч.

Г.Занданшатар: Хэн хариулах уу. 85 хариулъя. Саруул.

Энэ ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихъя.

Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Дунхүүгийн Аюуш Монголбанкны Хууль зүйн газрын захирал, Болдбаатарын Билгүүн Стандарт хэмжил зүйн газрын дарга, Отгоны Одончимэг Эдийн засаг хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Төмөрчөдөрийн Нарантунгалаг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Батдэлгэрийн Нямдорж Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга, Туулхангайн Ганбаатар Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Цахим хөгжил харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, Доржийн Батмагнай АМГТГ-ын Кадастрын хэлтсийн дарга, Бат-Эрдэнийн Төрбат ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын шинжээч.

82.

Б.Билгүүн: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбарын эмчилгээний стандарт яалт ч үгүй бас хоцрогдох хугацаа алдах асуудлууд байдаг. Үүнийгээ бид нар ЭМЯ-тайгаа яриад яг эмчилгээ, арга зүйтэй холбоотой стандартуудаа яамных нь эрх мэдэлд өгөөд тэрийгээ журам, заавар зөвлөмжөөрөө явахаар тохирчихсон байгаа. Одоо нэг ёсондоо заавал эмчилгээг стандартчилахгүйгээр тухайн ЭМЯ маань өөрөө тэрийгээ зохицуулаад явдаг зохицуулалттай болсон. Бусад зүйлийг нь бол стандартчилах хэвээр нь үлдээгээд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эмчилгээний арга зүйн стандартуудыг бол хүчингүй болгож байгаа. Ийм шинэчлэл хийгдэж байгаа. Мөн адил. Олон улсын заавар зөвлөмжийнх нь дагуу шууд ЭМЯ батлаад явдаг болж байгаа юм.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: ЗГ-ын оруулж ирж байгаа хууль дээр нэг баахан шунаж зүтгэж явж сайд болцгоосон нөхөд бүгдээрээ ирцгээгээрэй. Учралаас бусад нь алга. Уул нь тэд нарыг орж ирсний дараа уг нь. Үг уначих гээд байна. Зөвшөөрлийн тухай хуулийн ажлын хэсэгт байсан. 2019 онд орж ирсэн. 2 парламент дамжаад би энэ ажлын хэсэгт байгаа. Ерөөсөө хоёрхон зарчим дээр би хатуу манаач хийсэн. Зөвшөөрснөөс бусад бүх зүйлийг хориглохгүй гэдэг зарчим дээр, бүх зүйлийг Монголын ард түмэн, Монголын бүх бизнесүүд хийх боломжтой ААН-үүд.

2 дахь нь бол зөвшөөрлийн материал өгөөд 21 хоногийн дотор материалд хариу өгөхгүй бол тэр хүн шууд ажлаа эхлэх боломжтой. Тэр төрийн ажилтны удсанаас үл шалтгаалан үйл ажиллагаагаа явуулах боломжтой ийм хуулийн заалтыг оруулахын төлөө явсан. Энэ маань 2-улаа орсон байгаа.

Тэгээд ажлын хэсэг ахалсан Ганхуяг тэргүүтэй ажлын хэсэгт баярлаж байгаа. 1600 зөвшөөрлийг 362-д буулгасан шүү дээ. Энэ бол өнөөдрийн МАН-ын энэ олон гишүүдийн бас том амжилт шүү гэдгийг нэгдүгээрт хэлье.

Зөвшөөрлийг цахимжуулах асуудал, намайг түрүүн нэг Занданшатар дарга гадаадаар яваад байна, чи ямар үр дүнтэй явсан юм гээд. Би Сингапур явсан, энэ ажлын хэсэгт ороод. Тэгээд ороод би нэг зүйлийг Дэлхийн банк дээр амласан. Та нар энэ зээлээ асуудлаа маш хурдан Их Хурлаар оруулаад өгье гээд. Их Хурлаар оруулаад ирэх юм бол энэ зөвшөөрлийг цахимжуулах асуудлыг хөрөнгө оруулалт тавьж чадах уу гэсэн, тавина гэсэн. Тэгээд би ирээд Тэмүүлэн даргатай Төсвийн байнгын хороонд хүсэлт тавьсан. Тэмүүлэн дарга маш хурдан

оруулж ирээд энэ асуудлыг оруулаад батлаад гаргасан. 1 сая долларыг энэ цахимжуулах программ тавьчихсан байсныг нь 5 сая доллар болгохоор ерөнхийдөө ажиллаж байгаа. Сайн программ хийх ёстой, сайн программ хийсний үр дүнд яах вэ, жишээ нь ААН зөвшөөрөл хүслээ гэхэд ААН-ийн гэрчилгээг шууд нөгөө улсын бүртгэлийн дата-наас татаад, аваад шууд линкийг нь оруулчихдаг. Өөр бусад янз янзын бичиг баримтыг бүгдийг нь линк татаад оруулчихдаг, өөрөөс шалтгаалах юмаа сканерддаг байдаг юм уу, яадаг юм байдаг юм, ингээд оруулчих. Тэгээд л маш хурдтайгаар одоо тэр цаад талын төрийн албан хаагч нь зөвшөөрлийг нь хэвлээд өгөх боломжтой ийм программ хангамжийг л хийхийг зорьж байгаа.

Бид нар бол энэ Их Хурлаар маш сайн хуулиуд батлагддаг, энэ хуулийн хэрэгжилт дээр дандаа хүнд сурталтнууд журам гаргаж будилуулдаг. Энэ зүйлийг бид нар цахимжуулж, ямарваа нэгэн асуудалгүй болгох нь хамгийн чухал байгаа юм. Учрал сайд сая нэг юм яриад л сууж байна, чи тэр нэг нүүрсний хулгайны асуудлыг цэгцлээд тэр нүүрсийг цахимаар худалддаг тэр юмаа л сайн хий, битгий энэ янз янзын юм энд яриад бай. Зөвшөөрлийн хууль дээр 1 сарын 1-ээс хойш дахиж гар хүргүүлэхгүй, яагаад гэвэл энэ бол маш том даваа давж байж зөвшөөрлийг энэ Их Хурлаар батлуулж, ЗГ оруулж байгаад батлуулах ийм л юмыг хийсэн байгаа юм.

Тийм учраас энэ зөвшөөрлийн хууль бол энэ өнөөдрийн МАН-ын олонхдоо энэ парламентын бол хамгийн том, чухал зүйл, чухал хууль. Тийм учраас энэ өөрсдийнхөө энэ эх барьж авсан энэ хуулиа бид нар хамгаалж, цаашидаа улам сайхан, ард түмний хамгийн чухал хэрэгсэл болгохын төлөө бид нар ажиллах ёстой. Тийм учраас энэ гишүүдийн дундаас нь гаргаад л нэг их хүнд суртал бий болгох гээд янз янзын юм яриад байгаа юмыг ерөөсөө Их

Хурлын гишүүд хүлээж авах ёсгүй шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй 96 санал байгаа. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Журмаар зөвшөөрөл тогтоож байсныг л хязгаарлаж байгаа юм л даа.

АН-ын бүлгийн төлөөлөл ингэж сайн дэмжиж байж гишүүдээ дууд, санал хураалтад оруул. Одоо ер нь тэгээд хүмүүс үг биш, үйлдлийг чинь л хардаг болчихсон шүү дээ. Амаараа сайхан дэмжээд байх юм.

Санал хураалтдаа бэлдээрэй. Тэгээд та хэд техникийн зохицуулалт чинь бол заавал дагаж мөрдөх бичиг баримт шүү дээ. Тэгсэн чинь сонгож хэрэглэхээ стандартаа сонгож хэрэглэхээр яачхаад, техникийн зохицуулалтаа тодорхойлдоггүй, орхичихдог чинь яаж байгаа юм бол. Үндсэн хууль дээрээ байсныг нь сонгож хэрэглэх болон техникийн зохицуулалт 2-ыг чинь нэг болгоод оруулаад ирсэн шүү дээ.

Салбар хууль дээрээ зассан юм уу тийм ээ. Энэ дээр чинь ингээд ийм болгосон байна лээ л дээ. Тайлбартай болгочихсон байна лээ.

Үндсэн хууль дээрээ тэр дор заавал дагаж мөрдөх баримт бичиг гэж байдаг байх тийм ээ. Тэр нь тэгэхдээ энд давхардаж байсан юм байна л даа. Өргөн барихдаа тэгвэл.

Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан нийцүүлэхээр хуулийн давхардал, хийдэл,

зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

Нэг.Авто замын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 33.3 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг” гэснийг “зөвшөөрлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Хассуурийн Ганхуяг, Ганибалын Амартүвшин, Хүрэлбаатарын Булгантуяа, Гочоогийн Ганболд, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Бөхчулууны Пүрэвдорж, Баттөмөрийн Энхбаяр, цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт явуулъя.

Энэ эдийн засгийн либералчлалын хамгийн чухал хуулийг АН-ын бүлгээс ажлын хэсэгт орсон ганцхан хүнээс бусад хүн нь дэмжихгүй байна гэж ойлгох уу. Санал хураалт.

Одоо үг биш, үйлдлээрээ л харуулцаа гэж байгаа шүү дээ. Ярьсаар байтал.

Чинзориг гишүүн байсан юм байна. Чинзориг гишүүн.

Энэ Содномын Чинзориг гишүүний хурууг дахиж уншуулахгүй бол хурууны хээ нь өөрчлөгдсөн байна гэж байна. Танихгүй болчихоод байна. Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Хуруу уншигдахгүй байна, дарга аа. Саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулъя.

Г.Занданшатар: Чинзориг гишүүний гаргасан саналаар энэ санал

хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгдүгээр саналыг дахин санал хураалт явуулъя.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 1, 2, 4, 5, 6 дахь заалт, мөн зүйлийн 3 дахь заалтын 20.1 дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. Саналын томъёоллын 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан 2 дугаар зүйлийн “дараах хэсэг, заалтыг” гэснийг “20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1. Төслийн 2 дугаар зүйлийн “, 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалтын “байшин,” гэсний дараа “стандартын шаардлага хангасан дулаалгатай гэр,” гэж тус тус” гэснийг хасах. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

54.8 хувийн талаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 4 дүгээр зүйлийн ““хэрэгжилтэд мэргэжлийн” гэсний дараа “хяналтын асуудал эрхэлсэн” гэж

нэмж, мөн зүйлийн ““тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг “болон энэ хуулийн 25.5-д заасан мэргэжлийн байгууллагын эрх олгоход тавигдах шаардлагыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, мөн зүйлийн “Засгийн газраас томилсон эрх бүхий” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, мөн зүйлийн “хяналтын стандартын хэрэгжилтэд холбогдох” гэснийг “стандартын хэрэгжилтэд холбогдох” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажиллах хүчний ишлжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Төслийн нэрийн “ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ” гэснийг “ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ” гэж өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

Нэрийг нь буруу хэрэглэжээ. Нэмэлт, өөрчлөлт оруулаагүй юм байна лээ. Зарим хэсэг заалтыг нь ч гэсэн.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хуруугаа хийж чадсангүй. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Сая миний хурууны хээ танигдсангүй бололтой, тэгэхдээ нэг зүйлийг хэлээдэхье. Энэ Учрал гишүүнээс бусад бүх сайд нарыг бүгдийг нь дууд.

2 дугаарт нь, Чинзориг сайд аа тэр 7-г 5 жил болгох тухай хуулийг маш хурдан ажлын хэсгийг хуралдуулж, тэр тэтгэвэрт гарах гэж байгаа хүмүүсийг одоо асуудлыг шийдээрэй би танд хэлье.

Тэгээд би яах вэ, та нарыг бодоод энэ дахин санал хураалгах хүсэлтийг гаргаж байна.

Г.Занданшатар: Ажлын хэсэг хуралдаад ЗГ-аас төсөвт өөрчлөлт оруулах учраас санал авахаар явуулсан байгаа шүү дээ.

Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Санал хүчингүй болсонд тооцлоо.

Горимын санал дэмжигдэж санал хүчингүй болсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

Ер нь яг тэтгэврийн зөрүү бол тийм юмнаас үүсэж байгаа шүү дээ. Сүүлийн үеийнх нь маш өндөр цалинтай гарна, гэтэл 90 оны 1000 төгрөг хэдэн төгрөг байсан юм. Индексжүүлэх ёстой, шударга ёсны зарчим.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.7-д заасан” гэснийг хасаж, мөн зүйлийн 3 дахь заалтын 29¹.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29¹.1.Энэ хуулийн 20.2-т заасан ховор амьд амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрөл, 25.1-д заасан тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу дуудлага худалдааны журмаар олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Пүрэвдорж гишүүн ээ, одоо амаа жаахан тат.

Пүрэвдорж гишүүн өөрийнхөө. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Миний хурууны хээ ажилласангүй тул дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Санал хураалтыг Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг хүчингүйд тооцсон, санал хураалтыг дахиж явуулъя.

Зүүн жигүүрээс Чинзориг гишүүн, Баруун жигүүрээс Пүрэвдорж гишүүн 2 л хамгийн их ярих юм. Санал хураалт, санал хураалтыг дахиж явуулъя.

Батлут, Баттөмөр. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ хуулийн төслийг би дэмжиж байгаа юм аа. Тэгэхээр сая энэ аппарат ажилласангүй. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Саналын томъёоллыг дэмжиж байгаа боловч дэмжсэн санал дэмжигдээгүй учраас хүчингүйд тооцох Баттөмөр гишүүний саналаар санал хураалт явуулъя. Горимын саналаар санал хураалт явуулъя.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баттөмөр гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг хүчингүйд тооцож санал хураалтыг дахиж явуулъя.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төвлөрөөд санал өгөхөөр ингээд зүгээр өгөөд байгаа юм. Хүмүүс үймүүлэхээр тэгээд.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 29^{1.2} дахь хэсгийн “баталснаас” гэснийг “баталсан шийдвэр гарснаас” гэж өөрчилж, 29^{1.3} дахь хэсгийн “этгээд” гэсний дараа “, эсхүл” гэж, 29^{1.4} дэх хэсгийн “24 цагийн өмнө” гэсний дараа, 29^{1.7} дахь хэсгийн “24 цагийн дотор” гэсний дараа “дуудлага худалдаа зохион байгуулагчийн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 29^{1.8} дахь хэсгийн “Хэрвээ ялсан этгээд тогтоосон хугацаанд” гэснийг “Дуудлага худалдааны ялагч” гэж, 29^{1.9} дэх хэсгийн “дүрс” гэснийг “дуудүрсний” гэж, 29^{1.10} дахь хэсгийн “худалдааны ялагч нь тэмдэглэл болон гэрээнд” гэснийг “худалдаанд оролцогчид тэмдэглэлд үндэслэлгүйгээр” гэж, мөн хэсгийн “зайлсхийсэн” гэснийг “татгалзсан” гэж, 29^{1.14} дэх хэсгийн “29.1-д” гэснийг “29^{1.1-д}” гэж, мөн тус тус өөрчилж, мөн заалтын 29^{1.12.3} дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29^{1.12.3}.энэ хуулийн 29^{1.8-д} заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээд татгалзсан тохиолдолд.” Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 36.7, 36.8 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“36.7.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 36.1-д заасан зөвшөөрлийг сунгуулах өргөдлийг хүлээн авах, магадлан шалгах ажиллагааг ажлын 15 өдрийн дотор явуулах бөгөөд уг ажиллагааг дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

36.8.Засгийн газар энэ хуулийн 36.7-д заасан саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.” Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын 25.5 дахь хэсгийн “заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга” гэснийг “заасан зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд” гэж, мөн зүйлийн 5 дахь заалтын 36.1 дэх хэсгийн “заасны дагуу нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар” гэснийг “заасан зөвшөөрлийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу Засгийн газар” гэж өөрчилж, мөн заалтын 36.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх асуудлыг мөн хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Нэн ховор амьд амьтны цуглуулга гэж юу байдаг юм, ер нь. Амьд амьтны цуглуулга гэж юу байдаг юм бэ. Түрүүн нэг гарсан, түрүүний гарсан, одоо нэн ховор амьтныг амьдаар гадаад улс. Энэ заалтуудаа дараа нь тодорхой болгохгүй

бол бас. Амьд амьтны цуглуулга гэж. Эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай. Тэр үг, үсгүүд.

6. Төслийн 3 дугаар зүйлийн “7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Нэн” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.5-д заасны дагуу нэн” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга” гэснийг “заасан зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд” гэж өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үүнийг хууль дээр бол ховор амьтны цуглуулга гэж байхгүй байгаа юм. Цуглуулга гээд нэг шинэ нэр томъёо ороод ирж.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 29¹.8 дахь хэсгийн “29¹.7-д заасан” гэсний дараа “хугацаанд” гэж нэмж, 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын “25.1, 25.5 дахь” гэснийг “25.1 дэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

Энэ чинь эдийн засгийн байнгын хороо ажилласан уу. Танай референтүүд найруулгын саналыг нэгтгээд хураалгачих ёстой байхгүй юу. Дандаа тусад нь оруулж ирж байх юм.

Тав. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 3 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд архивын баримтыг хадгалуулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан

төрийн захиргааны байгууллагын дарга батална.” Санал гаргасан Ажлын хэсэг, санал хураалт.

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гарсан, Улсын Их. Энэ чинь санал гаргасан гишүүн нь санал гаргаагүй бол гүйцээн боловсруулах чиглэл өгөх. Энэ чинь гүйцээн боловсруулах гэж, хууль санаачлагч буцаах гэсэн саналыг яаж гүйцээн боловсруулах гэж хэлэх. Үг хэлэх, санал хураалт явуулъя, шуурхайлъя, санал хураалт.

Энэ чинь нэлээн их саналаар унаж байна даа. Ажлын хэсгийнхэн бүгд эсрэг өгсөн байна.

Дараагийн саналд оръё.

Долоо. Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэр 29-ийн итрих нэг дээр нэмж байгаа 22-т заасан ховор амьтны цуглуулга гэж байхгүй байна шүү. Ховор амьтны жагсаалт гэж байгаа болохоос биш 29-ийн 2-т. Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор амьтныг агнах, барих зөвшөөрөл гэж байгаа юм. Тэгтэл ховор амьтны цуглуулга гээд шинэ нэр томъёо оруулж ирж байгаа нь цуглуулгаар нь зөвшөөрөл өгөх нь байна шүү дээ, бүр. Амьдаар нь.

7-гийн 2 дахь заалт, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

29-ийн итрих 1-ийн ховор амьтан бол нөгөө юу ан агнуурын зориулалтаар нь орж байгаа боловч сонин л юм байна даа. Энэ дуудлага худалдаа зохион байгуулах.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 24.2.2 дахь заалтын, мөн зүйлийн 5 дахь заалтын 36.20.5 дахь заалтын “үндэсний аюулгүй байдал,” гэж гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Үүнийг яагаад хасаж байгаа юм, энэ болохгүй шүү дээ. Үүнийг бол ёстой гүйцээн боловсруулах чиглэл өгөх заалт байна.

57.1 хувийн саналаар санал дэмжигдсэн байна.

Ес. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль.

1. Төслийн 2 дугаар зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “10¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “аргачлал, эрх олгох” гэснийг “аргачлалын” гэж” нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийн “10¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арав. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Боловсролын хууль хэзээ батлагдах хүртэл байна шүү дээ, энэ хуучин зөвшөөрлийнх нь процесс хэвээрээ үлдчих нь байна шүү дээ. Боловсролын хууль хэзээ ч

Арван нэг. Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 139.1.13 дахь заалтын “, Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг нотолсон цагдаа, гаалийн байгууллагын тодорхойлолт” гэснийг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 171.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“171.1.10.хилийн боомт, олон улсын нисэх буудалд ажиллаж байгаа татваргүй барааны дэлгүүр зорчигчийн гадаадад зорчих тийз, гадаад паспорт, гаалийн нутаг дэвсгэрийн гүнд байрлах дэлгүүр нь Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын болон олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдлэх албан тушаалтнуудын паспорт эсхүл дипломат үнэмлэх болон худалдан авсан барааны мэдээллийг борлуулалт хийх тухай бүр цахим төлбөрийн баримтын системд бүртгээж, цахим баримт олгох;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үүнийг илүү сайн, энэ их зөв заалт шүү, татваргүй оруулж ирдэг арга болчихсон.

Арван хоёр. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 7.7, 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.7.Гадаадын иргэн нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу улсын онц чухал объектод ажиллаж болно.

7.8.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 7.6-д заасан өргөдлийг хүлээн авч Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу магадлан шалгах ажиллагааг хэрэгжүүлж, саналаа хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газарт хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 7.11 дэх хэсгийн “7.7, 7.8, 7.9-т” гэснийг “7.8-д” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.10, 7.12 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван гурав. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.4 дэх хэсгийн, мөн зүйлийн 5 дахь заалтын 12.2 дахь хэсгийн “худалдаа эрхлэх,” гэсний дараа, “газрын

тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 5 дахь заалтын “12.2.1 дэх заалтын “4.1.10-т” гэснийг “4.1.9-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 5.2.5 дахь заалтын “1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт” гэснийг “3.3 дугаар зүйлийн 1-д” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь заалтын 8.3.5 дахь заалтыг, мөн зүйлийн 4 дэх заалтын 9.2.2 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1. Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын “бүтээгдэхүүнийг” гэсний дараа “энэ хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь заалтын “уг зөвшөөрлийг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван дөрөв. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван тав. Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10, 11, 12 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“10.Засгийн газар энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлнэ.

11.Энэ хуулийн 6 дахь хэсэгт заасан зөвшөөрөл хүссэн өргөдөл болон зөвшөөрөл сунгуулах өргөдлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авах, магадлан шалгах ажиллагааг ажлын 15 өдрийн дотор явуулах бөгөөд уг ажиллагааг дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

12.Засгийн газар энэ зүйлийн 11 дэх хэсэгт заасан саналыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Битгий дэмий юм яриад бай, та нар, хуралдаа суухгүй, саналаа өгөхгүй, хурдан удаан унисандаа биш, та нар саналаа зүгээр өгч байвал энэ чинь аль хэдийн дахин санал хураалт явахгүй явж байна. Ер нь жоохон аятайхан байцгаана шүү.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 13 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 4 дэх хэсгийн “13 дахь” гэснийг “3 дахь” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван зургаа. Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийт 89 хуульд өөрчлөлт оруулахаас одоо 16 дахь дээр явж байна. Жаахан удаан тайван унишина.

Арван зургаа. Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Энэ санал хураалт сая явуулчихсан, явуулчихсан учраас удаашируулж дахиж оруулж байгаа энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. 1 санал хураалтыг ингээд 2 хураагаад явчихна, Цогтбаатар гишүүний саналаар.

2. Төслийн 3 дугаар зүйлийн “18 дугаар зүйлийн 18.5” гэснийг “19 дүгээр зүйлийн 19.5” гэж, мөн зүйлийн “, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Галт зэвсэг ашиглах спортын тэмцээн, сургалтад оролцох, ан агнах зорилгоор” гэснийг “Ан агнах зорилгоор” гэж” гэснийг “13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “загвар, гэрчилгээ олгох журмыг” гэснийг “загварыг” гэж” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураах уу. Санал хураалт.

56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан Адъшаа гишүүн суугаарай.

Тэгээд л гарч ороод л гүйгээд байх юм, та сууж, саналаа өг. Энэ чухал либералчлалын хуулийг үзэл баримтлахынхаа хүрээнд дэмж.

Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван долоо. Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 7.9 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван найм. Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Төслийн 2 дугаар зүйлийн 15.13, 15.14 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Энэ төлөөллийн ардчиллын зарчмаар ард түмнийг төлөөлөх эрх, үүрэгтэй цорын ганц субъект нь УИХ-ын гишүүд.

58.7 хувиар санал дэмжигдлээ.

Арван ес. Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1. Зар сурталчилгааны хууль дээр үү, бүхэлд нь үү.

Энэ гүйцээн боловсруулахгүй бол энэ 9 заалт бараг нэг хуудас санал байна аа, үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Дотор нь юу ч байгаа юм, гадна зар сурталчилгаа гэж гудамжны гэх юм уу.

Дараагийн асуудал.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2, 6, 7 дахь заалтыг тус тус хасах. Санал аргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүд ээ, анхааралтай, санал хураалт.

57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 10.14 дэх хэсгийн “Командлалын зөвшөөрлийг үндэслэн” гэснийг “Командлал, эсхүл” гэж өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ “үйлчилгээ эрхлэх” гэсний дараа “зорилгоор талбай ашиглах” гэж “үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай ашиглах” гэдгийг оруулна гэхээр болохгүй байна. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

4. Төслийн 4 дүгээр зүйлийн “5.2 дугаар” гэснийг “4.2 дугаар” гэж, мөн зүйлийн “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар” гэснийг “Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж, мөн зүйлийн “12.13 дахь” гэснийг “12.14 дэх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн “Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэсний дараа “мөн хэсгийн

1.23 дахь заалтын “сум, дүүргийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж, гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Нямбаатар сайд аа, МХЕГ-ын нэр өөрчлөгдсөн үү. Бат-Эрдэнэ гишүүний санал эсрэг гарсан байна. Хассуурийн Ганхуяг. Энэ чинь заавал орохгүй бол болохгүй юм байна шүү дээ, тэгээд унаа байна шүү дээ. Энэ санал уначихлаа.

Наад МХЕГ гэдэг чинь байхгүй болчихоод байхад. Ганхуяг гишүүн өөрөө горимын санал гарга.

Х.Ганхуяг: Сая энэ хуруугаа уншуулж амжсангүй, дахиад нэг санал явуулж өгнө үү. Саян санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

Г.Занданшатар: Хуруу уншуулж чадаагүй биш ээ. Мөнх-Оргил гишүүн та 2 ярьж байгаад хоёулаа эсрэг гарчихлаа. Тэгээд дэмжиж байсан өөрийнх нь оруулсан санал эсрэг гарчихсан учраас Ганхуяг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хүчингүйд тооцох санал хураалт.

61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саяыг хүчингүйд тооцсон учраас саяын саналыг дахиж хураая. 4 дэх саналыг санал хураая. Тогтохоо дарга аа, Мөнхбат гишүүн ээ, санал хураалт. Энэ сая унасан санал.

Үгүй ээ, энэ болохоо больчихлоо шүү дээ, болохгүй байна. Сая ажилласангүй, энэ фульт дээр анхааръя. Энэ техникийн шалтгаанаар энэ ажилласангүй, хүчингүйд тооцлоо. Санал хураалт явуулна. 4 дэх саналаар санал хураалт дахиж явуулж байна.

63.8.

5. Төслийн 5 дугаар зүйлийн “, 10 дахь хэсгийн 10.11 дэх хэсгийн “болон

нийтийн эзэмшлийн гудамж, талбайд” гэснийг” хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин хоёр. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Төслийн 3 дугаар зүйлийн “хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 18, 21, 22 дахь” гэснийг, мөн зүйлийн “6.1 дүгээр зүйлийн 18, 21, 23 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.6 дугаар зүйлийн 6,7 дахь хэсэг, 7.15 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 10.23 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэснийг “тусгай зөвшөөрөлгүйгээр” гэж,” гэснийг, мөн зүйлийн “7.15 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “, зөвшөөрөл” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “тусгай зөвшөөрлийг” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4, 5 дугаар зүйл болгох:

“4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтын “, эсхүл зөвшөөрөл авах журам зөрчсөн” гэснийг, 6.15 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулсан” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг, 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг, 6.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг, 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг, 7.13 дугаар зүйлийн 9.5 дахь заалтыг, 7.15 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг, 7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг, 7.18 дугаар

зүйлийн 2.1 дэх хэсгийг, 10.18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг, 12.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг, 13.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг, 13.4 дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсгийг, 14.5 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг, 16.3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Баярсайхан гишүүн сүүлийн үед ерөөсөө харагдсангүй, хайчсан юм бэ.

Хорин гурав. Зөрчил шалган ишийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “, мөн зүйлийн 6.10 дахь заалтын “14.13” гэснийг дараа “,14.15” гэж тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

68.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ганхуяг гишүүн ээ, үүнийгээ дагаад тэр Зөрчлийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт орохгүй байсан юм уу. Эцсийн хэлэлцүүлэг дээр хараарай.

Хорин дөрөв. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Кибер аюулгүй байдлын тухай хууль. 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах. Үүнийг гүйцээн боловсруулахгүй бол болохгүй юм байна. Аюулгүй байдалтай холбоотой. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Үүнийг

чинь тэр чигээр нь хасчихвал энэ кибер аюулгүй байдлын асуудал чинь хакер чинь ерөөсөө. Гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн.

Хасаж лав болохгүй юм байна, энэ санал.

Хорин зургаа. Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Үүнийг санал хураалт явуулаад унагаачихъя. Санал хураалт. Гүйцээн боловсруулаад байвал энэ бас улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн баримтаа хавсрах гэснийг л хасаж байгаа юм байна шүү дээ, энэ чинь. Тэмдэгтийн хураамжаа төлөх хэрэгтэй шүү дээ.

Энэ санал дэмжигдсэнгүй. Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах санал дэмжигдсэнгүй.

Найруулгын санал. 1. Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын “7.1.4, 7.1.5 дахь” гэснийг “7.1.4 дэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.1.5 дахь заалтыг 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгон, мөн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 20.2.5-20.2.12 дахь заалтыг 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт болгон, мөн заалтын 20.2.4 дэх заалтыг 2 дугаар зүйлийн 3 дахь заалт болгон, мөн заалтын 20.3 дахь хэсгийг мөн зүйлийн 4 дэх заалт болгон, мөн заалтын 20.5 дахь хэсгийг мөн зүйлийн 5 дахь заалт болгон тус тус шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин долоо. Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 25.5 дахь хэсгийн “зөвшөөрлийг үндэслэн” гэснийг “зөвшөөрлийн дагуу” гэж, мөн

хэсгийн “боомт нэвтрэх зөвшөөрлийг олгоно” гэснийг “боомтод нэвтэрч үйл ажиллагаа явуулахад энэ хуулийн 25.4-т заасан баримт бичгийг бүрдүүлж, энэ хуулийн 25.2-т заасан байгууллагад хүргүүлнэ” гэж, мөн зүйлийн 25.6 дахь хэсгийн “25.4, 25.5-д” гэснийг “25.4-д” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 25.8 дахь хэсгийн “нислэг үйлдэх” гэсний дараа “нислэгийн бүрэлдэхүүнд хилийн зурвас, бүсэд нэвтрэх” гэж нэмж, мөн хэсгийн “ажлын нэг өдрийн дотор” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн “26.2.3, 30.2.3-т” гэснийг “26.2.3-т” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Төрийн ажлаа хий гэж ард түмэн шаардаж байгаа шүү. Ард түмнийг төлөөлөх эрхтэй субъект бол Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд, өөр хэн ч төлөөлөхгүй.

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин найм. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 2 дугаар зүйлийн 14.3 дахь хэсгийн “зөвшөөрөл олгох,” гэсний дараа “сунгах,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин ес. Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 4 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5. Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

75 хувь нь явлаа.

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гуч. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.6 дахь хэсгийн “Сонгон шалгаруулалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна” гэснийг хасаж, 3 дугаар зүйлийн 4 дэх заалтыг 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтад шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин нэг. Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгон шилжүүлж, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 11.1 дэх хэсгийн “зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл /цаашид “эрхийн бичиг” гэх/” гэснийг “болон энгийн зөвшөөрөл” гэж, мөн хэсгийн “тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авах өргөдлийг хүлээн авч” гэснийг “зөвшөөрөл хүссэн” гэж тус тус өөрчилж, мөн заалтын 11.4 дэх хэсгийн “Сонгон шалгаруулалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Хууль тогтоомжийн хуулийн 19 дүгээр зүйлийг эргэж сэргээмээр байгаа юм. Тамгын газар эрх зүйн дүгнэлт гаргадаг байсан.

61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

01 сарын 01-ээс хэрэгжиж эхлэх хууль учраас тэгээд л яалт ч үгүй.

Гучин хоёр. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

68.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15¹.1 дэх хэсгийн “чөлөөт бүсийн захирагчид” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.4 дүгээр зүйлд зааснаас гадна” гэж нэмж,

мөн заалтын 15^{1.1.3} дахь заалтын “хяналтын” гэснийг “хяналт шалгалт хэрэгжүүлэх” гэж өөрчилж, мөн заалтын 15^{1.1.1} дэх хэсгийг хасаж, мөн заалтын 15^{1.2} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15^{1.2}.Энэ зүйлийн 15^{1.1}-д заасан баримт бичиг нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

68.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15^{1.4} дэх хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлийн 3 дахь заалтын 15^{2.1} дэх хэсгийн “нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчилж, мөн заалтын 15^{2.1.3} дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

5. Төслийн 4 дүгээр зүйлийн “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “татвар, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.2-т заасан журмын дагуу” гэснийг “татварын байгууллагын санал, хяналтын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ганхуяг гишүүн сайн ажилласан. Нөгөө Үндсэн хуулийнхаа концепц. Ганхуяг, Мөнх-Оргил гишүүн 2 түрүүн тэр согтууруулах ундааны энэ эргэлтэд хяналт тавих саяны өөрчлөлтүүд бий шүү дээ. Үүнтэй ер нь холбогдоод цааши цаашидаа түрүүн бас нэг дутифри дэлгүүрүүд гарлаа шүү дээ, тийм ээ. Үндэсний үйлдвэрлэлээсээ илүү энэ гаднаас орж ирж байгаа чанартай, чанартай, баталгаатай, хуурамч үгүй нь мэдэгдэхгүй үнэтэй энэ архины импортын валютын нөөцийн бодлого ч гэсэн 270000000 долларын архи тийм их импортоор авч байна шүү дээ. Үүний эргэлтэд яг үнэн бодитой байдаг юм уу? Хуурамч оруулаад байдаг юм уу? Хаана ч гэнэ ээ, ингээд үйлдвэрлээд л ингээд л хуурамч оруулаад байдаг гэсэн тийм яриа, санал шүүмжлэл энэ хуулийн дараа Ди парламентаар их ирсэн. Түүнийг нээрээ анхаараад нэг энэ дутифринүүдээр дамжиж хуурамчаар архи их зарагддаг гэсэн тийм мэдээллүүд ирээд байгаа. Түүнийг ер нь цэгцэлмээр юм биш үү, энэ зөвшөөрлийг нь ч гэсэн. Манайх шиг ийм олон дутифритэй улс байдаг ч юм уу, үгүй ч юм уу.

Найруулгын санал. 1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн “даргад,” гэснийг “дарга, эсхүл” гэж, мөн хэсгийн “бичгийн хамт албан бичиг” гэснийг “бичгийг цахимаар” гэж, мөн заалтын 15^{1.3} дахь хэсгийн “хийж шийдвэр гаргах” гэснийг “шийдвэрлэж, зөвшөөрөл олгох” гэж тус тус өөрчилж, мөн заалтын 15^{1.3} дахь хэсгийн “дүгнэлт гаргах” гэсний дараа “үүрэг бүхий” гэж, мөн хэсгийн “нийслэлийн Засаг дарга,” гэсний дараа “эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт” гэж, 15^{1.4} дэх хэсгийн “нийслэлийн Засаг дарга,” гэсний дараа “эсхүл” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

68.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин гурав. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 52.16 дахь хэсгийн “Ийнхүү шилжсэн” гэснийг “Зөвшөөрөл эзэмших эрхийг шилжүүлэн авсан” гэж өөрчилж, мөн заалтын 52.15.6 дахь заалтын “нэн” гэснийг, 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 53.2 дахь хэсгийн “заавал” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин дөрөв. Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн заалтын 9.6 дахь хэсгийн “нь энэ зүйлийн 9.5-д заасан стандартыг заавал” гэснийг “энэ хуулийн 6.7-д заасан техникийн зохицуулалтыг дагаж” гэж өөрчлөх.

“9.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.3, 1.5, 1.12, 1.13, 1.15, 1.16, 1.17, 1.18, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.2, 7.4, 7.6 дахь заалт, 11 дэх хэсгийн 11.7 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн болон 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.9, 1.11 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.1 дэх заалтад заасан энгийн зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

2 дугаар зүйлээ нөгөө заавал дагаж мөрдөх, тэгээд сонгон хэрэглэх баримт бичиг болгосон гэснийгээ ахиад янзлах гэж үү. Энэ чинь тайлбар л юм байна шүү дээ. Үүнийг гүйцээн боловсруулах юм байна. Тэр үндсэн 2 дугаар зүйлийг хөндөөгүй зүгээр тайлбар

болгочихсон байна шүү дээ. Үүнийгээ гүйцээн боловсруулъя.

Саяын санал 68.1-ээр дэмжсэн.

Энэ 2 дугаар заалт дээр тэр тайлбараа засахгүй л дээ. Тэр тодорхойлолт дээрээ заавал дагаж мөрдөх баримт бичиг гээд биччихсэн байгаа юм чинь тодорхойлолтоо өөрөө засна шүү дээ. Үүнийгээ гүйцээн боловсруул аа.

Гучин тав. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 7¹.2 дахь хэсгийн “стандартад заасан” гэснийг “холбогдох стандартын шаардлагаас гадна” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Шаардлагаас гадна гэхээр наадах чинь найруулгын засвар биш, агуулгын засвар болчихож байна л даа. Үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээрээ та хэд нягталж үзээрэй.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн “чөлөөт бүсэд тухайн” гэснийг “чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт” гэж, мөн зүйлийн 7.11 дэх хэсгийн “зөвшөөрлийн хугацаа” гэснийг “зөвшөөрлийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.11.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин зургаа. Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 16.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.12.Төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.1-д заасны дагуу Засгийн газар олгох, сунгах, хүчингүй болгох бөгөөд мөн хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх шийдвэрийг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

68.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин долоо. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй. 29.8 хувийн дэмжлэг авсан байна. Санал гаргах гишүүн байгаа юу, алга байна. Энэ санал дэмжигдсэнгүй.

Гучин найм. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн” гэсний дараа “14.1 дэх хэсгийн “авмагц доор дурдсан ажиллагаа явуулна” гэснийг “авч, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2-т зааснаас гадна дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж, мөн зүйлийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин ес. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний мэргэжлийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 3 дугаар зүйлийн “мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран” гэснийг, мөн зүйлийн “13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын төв байгууллагын зөвшөөрөлтэйгөөр худалдаж” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэнээр шилжүүлж” гэж, мөн зүйлийн “13.4” гэснийг “13.2” гэж, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын төв” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “энэ хуулийн 5.1.6-д заасан журмын дагуу мэдээллийн нэгдсэн санд” гэж,” гэснийг, мөн зүйлийн мэргэжлийн хяналтын төв байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх зүйлийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 23.3

дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтын төв байгууллага” гэснийг “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ чинь ЦЕГ-тай яаж байж авдаг байсан биш үү, Үндсэн хуульдаа тэр ЦЕГ-аас нэг зөвшөөрөл авч байж тэсэрч дэлбэрэх бодисын зөвшөөрөл олгоно гэсэн тэр хэвээрээ байгаа биз дээ. Тэгэхгүй бол энэ чинь зөвхөн геологи, уул уурхайн мэргэжлийн хяналтын юмнуудыг энэ.

Дараагийнх нь 63.8 хувийн саналаар санал дэмжигдсэн.

2. Төслийн 4 дүгээр зүйлийн “22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын төв байгууллага,” гэснийг, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтын “болон мэргэжлийн хяналтын” гэснийг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Найруулгын санал байна шүү дээ, энэ чинь.

Найруулгын саналаа гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Дөчин нэг. Усны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Агар-Эрдэнэ дарга аа, Эдийн засгийн байнгын хороо, энэ нэг багц хууль юм чинь хооронд нь уялдуулж давхардал хийдлийн зөрчлийг нь арилгаж байгаа юм чинь найруулгын санал нэгдсэн нэг нэр томъёо энэ тэрийг нэг санал хураалтаар шийдэж болно шүү дээ. Хооронд нь уялдуулж. Дэг дугаарыг нь өөрчлөхөөс

авхуулаад найруулгын саналыг чинь нэг өөрчлөгддөг шүү дээ, дэг дугаар өөрчилнө энэ тэр гээд. Энэ чинь ингээд бараг.

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

1. Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “өөрчлөлт” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Дөчин хоёр. Үйлдвэрлэл, технологийн парк эрхзүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

72.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Үүнийг найруулгын саналаар өмнө нь санал хураалт явуулчихсан гэж тооцъё. Өөрчлөлт гэснийг хасах гэдгээр гарчихсан, протоколд тэмдэглэе.

Дөчин гурав. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 4 дүгээр зүйлийн “11.1.12 дахь заалт,” гэснийг, мөн зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.1.10 дахь” гэснийг, мөн зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “батална.” гэснийг “тогтооно.” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөчин дөрөв. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Ням-Осорын Учрал гишүүн дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх санал гаргасан учраас Ням-Осорын учрал гишүүн үг хэлнэ. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Н.Учрал: Тэр түрүүн Кибер аюулгүй байдлын хууль дээр нэг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн, тэгээд энэ бол ЗГ-аас энэ харилцаа холбооны хууль кибер аюулгүй байдлын хуулийг ингээд оруулж ирсэн. Тэгэхээр сая гүйцээн боловсруулж чиглэл өгсөн учраас энэ харилцаа холбооных нь хуулийн энэ заалтыг хасахгүйгээр нийцүүлэхгүй энэ болохгүй юм байна. Тэгээд Ганхуяг гишүүн бол түрүүн энэ мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх 3 асуудлыг онц чухал гэж үзээд дахин боловсруулья гэсэн ийм саналтай байгаа илэрхийлсэн.

Тэгээд манай энэ ажлын хэсгийн ахлагч Ганхуяг бол мэдээллийн аюулгүй байдлын аудит ямар чухлыг надаас илүү мэддэг хүн, тэгээд яалт ч байхгүй Пүрэвдорж гишүүн, Ганхуяг гишүүн гээд манай ажлын хэсгийнхэн сүүлийн хэд хоног маш их цаг завгүй ажилласан учраас санаандгүйгээр, санамсаргүйгээр энэ 2 хуулийг хасахаар оруулж ирсэн дээ. Энхбаяр гишүүний хэлдэг шиг ухар мөчид ухаарч тэр дахин гүйцээн боловсруулья гэж байна.

Тэгэхээр дарга аа, энэ харилцаа холбооны хууль дээрээ гүйцээн боловсруулах гээд нийцүүлэхгүй бол нөгөөдөх нь гүйцээн боловсруулаад хийчихдэг энэ хасагдчихдаг. Тэгэхээр энэ чинь хоорондоо холбоотой хууль байгаа байхгүй юу. Тийм, тэгэхээр энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл авмаар байна.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Гүйцээн боловсруулья дарга аа.

Г.Занданшатар: Гүйцээн боловсруулья. Хувь хэмжээ тогтоох чинь бас үзэмж, хэн тогтоох юм, тэгээд.

Дөчин тав. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Шинэ, хуучин 2 Ёс зүйн байнгын хорооны дарга саналаа өгөхийг хүсэж байна.

58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөчин зургаа. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Цогтбаатар гишүүн ээ, Бат-Эрдэнэ гишүүн ээ, та бүхний саналын дагуу маш хурдан уншсанаас ингээд үндсэндээ дуусаж байна. Тавхан санал үлдлээ.

Дөчин долоо. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 3 дугаар зүйлийн “11¹ дүгээр зүйлийн гарчиг, 11¹.1, 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.3, 18 дугаар зүйлийн 18.8, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.4, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “мэргээжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “цөмийн болон цацрагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг, мөн зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргээжлийн хяналтын” гэснийг “харьяалах хяналтын” гэж,” гэснийг, мөн зүйлийн “19.8 дахь хэсгийн “мэргээжлийн хяналтын байгууллага” гэснийг “цөмийн болон цацрагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг, “, 22 дугаар зүйлийн 22.5.2 дахь заалтын дугаарыг “22.5.1” гэж, 22.5.3 дахь заалтын дугаарыг “22.5.2” гэж,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “23 дугаар зүйлийн гарчгийг”

гэснийг “23 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх” гэснийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөчин найм. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.2, 7.5 дахь хэсгийн “Малын” гэснийг “Мал, амьтны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

72.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 4 дүгээр зүйлийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, “зөвшөөрлийн” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөчин ес. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1. Төслийн 3 дугаар зүйлийн “гэж, 41 дүгээр зүйлийн гарчгийн “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх, худалдах”” гэж гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

70.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 5 дугаар зүйлийн “19.8 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор”,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Зарчмын зөрүүтэй 9 саналаар санал хурааж дууссан.

6 цаг болоогүй байгаа учраас дараагийн асуудалд орно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлнэ.

17.47 цаг

Найм. ““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын эрхэм гишүүн Телиуханы Аубакир танилцуулна.

Т.Аубакир: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол УИХ-ын гишүүн Н.Алтанхуягаас 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Эрдэнэт үйлдвэр, төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг УИХ-ын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 27-

ны өдрийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр, төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Аубакираар ахлуулан, УИХ-ын гишүүн Адьяасүрэн, Алтанхуяг, Амартүвшин, Батжаргал, Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Дамдинням, Наранбаатар, Өнөрболор, Тэмүүлэн, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Тус Байнгын хороо төслийн анхны хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүн Раднаасэд одоогоор Эрдэнэт үйлдвэрийн технологид тохирохгүй, хүдрийн овоолгыг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийн эрх зүйн зохицуулалтын талаар асууж, өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн агуулгыг өөрчилж, ЗГ-т чиглэл өгсөн тогтоол болгох нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно.

Монгол УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай нийцсэн эсэх талаар төсөл санаачлагчийн байр суурийг тодруулан, хүдрийн авуул ашиглан үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-үүдэд буцаж үйлчлэх заалт төсөлд тусгагдсан эсэх талаар асуулт асууж,

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хариулт авлаа. Түүнчлэн УИХ-ын гишүүн Батжаргал тогтоолын төсөлд тусгагдсан үйлдвэрийн технологид тохирохгүй, үүсмэл ордуудыг ашиглах талаарх зохицуулалтыг УИХ хэлэлцүүлгийн шатанд байгаа холбогдох хуулийн төслүүдэд тусган шийдвэрлэх, мөн ашигт малтмалын орд бүхий орон нутгийн иргэдийг ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөр, татварын хуваарилалтаар дэмжих, үүнээс тодорхой хувийг орон нутагт баялаг бүтээгчдэд түлхүү хайрлах талаар хуваарилах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Ажлын хэсгээс Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.23 дахь хэсэгт заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр, төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжлээ.

“Эрдэнэт үйлдвэр, төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, “Эрдэнэт үйлдвэр, төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Хоролсүрэнгийн Бадамсүрэн Эрдэнэс Монгол ХХК-ийн Зэс Металлын группийн дарга.

Энэ чинь эхний хэлэлцүүлэг юм байна. Ажлын хэсэг шаардлагагүй юм байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу. Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Би нэг товчхон юм Алтанхуяг гишүүнээс асуух гэсэн юм аа. Энэ тогтоол чинь өмнө нь чуулган дээр ороод дэмжигдсэн, Байнгын хороон дээр дэмжигдээд, чуулган дээр дэмжигдээд, тэгээд дахиад Байнгын хороон дээрээ уначихсан юм уу даа. Энэ яг яагаад энэ сүүлийн Байнгын хороон дээр энэ асуудал ингээд дэмжигдээгүй юм бол Алтанхуяг гишүүн энэ дээрээ нэг тодорхой тайлбар хэлээд өгөөч.

Г.Занданшатар: Байнгын хороо хариулна. Ажлын хэсэг хариулах уу, Байнгын хорооны дарга хариулах уу. Байнгын хорооны дарга Төмөртоогогийн Энхтүвшин Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга хариулна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Алтанхуяг гишүүнээс 2022 оны 4 сарын 14-ний өдөр “Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн байж байгаа. Энэ тогтоолын төслийн дагуу Үйлдвэржилтийн байнгын хороо, УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн газар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. Хууль зүйн дүгнэлт маань юу гэдэг юм, 2022 оны 6 сарын 27-ны өдөр ирсэн. Монгол Улсын Үндсэн хууль, Компанийн тухай хууль, Төсвийн тухай хууль зөрчсөн учир энэ хууль, эрх зүй

хууль зөрчсөн байна гэдэг дүгнэлтийг УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн газар гаргуулсан байж байгаа. Үүний дагуу Үйлдвэржилтийн байнгын хороо хуралдаад хуулийн тогтоолын төсөл санаачлагч Норовын Алтанхуягт тогтоолын төслийн саналыг хууль тогтоогчид нь буцаах нь зүйтэй гэдэг ийм тогтоолын төслийг гаргасан байж байгаа.

Дараа нь юу гэдэг юм, УИХ-ын чуулганаар хэлэлцээд ирц бас хангалтгүй байсан, энэ үед бас хэлэлцээд УИХ-ын тогтоолын төсөл унаад, эргээд анхны хэлэлцүүлэгт шилжсэн байж байгаа. Анхны хэлэлцүүлэгт шилжсэн, чуулганы асуудлыг Байнгын хороогоор хэлэлцээд Байнгын хорооноос ямар ч байсан ажлын хэсэг гаргах нь зүйтэй юм байна гэдэг ийм санал дүгнэлтийг гаргасан байж байгаа. Үүний дагуу 12 хүний бүрэлдэхүүнтэй Аубакир гишүүнээр ахлуулсан Эрдэнэтийн энэ овоолгыг судалж үзэх ийм ажлын хэсэг гарсан байж байгаа. Ажлын хэсэг маань 2022 оны 11 сарын 14-нд ажлын хэсгийн танилцуулгыг бэлдэж Байнгын хороонд ирүүлсэн. Ажлын хэсгийн дүгнэлт дээр мөн ялгаа байхгүй, Үндсэн хууль болон Компанийн тухай хуулийг, Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна, тийм учраас “Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газрын технологит тохирохгүй хүдрийн явуулгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийг Монгол УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.23 дахь заалтыг үндэслэн хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэдэг ийм ажлын хэсгийн дүгнэлт гарсан байж байгаа.

Энэ дүгнэлтийг Байнгын хороогоор хэлэлцээд буцаах нь зүйтэй юм байна гэдэг ийм асуудлыг шийдчихсэн, ийм тайлбар хэлж байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Энэ овоолгын талаар би яах вэ, Алтанхуяг гишүүний тавьж байгаа биш, ер нь энэ овоолгын талаар асуух гэж байгаа юм. Энэ овоолго мэдээж би бодохдоо бол Эрдэнэт үйлдвэр анх ашиглалтад орсноос хойш л бий болсон байх. Сүүлийн үед энэ Эрдэнэт үйлдвэрийг удирдаж байсан Бадамсүрэн гуайгаас асуух гэж байгаа юм. Энэ овоолгыг ер нь яагаад Эрдэнэт үйлдвэр өнөөдрийг хүртэл ашиглаагүй юм бэ, үр ашиггүй гэж үзсэн юм уу гэсэн нэг дэх асуулт байна.

2 дахь асуулт, юу гэхээр энэ өнөөдөр хамгийн их хэрэглэж байгаа нь тэр Ачит эх гээд компани байгаа. Ачит ихтэд бол Монгол Улсын төрийн эзэмших, Эрдэнэт үйлдвэрийн эзэмших хувь маань 34 хувь байснаа 0 болчихсон. Тэгээд эрдмийн гээд үйлдвэр байгаа байх, тэнд 51 хувь байснаа 25 хувь болчихсон. Тэгээд энэ шийдвэрүүдийг хэн гаргадаг юм бэ гэсэн 2 дахь асуулт.

3 дахь асуудал, юу гэхээр энэ үйлдвэрүүд ямар үнээр худалдаж авдаг юм бэ? энэ чинь мэдээж хөдөлмөр шингэчихсэн байгаа шүү дээ тийм ээ. Дэлбэлээд зөөгөөд авчраад овоолоод, мэдээж хөдөлмөр шингэчихсэн байгаа. Тэр Үндсэн хуулийн тодорхой, тэр заалтуудын дагуу энэ чинь нөгөө ард түмний мэдэлд байгаа, ард түмний мэдэлд байх баялаг шүү дээ. Тэгэхээр үүнийг ямар үнэтэй худалдаж авдаг юм бэ? Өнөөдөр тэгээд Эрдмийн, тэгээд дээрээс нь нөгөө Ачит ихт тийм. Нөгөө бас нэг юу билээ, Баялаг бас нэг Зэс эрдэнийн хувь гээд ийм, 3 ч компани эзэмшиж, эхлэх байх. Тэгэхээр энэ ямар үнэтэй авдаг юм бэ?

Энд статистик байна л даа. Гаалийн статистик. Энэ 15 оноос хойш энэ 6 жилийн хугацаанд 64000 тонн катодын цэвэр зэс экспортолсон байна. Статистик дүн нь 355000000 доллар олсон байгаа юм. Тэгээд үүнийг энэ үйлдвэр өөрийнхөө бүтээгдэхүүнийг ашиглах, мэдээж Эрдэнэт үйлдвэр бол

татвар төлөлт олж байгаа орлогоороо Монголд тэргүүлдэг, миний ойлгосноор бол бараг Монголд сүүлийн 19 жил, нөгөө шилдэг компани, шилдэг татвар төлөгч гэж явж байгаа шүү дээ. Асар их хэмжээний хуримтлалтай, эндээ үйлдвэр байгуулж яагаад болохгүй байгаа юм бэ? Яагаад болоогүй юм? Үр ашиггүй гэж үзээд байгаа юм уу? Энэ үйлдвэрүүд ороод хувийн компаниуд ороод үр ашигтай 355000000 доллар болчихоод байна. Яагаад үүнийг ашиглаагүй юм бэ? Ер нь цаашидаа яах юм? Ийм асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах уу. Бадамсүрэн гуай. 85 Хоохорын Бадамсүрэн Эрдэнэс Монгол компанийн Зэс металлын группийн захирал.

Х.Бадамсүрэн: Эрхэм гишүүдийнхээ амар амгаланг айлтгая. Тэгэхээр Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Энэ овоолгыг Эрдэнэт үйлдвэр яагаад ашигладаггүй юм бэ гэж, тэгэхээр энд яг хамтраад ашиглаж байгаа нь Эрдмийн. Эрдмийн нөөц баялагтай холбогдоод тэр үед Эрдэнэт үйлдвэр Монгол-Оросын хамтарсан үйлдвэр байсан. Тэгээд тэр үедээ ярьж байгаад үр ашиг муудаж байна гээд зэсийн үнэтэй, тухайн үед нь яг хэлэлцэж байсан үед нь үнэ доогуур байсан гээд тэгээд энэ хувь долио багасгасан юм билээ. Цаашид Эрдэнэт үйлдвэр гол нь ийм асуудалд хөрөнгө оруулах боломжгүй гэж Монгол-Оросын хамтарсан үйлдвэр байх үед шийдэж байсан юм байна лээ. Дараа нь энэ зэс эрдэнийн хувийн асуудал яригдсан, Ачит ихтийн асуудал, үйл ажиллагаа нь бол явж байгаа. Ачит ихтийн хувьд ер нь хамтарсан үйлдвэрийнхээ зөвлөлөөр хэлэлцүүлээд хувь доль эзэмших нь үр ашиггүй юм аа. Тийм учраас Эрдэнэт үйлдвэр нөөц ашигласны төлбөрийг аваад явах нь зүйтэй гэдэг тэр гэрээгээр явж байсан.

Тэгээд та сая цаашид яах юм бэ гэж. Тэгээд би энэ Эрдэнэт үйлдвэрийн

ерөнхий захирлаар томилогдоод салбарынхаа яамтай, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтраад ер нь үндсэндээ бодлого гаргачихсан гэж бодож байгаа. Цаашид үүнийг тийм, хэл ам дагуулсан, өөр өөр зарчмаар биш, ерөөсөө нэгэнт бий болгосон Эрдэнэт үйлдвэрийн хувьд үнэт зүйлийгээ, тэгээд яг мэргэжлийн хэллэгээр болох юм бол үүсмэл орд, үүнийг бол ерөөсөө төр өөрсдөө эрсдэл гаргаж хөрөнгө оруулалт хийхгүйгээр энэ овоолгоо ашигласны төлөө 34 хувийг нь үнэ төлбөргүй эзэмшээд явах ийм зарчим гаргасан. Тэрийгээ холбогдох төрийн байгууллагад бол Эрдэнэт үйлдвэр хүргэсэн. Тэгээд энэ ЗГ-аар нэг мөр шийдэгдээд ЗГ-ынхаа түвшинд эцэслэн шийдэх юм уу, аль эсвэл Их Хуралдаа танилцуулах юм уу. Ингээд цаашидаа бол ингээд цэгцрээд явна гэж ойлгож байгаа. Ийм бодлогыг бол Эрдэнэт үйлдвэр гаргасан.

Г.Занданшатар: Баттөмөр гишүүн 1 минут.

Б.Баттөмөр: Энэ үйлдвэрийг анх санаачилж байгуулсан Цэдэнбал дарга тухайн үедээ би үзээгүй л дээ, энэ Монголын ард түмний баялаг юм аа, үүнийг хойч ирээдүй үе маань ашиглана гэж ингэж бичиж үлдээсэн байдаг гэж надад хүн ярьж байсан юм. Би дахиад танаас асуучихъя, энэ Эрдэнэт үйлдвэрийн балансанд бүртгэлтэй байна уу. Та нарын тооцож байгаагаар тэр овоолгууд дээр цэвэр зэсийн хэмжээ хэчнээн байна аа? зэсийн хэмжээ, цэвэр зэсийн хэмжээ. Тэгээд 34 хувийг аваад явъя гэдэг бол юу гэхээр тэр компаниудтайгаа яриа хэлцэл хийж үзсэн үү? Би түрүүн асуусан шүү дээ, Ачит ихт 34 байж байгаад яагаад больчихсон юм бэ. Ямар шийдвэрээр больчихсон юм бэ гэж. Ийм асуултуудад гүйцэд хариулт өгөөч.

Г.Занданшатар: 85 Хоохорын Бадамсүрэн захирал хариулъя.

Х.Бадамсүрэн: Түрүүн таны асуултад бас би дутуу хариулсан байна. Эрдэнэт үйлдвэр өөрөө үйлдвэр байгуулъя гээд ТЭЗҮ хийгээд дууссан. Тэгээд эндээ бид ямар ч байсан тэр үйлдвэрээ гаргах зорилгоо бол тавьсан, бусдад үлгэр жишээ болохоор. Металл авалт өндөртэй, үр ашиг өндөртэй, тэгээд байгаль орчинд хал балгүй ийм 10000 тонн катодын зэс үйлдвэрлэх ийм чиглэлийг барьж байгаа. Та энэ овоолго бол 2 төрлийн овоолго байгаа.

1 дүгээрт нь, ер нь энэ технологийн хувьд дэлхий дээр зэсийг хөвүүлэн баяжуулах ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчих 85, товч тодорхой хариулъя, цаг дэгээрээ л явна.

Х.Бадамсүрэн: Тэгэхээр энэ нөөц исэлдсэн өдрийн овоолгод энэ оны 10 сарын 01-ний байдлаар 261.6 мянган тонн зэс байгаа.

Мөн ядуу агуулгатай хүдрийн овоолго гэж байгаа. Тэнд нь бол 439.4 мянган тонн зэс агуулагдаж байгаа.

Г.Занданшатар: ... асуулт асууж байгаа. Байнгын хорооны санал, дүгнэлт бол 1 л санал хураалт байгаа юм, нэг л санал хураалттай юм байна.

Норовын Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Энэ 4 сард өргөн барьсан тогтоолын төсөл л дөө. Тэгээд би энэ МАН-ыг баялагтаа эзэн болно гэдэг амлалтдаа эзэн байгаа юм байх даа гэж бодож л барьсан юм, нэг.

2 дугаарт, Монголд баян хоосны ялгаа хэтэрхий ихэслээ. Байгалийн баялгийн яг хажууд нь байгаа ард түмэн ядуу, тэр баялгаас нь нэг хүн, нэг гэр бүл 100 сая доллар жилдээ авдаг ийм дэндүү шударга бус байдал байна. Үүнийг л болиулъя гэсэн юм. Тэгээд үүнийг болиулах гэснийхээ шанд би юу амсаж

байгаа вэ гэхээр ямар саадтай гүйлтээр гүйж болдог юм, ямар саад бэрхшээл тавьж болдог юм бүгдийг нь үзлээ.

УИХ-ын гишүүн хууль санаачлах эрх Үндсэн хуулиар олгогдсон эрх. 4 сард өргөн барьсан чинь 6 сард л энэ Алтанхуягийн барьсан энэ юмыг ер нь Үндсэн хууль зөрчсөн байна уу, үгүй юу дүгнэлт гарга гэсэн. Тамгын газрыг энэ муухай үйлдэл дээр татан оруулсан. Тогтохсүрэн дарга би тантай бас гэмгүй байдаг хувьд хэлчихье. Та нар энэ арга барилаа өөрчил, энэ нэг ялзарсан үхиурсэн новширсон аргаасаа сал. Танай намын бүлэг яриад л үгүй гээд шийдчихсэн байгаа байхгүй юу. Тэгэх мөртөө түүнийгээ хүний гараар могой бариулаад Тамгын газраас аваачиж хэдэн хууль ч гаргаж байгаад Алтанхуягийн энэ Үндсэн хууль зөрчсөн гээд ийм шийдвэр гаргаад байгаа юм. Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Тамгын газар чинь шийддэггүй байхгүй юу, тэр чинь ҮХЦ гэдэг газарт. Тэгэхээр ийм аргаар та нар ингээд яах вэ дээ, онцгүй юм болж байна.

Тэгээд эртээр нөгөө Байнгын хороо дэмжихгүй гээд хэлчихсэн, дараа нь энэ чуулган дээр дэмжигдчихсэн, сая тэгээд ажлын хэсэг Аубакир чи шударга бай, та нар. Ардын намын залуучууд Ардын намын архаг хулгайч нарын арга барилтай болсон байна гээд хэлчихье, уучлаарай. Та нар Монголын төрд цаашаа их удаан явах байх. Ажлын хэсэг байгуулсан, үнэн. Ажлын хэсэг хуралдаагүй, цугласан, хуралдаагүй. Тэгсэн мөртөө дахиад Тамгын газрын нөгөө Алтанхуягийн энэ тогтоол нь Үндсэн хууль зөрчиж байна гэсэн юмыг Байнгын хороон дээр уншиж байна лээ, хуралдаагүй байхгүй юу.

Өшөө нэг юм хэлье. Алтанхуягийн тогтоол бол хувийн өмчид халдаж байна гээд байгаа юм. Энэ Бадамсүрэн гэж дүлгэнээд юм ярьдаггүй байхгүй юу. Энэ сая тэр нөгөө Монголын тал 100 хувь аваад ерөөсөө дампууруулах шиг боллоо.

Бадамсүрэн одоо ард түмний өмнө шударгаар хэл, хэлж байна шүү дээ. Энэ хувийн өмч юм уу. Тэр Эрдэмийн тэр үйлдвэр нь хувийн өмч магадгүй, овоолго нь улсын өмч, ард түмний өмч. Цагааны тэр бас үйлдвэр нь тэр хувийн өмч нь байж магадгүй, тэнд байгаа овоолгууд нь ард түмний өмч. Энэ хүн сая хэллээ шүү дээ. Тэр овоолго гээд байгаа хаягдал гэж нэрлээд новируулаад байгаа байхгүй юу. Түүн дотор хэчнээн хэмжээний цэвэр зэс байгаа вэ гэхээр 2-уулаа нийлээд 600000 тонн цэвэр зэс байгаа, 600000 тонн цэвэр зэс. Үгүй ээ, та нар яагаад энэ нүүрсний хулгайг идчихээд, зэсийг нь ийм галзуу хулгайтай тэмцэж өгөхгүй байгаа юм бэ? Яагаад дэмжихгүй байгаа юм? Би ерөөсөө ойлгохгүй байна.

600000 тонн цэвэр зэс гэдэг ГОК-ийн манай баяжуулах үйлдвэрийн 5 жил гаргадаг цэвэр зэс байхгүй юу. 5 жил 560000 тонн баяжмал гаргаад, түүнийг ялгаад авахаар 120000 болдог юм. Үгүй ээ, тэгээд ийм юмыг яагаад ингээд хийдэггүй юм бэ? Энэ ард түмэн яах юм бэ? хажуу талд чинь 100 сая доллартой хүн байж байна. Тэнд байгаа 100000 хүн нь гэр хороололд гаднаа нойлтой, амаа өрөмтүүлээд яаж амьдардаг билээ гээд явж байна. Ингэж амьдрах юм уу, бид нар. Шударга ёс ингэж тогтох юм уу. Тэгээд Бадамсүрэн шиг ингээд хүний гар хөл болдог нэг амьтныг аваачаад түүний захирлаар тавьчихна. Тэгээд тендерийн бүтэн хулгай хийсэн.

Эрдэнэтэд бол 3 төрлийн хулгай байгаа шүү.

1 дүгээрт, зэсийн хүдрийн баялгийг зараад та дараа хожим нэг өдөр хуулийн байгууллагад очиж хэлэх байх. Тэндээс тонн тутамд нь доллар авдаг.

2 дахь нь, овоолгын ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хариултын дараа авна. Тэндээс хариулъя гэж байна

л даа. Байнгын хорооны дарга, Төмөртогтоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Энэ Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заачихсан байгаа юм л даа. Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно оо л гэсэн байж байгаа, өмчлөгчийн эрхийг шүү дээ. Компанийн тухай хуульд нь мөн заачихсан байж байгаа, шинээр компани байгуулах, компанийн хувьцаа эзэмших асуудлыг Компанийн тухай хуулиар зохицуулна гээд заачихсан байгаа. Тийм учраас энэ УИХ дээр, энэ УИХ-ын тогтоол гаргах шаардлагагүй ээ л гэж бид нар яриад байгаа шүү дээ.

2 дахь асуудал, Ашигт малтмалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль мөн юу гэдэг юм, Төрийн өмч болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль дээр энэ хувь хувьцааныхаа асуудлыг шийдэх хэрэгтэй, хуульд өөрчлөлт оруулах замаар.

3 дахь асуудал, өнөөдөр юу гэдэг юм, бид төрийн өмчтэй компаниуд юу гэдэг юм, хулгайч ихтэй байна, орон нутгийн өмчтэй компаниуд бас үйл ажиллагаа явуулж чадахгүй байна гээд БЭТ тавьчихаад байхад хувийн өмчтэй компаниудаа 34 хувийг нь Эрдэнэт авах гээд, 33 хувийг нь орон нутгийн өмчит авах гээд, 33 хувийг нь иргэдэд өгнө гээд ийм тогтоолын төслийг УИХ дээр өнөөдөр оруулж ирж байгаа нь өөрөө хууль зөрчсөн асуудал. Үндсэн хууль дээр заачихаад байна шүү дээ. Энэ өмчлөлтэй холбоотой асуудлыг зөвхөн хуульд зааснаар л хуулиар л хязгаарлаж, гагцхүү хуулиар хуульд заасан үндэслэлээр л хязгаарлаж болно оо гэж заачихаад байхад өнөөдөр ингээд шууд хүний, компанийн хувьцааг шууд УИХ-ын тогтоол гаргаад авчхаж болдог юм уу, болохгүй шүү дээ.

Өнөөдөр бид нар Таван толгойгоо юу гэдэг юм, олон нийтийн болгоё гэж ярьж байна. Өнөөдөр юу гэдэг юм,

жижиг таван толгой хулгай гээд БЭТ тавиад явж байна. Гэтэл эргүүлээд хувийн хэвшлийн компанийн өмчийг төр авна, орон нутаг авна гэдэг байдлаар хандаж болохгүй. Энэ бол өөрөө хууль зөрчсөн асуудал шүү. Ийм тогтоол УИХ-д гарах юм бол үнэхээр ичгүүртэй асуудал болно.

Харин би танд юу гэж хэлэх вэ гэхээр энэ хуулиуддаа хэдүүлээ өөрчлөлт оруулъя. Энэ овоолгын асуудлыг хуульд өөрчлөлт оруулах байдлаар ялангуяа Ашигт малтмалын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар шийдэх гарц гаргалаа байна гэдгийг л хэлээд байгаа юм. Бусдаар өөр ямар ч бололцоо, боломж байхгүй юм билээ. Үүнийг бол бид нар олон хүмүүсээс, олон хуульчдаас асуусан, олон удаа хуралдаж шийдсэн байж байгаа. Тийм учраас энэ дээр бид ингэж хамаагүй, ингэж иүүд тогтоол гаргаж хувийн өмчид халдаж болохгүй байх гэж миний хувьд бодож байна.

Г.Занданшатар: Норовын Алтанхуяг гишүүн 1 минут.

Н.Алтанхуяг: Энхтүвшин дарга та нар залуу хүн байна, Монголын төрд хол явна, би та нарт хэлж байна, битгий хулгайч нарын хойноос хулгайч болоод бай. Хувийн өмчид халдаагүй, магадгүй тэр үйлдвэр нь хувийн өмч байж магадгүй, энэ Бадамсүрэн надад нэмэр болохгүй байна л даа. Тэр байгаа овоолго чинь ард түмний юм байхгүй юу, хувийн өмчид халдана гэж огт байхгүй, би ганзагын наймаа хүртэл хийж явсан, тийм юм хийхгүй. Ард түмний өмчийг үгүй ээ, чи энэ Бадамсүрэн хэл л дээ, хариулт өгөхгүй. Юуных чинь зүгээр авдаг байхгүй юу, Ачит ихтийнх чинь. Эрдэмийнд болохоор нь хэдэн юмаар худалддаг байхгүй юу. Үгүй ээ, тэгээд энэ зүгээр байгаа энэ ард түмний өмчийг аваад энэ дээр үйлдвэр барьчхаад, энэ миний хувийн өмч гэж яаж хэлж чаддаг юм. Тэгээд улаан цайм яах вэ, та нар

Ардын намын даалгавар авчихсан учраас өнөөдөр үүнийг ингээд л унагаагаад явах байх.

Тэгэхдээ өнөөдөр энэ хулгайч нарыг зэсийн хулгайчийг зогсоох гэсэн тогтоол, ард иргэдийг нь зэсийн баялагт эзэн болох гэсэн тогтоолыг та нар унагаасан ч гэсэн энэ хэзээ нэгэн цагт Монголын ард түмэн баялагтай эзэн болно шүү.

Г.Занданшатар: Энхтүвшин гишүүн хариулах уу, хариулъя.

Ер нь улс бол төмрөө ч боловсруулдаг, боловсруулах бүх үйлдвэрийг дэмжиж байж л улс Солонгос ч, Япон ч, Хятад хөгждөг юм байна шүү дээ. Ер нь боловсруулах бүх үйлдвэрийг дэмжихгүй, ингэж янз бүрийн аргаар унагаадаг бол гаднын явуулга гэж бас холбогдох байгууллагуудын дүгнэлт ч яригддаг. Ер нь энэ ноосоо, ноолуураа дандаа түүхийгээр нь гаргадаг энэ юм, бас тэр дээр ахиц дэвшил хийж байгаа юмнуудыг бол уул нь тэр ажлын байр бий болгож байгаа, баялаг бүтээж байгаа тийм шинэ баялгийг бол дэмжих хандлагатай гэж Үйлдвэржилтийн байнгын хороо үзсэн юм байна лээ шүү дээ, тийм ээ.

Төмөртогтоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Энэ Алтанхуяг гишүүний оруулж ирсэн тогтоолын төсөл бол компанийн хувь хувьцааг л авах асуудал байж байгаа юм. Компанийн хувь хувьцааг. Ялангуяа 7 жил болоод үр ашгаа нөхсөн бол 34 хувь нь Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрт, 33 хувийг нь орон нутгийн өмчит ЗДТГ-т нь, 33 хувийг нь ард иргэд дээр өгөхөөр ийм компанийн хувь хувьцааг л эзэмших асуудлыг л энэ тогтоолоор оруулж ирж байгаа юм.

Үүсмэл ордын хувьд бол шал өөр ашигт малтмалын тухай хуульд

заачихсан байж байгаа, үүсмэл орд гэж юуг хэлэх вэ гэдэг. Тийм учраас Алтанхуяг гишүүнд бид нар Байнгын хороон дээр бол 2 ч удаа хэлсэн байж байгаа. Ашигт малтмалын тухай хууль дээрээ үүсмэл ордыг цаашид яаж ашиглах вэ гэдэг байдлыг тодорхой, хэдүүлээ өөрчлөлт оруулаад явъя. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль гээд баригдаад явж байгаа. Энэ дээрээ энэ тэр өмчлөлийн асуудлыг нь ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Энэ эхний хэлэлцүүлэг учраас Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол хаана байна.

“Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн явуулгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1. “Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Тилеуханы Аубакир, Жигжидийн Батжаргал, Жадамбын Бат-Эрдэнэ Гонгорын Дамдинням, Нанзадын Наранбаатар, Ганзоригийн Тэмүүлэн, Төмөртоогогийн Энхтүвшин. Санал хураалт явуулъя.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Норовын Алтанхуяг гишүүн, Баттөмөр гишүүн, Энхтүвшин гишүүнээр тасаллаа.

Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Ер нь Монголд цаашаа яаж хөгжих вэ гэхээр миний ойлгож мэдэрсэн өдрөөс өдөрт Монголд дарга нар, эрх мэдэлтнүүд хулгайчаар тодорч байгаа энэ цаг үед би юу гэж ойлгосон гэхээр миний буруу ч байж магадгүй, та нар сонсож байгаад хожим тэгэхдээ та нар яг энэ зам дээр ирнэ. Аубакир чи ирнэ, Энхтүвшин чи ирнэ. Хэрвээ ард түмнийхээ төлөө ажиллая гэвэл. Яах вэ гэхээр улсын төсөв рүү хамаг мөнгийг татдагийг болих хэрэгтэй. Бүх аймагт, магадгүй ямар нэгэн уурхай, уурхай байгаа. Тэгээд тэр уурхайн нэг жоохон хувийг нь иргэдэд нь, нэг жоохон хувийг нь орон нутагт нь эзэмшүүлнэ. Ямар хэлбэрээр вэ гэхээр зөвхөн ноогдол ашиг хэлбэрээр. Та нар бас ингээд ярьсан л даа, АМНАТ. Би Сангийн сайд байсан хүн, түүнийг чинь мэднэ. АМНАТ-ыг нь нэмэгдүүлээд өгөхөөр өгч байсан мөнгөө татчихдаг юм. Ингээд шор нь адилхан болчихдог юм аа. Ноогдол ашиг гэдэг бол гарцаа байхгүй тэндээ үлддэг учраас би энэ дээр зүтгээд байгаа юм. Тэгэхдээ хамаагүй, та нар улс төрийн шийдвэр гаргаад үүнийг унагаана гэхихсэн учраас би нэг их надад уйлан дуугараад байх юм алга.

Цаана чинь ард түмэн чинь уйлан дуугарч байгаа шүү дээ. Ядуураад, хоосроод, дэндүү шударга бус байгаа шүү дээ. Энэ чинь дэндүү шударга бус байна шүү дээ. Би тийм учраас та нарыг бас наанатай цаанатай юманд хандах болов уу гэж бодсон юм.

Манай залуучууд нэг юм хиймээр байна, Ардын намын залуучууд ч гэсэн. Жаахан мэдээлэлтэй болмоор байна, юм яримаар байна. Би нэг юманд гомдохгүй үлдэж болж байсан юм, хэн ээ, Энхтүвшин. Та нар ажлын хэсгээ хуралдуулаад Энэ Бадамсүрэн, тэр Цэнгэл энэ бүх хүмүүсийг оруулж ирээд бас нэг 2 юм, үгүй ээ, ядаж нэг удаа сайхан хуралдаад үгүй ээ, тэгээд түүн

дээрээсээ мэдээллээ авч байгаа шийдвэр гаргасан бол би та нарт ерөөсөө гомдох юм байхгүй. Ардын намын бүлгийн хурал дуусахаар ажлын хэсэг хуралдана гэж надад хэлсэн юм. Тэгэхээр нь би хүлээж байгаад орсон чинь өө сая хуралдчихсан шүү дээ гэж, хуралдаагүй байхгүй юу. Тэгэхээр залуу хүмүүс бас ийм хулгай луйвар багаасаа сурч болохгүй. Монголын төр ерөөсөө нэг жаахан хулгайн үүрээс хол байх ёстой. Та нар жаахан нуруутай байх ёстой, юм мэдэх ёстой. Энэ ах нар архагууд хулгайч нар муу юм зааж өгч байна, та нарт. Муу юмыг нь сурч болохгүй шүү дээ.

Ер нь эцсийн эцэст заавал л байхад бас сурдаг ганц авьяастай, ганц 2 авьяастай хүн байгаа юм. Би хэлж байна шүү, үнэхээр Ардын намынхан та нар нээрээ энэ ард түмнийхээ амьдралыг бод л доо. Жишээ нь Эрдэнэт бол ингээд бүр сонгодог жишээ байхгүй юу. Хажуу талд нь дэлбэлээд л, ачаад л, ачаад л, ачаад л яваад байдаг. 74 оноос хойш 48 жил амьдарч байгаа хүмүүс байхгүй юу. Үгүй ээ, би тэнд чинь очоод бүр ингээд зүрх сэтгэл минь ингээд шимширээд байдаг байхгүй юу. Үгүй энэ, хажууд нь ядаж байхад та нарын хэлээд байгаа хувийн өмчийн уурхай боссон юм. Үхсэн элэнцгийнхээ хувийн өмч байх вэ дээ.

Одоо би хэлчихье. Энэ худлаа хэлсэн шүү, энэ Бадамсүрэн. Зэсийг нь уначихсан байхад 5000 доллар гэж бод, тэгвэл 5000 доллар байх үед 50 мянган, 50 сая доллароор тэр үйлдвэр босно. Жилийнх нь борлуулалт бол хангалттай, одоо 3 жил ажиллаад л ашгаа нөхчихнө, ашиг биш хөрөнгө оруулалтаа нөхөөд ашгаа аваад эхэлчихнэ. Үгүй ээ, тэгээд та мэдэж байгаа шүү дээ, Эрдэмийн 51 хувь нь Эрдэнэт концерн дээр байсан чинь ямар хулгайч нар нь өнөөдөр авсаар байгаад Эрдэнэт дээр 25 хувь болгочихдог юм. Үгүй ээ, ингээд хулгайг янз бүрээр хийгээд байна шүү дээ. Хулгайг чинь. Ингээд тоон дээр ажиллаад хувь процентыг чинь өөрчлөөд хүртэл хулгай хийчхэж байна.

Тэгээд та нар минь шийдвэрээ гаргаарай. Ард түмэн харж байгаа. Та нар тэгэхдээ зөв юм хийгээрэй. Үүнийг унагааж болно. Ард түмэн баялагтаа эзэн болох ёстой шүү.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлнэ.

Б.Баттөмөр: Энэ бол баялгийн менежментийн л асуудал юм байгаа юм л даа. Монгол Улс яаж хөгжих вэ гэвэл баялгийн менежментээ зөв хийж байж хөгжинө. Би Монголын үндэсний татварын ерөнхий газрын дарга байсан. 2030 онд хүртэл Монгол Улс яг ийм байдлаар татвар хураагаад Монголын ард түмний амьдралд ямар ч өөрчлөлт гарахгүй, төсөвт мөнгө цугларахгүй, яг л нэг ийм байдлаар нөгөө л нэг 5.4 тэрбум долларын л бид нар нэг төсвийн орлоготой шүү дээ. Үгүй ээ, яаж энэ төр төсөв мөнгөтэй болохыг бол энэ баялгийн менежментээ л зөв хийх ёстой шүү дээ. Тэгээд би бол Үйлдвэржилтийн байнгын хороог энэ хэний Алтанхуяг гишүүний энэ 34, 34, 33 гэсэн энэ чинь тэр Үндсэн хууль хууль зөрчсөн хүний юмыг авах гэж байна гэдэг утгаар тэгж гарсан байх. Түүнээс биш үнэгүй өг гэж гарч байна гэж би бол ойлгохгүй байна.

Үгүй ээ, тэгээд үүнийг хийе л дээ, юу болоод, юу энэ чинь хангалттай, 15 оноос хойш ашиглачихсан байна шүү дээ энэ чинь. 355000000 долларыг тэгээд авчихсан байна шүү дээ. 2 компани. Үгүй ээ дээ, энэ ард түмний чинь амьдрал ямар байна аа? Нөгөө бид нар одоо хулгай л гэж яриад байгаа шүү дээ. Энэ чинь бас л нэг тийм соёлтой хулгай ч юм уу, юу ч юм одоо ингээд бид харсан ч хараагүй юм шиг л ингээд суугаад байж болохгүй шүү дээ.

Үгүй ээ, энэ тодорхой хэмжээгээр үнэлээд худалдчихъя л даа. Яагаад болохгүй байгаа юм бэ? Төсвийн байнгын хороо, Сангийн яам, манай энэ Хөгжлийн яам энэ дээр юу бодож байдаг юм бэ? Ийм боломж байна шүү дээ.

Энэ 355000000 доллароос 60, 70 сая төгрөг доллароор нь худалдаад яах чинь энэ чинь Монгол Улсын төсөвт орно шүү дээ. Яагаад үүнийг бид нар харахгүй байгаад байгаа юм? Ийм их баян, ийм их мөнгөтэй болчихсон юм уу? Байхгүй шүү дээ. Энэ сая тэр Алтанхуяг гишүүний ярьж байгаа энэ 600000 тонн цэвэр зэс байна аа, энэ чинь ГОК-ийн 5 жилийн ажилтай тэнцэнэ ээ гэж байгаа юм. Энэ маш их том, ийм боломж байна шүү дээ. Үүнийг чинь хүн бий болгочихсон, энэ Эрдэнэтийн тэр ажилчид ГОК компани үүнийг бий болгочихсон байна шүү дээ, бий болгочихсон юмаа худалдъя л даа. Тийм учраас энэ нэг тогтоолыг хаагаад өнгөрөхөө биш, би ямар санал хэлэх гэж байна гэхээр зэрэг үүнийг тодорхой хугацаа заагаад эндээс тодорхой хэмжээний орлогыг олж, энэ төсвөө бүрдүүлж энэ ард түмнийхээ цалин, тэтгэврийг нэмэх, энэ тэр баялгийнхаа сандаа төвлөрүүлээд тэр ипотека энэ тэрдээ зарцуулах энэ ийм юмаа хийе л дээ.

Би үүнийг нэг хүн мөнгөтэй болж байгаад нэг их хордоод, нэг их тэнд их яагаад бачуураад байгаа юм ерөөсөө алга. Энэ баялгаас бусад юман дээр юугаа хийнэ, бүгдийг нь дэмжих хэрэгтэй. Газрын баялаг дээр өөр шүү, нөхөд өө. Ийм байж ерөөсөө болохгүй. Нийт энэ хүн амын чинь 45 хувь нь ядуурчихсан байна шүү дээ. Энэ хүмүүсийг яаж ядуурлаас гаргая гэвэл баялгийн менежментээ зөв хийж байж гарна, өөр гарц байхгүй, Монголд, ойрын хугацаанд. Тийм учраас энэ дээрээ та бүгд анхаараач ээ.

Би бол энэ дээр ямар санал хэлэх гэж байна вэ гэвэл худалдах хэрэгтэй. Шинэ оноос эхлээд эхний тэр овоолгоос ашиглах тэр материалыг бол тэр овоолгыг тодорхой хэмжээгээр худалдаж, төсөвт мөнгө оруулах хэрэгтэй. Ийм маш их боломжууд байгаа шүү дээ. Үүнийг бид ашиглаж чадахгүй байгаа, харамсалтай байна, маш ойрын хугацаанд энэ асуудлыг шийдэх хэрэгтэй.

Ийм шаардлагыг би Их Хурлын гишүүний хувьд тавьж байна.

Г.Занданшатар:

Төмөртөгоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Би нэг ганц 2 юм хэлье. 1 дүгээрт, юу гэдэг юм, тэр Эрдэнэтийн овоолгыг ашиглаж байгаа компаниудын эздийг нэгдүгээрт би танихгүй, Аубакир гишүүн ч бас танихгүй болов уу гэж бодож байна. Бид бол хуулийн хүрээнд л ажиллаж байгаа, хууль зөрчсөн зүйл байхгүй ээ. Харин та битгий хууль зөрчиж яриад бай гэж хэлмээр байна.

1 дүгээр асуудал, тухайн компани хөрөнгөө оруулаад олон жил үр ашигтай ажиллаж байна.

2 дахь асуудал, маш олон ажлын байрыг бий болгоод явж байна.

3 дахь асуудал, орон нутагтаа болон улсын төвлөрсөн төсөвт татаасаа төлөөд татвараа төлөөд явж байна.

4 дэх асуудал, орон нутгаас маш их хэмжээний худалдан авалт хийж, орон нутагт тодорхой хэмжээнд баялаг үүсгээд явж байгаа компаниуд юм байна лээ.

Анх юу гэдэг юм, үүнийг Монгол Улсын ЗГ буюу Эрдэнэт үйлдвэр өөрөө гэрээ байгуулаад энэ 3 компанид эрхийг нь өгөөд 7-оос дээш хугацаанд ажиллаад явж байгаа компаниуд.

Таны яриад байгаа энэ үүсмэл ордыг худалдъя гэдэг асуудал дээр би санал нэг байна. Тэгэхдээ зүгээр юу гэдэг юм, Үйлдвэржилтийн байнгын хорооноос тогтоол гараад энд үүсмэл ордыг худалдъя гэдэг шийдвэр гаргаж болох уу. Болохгүй шүү дээ. Тийм учраас би хэлээд байгаа юм.

Та хэд маань Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулчхаач ээ, үүсмэл ордоо цаашид яах ёстой юм, компанийн тухай хууль дээрээ өөрчлөлт оруулчхаач ээ, энэ компанийн хувь хувьцааны асуудлыг яах ёстой юм гэдэг асуудлыг л яриач ээ гэж хэлж байгаа юм. Бусдаар юу гэдэг юм, УИХ-ын нэг тогтоол гаргаад өнөөдөр хэвийн ажиллаж байгаа компанийн 34 хувийг төрд авна, 33 хувийг нь орон нутагт авна, 33 хувийг иргэдэд өгнө гээд ийм байдлаар энэ хөрөнгө оруулагчдыг үргээж, энэ хөрөнгө оруулагчдыг ингэж дарамталж, хувь хувьцааг нь авч болох юм уу. Та өөрөө бизнес хийдэг хүн, болохгүй шүү дээ. Үндсэн хууль дээр заачхаад байна шүү дээ, би харин Үндсэн хуулийн зарчмыг танд уншиж өгөөд байна шүү дээ. Үндсэн хууль дээр Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахид өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно оо гээд ингээд Үндсэн хууль дээр заачихсан байхад хувь хувьцааг нь авна гэдэг л юм ярьж байна шүү дээ.

Та тэр үүсмэл ордынхоо асуудлыг тэр Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулаад л ярь, шууд Үйлдвэржилтийн байнгын хороо ингээд хуралдаад хуульд өөрчлөлт оруулдаг асуудал байхгүй шүү. Тийм учраас үгүй ээ, харин тийм учраас би таныг хэлээд байна, бид хуулийн хүрээнд ажилласан, та хуулийн хүрээнд л ярь.

Г.Занданшатар: Тилеуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Алтанхуяг гишүүн ээ, бид нар, та хуралдаагүй гээд бас улаан цайм тэгж болохгүй байх. Бид нар 2022 оны 11 сарын 09-ний өдөр 12 цагт хурал зарлаад 12:30 хүртэл хуралдаад яг гарч байгаад та бид тэр үүдэнд таарсан. Хуралдах нь бол хуралдана шүү, дарга аа. Энэ хурал дээр миний би Батжаргал гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Дамдинням, Наранбаатар, Тэмүүлэн, Энхтүвшин

нарын гишүүд байсан. Бас л тал талаас нь бид нар таныг орж ирэхээс өмнө, ялангуяа Ганболд гишүүн бол санал гаргаж байсан. Үүнийгээ яг энэ Алтанхуяг гишүүний гаргасан энэ саналаар биш Ашигт малтмалынхаа тухай хуулиар, төрийн төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиар бас зохицуулж болох юм гэж. Асуудлуудыг бид нар бас тодорхой хэмжээнд ярилцсан Алтанхуяг гишүүн ээ. Бид нар Баттөмөр гишүүн ч бай, Алтанхуяг гишүүн ч бай, бид нар мөн тантай, та нартай адилхан л бодолтой байж байгаа.

Энэ үүсмэл ордыг ашиглахын тулд технологид тохирохгүй овоолго гэж байгаа шүү дээ. Технологид ер нь энэ Эрдэнэт үйлдвэрийн технологид ерөөсөө тохироогүй. Үүнийгээ яах юм бэ, хаях юм уу. Өчнөөн тонн атваал үүсчихсэн байдаг. Үүнийгээ хаях юм уу, яах вэ гэж байхад хувийн хэвшлийнхэн нь өөрсдөө технологио олж ирээд, хөрөнгө мөнгөө гаргаад, тодорхой хэмжээний ашиг олоод, улсдаа татвараа төлөөд л явж байгаа зүйл. Тийм учраас үүнийг хэтэрхий нөгөө талаас нь юу гэдэг юм, ард иргэдийг төөрөгдүүлэх байдлаар та нарын авах байсан зүйлийг ингэчихлээ шүү дээ гэж бас буруу ойлгуулаад байх нь арай явцуу байх гэж бодож байна.

Мөн энэ дээр бол гаргалгаа бол байгаа. Ашигт малтмалынхаа тухай хууль дээр ярьж болно, орон нутгийн болон төрийн өмчийн тухай хууль дээр ярьж болно. Яг бид нарыг зөвхөн энэ ажлын хэсэг байгуулагдаад та нар хүчээр муйхарлаад хууль зөрччихлөө гээд ингээд байх юм. Энэ чинь бид нар бас хуулийн зөвлөгөө авах эрхтэй хүмүүс шүү дээ. Тийм учраас Үндсэн хууль, Компанийн тухай хууль, Төсвийн тухай хууль зэрэг хуулиудад тухайн харилцааг хуулиар зохицуулахаар заасан атал тогтоолоор зохицуулахаар төсөлд тусгасан нь хууль зүйн хүчин чадал, хэлбэрийн хувьд шаардлага хангахгүй байна гэдэг зөвлөгөөг бид нарт өгч

байгаа. Бид нар мөн л нээрээ тийм шүү гээд л юу гэдэг юм попроод л ингээд байж болохгүй шүү дээ. Бид нар өөрсдөө хууль зөрчөөд суугаад байж болохгүй шүү дээ. Танд бусад гаргалгаанууд бэлэн байж байгаа. Тийм учраас тэр талаас нь ингээд хандаад ярихгүй бол, ялангуяа Ардын намын залуучууд гээд бас нэг харлуулах гээд байгаа ч юм шиг, бас байдал ажиглагдаад байна. Тийм учраас хэдүүлээ үүнийг бас зөв болох талаас нь цаашидаа шийдээд явах ёстой гэсэн саналтай байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй.

Тэгэхдээ ер нь бас нийгэмд зөв ойлголт өгөх зорилгоор энэ нүүрсний хулгай, баялгийн хулгайтай бол УИХ түр хороо байгуулж, УИХ, ЗГ бол шүгэл хүлээж, энэ жинхэнэ энэ Ганболд гишүүний түр хороо энэ тэр дээр яригдаж, гишүүд ч гэсэн санаачилгатай ажиллаж, тэгээд сүүлд нь л ингээд янз янзын нотлогдсон, нотлогдоогүй зүйлүүд, тоо баримтууд дэгстэй, догостой ч юм шиг юм зарлаж, ингэж бухимдуулаад байгаа болохоос биш төр ард түмнийг төлөөлөх үүргийнхээ хүрээнд тэр ажлаа хийж байгаа шүү дээ. Тэгэхгүй бол үүнийг чинь бас мушгин гуйвуулж байгаа. Үүгээр далимдуулаад энэ хулгай, авлига бол төрийн өмчийн компани, төрийн өмчийн компаниуд дээр л байгаа гэдгийг хүн болгон яриад байна. Үүгээр далимдуулж хувийн хэвшлийг хөрөнгө оруулалт, эрсдэлээ гаргаад явж байгаа цементийн ч байна уу, юуны ч байна уу, одоо овоолго ашигт малтмал ашиглаад хөрөнгө оруулалт хийж байгаа компаниуд руу УИХ шууд тэгж чиглэл өгч халдах энэ тэр бол энэ эдийн засгийн хөгжил, зах зээлийн хөгжилтэйгөө хэр нийцтэй юм бэ л гэж энэ ажлын хэсэг дүгнэсэн юм байна шүү дээ гэж ойлголоо. Тэгээд зөв талаар нь ойлгоод байгаа нийгэмд тэгж ойлголт өгөөд явах нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулъя.

Харин тэр Эрдэнэтийгээ тэр худалдан авалт, борлуулалт тэр юмнуудаа харин тэр ярих ёстой юм байна гэж би ойлгож байгаа шүү.

Ингээд Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Түрүүн уншихсан тийм ээ. Үг хэлсэн, дэмжсэн, дэмжээгүй саналын томъёоллоор үг хэлчихсэн. Санал хураалт явуулах юм байна шүү.

Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Түрүүн уншихсан учраас дахиж унших шаардлагагүй байна, тийм ээ. Ажлын хэсгийг ч уншихсан юм байна. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналыг 66.7 хувь нь дэмжлээ.

Энэ асуудал дуусаагүй байна шүү. Зарчмын зөрүүдтэй саналын томъёолол дэмжигдсэн тул тогтоолын төсөл буцаах тухай УИХ-ын тогтоолыг баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

УИХ-ын гишүүн Норовын Алтанхуягаас 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Эрдэнэт үйлдвэр, төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ